



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Монгол Улсын эрчим хүчний засаглалын үнэлгээний тайлан



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

СУДАЛГААНЫ БАГ:

Бодлогын үйл явцын үнэлгээ

Б.Бат, МУИС
Д.Цэрэнжав, “Ил тод байдал сан” ТББ

Зохицуулалтын үйл явцын үнэлгээ

Ж.Доржпүрэв, CDM төв ТББ
Г.Пүрэвдорж, Монголын эрчим хүчний ассоциаци

Дүн шижилгээний хэсгийг:

Д.Цэрэнжав, “Ил тод байдал сан” ТББ

Олон улсын зөвлөх:

Давида Воод, Дэлхийн Нөөцийн Хүрээлэн, АНУ
Бахотир Кабибов, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, Тажикстан

Дотоод зөвлөх:

Д.Сүхгэрэл, “Оюу толгойн хяналт” ТББ-ын тэргүүн
Ц.Түмэнцогт, Женирал Электрик Интернэшнл Инк. компанийн Монгол дахь суурин төлөөлөгч
Р.Ганжуур, Эрчим хүчний инженерүүдийн холбооны ерөнхийлөгч
Б.Туяа, Эрчим хүчний газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга
Х.Ганбаатар, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал
Я.Нямжаргал, ЭБЭХЯ-ны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга
Р.Ган-Эрдэнэ, Эрчим хүчний зохицуулах газрын Эрх зүй, захиргааны албаны дарга

Судалгааг удирдаж, хянан тохиолдуулсан:

Б. Мөнхсоёл, Нээлттэй Нийгэм Форумын менежер

© Нээлттэй Нийгэм Форум 2012.

Энэхүү тайланг бүтнээр нь болон хэсэгчлэн хувилж олшруулах, дахин хэвлэхийг хүсвэл доорх хаягаар хандаж зөвшөөрөл авна уу.

Хаяг: Жамьян гүний гудамж
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар -48,
Утас: 976-11-313207
Факс: 976-11-324857
Вэб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn

DDC
333.79
M-692
ISBN 978-99962-56-51-6

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ.....	4
ӨМНӨХ ҮГ	5
ОРШИЛ	7
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ.....	9
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ТОВЧ ТОЙМ	13
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	23
ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧОО	24
БОДЛОГЫН ҮЙЛ ЯВЦ: ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....	29
Эрчим хүчний салбарын бодлогын үйл явцын тодорхойлолт	29
Эрчим хүчний салбарын хууль, эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал	29
Бодлогын үйл явцад хамаарах институциуд: Бүтэц, эрх мэдэл, чадавхи, хүлээх үүргийн ил тод байдал (БҮЯ01 - БҮЯ13)	31
Бодлого боловсруулах үйл явц: Хэлэлцүүлгийн чанар, ил тод байдал, оролцоо (БҮЯ14 - БҮЯ23)	34
Бодлогын хэрэгжилт: Ил тод, нээлттэй байдал, хариуцлага (БҮЯ24 - БҮЯ29)	38
Байгаль орчин, нийгмийн асуудлууд: Олон нийтийн оролцоо, бодлого, төлөвлөлт, үнэлгээ (БҮЯ30 - БҮЯ36)	39
Бодлогын үйл явцын зөвлөмжүүд	41
ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ ЯВЦ: ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....	46
Эрчим хүчний салбарын зохицуулалтын үйл явцын тодорхойлолт.....	46
Зохицуулалтын үйл явцын хууль, журам, эрх зүйн бусад баримт бичгүүд	46
Зохицуулах бүтэц: Эрх мэдэл, ил тод байдал, хараат бус байдал, чадавхи (ЗҮЯ01 - ЗҮЯ14)	48
Шийдвэр гаргах үйл явц: Үндэслэл, ил тод байдал, олон нийтийн оролцоо (ЗҮЯ15- ЗҮЯ27)	50
Үйл ажиллагааны асуудлууд: Зарчим, гүйцэтгэх үүрэг, тайлагнал (ЗҮЯ28 - ЗҮЯ32)	55
Зохицуулах үйл явцын зөвлөмжүүд.....	56
АСУУЛГЫН ХАРИУЛТУУД: Бодлогын үйл явц.....	61
АСУУЛГЫН ХАРИУЛТУУД: Зохицуулалтын үйл явц	109

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ

УИХ	Улсын Их Хурал
ЭБЭХЯ	Эрдэс баялаг, эрчим хүчний яам
ЭХЗГ	Эрчим хүчний зохицуулах газар (2012 он хүртэл)
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо (2012 оноос)
ДҮТ	Диспетчерийн үндэсний төв
ТБЭХС	Төвийн бүсийн эрчим хүчний систем
ББЭХС	Баруун бүсийн эрчим хүчний систем
ДБЭХС	Дорнод бүсийн эрчим хүчний систем
АУЭХС	Алтай-Улиастайн бүсийн эрчим хүчний систем
ТБЦДС	Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ
ББЦДС	Баруун бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ
УБЦТС	Улаанбаатарын цахилгаан түгээх сүлжээ
ДСЦТС	Дархан-Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ
ЭБЦТС	Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ
БНЗӨБЦТС	Багануур, Зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ
УБДС	Улаанбаатарын дулааны сүлжээ
ДДС	Дарханы дулааны сүлжээ
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦТС	Цахилгаан түгээх сүлжээ
ДЦС	Дулааны цахилгаан станц
УЦС	Усан цахилгаан станц
СЦС	Салхин цахилгаан станц
НЦС	Нарны цахилгаан станц
ДиЦС	Дизель цахилгаан станц
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
ТЗЭ	Тусгай зөвшөөрөл эзэмшигч
СЭХ	Сэргээгдэх эрчим хүч
ДБ	Дэлхийн банк
АНУ-ын ОУХА	АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг
ХХХ	Хүлэмжийн хийн худалдаа
ЦХМ буюу CDM	Цэвэр хөгжлийн механизм
БОНБУ	Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ

ӨМНӨХ ҮГ

Эрчим хүч нь улс орны эдийн засаг, тогтвортой хөгжил, ард иргэдийн амьдралын чанарт шууд нөлөөлдөг дэд бүтцийн онцгой чухал салбар билээ. Хэрвээ энэ салбар хямарч доголдвол улс орны амьдрал бүхэлдээ хүндрэх үр дагавартай. Тиймээс эрчим хүчний салбарын бодлого, зохицуулалт, тэдгээрийн хэрэгжилт онцгой анхаарал татсан асуудал юм.

Өнөөдрийг хүртэл Монгол Улсад эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлтийг бараг бүхэлд нь төр өөрөө хариуцан эрхэлж ирлээ. Сүүлийн жилүүдэд улс орны эдийн засаг огцом тэлж өсөхийн хэрээр эрчим хүчний хэрэгцээ эрс нэмэгдэж, нөгөө талаар иргэдийн амьдралын түвшинг сайжруулах, нийгмийн ялгааг багасгах, байгаль орчны доройтлыг бууруулах зэрэг тулгамдсан зорилтуудыг шийдвэрлэхийн тулд асар их хөрөнгө оруулалт, гадаадын зээл тусламжаар тэтгэгдэж ирсэн тус салбарын бодлого төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг урьд урьдынхаас илүү хариуцлагатай, иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй болгох шаардлага хурцаар тавигдаж байна.

Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн Төв-Евразийн төслийн дэмжлэгтэйгээр Нээлттэй Нийгэм Форум эрчим хүчний салбарт хариуцлагатай, сайн засаглалыг бэхжүүлэхэд тус дэм үзүүлэх зорилгоор “Эрчим хүчний засаглалын үнэлгээ” хийснээ Та бүхэнд хүргэж байна. АНУ-ын Дэлхийн нөөцийн хүрээлэн болон Энэтхэгийн Прайас энержи групп байгууллагын хамтран боловсруулсан Эрчим хүчний засаглалын санаачлага хэмээх үнэлгээний аргачлалд үндэслэн (i) салбарын засаглалыг зохицуулах үйл явц, (ii) бодлогын үйл явц гэсэн үндсэн хоёр асуудлын хүрээнд чадавхи, ил тод байдал, иргэдийн оролцоо, хариуцлагатай байдлыг нийт 68 үзүүлэлтээр дүгнэсэн юм.

Эрчим хүчний засаглалын санаачлага нь тус салбарт үйл ажиллагаа явуулдаг, үр шимийг нь хүртдэг болон ашиг сонирхол нь хөндөгдөж байдаг бүх тал, тэдгээрийн дотор төр, бизнес, эрдэм шинжилгээ, судалгаа, төрийн бус байгууллагууд, орон нутаг болон иргэдийн идэвхитэй оролцоонд түшиглэх зарчмыг баримталдаг. Эдгээр тал өөр өөрийн эрх хэмжээ, хүлээх үүрэгтэй, зөвхөн зарим нь эцсийн албан ёсны шийдвэр гаргах эрх мэдэлтэй хэдий ч тэрхүү шийдвэрийг гаргахад байр сууриа илэрхийлэх, нөлөөлөх боломж бүгдэд нээлттэй байх учиртай.

Бид өнгөрсөн оны 11 дүгээр сард үнэлгээний үр дүнг хэлэлцүүлэх уулзалт зохион байгуулсан бөгөөд уг хэлэлцүүлэгт хөндөгдсөн чухал асуудлуудыг уншигчиддаа хүргэх үүднээс уулзалтын тэмдэглэлийг энэхүү тайланд хавсаргалаа. Монгол Улсын эрчим хүчний засаглалын дундаж үнэлгээ 3.15 оноотой (нийт 5 онооноос) гарсан нь энэ салбарын бодлогын болон зохицуулах үйл явц, түүн дотроо гарсан шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулах зэрэг нэлээдгүй асуудал байгааг илэрхийлж буй юм.

ННФ үнэлгээний үр дүн болоод хэлэлцүүлгийн үеэр гарсан саналын дагуу цаашид эрчим хүчний салбарын засаглалын асуудалд анхаарал хандуулж, байр сууриа илэрхийлэх иргэний нийгмийн байгууллагын эвсэл байгуулж ажиллахаар төлөвлөж байна.

Энэхүү үнэлгээг ерөнхийдөө 2011 он, зарим талаар 2012 оны эхний хагас жилийн баримт мэдээлэл, нөхцөл байдалд тулгуурлан хийж гүйцэтгэсэн ба түүнээс хойш 2012 оны 6 дугаар сард Улсын Их Хурлын сонгууль болж төр, засгийн дотоод бүтэц, түүний дотор эрчим хүчний засаглалын тогтолцоонд зарим өөрчлөлт хийгджээ. Тухайлбал, Эрдэс баялаг, эрчим хүчний яамыг татан буулгаж Эрчим хүчний дагнасан яамыг байгуулж, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг - Эрчим хүчний газрыг татан буулгаж чиг үүргийг нь яаманд нэгтгэжээ. Гэхдээ одоогоор эрчим хүчний салбарын бодлого, зохицуулалтад хамаарах томоохон өөрчлөлт хараахан гараагүй байна.

Нээлттэй Нийгэм Форумын захиалгыг амжилттай гүйцэтгэж энэ судалгааг Таны гарт хүргэх бололцоо олгосон судалгааны багт талархлаа илэрхийлье.

П. Эрдэнэжаргал

Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал

ОРШИЛ

Эрчим хүч нь дэд бүтцийн онцгой чухал салбар бөгөөд түүнээс улс орны эдийн засаг, тогтвортой хөгжил, ард иргэдийн амьдралын чанар шууд шалтгаалдаг.

Нээлттэй Нийгэм Форумаас Төв Евразийн Төсөлтэй хамтран аливаа улс орны хөгжил цэцэглэлт, хүмүүсийн өдөр тутмын амьдралд тулгуур ач холбогдолтой байдаг эрчим хүчний салбарт хариуцлагатай, сайн засаглалыг бий болгож бэхжүүлэхэд тус дөхөм үзүүлэх зорилготой олон улсын “Эрчим хүчний засаглалын санаачлага”-ыг 2011 оноос Монгол Улсад хэрэгжүүлж эхлээд байна.

Санаачлагын англи нэр нь *The Electricity Governance Initiative* буюу Цахилгаан эрчим хүчний засаглалын санаачлага юм. Манай орны нөхцөлд цахилгааны эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээг дулааны эрчим хүчнийхээс салгах боломжгүй, бодлого, зохицуулалт нь нэг хууль тогтоомж, яам, агентлагийн эрхлэх ажлын хүрээнд хамаардаг учраас санаачлагыг нийт эрчим хүчний салбарын хүрээнд авч үзлээ.

Эрчим хүч нь дэд бүтцийн онцгой чухал салбар бөгөөд түүнээс улс орны эдийн засаг, тогтвортой хөгжил, ард иргэдийн амьдралын чанар шууд шалтгаалдаг гэж хэлж болно. Хэрвээ энэ салбар хямарч доголдвол улс орон тэр чигээрээ хямрахад хүргэх үр дагавартай. Тиймээс эрчим хүчний салбарын бүтэц, бодлого, түүний хэрэгжилт, зохицуулалтын асуудал онцгой анхаарал татсан асуудал юм.

Өнөөдрийг хүртэл Монгол Улсад эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлтийг бараг бүхэлд нь төр өөрөө хариуцан эрхэлж ирлээ. Сүүлийн жилүүдэд улс орны эдийн засаг огцом тэлж өсөхийн хэрээр эрчим хүчний хэрэгцээ тэр хэмжээгээр нэмэгдэж, нөгөө талаар хүмүүсийн амьдралын түвшинг сайжруулах, нийгмийн ялгааг багасгах, байгаль орчны доройтлыг бууруулах зэрэг тулгамдсан зорилтуудыг шийдвэрлэхийн тулд асар их хөрөнгө оруулалтаар барьж байгуулагдсан, мөн гадаадын зээл тусламжийн үлэмжхэн хэсгээр шинэчлэгдэж ирсэн тус салбарын бодлого төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг урьд урьдынхаас илүү хариуцлагатай, иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй болгох шаардлага хурцаар тавигдаж байна.

Эрчим хүчний засаглалын санаачлага нь тус салбарт үйл ажиллагаа явуулдаг, янз бүрээр оролцдог, үр шимийг нь хүртдэг болон ашиг сонирхол нь хөндөгдөж байдаг бүх тал, тэдгээрийн дотор төр, бизнес, эрдэм шинжилгээ, судалгаа, төрийн бус байгууллагууд, орон нутаг болон


иргэдийн идэвхитэй оролцоонд түшиглэх зарчмыг баримталдаг. Эдгээр талууд өөр өөрийн эрх хэмжээ, хүлээх үүрэгтэй, зөвхөн зарим нь эцсийн албан ёсны шийдвэр гаргах эрх мэдэлтэй хэдий ч тэрхүү шийдвэрийг гаргахад байр сууриа илэрхийлэх, нөлөөлөх боломж бүгдэд нээлттэй байх учиртай. Ийм учраас цаашид эрчим хүчний салбарт талуудын хамтын ажиллагааны зөвлөл буюу зөвлөлдөх механизмыг бий болгож уг санаачлагыг Монгол Улсын хэмжээнд удирдан зохион байгуулах чиг үүрэгтэй ажиллуулахаар төлөвлөж байна.

Өнгөрсөн хугацаанд бид уг санаачлагыг хэрэгжүүлж байгаа зарим улс орны мэргэжилтнүүдийг урьж сонирхогч талуудад сургалт зохион байгуулж туршлага, сургамжаас нь суралцсан болно.


Энэхүү үнэлгээг ерөнхийдөө 2011 он, зарим талаар 2012 оны эхний хагас жилийн баримт мэдээлэл, нөхцөл байдалд тулгуурлан хийж гүйцэтгэлээ. Түүнээс хойш 2012 оны 6-р сард Монголд Улсад парламентын сонгууль явагдаж төр, засгийн дотоод бүтэц, түүний дотор эрчим хүчний засаглалын тогтолцоонд зарим өөрчлөлт хийгджээ. Тухайлбал, эрчим хүчний асуудлыг хамаардаг УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны бүрэлдэхүүн шинэчлэгдэв. Өмнөх УИХ-д байсан эрчим хүчний мэргэжилтэй А.Тлейхан гишүүн дахин сонгогдсон боловч тодорхой шалтгааны улмаас тус байнгын хорооны бүрэлдэхүүнд хараахан ороогүй байна.

Эрдэс баялаг, эрчим хүчний яамыг татан буулгаж Эрчим хүчний дагнасан яамыг байгуулжээ. Эрчим хүчний Сайдаар нь УИХ-ын гишүүн М.Сономпил томилогдон ажиллаж байна. Мөн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг - Эрчим хүчний газрыг татан буулгаж чиг үүргийг нь яаманд нэгтгэжээ.

Гэхдээ одоогоор эрчим хүчний салбарын бодлого, зохицуулалтад хамаарах томоохон шийдвэр шинээр хараахан гараагүй байна. Гэхдээ Улаанбаатар хотод байгуулахаар төлөвлөсөн дулааны 5-р цахилгаан станцын байршлын талаар Засгийн газраас хэд хэдэн удаа хэлэлцэж тодорхой шийдвэр гаргахаар ажиллаж байгаа бөгөөд энэ үйл явц нь үнэлгээний явцад бидний хийсэн дүгнэлтийг ерөнхийдөө дахин нотолж байна гэж үзлээ.



Эрчим хүчний засаглалын ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ



Төв аймгийн Бүрэн сумын нутагт, 2011 он. Гэрэл зургийг Ц.Батбаатар

*Сүүлийн жилүүдэд
эрчим хүчний
салбарын хууль,
эрх зүйн орчин
шинэчлэгдэн
бүтцийн нэлээд
өөрчлөлт хийгдэж
тус салбарыг зах
зээлийн харилцаанд
шилжүүлж
өрсөлдөөнийг бий
болгох, эрчим хүчний
зохицуулалтын
бие даасан, хараат
бус механизмыг
тогтоох үндсэн
нөхцөл бүрдсэн
хэрнээ тэдгээрийн
хэрэгжилт
хангалтгүй буюу
удаашралтай
байна гэж салбарын
мэргэжилтэн,
судлаачид дүгнэлт
хийдэг.*

“Монгол Улсын эрчим хүчний засаглалын үнэлгээ” нь тус санаачлагын эхний алхам, нэг хэсэг бөгөөд эрчим хүчний салбар дахь засаглалын чанарыг үнэлэх анхны оролдлого юм.

АНУ-д төвтэй “Дэлхийн нөөцийн хүрээлэн” судалгааны байгууллага ба Энэтхэг улсын “Прайас Энержи Групп” хэмээх ашгийн бус байгууллагаас боловсруулж гаргасан “Эрчим хүчний засаглалын гарын авлага” аргачлалыг удирдамж болгон энэхүү үнэлгээг явууллаа. Ингэхдээ үнэлгээний асуулт тус бүрийг хариулахад шаардлагатай эрчим хүчний салбарын хууль тогтоомж, бодлого боловсруулах ба зохицуулах тогтолцоо, үйл явцын болон статистикийн баримт мэдээллийн хүрээг тодорхойлж тэдгээрийг янз бүрийн эх сурвалжаас цуглуулан задлан шинжлэх болон нэгтгэн дүгнэх ажлыг хийж гүйцэтгэсний дараа асуултуудад хариулж дээрх гарын авлагад заасан аргачлалын дагуу үнэлсэн болно.

Үнэлгээний тайлангийн оршил болгож Монгол Улсын эрчим хүчний салбарын товч тоймыг оруулав. Энэ нь манай эрчим хүчний засаглалын үнэлгээний дүн болон асуулгын хариултуудыг салбарын өнөөгийн бодит байдалтай харьцуулж үзэх боломжийг олгох юм.

Эрчим хүчний засаглалын үнэлгээ нь бодлогын ба зохицуулах үйл явц гэсэн хоёр үндсэн чиглэлээр хийгдэж тус бүрт хамаарах тогтолцоо, шийдвэр гаргах болон хэрэгжүүлэх үйл явц, мөн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн байдалд тусгайлан үнэлэлт дүгнэлт өгсөн юм.

Бодлогын үйл явц (БҮЯ)	Институцийн	Бодлого боловсруулах	Хэрэгжилтийн	Байгаль орчин,
Зохицуулах үйл явц (ЗҮЯ)	Институцийн	Үйл ажиллагаа	Хэрэгжилтийн	нийгмийн асуудлууд

Нийт 68 асуулга, асуулга тус бүрт багтсан 8 хүртэлх асуултын дагуу хариулж дүгнэлээ. Үнэлгээ тус бүр нь эрчим хүчний салбар дахь тухайн асуудалд хамаарах сайн засаглалын чанарын үзүүлэлт хангагдсан эсэхийг баримтжуулсан тайлбар дээр үндэслэсэн болно.

Бид Монгол Улсад хууль тогтоох эрх мэдлийг эдэлдэг Улсын Их Хурал (Монгол Улс парламентын засаглалтай, харин Ерөнхийлөгчийн зүгээс УИХ-ын шийдвэрт хориг тавих эрхтэй байдаг), эрчим хүчний асуудлыг хариуцсан яам, агентлаг, тэдгээрийн албан тушаалтнуудаас үндсэн мэдээллийг авч, эрчим хүчний салбарын холбогдолтой хуулийн төслийг боловсруулж баталсан үйл явцад дүн шинжилгээ хийх, хамгийн сүүлд шинэчлэн баталсан Эрчим хүчний тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, түүнтэй уялдуулан гаргасан УИХ-ын тогтоол, Засгийн газрын тогтоол, салбарын яамны шийдвэр, Эрчим хүчний зохицуулах газраас үнэ тариф тогтоох, эрчим хүчний салбарын зохицуулалт хийх талаар гаргасан заавар журмыг судалж танилцах, хуулийн хэлэлцүүлэгт оролцох, холбогдох хүмүүстэй уулзаж ярилцах, баримтын болон кейс судалгаа хийх зэрэг аргаар үнэлгээг хийж гүйцэтгэв.


Үнэлгээний асуултуудын хариулт ба үнэлгээний хэсэг тус бүрийн дүнг үндэслэн Монгол Улсын эрчим хүчний засаглалын өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өглөө.

Сүүлийн жилүүдэд эрчим хүчний салбарын хууль, эрх зүйн орчин шинэчлэгдэн бүтцийн нэлээд өөрчлөлт хийгдэж тус салбарыг зах зээлийн харилцаанд шилжүүлж өрсөлдөөнийг бий болгох, эрчим хүчний зохицуулалтын бие даасан, хараат бус механизмыг тогтоох үндсэн нөхцөл бүрдсэн хэрнээ тэдгээрийн хэрэгжилт хангалтгүй буюу удаашралтай гэсэн дүгнэлтийг салбарын мэргэжилтэн, судлаачдын зүгээс хийдэг. Энэ дүгнэлтийг манай үнэлгээ нотолж байна. Бид үүний зэрэгцээ Монгол Улс дахь эрчим хүчний засаглалыг сайжруулах, ялангуяа хариуцлагатай, ил тод, нээлттэй, олон нийтийн оролцоотой болгоход чиглэсэн тодорхой зөвлөмжүүдийг боловсруулж гаргалаа.

An aerial photograph of Ulaanbaatar, Mongolia, showing a dense urban landscape. The ground is covered in a layer of snow, and several multi-story buildings are visible. The sky is overcast and hazy. The text is overlaid on the upper part of the image.

УЛААНБААТАР ХОТ

2012 оны 1 дүгээр сарын 24, 12:30



Эрчим хүчний салбарын ТОВЧ ТОЙМ

УЛААНБААТАР ХОТ

2011 оны 9 дүгээр сарын 11, 14:30



ЕРӨНХИЙ ТОЙМ

Монгол Улс нь Төвийн бүсийн эрчим хүчний систем (ТБЭХС), Баруун бүсийн эрчим хүчний систем (ББЭХС), Дорнод бүсийн эрчим хүчний систем (ДБЭХС), Алтай-Улиастайн эрчим хүчний систем (АУЭХС) гэсэн цахилгааны дөрвөн тусдаа эрчим хүчний системтэй. Мөн бие даасан Даланзадгадын ДЦС, Ухаа худагийн ДЦС ажиллаж байна.

Монгол Улсын эрчим хүчний систем: Одоо ба ирээдүйн хөгжлийн бүдүүвч

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ НЭГДСЭН СИСТЕМ



Монгол Улсын эрчим хүчний хангамжид ашиглаж байгаа эрчим хүчний эх үүсвэрийн одоогийн хүчин чадал, хамрах хүрээг дор хүснэгтээр харуулав.

Хамрах хүрээ	Эх үүсвэр, чадал, МВт	Хамрах хүрээ	Бусад эрчим хүчний системийн холболт	Хамрах хүн ам	
ТЭХС	ДЦС-2 - 21.5 МВт ДЦС-3 – 136 МВт ДЦС-4 - 560 МВт Дарханы ДЦС - 48 МВт Эрдэнэтийн ДЦС - 28.8 МВт Нийт - 794.3 МВт ТБЦДС, Дархан, Эрдэнэт, Улаанбаатар, Багануурын ЦТС	Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот, Архангай, Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Орхон, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Хэнтий, Хөвсгөл аймаг /270 сум/	220 кВ-ын шугамаар ОХУ-ын Буриадын ЭХС-тэй холбосон.	1,650,000	
ДБЭХС	Дорнодын ДЦС – 36 МВт	Дорнод, Сүхбаатар аймгийн сумд	110 кВ-ын шугамаар ТЭХС-тэй холбосон боловч энэ шугам ажиллах чадваргүй	55,000	
ББЭХС	Дөргөний УЦС-12 МВт	Увс, Баян-Өлгий, Ховд аймгийн сумдууд	110 кВ-ын шугамаар ОХУ-ын Красноярскийн ЭХС-д холбосон.	11,5000	
АУЭХС	Тайширын УЦС-11 МВт	Завхан, Говь-Алтайн / 31 сум/	-		
Бие даасан	Даланзадгадын ДЦС - 6МВт	Өмнөговь	-	28,000	
Бие даасан	Ухаа худаг ДЦС	Өмнөговь	-		
Бие даасан	Сумын төв, суурингийн нар салхи, жижиг УЦС (11 УЦС, 6 нар, салхи хосолсон ЦС, 3 НЦС, 5 СЦС)	Завхан Говь-Алтай Өмнөговь, Дорноговийн зарим сумд нийт 22 сум	Үгүй	270000	
	Айл, малчин өрхийн хэрэглэж байгаа цахилгаан үүсгүүр	150,000 малчин өрх	Үгүй	500,000	
Эх үүсвэрийн төрөл ¹	Нийт	ДЦС	Импорт	Дизель	СЭХ
Чадал, МВт	1047.6	835.5	134.4	46	31.7
Эзлэх хувь %		79.8	12.8	4.4	5.4

¹ ЭБЭХЯ-ны вэб хуудас: www.mmre.energy.mn

2013-2015 онд дотоодын эх үүсвэр чадлын дутагдалд орж байгаа учраас шинэ эх үүсвэрүүдийг яаралтай барих шаардлагатай нь тодорхой болжээ.

Өнөөдөр ДЦС-уудын үйлдвэрлэж байгаа болон Оросын Холбооны Улсаас импортолдог хүчин чадал нь нийлээд төвийн бүсийн цахилгааны хэрэгцээг бүрэн хангаж байна. Нийт 794.3 МВт суурилагдсан, 627 МВт-ын боломжит хүчин чадалтай, ОХУ-тай холбогдсон өндөр хүчдлийн шугамаар 240 МВт хүртэл чадал авах боломжтой. Гэхдээ станцуудын тоноглол хуучирсан, хамгийн шинэ станц болох Улаанбаатарын ДЦС-4 нь 1981 онд ашиглалтанд оржээ.

Эрчим хүчний эрэлт жилд 5-7%-иар өсч байна.

Одоо эрчим хүчний системийн бодит оргил ачааллын зөрүүг ОХУ-аас импортлодог цахилгаанаар нөхөж байна. Энэ зөрүү 2007 онд 98 МВт байсан бол 2010 онд 70 МВт байв. Ирэх жилүүдэд цахилгаанаар дөнгөн данган хангах боломжтой хэдий ч ялангуяа Улаанбаатар хотыг дулаанаар хангахад хүндрэлтэй болж эхэлнэ. Иймд шинээр ДЦС эсвэл оргил ачааллыг хаах дулааны станц барьж, нөөц чадлыг зохих түвшинд байлгахын тулд ОХУ-аас авах импортын чадлын хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай болж байна.

Өнөөгийн байдлаар ТБЭХС-д Улаанбаатарын ДЦС-4, ДЦС-3, ДЦС-2, Дарханы ДЦС, Эрдэнэтийн ДЦС гэсэн таван дулаан, цахилгаан хослон үйлдвэрлэдэг цахилгаан станцууд байна. Харин ДБЭХС-д Чойбалсангийн ДЦС, Өмнөговь аймагт Даланзадгадын ДЦС, Ухаа худагийн ДЦС ажиллаж байна.

2013-2015 онуудад дотоодын эх үүсвэр чадлын дутагдалд орж байгаа учраас шинэ эх үүсвэрүүдийг яаралтай барих шаардлагатай нь тодорхой болжээ.

Шинээр барихаар төлөвлөсөн эх үүсвэрүүд болох Могойн голын 60МВт-ын ДЦС-ыг 2011-2013 онд, Даланзадгадын 3МВт-ын өргөтгөлийг 2011 онд, Дорнодын шинэ эх үүсвэрийн 100 МВт-ын өргөтгөлийг 2012-2013 онд, Улаанбаатарын ДЦС-5 болон Тавантолгойн ДЦС-ыг 2012-2015 онд, Цайдамын ДЦС 600МВт-ыг 2012-2014 онд, Чандагана талын ДЦС-ыг 2012-2015 онд, Эрдэнэцогтын ДЦС-ыг 2012-2013 онуудад барьж ашиглалтанд оруулна гэсэн төлөвлөгөөтэй байна. Мөн шинээр баригдах болон урьд байсан эх үүсвэрүүдээс хэрэглэгчид хүртэл цахилгаан дамжуулах шугам сүлжээнүүдийг байгуулах юм².

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

ТБЭХС, ББЭХС, ЗБЭХС-ийн дүнгээр 2010 онд ДЦС-аар 3,989.7 сая кВт.ц, УЦС-аар 11,05 сая кВт.ц цахилгаан үйлдвэрлэж, импортоор 180.8 сая кВт.ц цахилгаан худалдан авч, экспортод 21.2 сая кВт.ц цахилгаан гарган, 2,746.9 сая кВт.ц цахилгаан, 6,399.7 мян.Гкал дулааныг хэрэглэгчдэд түгээжээ.

Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд 2010 онд нийт 285.5 тэрбум төгрөгний үйл ажиллагааны орлого олж, 325.6 тэрбум

² Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2008-2012 он

Сүүлийн жилүүдэд эрчим хүчний салбарт хувийн хөрөнгө оруулалт болон хувийн хэвшлийн менежментийг дэмжиж байна.

төгрөгний зардал гарган үндсэн үйл ажиллагаанаас 46.1 тэрбум төгрөгний алдагдалтай ажилласан ба татварын дараах балансын алдагдал 23,2 тэрбум төгрөгт хүрсэн. Эрчим хүчний салбар зохицуулалтанд орсноор эрчим хүчний үнэ тарифт өнгөрсөн хугацаанд 6 удаа зохицуулалт (2002, 2005, 2007, 2008, 2009, 2011 онд) хийсний үр дүнд борлуулалтын орлого 2001 онд 96.0 тэрбум төгрөг байсан бол 2010 онд 280.0 тэрбум төгрөг буюу орлого 2.9 дахин нэмэгджээ.

Төвийн бүсийн хэрэглэгчдэд борлуулах цахилгааны үнэ 2001 оны эцэст байснаас 1.5 дахин, орон сууцны халаалтын тариф 1.65 дахин, ахуйн хэрэгцээний халуун усны тариф 2.5-3.75 дахин нэмэгдэж, эрчим хүчний томоохон 18 компанийн үйл ажиллагааны борлуулалтын орлого 2001 онтой харьцуулахад 142.0 тэрбум төгрөгөөр буюу 2.5 дахин нэмэгдсэн байна.

Эрчим хүчний салбарт олон нааштай эерэг үр дүн гарч байгаагийн зэрэгцээгээр бүтцийн өөрчлөлт хийгдэхээс өмнө болон түүнээс хойш ч шийдвэрлэж чадахгүй байгаа нэг тулгамдсан асуудал бол салбарын өр, авлагын сүлжээ юм. Эрчим хүчний үйлдвэр, уурхай, бэлтгэн нийлүүлэгч, хэрэглэгчийн хоорондын өр, авлагын хэмжээ дорвитой буурахгүй байгаагаас компаниуд хөрөнгийн эх үүсвэрийн хомсдолд орж санхүүгийн хувьд хүндрэлтэй байдалд үйл ажиллагаа явуулж байна.

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ШИНЭЧЛЭЛ

2001 онд Эрчим хүчний тухай шинэ хууль батлагдсаны дараа Монгол Улсын Засгийн газраас 164 дугаар тогтоол гаргаж тус салбарт бүтцийн өөрчлөлтийг хийж социализмын үед бий болсон эрчим хүчний салбарын төвлөрсөн бүтцийг задлан Төвийн эрчим хүчний системийн харьяанд байсан үйлдвэрлэгч, дамжуулах болон түгээх сүлжээний төрийн өмчит хувьцаат кампани (ТӨХК), Диспетчерийн үндэсний төв (ДҮТ) зэрэг 18 компанийг бие даалган зохион байгуулсан юм.

Сүүлийн жилүүдэд эрчим хүчний салбарт хувийн хөрөнгө оруулалт болон хувийн хэвшлийн менежментийг дэмжиж байна. Хот, хөдөөгийн дулаан хангамжийн жижиг компаниудын ихэнх нь хувьчлагджээ. Мөн хувийн хөрөнгө оруулагчдаас тавьж байгаа саналуудыг дэмжиж томоохон чадлын салхин цахилгаан станц, ДЦС байгуулах хэд хэдэн тусгай зөвшөөрлийг олгожээ.

2011 оны байдлаар хувийн хэвшлийн менежментээр “Улиастай эрчим хүч” ХХК ажиллаж, “Дархан, Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХХК нь 100 % хувийн өмчит кампани болжээ. “Баянхонгорын цахилгаан түгээх сүлжээ” ХХК, “Хөвсгөлийн цахилгаан түгээх сүлжээ” ХХК-иуд нь орон нутгийн өмчит кампани юм.

2011 оны Эрчим хүчний салбарын статистик үзүүлэлтээс үзвэл нийт 73 компанид эрчим хүчний ажил үйлчилгээ эрхлэх 10 төрлийн нийт 173 тусгай зөвшөөрлийг олгожээ.

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, СТРАТЕГИ

Монгол Улсын эрчим хүчний салбар нь “Үндэсний хөгжлийн цогц бодлого”, “Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр”, “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр” гэсэн УИХ-аас баталсан үндсэн баримт бичгийг баримтлан хөгжиж байна.

Монгол Улсын түлш-эрчим хүчний хөгжлийн стратеги нь тухайн нөхцөл байдалд буй болсон гадаад ба дотоод хүчин зүйлд зохицсон хийгээд эдийн засаг, эрчим хүчний хөгжлийн хоорондын зохицолдоог хангасан байх дараах зарчмыг баримталж байна. Заримыг дурдвал,

- Уул уурхай, барилгын салбарын эрчим хүчний өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангах ДЦС-ыг ойрын жилүүдэд нүүрсний уурхайнуудыг түшиглүүлэн байгуулах.
- Нүүрсний арвин нөөцөндөө тулгуурлан ДЦС байгуулж хөрш зэргэлдээ улс орнууд руу их хэмжээний цахилгаан үйлдвэрлэж, экспортлох.
- Төвийн бүсийн эрчим хүчний системийн ачаалал тохируулах болон аваарийн эх үүсгүүрийн асуудлыг шийдвэрлэхүйц УЦС байгуулах.
- Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудад ойрын жилүүдэд бий болох дулааны чадлын дутагдлыг, жилд цөөн (3-4) сар ажилладаг оргил ачааллыг хаах зориулалттай ус халаах зуух бүхий дулааны станц байгуулах замаар шийдвэрлэх, эсвэл ДЦС байгуулах.
- Сумын төв, суурингийн дулаан хангамжийг оновчтой шийдвэрлэх цогц судалгаа явуулж, нүүрсний хийн дулааны станц, сайжруулсан нүүрс, шингэрүүлсэн шатдаг хийгээр ажилладаг дулааны эх үүсвэрүүдийг бий болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх.
- Эрчим хүчний үнэ тарифыг аажмаар үе шаттайгаар нэмэгдүүлэн гаргасан зардлаа нөхдөг байх тийм хэмжээнд ойрын үед хүргэх зэрэг болно³.

Салбарын бодлогын үндсэн баримт бичиг болох 2040 он хүртэл эрчим хүчний хөгжлийг тодорхойлсон “Монгол Улсын Эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр”-ийн хүрээнд дараах зорилтыг шийдвэрлэх зорилт дэвшүүлжээ.

- Хараат бус бие даасан эрчим хүчний найдвартай хангамжийн системийг байгуулж, үр ашиг өндөр, алдагдал багатай үйлдвэрлэлийн бүтцийг бий болгох;
- Цахилгаан станцуудыг оновчтой, зөв байршуулан эрчим хүч экспортлох;
- Эрчим хүчний хэмнэлтийн бодлогыг тодорхойлох, үр ашигтай шинэ техник, технологи нэвтрүүлэх, сэргээгдэх эрчим хүчний нөөцийг ашиглах замаар эрчим хүчний эх үүсвэрийн бүтцийн шинэчлэлт хийж төв, орон нутгийн хангамжийг найдвартай болгох;

³ Дорнод бүсийн эрчим хүчний системийн шинэчлэл, өргөтгөлийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа / ҮХШХ, МЭХА 2011, -365 х.

УИХ-аас гаргаж байгаа зарим шийдвэр оновчтой биш. Тухайлбал, УИХ-ын гишүүд сонгогдсон тойргийнхоо эрх ашигт хэт үйлчилсэн явцуу шийдвэрүүдийг гаргаж, эрчим хүчний салбарын хөгжлийн бодлогыг сулруулж үр ашиг багатай шугам сүлжээг өргөтгөх, оновчтой бус эх үүсвэрүүдийг бий болгох нөхцөлийг бүрдүүлж байна гэсэн шүүмжлэл тасрахгүй байна.

- Шинэ эх үүсвэр, усан цахилгаан станц шинээр барьж өндөр хүчдлийн шугамаар холбох замаар бүс нутгийн эрчим хүчний хангамжийг найдваржуулах, цаашид эдийн засгийн үр ашигтай горим, ажиллагааг хангасан Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем байгуулах;
- Зах зээлийн нөхцөлд тохирсон хууль, эрх зүйн орчин, менежментийг боловсронгуй болгох, түлш, эрчим хүчний салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг болно;

1999 онд Сэргээгдэх эрчим хүч ашиглан хөдөөг цахилгаанаар хангах “100000 нарны гэр” үндэсний хөтөлбөр, 2005 онд “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр”-ийг тус тус батлан хэрэгжүүлж, 2007 онд Сэргээгдэх эрчим хүчний тухай хуультай болсон билээ. Ингэснээр сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэхэд шаардлагатай хууль эрх зүйн орчин бүрдсэн болно.

Гэхдээ дээр дурдсан баримт бичгийн хэрэгжилт төдийлөн сайнгүй байна. УИХ-аас гаргаж байгаа зарим шийдвэр оновчтой биш, тухайлбал, УИХ-ын гишүүд өөрсдийн сонгогдсон тойргийн эрх ашигт хэт үйлчилсэн явцуу шийдвэрүүдийг гаргаж, эрчим хүчний салбарын хөгжлийн бодлогыг сулруулж үр ашиг багатай шугам сүлжээг өргөтгөх, оновчтой бус эх үүсвэрүүдийг бий болгох нөхцөлийг бүрдүүлж байна гэж шүүмжлэл тасрахгүй байна.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАЛТ

2001 онд Эрчим хүчний зохицуулах газрыг (2012 оноос ЭХЗХ) байгуулснаас хойш эрчим хүчний зохицуулалтыг 10 гаруй жил хэрэгжүүлж байна⁴. Өнгөрсөн хугацаанд гарсан өөрчлөлтийг тус байгууллага өөрөө дараах байдлаар дүгнэжээ. Заримыг дурдвал,

- Тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын тарифын орлогыг нэмэгдүүлсэн;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд гүйцэтгэлийг гэрээний үр дүнгээр урамшуулал авдаг болсон;
- Гүйцэтгэлийн аудит хийдэг болсон;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, рейтинг тогтоодог болсон;
- Хэрэглэгчдийн цахилгаан хангамжийн тасалдлыг олон улсын хэмжээнд мөрддөг индексүүдийг ашиглан тогтоодог болсон;
- Сэргээгдэх эрчим хүчний хуулийн дагуу СЦС-аас үйлдвэрлэх цахилгааныг худалдан авах анхны гэрээг байгуулсан;
- Үнэ, тарифыг зохицуулалтын ил тод байдлыг хангасан, зохицуулалтын үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлсэн;
- Эрчим хүчний статистик үзүүлэлтийг жил бүр гаргадаг болсон;
- ЭХЗГ-ын үйл ажиллагаанд олон улсын байгууллагын үнэлгээ хийлгэдэг болсон;

⁴ Эрчим хүчний зохицуулалт -10 жилд // ЭХЗГ-ын 10 жилийн ойд зориулсан эмхтгэл, 2011. УБ: - 251 х.

*2010 онд гарсан
УИХ-ын 72-р
тогтоолоор
ойрын жилүүдэд
үнэ тарифыг
индексжүүлж
үе шаттайгаар
нэмэх замаар 2014
оноос зах зээлийн
зарчимд шилжүүлэн
ажиллуулах бодлого,
зохион байгуулалтын
арга хэмжээ авахыг
Засгийн газарт
даалган хэрэгжүүлж
эхлээд байна.*

Эрчим хүчний салбарт нэн түрүүнд шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудал бол эрчим хүчний үйлдвэр, шугам сүлжээ нь эдийн засаг санхүүгийн хувьд бие даан ажиллахад хангалттай тийм үнэ тарифыг бий болгох ёстой атал тусгай зөвшөөрөл эзэмшигч компани, аж ахуйн нэгжүүдийн хэрэглэгчдэд худалдах цахилгаан, дулааны үнэ тарифыг үйл ажиллагааны бодит өртөг зардалд үндэслэн тогтоож өгөхгүй, үнэ тарифыг улс төрийн зорилгоор хатуу тогтоон барьж байгаа явдал юм. Харин 2010 онд гарсан УИХ-ын 72-р тогтоолоор ойрын жилүүдэд үнэ тарифыг индексжүүлж үе шаттайгаар нэмэх замаар 2014 оноос зах зээлийн зарчимд шилжүүлэн ажиллуулах бодлого, зохион байгуулалтын арга хэмжээг авахыг Засгийн газарт даалгаад хэрэгжүүлж эхлээд байна.

ХУВЬЧЛАЛЫН ТУРШЛАГА, ОДОО БАРИМТАЛЖ БАЙГАА БОДЛОГО

2001 онд эрчим хүчний салбарыг зах зээлийн зарчимд шилжүүлэхийн тулд бүтцийн өөрчлөлт хийж төрийн өмчит үйлдвэрүүдийг төрийн өмчит хувьцаат компани (ТӨХК) болгон өөрчлөн зохион байгуулсан боловч тэдгээрийг хувьчлаагүй өдий хүрсэн юм. Гэхдээ 2001-2011 онуудад 83 аж ахуйн нэгжид 10 төрлийн нийт 173 тусгай зөвшөөрлийг олгосны ихэнх нь хувийн компаниудад ногдож байна.

2011 оны хувьд эрчим хүчний шинэ эх үүсвэр барих буюу “Ийст энерги девелопмент” ХХК-д 600 МВт-ын, “Юнайтэд Пауэр” ХХК-д 18 МВт-ын дулааны цахилгаан станц, “Сайншанд салхин парк” ХХК-д 52 МВт-ын, “Клин Энержи” ХХК-д 50 МВт-ын, “АБ солар винд” ХХК-д 100 МВт-ын, “Айденер Глобал” ХХК-д 50.4 МВт-ын салхин цахилгаан станц, “Оюутолгой” ХХК-д 44 МВт-ын дизель станц болон 72 МВт-ын дулааны станц, Иргэний нисэхийн ерөнхий газарт 443 кВт-ын нарны цахилгаан станц барих тусгай зөвшөөрлүүдийг тус тус олгосон нь ИНЕГ-аас бусад нь хувийн хэвшлийн компаниуд байна.

2010 онд Концессын тухай хууль батлагдсанаар төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хувьчлалгүйгээр түүнд хувийн хөрөнгө оруулалтыг оруулах эрх зүйн үндсийг бүрдүүлээ. Өнөөдөр эрчим хүчний үйлдвэрийн концессын гэрээний үндсэн дээр хувийн хэвшлийн менежмент давамгайлсан “Улиастай эрчим хүч” ХХК-ийн ажиллаж байна.

Концессын тухай хуулийн дагуу Монгол Улсын Засгийн Газрын тогтоол 198 дугаар тогтоолоор баталсан концессын зүйлийн жагсаалтад хувийн хөрөнгө оруулалт оруулах болон цаашид хувьчлахад чиглэсэн хөрөнгө оруулалттай эрчим хүчний эх үүсвэрүүдийг багтаасан юм.


2010 онд Концессын тухай хууль батлагдсанаар төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хувьчлалгүйгээр түүнд хувийн хөрөнгө оруулалт хийх эрх зүйн үндсийг бүрдүүлээ.

Концессын зүйлийн нэр	Концессын төрөл	Гүйцэтгэх ажил үйлчилгээ	Сонгон шалгаруулах арга
Таван толгойн цахилгаан станц	Барих-өмчлөх ашиглах	Эрчим хүчний барилга байгууламж барих, цахилгаан дулаан үйлдвэрлэх эзэмших	Уралдаант шалгаруулалт
Дулааны V цахилгаан станц	Барих-өмчлөх ашиглах	Эрчим хүчний барилга байгууламж барих, цахилгаан дулаан үйлдвэрлэх, эзэмших	Уралдаант шалгаруулалт
Дорнодын дулааны цахилгаан станц	Барих-өмчлөх ашиглах	Эрчим хүчний барилга байгууламж барих, цахилгаан дулаан үйлдвэрлэх, ашиглах, шилжүүлэх	Уралдаант шалгаруулалт
Дулааны III цахилгаан станц ХК төсөл	Шинэчлэн сайжруулах-ашиглах, эзэмших	Цахилгаан дулаан үйлдвэрлэх, ашиглах, эзэмших	Уралдаант шалгаруулалт
Эрдэнэтийн дулааны цахилгаан станц	Шинэчлэн сайжруулах-ашиглах, эзэмших	Цахилгаан дулаан үйлдвэрлэх, ашиглах, эзэмших	Уралдаант шалгаруулалт

Одоо энэ чиглэлээр тооцоо, судалгаа хийгдэж байгаа болно.



Гуравдугаар цахилгаан станц орчимд, 2011 он. Гэрэл зургийг Ц.Батбаатар



Эрчим хүчний засаглалын
**ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ,
ЗӨВЛӨМЖ**



ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧОО

Монгол Улсын эрчим хүчний засаглалын өнөөгийн байдлыг олон улсын аргачлалын дагуу бодлогын үйл явцад хамаарах 36, зохицуулах үйл явцын 32, нийт 68 асуулга, асуулга тус бүрийн доторх 3-8 асуулт буюу чанарын элементүүдийн дагуу задлан шинжилж тэдгээрийг хэрхэн хангаснаар 1 (доод), 2 (доодоос дунд), 3 (дунд), 4 (дундаас дээд), 5 (дээд) гэсэн үнэлгээ өгөхөд дараах дүн гарсан болно.

Бодлогын үйл явцын үнэлгээний дүн

Үзүүлэлтүүд		Үнэлээгүй. 1 (доод) 2 (доодоос дунд) 3 (дунд) 4 (дундаас дээд) 5 (дээд)
Институцууд		
БҮЯ1	Бодлого боловсруулах хорооны эрхзүйн чадамж	4
БҮЯ2	Хууль тогтоомжийн хорооны байгаль орчны асуудлуудыг үнэлэх чадавхи	1
БҮЯ3	Хууль тогтоомжийн хорооны нийгмийн асуудлуудыг үнэлэх чадавхи	3
БҮЯ4	Хууль тогтоох хорооны зүгээс цахилгааны чиглэлээр үр дүнтэй үйл ажиллагаа явуулах	3
БҮЯ5	Эрчим хүчний яам/газрын боловсон хүчний бодлого	5
БҮЯ6	Гүйцэтгэх байгууллагын байгаль орчны чиглэлээр хүлээх үүргийн тодорхой, ил тод байдал	3
БҮЯ7	Гүйцэтгэх байгууллагын нийгмийн чиглэлээр хүлээх үүргийн тодорхой, ил тод байдал	3
БҮЯ8	Гүйцэтгэх түвшний байгууллагын байгаль орчны асуудлыг үнэлэх чадавхи	1
БҮЯ9	Гүйцэтгэх түвшний байгууллагын нийгмийн асуудлыг үнэлэх чадавхи	5

БҮЯ10	Эрчим хүчний яам/газрын жилийн тайлан	4
БҮЯ11	Эрчим хүчний яам/газрын зөвлөх хороо	4
БҮЯ12	Тусгай төлөвлөлт, бодлогын агентлагын үйл ажиллагааны үр дүн	3
БҮЯ13	Иргэний нийгмийн байгууллагуудын чадавхи	3
	Дундаж үнэлгээ	3.2

Бодлого боловсруулах

БҮЯ14	Эрчим хүчний хуулийн асуудлаар хууль тогтоох хэлэлцүүлгийн чанар	5
БҮЯ15	Эрчим хүчний бодлого, шинэтгэлийг хэвлэл мэдээллээр мэдээлэх үйл явцын чанар	Үнэлээгүй
БҮЯ16	Бодлого боловсруулах олон нийт оролцох үйл явцын ил тод байдал	2
БҮЯ17	Бодлогын шинэчлэлийн үндэслэл болон зорилгын талаарх мэдээллийг олон нийтэд ил болгох	3
БҮЯ18	Олон нийтийн оролцооны үйл явцын үр дүнтэй байдал	2
БҮЯ19	Салбарын шинэтгэлийн хууль, бодлогод байгаль орчны асуудлыг харгалзан үзсэн нь	4
БҮЯ20	Эрчим хүчний салбарын бодлогын өөрчлөлт, салбарын шинэтгэлээс хамаарах ажлын байр буурах явдлын үнэлгээ	1
БҮЯ21	Бие даасан эрчим хүчний талаарх бодлогыг ил тод байдлаар тодорхойлох	2
БҮЯ22	Зөвлөх ажиллуулахтай холбоотой асуудал олон нийтэд нээлттэй байсан эсэх	3
БҮЯ23	Улс төрийн бодлогын өр зээлээр дамжуулан хандивлагчидын оролцоог ил тод болгох	5
	Дундаж үнэлгээ	3,0

Бодлого хэрэгжүүлэх

БҮЯ24	Техникийн тусалцааны хүрээнд хандивлагч байгууллагын оролцооны ил тод байдал	3
БҮЯ25	Бие даасан эрчим хүч үйлдвэрлэгчийн бодлого/хууль тогтоомжийн хэрэгжилтийн ил тод, хариуцлагатай байдал	3
БҮЯ26	Хувийн хэвшлийн үйлчилгээ үзүүлэгчдийг ил тод сонгон авсан эсэх	5
БҮЯ27	Хөрөнгийн үнэлгээ/санхүүгийн тайлангийн бүтцийн өөрчлөлтийн ил тод байдал	4
БҮЯ28	Төсвийн татаасыг төлөвлөж, хэрэгжүүлэхдээ ил тод ба хариуцлагатай байх	3
БҮЯ29	Эрчим хүчний салбарын төслүүдэд байгаль орчны талаас нь зөвшөөрөл өгөх эрх мэдэл ба эрх зүйн тодорхой байдал	5
	Дундаж үнэлгээ	3,8

Байгаль орчин, нийгмийн асуудлууд		
БҮЯ30	Байгаль орчны минимум стандартыг тогтооход олон нийтийн оролцоо	2
БҮЯ31	Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах бодлогыг боловсруулахад олон нийтийн оролцоо	3
БҮЯ32	Байгаль орчны асуудлыг эрчим хүчний салбарын үндэсний хэмжээний төлөвлөгөөнд багтаасан нь	2
БҮЯ33	Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээний хууль бодлого, үйл явцын цогц байдал	1
БҮЯ34	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнүүд дэх олон нийтийн оролцоо	4
БҮЯ35	Тодорхой төслийн нөлөөнд автаж буй хүмүүс төслийг батлах/ тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой эрхээ эдэлж буй цар хүрээ	3
БҮЯ36	Эрчим хүчний үйлчилгээний хүртээмжтэй холбоотой шийдвэр гаргалтад оролцох байдал	5
	Дундаж үнэлгээ	2,7
	Бодлогын үйл явцын дундаж үнэлгээ	3.2

Зохицуулах үйл явцын үнэлгээний дүн

Зохицуулах бүтэц		
ЗҮЯ1	Захиргааны шийдвэр гарах байгууллагын бүтэц	5
ЗҮЯ2	Захиргаа, зохицуулалт бүхий хуулийн этгээдийн эрх мэдэл	5
ЗҮЯ3	Зохицуулах байгууллагын эрх мэдэл	4
ЗҮЯ4	Зохицуулах байгууллагын байгаль орчны үүргийн цар хүрээ болон ил тод байдал	2
ЗҮЯ5	Зохицуулах байгууллагын нийгмийн хамааралтай үүргийн цар хүрээ болон ил тод байдал	4
ЗҮЯ6	Зохицуулагч нарын сонгон шалгаруулалт	2
ЗҮЯ7	Зохицуулагч нар албан ёсны ашиг сонирхлын зөрчилдөөнөөс сэргийлэх нь	4
ЗҮЯ8	Зохицуулагчдын хараат бус байдал	5
ЗҮЯ9	Давж заалдах механизм	4
ЗҮЯ10	Шүүх болон захиргааны байгууллага байгаль орчны болон нийгмийн нэхэмжлэлийг авч хэлэлцэх байдал	Үнэлээгүй
ЗҮЯ11	Зохицуулах байгууллагын гишүүд ажиллагсадын сургалтын байдал	4
ЗҮЯ12	Зохицуулагчийн байгаль орчны асуудлуудыг үнэлэх чадавхи	Үнэлээгүй
ЗҮЯ13	Зохицуулагчийн нийгмийн асуудлуудыг үнэлэх чадавхи	5
ЗҮЯ14	Зөвлөх ашиглахтай холбоотой мэдээллийн олон нийтэд хүртээмжтэй байдал	3
	Дундаж үнэлгээ	3,9

Шийдвэр гаргах үйл явц		
ЗҮЯ15	Зохицуулах үйл явц болон гаргасан шийдвэрийн бие даасан үндэслэлийн тодорхой байдал	Үнэлээгүй
ЗҮЯ16	Байгаль орчин, нийгмийн холбоотой нэхэмжлэлд зохицуулах байгууллагын өгөх хариу	Үнэлээгүй
ЗҮЯ17	Зохицуулагчийн зүгээс гаргаж буй урьдчилсан идэвх чармайлт	3
ЗҮЯ18	Зохицуулах байгууллагын эзэмшиж буй баримт бичгүүдийг нээлттэй болгох	4
ЗҮЯ19	Захиргааны хуулийн этгээдийн баримт бичиг олон нийтэд хүртээмжтэй байх журам	4
ЗҮЯ20	Зохицуулах үйл ажиллагаан дахь олон нийтийн оролцооны орон зай	4
ЗҮЯ21	Зохицуулах баримт бичгүүд болон сонсголүүдын олон нийтийн хүртээмж	Үнэлээгүй
ЗҮЯ22	Эмзэг бүлгийн сонирхлыг төлөөлөх институцийн механизм	2
ЗҮЯ23	Эмзэг бүлгийнхэн зохицуулах үйл явцад оролцох чадавхийг бий болгох нь	1
ЗҮЯ24	Зохицуулах үйл ажиллагаан дахь иргэний нийгмийн оролцоо	1
ЗҮЯ25	Эрчим хүчээр хангагчид иргэний нийгмийн байгууллагууд болон хохиролд өртсөн хүн амтай хамтран ажиллаж байгаа нь	2
ЗҮЯ26	Зохицуулах байгууллагын тушаал, шийдвэр	1
ЗҮЯ27	Шийдвэрүүдийг нийтэд түгээх	3
	Дундаж үнэлгээ	2,5
Үйл ажиллагааны асуудлууд		
ЗҮЯ28	Тарифын зарчим, философи	3
ЗҮЯ29	Эрчим хүчний үнийг боломжийн байлгахтай холбоотой шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох нь	2
ЗҮЯ30	Тусгай зөвшөөрөл олгох	3
ЗҮЯ31	Тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлдвэрүүдийн гүйцэтгэлийн тайлан	3
ЗҮЯ32	Хэрэглэгчдэд хандсан үйлчилгээ ба ханган нийлүүлэлтийн чанар	4
	Дундаж үнэлгээ	3,0
	Зохицуулах үйл явцын дундаж үнэлгээ	3,1

Үнэлгээний нэгдсэн дүн

БҮЯ	Бодлогын үйл явц	3,2
ЗҮЯ	Зохицуулах үйл явц	3,1
	Нэгдсэн дундаж үнэлгээ	3,15

Эрчим хүчний салбарын бодлогын ба зохицуулах үйл явцын үнэлгээний дүнг нэгтгэж үзэхэд, Монгол Улсын эрчим хүчний засаглал өнөөдрийн байдлаар 3,15 оноо авч дундаас арай дээгүүр түвшинд байгаагаар үнэлэгдлээ.

Үүнээс зохицуулах үйл явцын үнэлгээ бодлогын үйл явцынхаас бага зэрэг доогуур гарчээ. Манайд эрчим хүчний зохицуулалтын тогтолцоо олон улсын жишгээр зохион байгуулагдсан хэрнээ тодорхой шийдвэр боловсруулан гаргаж ялангуяа хэрэгжүүлэхэд гарч байгаа дутагдал, бэрхшээл үүнд нөлөөлсөн нь тухайн асуулгуудын дүнгээс харагдлаа.

Ерөнхийдөө манайд эрчим хүчний харьцангуй сайн засаглал бүрэлдэж эхэлсэн байна. Гэхдээ бодлого, зохицуулалтын аль алиныг хэрэгжүүлэх шатанд зарчмын өөрчлөлт гаргах шаардлагатай байгааг үнэлгээнүүд илэрхийлж байна.

Бодлогын ба зохицуулах үйл явцын үндсэн элемент тус бүрээр гаргасан судалгааны багийн дүгнэлт, зөвлөмж, мөн үнэлгээг хийж гүйцэтгэхийн тулд хариулсан 68 асуулгын материалыг дор үзнэ үү.

БОДЛОГЫН ҮЙЛ ЯВЦ: ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН БОДЛОГЫН ҮЙЛ ЯВЦЫН ТОДОРХОЙЛОЛТ

Эрчим хүчний засаглалын бодлогын үйл явц гэдэг нь тус салбарын бодлогыг тодорхойлсон Монгол Улсын хууль, УИХ, Засгийн газрын тогтоол, эрх зүйн бусад баримт бичиг, салбарын хөгжлийн стратеги, хөтөлбөр зэрэг баримт бичгийн үзэл баримтлал, төслийг боловсруулж Улсын Их хурлаар хэлэлцүүлэн батлах, тэдгээрийг Засгийн газар, Эрдэс баялаг, эрчим хүчний яам болон Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Эрчим хүчний газрын тогтоол, тушаал, дүрэм журамд тусган салбарын хэмжээнд хэрэгжүүлэхэд чиглэсэн удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг хэлнэ.

Бид шаардагдах баримт мэдээлэл цуглуулж судалсны үндсэн дээр тус салбарын бодлогыг боловсруулж гаргадаг, хэрэгжүүлдэг институцуудын үйл ажиллагаа, бодлогын үйл явцын үе шатуудад чадавхи, боломж, ил тод, нээлттэй байдал, олон нийтийн оролцоо, байгаль орчин, нийгмийн шаардлагыг хэрхэн хангаж байгаа тухайд дараах дүгнэлтийг хийж байна.

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1995 онд Монгол Улс анх удаа Эрчим хүчний тухай хуультай болж 2001 онд дахин шинэ хууль баталж түүнээс хойш нийт таван удаа нэмэлт өөрчлөлт оруулсан буюу шинэчлэн баталснаас гадна салбарын хууль, эрх зүйн бусад баримт бичиг, хөтөлбөрүүд батлагдан гарчээ. Энэ бүхний үр дүнд эрчим хүчний салбарыг зах зээлийн харилцаанд аажмаар шилжүүлэх, эдийн засгийн болон хүн амын тасралтгүй өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний хэрэгцээг найдвартай хангах, шударга өрсөлдөөн бий болгоход чиглэсэн эрх зүйн орчин бүрдэж, мөн эрчим хүчний зохицуулалтын хараат бус механизмтай болсон юм.

Ялангуяа сүүлийн хоёр жилд эрчим хүчний салбарт бодлогын шинжтэй томоохон өөрчлөлт хийгдэж байна. Үүнийг юуны өмнө хууль тогтоомжийн шинэчлэлээс харж болох юм. Тухайлбал, 2010 оны 12-р сард “Түлш, эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 72-р тогтоол гарч, уг тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас 2011 оны 4-р сарын 27-ны өдөр 139 тоот

тогтоол, ажлын төлөвлөгөөг баталжээ. Харин 2011 оны 12-р сард Эрчим хүчний хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсан юм.

Өнөөдөр тус салбарт хууль, эрх зүйн дараах үндсэн баримт бичгүүд үйлчилж байна. Үүнд:

МОНГОЛ УЛСЫН ХУУЛИУД		
Хуулийн нэр	Баталсан огноо	Нэмэлт өөрчлөлт орсон огноо
Монгол Улсын Эрчим хүчний тухай хууль	1995.12.01	1996.08.30 1998.01.15
Монгол Улсын Эрчим хүчний тухай хууль	2001.02.01	1996.11.30 2002.07.04 2007.11.11 2008.12.19 2009.07.16 2011.12.09
Монгол Улсын Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль Компанийн, Иргэний, Концессийн зэрэг хуулиуд	2007.01.11	2008.12.19
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛООР БАТАЛСАН БАРИМТ БИЧГҮҮД		
Эрх зүйн баримт бичгийн нэр	Баталсан огноо	Дугаар
Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр	2007.01.30	10
Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр	2005.06.09	32
Түлш эрчим хүчний талаар авах зарим арга хэмжээний тухай	2010.12.09	72
Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр - 2008-2012 он /тайлбар: 4 жил тутамд парламентийн сонгууль болдог бөгөөд түүний үр дүнгээр байгуулсан засгийн газар 4 жилийн хөтөлбөртэйгээр ажилладаг /		
Монгол Улсын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл	/жил бүр/	
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛООР БАТЛАГДСАН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮД		
Эрх зүйн баримт бичгийн нэр	Баталсан огноо	Дугаар
Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм	2001.12.05	263
Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм	2001.12.05	263
Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм	2001.12.05	263
Эрчим хүчний тогтвортой хөгжлийн стратеги төлөвлөгөө	2002.07.04	140

Монгол орон зах зээлийн харилцаанд орсон 1990-ээд онд тус салбар хямралд ороход олон улсын байгууллага, хандивлагчид, тэдгээрийн дотроос АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID) нь Монгол Улсын эрчим хүчний салбарын хөгжлийн стратегийг боловсруулахад дэмжлэг туслалцаа үзүүлж Монгол Улсын Эрчим хүчний тухай хууль боловсруулахтай холбоотой судалгаа, санхүүгийн тогтворжилтын талаар, эрчим хүчний салбарын бүтцийн өөрчлөлтийн талаар, эрчим хүчний хангамж үнэ тарифын талаар, эрчим хүчний хэмнэлт үр ашгийн талаар, чадавхийг хөгжүүлэх талаар зэрэг хэд хэдэн судалгааг хийсэн ба Монгол Улсын эрчим хүчний салбарыг хөгжүүлэх стратегийг тус агентлагийн тусламжтайгаар боловсруулж 2002 онд баталсан юм.

*Эрчим хүчний салбарын
хууль, эрх зүйн баримт
бичиг, стратеги,
хөтөлбөрүүдийн хэрэгжилт
төдийлөн сайнгүй байна.*

Үндэсний хөгжлийн цогц бодлого болон Засгийн газрын мөрийн хөтөлбөрүүдэд салбарын хөгжлийн ойрын болон урт хугацааны стратегийг тодорхой зааж тусгасан байдаг. Мөн Монгол Улсын Их хурал, Засгийн Газраас эрчим хүчний салбарын хөгжлийн хэтийн төлвийг тодорхойлсон “Монгол Улсын Эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр”, “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр”, “100,000 нарны гэр үндэсний хөтөлбөр” зэргийг батлан гаргаж хэрэгжүүлсэн.

2007 онд Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийг баталсан ба энэ хуулиар нар, салхи, усны эрчим хүчний эх үүсвэрээс үйлдвэрлэсэн цахилгааны үнэ тарифыг хууль батлагдсан өдрөөс 10 жилийн хугацаанд хатуу тогтоож мөрдүүлэхээр зааж өгсөн болно.

Гэхдээ эрчим хүчний салбарын хууль, эрх зүйн баримт бичиг, стратеги, хөтөлбөрүүдийн хэрэгжилт төдийлөн сайнгүй байна. Тухайлбал, УИХ-ын гишүүд өөрсдийн сонгогдсон орон нутгийн тойргийн эрх ашгийг хамгаалсан явцуу шийдвэрүүдийг гаргаж, асар их өртөг зардалтай хэрнээ үр ашиг багатай эрчим хүчний шугамыг алслагдсан аймаг сум руу татах, өргөтгөх, оновчтой бус эх үүсвэрүүдийг байгуулах зэргээр эрчим хүчний салбарын хөгжлийн бодлогыг сулруулж байна гэсэн шүүмжлэл мэргэжилтнүүд, олон нийтийн зүгээс байнга гардаг.

Нөгөө талаар Монгол Улсын эрчим хүчний засаглал улс төрөөс ихээхэн хамааралтай. 2008 оны УИХ-ын сонгуулийн үеэр нийслэл хотын захын гэр хорооллын айл өрхүүдийг цахилгаан халаагуурт шилжүүлэх, цахилгааны тарифыг тодорхой хэмжээнд тэглэх амлалтуудыг өгч байсан нь үүний нэг нотолгоо юм.

БОДЛОГЫН ҮЙЛ ЯВЦАД ХАМААРАХ ИНСТИТУЦИУД: Бүтэц, эрх мэдэл, чадавхи, хүлээх үүргийн ил тод байдал (БҮЯ01 - БҮЯ13)

Монгол Улсад хууль тогтоох байгууллага нь Улсын Их Хурал, эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага – Эрдэс баялаг, эрчим хүчний яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг нь Эрчим хүчний газар, зохицуулах байгууллага нь Эрчим хүчний зохицуулах хороо юм. Мөн тус салбарт үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагуудыг институцид хамааруулж болно.

Улсын Их Хурлын бүтцэд эрчим хүчний асуудлыг дагнан эрхэлсэн байнгын хороо байхгүй ч Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд “түлш, эрчим хүч” гэсэн багц асуудал хамаардаг. Тус байнгын хорооны бүрэлдэхүүнд эрчим хүчний мэргэжилтэй, энэ салбарт ажиллаж байсан дөрвөн гишүүн багтаж салбарын асуудлаар идэвхтэй байр суурь баримталж ажилладаг.

Эрчим хүчний бодлогын асуудлыг хэлэлцэх явцад байнгын хорооны нийт гишүүдийг мэдээллээр хангах маш чухал. Өнөөдөр УИХ-ын гишүүд салбарын яам, агентлаг, албан тушаалтнуудаас шаардлагатай мэдээлэл, тоо баримтыг гаргуулж авах эрх мэдэл хангалттай байна. Ажлаа явуулахад санхүүжилтын хувьд ямар нэгэн хүндрэл бэрхшээл гардаггүй.

УИХ-аас эрчим хүчний бодлогын холбогдолтой шийдвэр гаргахдаа байгаль орчин ба нийгмийн хүчин зүйл, нөлөөллийг авч үзэх мэдлэг, чадвартай гишүүд хангалттай байна. Гагцхүү үүнийг Эдийн засгийн байнгын хороо, цаашилбал УИХ-ын чадавхи болгон хөгжүүлэх тодорхой механизм, процедур үгүйлэгдэж байна.

Нөгөө талаар зөв, оновчтой бодлого шийдвэр гаргахад яам агентлагийнхаас гадна хөндлөнгийн, хараат бус байр суурь, үнэлэлт, дүгнэлтийг мэдэж байх шаардлагатай. Эдийн засгийн байнгын хорооны дэргэд өөрийн судалгааны нэгж байхгүй ч УИХ-ын тамгын газрын судалгааны төв нь гишүүдийн захиалгаар судалгаа хийж өгдөг.

Тухайлбал, 2010 онд УИХ-ын гишүүн Ж.Батсуурийн захиалгаар “Эрчим хүчний салбарын өнөөгийн байдал, цаашдын зорилт, хэтийн төлөв” (судлаач Н.Түвшинтөгс, Б.Ариунжаргал), УИХ-ын гишүүн Х.Бадамсүрэнгийн захиалгаар “Эрчим хүчний салбарын хөгжлийн бодлого, хөтөлбөрт холбогдох судалгааны лавлагаа-мэдээлэл” (судлаач Н.Түвшинтөгс, Б.Ариунжаргал) гэсэн хоёр судалгааг хийж гүйцэтгэжээ. Хоёулаа “Түлш эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 72-р тогтоолын төслийг хэлэлцэхийн өмнө хийгдсэн байна.

УИХ-аас эрчим хүчний бодлогын холбогдолтой шийдвэр гаргахдаа байгаль орчин ба нийгмийн хүчин зүйл, нөлөөллийг авч үзэх мэдлэг, чадвартай гишүүд хангалттай байна гэж үзлээ. Гагцхүү үүнийг Эдийн засгийн байнгын хороо, цаашилбал УИХ-ын чадавхи болгосон тодорхой механизм, процедур үгүйлэгдэж байна. Эрчим хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгээс үзэхэд байнгын хорооны гишүүдийн идэвх хангалтгүй байв. Гэхдээ үүнийг нэгдсэн хуралдаан дээр нийт гишүүдийн харьцангуй идэвхтэй оролцоо ямар нэг хэмжээгээр нөхөж байлаа.

Эрчим хүчний бодлого бол эдийн засаг, техник, технологи, байгаль, нийгмийн хүчин зүйл, нөлөөллийг хамарсан цогц асуудал юм. Гэтэл Монгол Улсын харьцангуй жижиг хууль тогтоох байгууллагад тусад нь хамаардаг байнгын, эсвэл дэд хороо байхгүй учраас Эдийн засгийн байнгын хорооны эрхэлдэг олон асуудлын зөвхөн нэг байдаг төдийгүй Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хороо, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны оролцоогүйгээр бэлтгэгдэж УИХ-ын нэгдсэн хуралдаанаар орж батлагдаж байна.

Салбарын бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүрэгтэй ЭБЭХЯ ба Эрчим хүчний газрын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх нь боловсон хүчний асуудлаар эхэлж, тэдгээр байгууллагын хамгийн дээд гурван албан тушаалын түвшинг авч үзэхээр үнэлгээний асуулгад заажээ.

Эрдэс баялаг, эрчим хүчний яам (ЭБЭХЯ)-ны хамгийн дээд албан тушаалтнууд 2012 оны эхний байдлаар 1.Сайд, УИХ-ын гишүүн Д.Зоригт, 2.Дэд сайд Т.Энхтайван (эрчим хүчний асуудал хариуцсан), дэд сайд Б.Ариунсан (геологи, эрдэс баялгын асуудал хариуцсан), 3. Төрийн нарийн бичгийн дарга Д.Хүрэлбаатар, 4. Эрчим хүчний бодлого, зохицуулалтын газрын дарга Т.Цэрэнпүрэв нар юм. Сайдуудын хувьд 2008 оны УИХ-ын сонгуулийн дараа эрх баригч нам, сөрөг хүчин хоёр зөвшилцөж хамтарсан Засгийн газрыг байгуулахад ЭБЭХ-ны сайдын албан тушаалыг МАХН (одоо МАН)-д, бас нэг дэд сайдын албан тушаал нэмж дээрх хоёр намд нэг нэгээр хуваарилсны дагуу шинээр буюу дахин томилогдсон хүмүүс юм. Нэр дурдсан Т.Энхтайван, мөн Т.Цэрэнпүрэв нар эрчим хүчний мэргэжилтэй

*Гүйцэтгэх түвшний
байгууллагууд эрчим
хүчний салбарын
чухал ач холбогдолтой
шийдвэрүүдийг байгаль
орчин, нийгмийн нөлөөллийн
талаас нь хангалттай
сайн боловсруулж чадахгүй
байгаа нь нийслэлд
барьж байгуулахаар
төлөвлөсөн 5-р цахилгаан
станц, Сэлэнгэ мөрөн
дээрх Шүрэнгийн усан
цахилгаан станцтай
холбогдон өрнөсөн маргаан,
шүүмжлэлээс харагдаж
байна.*

хүмүүс хэдий ч салбарын яамны тухайн түвшний боловсон хүчний бодлого улс төрөөс нэлээд хамааралтай байна гэж үзлээ.

Харин Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг - Эрчим хүчний газрын хамгийн дээд албан тушаалтнууд нь 1. Дарга Б.Баярбаатар, 2. Орлогч дарга П.Ганхүү, 3. Ерөнхий хэлтсийн дарга Д.Чимэддорж нар бөгөөд эрчим хүчний болон эдийн засгийн мэргэжилтэй хүмүүс юм. Өөрөөр хэлбэл тус байгууллагад боловсон хүчний томилгоо Төрийн албаны хуулийн дагуу байна.

Гүйцэтгэх түвшний байгууллагууд эрчим хүчний салбарын чухал ач холбогдолтой шийдвэрүүдийг байгаль орчин, нийгмийн нөлөөллийн талаас нь хангалттай сайн боловсруулж чадахгүй байгаа нь нийслэлд барьж байгуулахаар төлөвлөсөн 5-р цахилгаан станц, Сэлэнгэ мөрөн дээрх Шүрэнгийн усан цахилгаан станцтай холбоотой дэгдсэн маргаан, шүүмжлэлээс харагдаж байна. Байгаль орчин, нийгмийн асуудлаар тусгайлан үүрэг хүлээсэн газар, хэлтэс, алба нэгж аль алинд нь байхгүй, хэрэгжүүлэх үр дүнтэй механизм тогтоогүй, бодлого шийдвэрийг хэрэгжүүлэхдээ хэрхэн харгалзсан тухай тодорхой тайлбар, танилцуулга хийдэггүй, энэ талын мэдээлэл олон нийтэд нээлттэй биш байгаа юм. ЭБЭХ-ын сайдын дэргэд Шинжлэх ухаан, технологийн зөвлөл, Эрчим хүчний газарт салбарын техникийн зөвлөл нэлээд өргөн төлөөлөлтэй ажилладаг боловч гол төлөв үйлдвэрлэл, технологийн шинжтэй зөвлөмж гаргадаг юм байна.

Эрчим хүчний салбар дахь иргэний нийгмийн буюу төрийн бус байгууллагуудыг ихэнхдээ урьд нь тус салбарт ажил, албан тушаал эрхэлж байсан мэргэжлийн хүмүүс үүсгэн байгуулсан бөгөөд эрчим хүчний салбарын хөгжлийн нийтлэг асуудлаар дагнасан байна. Иймээс тэдний үйл ажиллагаанд судалгаа, шинжилгээний хандлага давамгайлдаг. Мөн Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо Эрчим хүч, геологи, уул уурхайн ҮЭ-ийн холбоо зэрэг салбарын ажиллагсдын эрх ашгийг хамгаалдаг байгууллагууд бий. ЭБЭХЯ-ны дэргэдэх төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах зөвлөл зөвхөн энэ хүрээнд зарим нэг үйл ажиллагаа явуулдаг нь хангалтгүй юм. Цахилгаан эрчим хүч, дулааны хэрэглэгчид, бодлогын хэрэгжилтийн нөлөөлөлд өртгөгсөд, орон нутгийн иргэд, эмзэг давхаргын эрх ашгийг хамгаалдаг иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо үгүйлэгдэж байна.

Эрчим хүчний барилга байгууламжийн байгаль орчинд үзүүлдэг нөлөөлөл, үр дагаврын талаар нийгэмд, наад зах нь тухайн орон нутагт яриа хэлэлцүүлэг өрнүүлэхгүй, талуудын байр суурийг албан ёсоор сонсохгүй байна. Жишээлэхэд, сүүлийн жилүүдэд ашиглалтанд орсон Тайшир, Дөргөний усан цахилгаан станцууд зэргэлдээх сумдын малын бэлчээр, гол нуурын урсац зэрэгт сөрөг нөлөө үзүүлж байгаа талаар гомдол гардаг боловч үүнийг хараат бус байдлаар үнэлж дүгнэсэн, шаардлагатай гэж үзвэл тэдний эрх ашгийг хамгаалсан нөлөөллийн идэвхтэй үйл ажиллагааг мэргэжлийн байгууллага, иргэний нийгмийн зүгээс явуулахгүй өдий хүрчээ.

Харин цөмийн эрчим хүчний асуудлаар иргэний нийгэм хатуу сөрөг байр суурь баримталж идэвхтэй эсэргүүцэж байгааг дурдах нь зүйтэй.

БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ ЯВЦ:

Хэлэлцүүлгийн чанар, ил тод байдал, оролцоо (БҮЯ14 - БҮЯ23)

Сүүлийн хоёр жилд УИХ-аас эрчим хүчний салбарт шинэчлэлийн ач холбогдолтой эрх зүйн хоёр баримт бичгийг батлан гаргасан билээ. Тэдгээрийн хэлэлцүүлгийн явцыг судалж үзлээ.

Кэйс 1:

Эрчим хүчний салбарыг 2014 оноос эхлэн зах зээлийн харилцаанд шилжүүлэхэд чиглэсэн “Түлш эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 72-р тогтоолын төслийг боловсруулах, хэлэлцүүлж батлах үйл явц дараах байдлаар өрнөжээ.

2009.12.22.

Улсын Их Хурлын даргын 2009 оны 204 дүгээр захирамжаар Түлш, эрчим хүчний салбарын санхүү, эдийн засгийн чадавхийг сайжруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох бодлогын баримт бичгийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулжээ. Ажлын хэсэгт дараах гишүүд оржээ. Намын харьяаллыг хашилтанд бичив. А.Тлейхан (МАН), Н.Батбаяр (АН), Ц.Цэнгэл (МАН), Б.Батбаяр (АН), Ц.Баярсайхан (АН), Х.Бадамсүрэн (МАН), Д.Ганхуяг (АН), Д.Дамба-Очир (МАН), Д.Тэрбишдагва (МАН), Ц.Шинэбаяр (МАН), З.Энхболд (АН), Ж.Батсуурь (МАН) нарын арван хоёр гишүүн ажиллав.

Хууль тогтоох хэлэлцүүлэг дараах байдлаар явагдсан байна.

2010.10.12.

УИХ-ын гишүүн А.Тлейхан, Н.Батбаяр, Д.Ганхуяг, Б.Батбаяр, Ж.Батсуурь нар Түлш эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төслийг УИХ-ын дарга Д.Дэмбэрэлд өргөн барьжээ.

2010.12.02

Түлш эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцжээ. Хууль санаачлагчдын илтгэлийг А.Тлейхан тавьсан ба илтгэлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байгаагүй бөгөөд маргааш нь үргэлжлүүлж хэлэлцэхээр болжээ.

2010.12.03

Нэгдсэн хуралдаанаар тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэв. Дараах гишүүд асуулт хариулт, хэлэлцүүлэгт оролцсон байна. Намын харьяаллыг хашилтанд бичив. Ж.Сүхбаатар (МАН), А.Тлейхан (МАН), Даш.Зоригт (МАН), Р.Раш (МАН), С.Бямбацогт (МАН), Н.Ганбямба (МАН), Ц.Сэвдванчиг (АН), Ч.Улаан (МАН), З.Энхболд (АН), Д.Оюунхорол (МАН), Р.Буд (МАН), Х.Бадамсүрэн (МАН), Р.Гончигдорж (АН), Д.Ганхуяг (АН), Ц.Баярсайхан (АН), Ж.Батсуурь (АН), Х.Наранхүү (МАН), Б.Балдан-Очир (МАН), Б.Бат-Эрдэнэ (МАН). Ингээд анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн байна.

2010.12.09.

Нэгдсэн хуралдаанаар Түлш, эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийжээ. Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Р.Буд танилцуулж уг санал дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэвдванчиг (АН), З.Энхболд (АН), Н.Ганбямба (МАН), Г.Батхүү (АН), Г.Баярсайхан (АН), Ц.Шинэбаяр (МАН), Ц.Цэнгэл (МАН), Ц.Батбаяр (МАН), Н.Энхболд (МАН) нарын асуусан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ц.Баярсайхан, Р.Буд, Даш.Зоригт нар хариулж, нэмэлт тайлбар хийсны дараа уг тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр баталжээ.

Дүгнэхэд, энэхүү тогтоолыг боловсруулж хэлэлцүүлж батлах үйл явц ажлын хэсэг байгуулснаас хойш тооцоход нийтдээ жил шахам үргэлжилсэн, мөн батлагдахаас хоёр сарын өмнө УИХ-д өргөн барьсан байна. Гэтэл эрчим хүчний үнийг аажмаар чөлөөлөх замаар тус салбарыг зах зээлийн харилцаанд бүрэн шилжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлсэн энэ чухал тогтоолын төслийг олон нийтэд ил тод болгоогүй, хэрэглэгчид болоод иргэний нийгмийн саналыг аваагүй явсаар баталсан юм. Уг тогтоолыг хэрэгжүүлэхээр сонгож авсан арга механизм хэр үр дүнтэй болох, одоо хэрхэн зөв хэрэгжүүлж байгаа, олон нийтийн зүгээс дэмжлэг хүлээх эсэхийг 2014 оноос нааш мэдэх аргагүй юм.

Кэйс 2:

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж баталсан үйл явц дараах байдлаар явагдсан байна.

2011.04.12.

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлжээ.

2011.10.14

УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар Эрчим хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцжээ. Хуулийн төслийн талаарх төсөл санаачлагчийн илтгэлийг УИХ-ын гишүүн, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн А.Тлейхан нар тус тус танилцуулж УИХ-ын гишүүн Д.Оюунхорол (МАН), Х.Баделхан (МАН), Р.Раш (МАН), Ц.Мөнх-Оргил (МАН) нарын асуусан асуултад Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, ажлын хэсгээс Т.Цэрэнпүрэв, Н.Мягмарсүрэн нар хариулж, тайлбар хийв. Уг асуудлыг дараагийн чуулганы нэгдсэн хуралдаанаар ирэх долоо хоногт үргэлжлүүлэн хэлэлцэхээр тогтов.

2011.10.20.

УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэв. Улсын Их Хурлын гишүүн П.Алтангэрэл (АН), Д.Одбаяр (МАН), Ц.Сэвдванчиг (АН), Р.Гончигдорж (АН), Н.Ганбямба (МАН), Г.Батхүү (АН), А.Тлейхан (МАН), Ц.Цэнгэл (МАН), Г.Баярсайхан (АН), З.Энхболд (АН) нарын асуусан асуултад ажлын хэсгээс Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Хүрэлбаатар, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Даш.Зоригт, дэд сайд Т.Энхтайван, Эрчим хүчний зохицуулах газрын зохицуулагч Д.Бассайхан, Эрчим хүчний газрын дарга Ц.Баярбаатар нар хариулж, тайлбар хийв. Улсын Их Хурлын гишүүн Г.Батхүү (АН), А.Тлейхан (МАН), Ц.Шинэбаяр (МАН), Ц.Цэнгэл (МАН), П.Алтангэрэл (АН), Д.Энхбат (намын харьяалал тодорхойгүй), Ц.Баярсайхан (АН) нар санал хэлэв. Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг 58,1 хувийн саналаар дэмжиж хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

2011.11.23.

УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд нэгдсэн хуралдаанд оруулахаар болов.

2011.12.02.

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийв. Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэг бэлтгэсэн талаархи Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн А.Тлейхан танилцуулав. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан УИХ-ын гишүүн Су.Батболдын (МАН) асуусан асуултад Улсын Их Хурлын гишүүн А.Тлейхан, Эрдэс баялаг, эрчим хүчний дэд сайд Т.Энхтайван нар хариулж, тайлбар хийв. Улсын Их Хурлын гишүүн Н.Ганбямба (МАН) санал хэлсэн. "Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

2011.12.06

УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийв. Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүн байсангүй. Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хийн батлах нь зүйтэй хэмээн Байнгын хороодын гишүүдийн олонхи үзлээ.

2011.12.09.

УИХ-ын нэгдсэн хуралдаанаар Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцлээ. Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг УИХ-ын гишүүн А.Тлейхан хийв. Гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Эрчим хүчний зохицуулах газрыг хороо гэж нэрлэх асуудлаар УИХ-ын гишүүн Н.Ганбямба (МАН) санал хэлэв. Ингээд Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 74.4 хувийн саналаар баталжээ.

Дүгнэвэл, Эрчим хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж хэлэлцүүлэх үйл явц 2010, 2011 оны туршид бүтэн хоёр жилийн турш үргэлжилсэн нь хангалттай хугацаа юм. Уг хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанд оруулахаас өмнө ЭБЭХЯ-наас олон нийтэд ил тод болгож санал авах ажлыг зохион байгуулжээ. Энэ хугацаанд салбарын мэргэжилтнүүд уулзалт, зөвлөгөөн, эрдэм шинжилгээний хурлаас гадна Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимаар хэлэлцүүлсэн нь шинэлэг байв. Энэ талаар ахиц дэвшил гарсан байна.

Кэйс 3:

Эрчим хүчний хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийн хэлэлцэж УИХ-аар баталсан үйл явцад олон нийтийн оролцоо ямар байсныг судлахад дараах байдлаар өрнөжээ.

2009.04.14.

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2009 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 83 дугаарын тушаалаар томилж тус яам болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Засгийн газрын харьяа агентлаг, эрчим хүчний газар, эрчим хүчний их сургууль, АНУ-ын олон улсын хөгжлийн агентлагийн эдийн засгийн бодлогын шинэчлэл өрсөлдөх чадварын төслийн төлөөллийг тус тус оролцуулжээ.

2010.01.06.

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал авч байгааг олон нийтэд зарлав. Зарыг бүрэн эхээр сийрүүлбэл:

“Монгол Улсын Засгийн газрын 2009-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Улсын Их Хурлын 2009 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 38 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2012 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Эрдэс баялаг, эрчим хүчний яамнаас “Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төслийг боловсруулж саналыг авахаар олон нийтэд нээлттэй байршуулаад байна. Иймд хуулийн төсөлд өгөх саналаа дараахи и-мэйл хаягаар ирүүлнэ үү. erkhembayaar@mmre.energy.mn. Холбоо барих утас: 51-264013 Г.Эрхэмбаяр (ЭБЭХЯ-ны Эрчим хүчний салбарын хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн)

2010.05.31.

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг ЭБЭХ-ний сайд Д.Зоригт, ХЗДХ-ийн сайд Ц.Нямдорж нарын тушаалаар баталжээ.

2011.02.09

Засгийн газрын хуралдаанаар Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтжээ.

2011.04.12.

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлжээ.

2011.02.17

Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Түлш, эрчим хүчний бодлогын дэд зөвлөлөөс “Иргэний танхим”-д “Монголын түлш, эрчим хүчний салбарын хөгжлийн бодлогын баримт бичгүүд, тэдгээрийн хэрэгжилт болон цаашдын зорилтын тухай” нээлттэй хэлэлцүүлэг зохион байгууллаа.

2011.05.27-28.

“Монголын эрчим хүч–2011: Бодлого-Хөрөнгө оруулалт-Технологи” олон улсын чуулга уулзалтаар уг хуулиар зохицуулах олон асуудлыг хөндөж ярилцсан байна.

2011.10-р сар.

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөлд хүргүүлэх саналын тухай Монголын эрчим хүчний инженерүүдийн холбооны Удирдах зөвлөл Эрчим хүчний салбарын хөгжлийн асуудлаар төрийн өмчит болон хувийн хэвшлийн 30 шахам байгууллага, компанийн 700 гаруй инженер, албан хаагчид, ажилчидтай уулзаж ярилцах, санал бодлоо солилцох ажлыг зохион байгуулж уг хуулийн төслийг хангалтгүй боловсруулсан гэж үзээд тодорхой тайлбар болон саналуудыг ЭБЭХЯ-нд хүргүүлсэн байна. Хэрхэн тусгаса н талаар ямар нэгэн мэдээлэл байхгүй.

2011.10.14

Хуулийн төслийг УИХ-ын нэгдсэн чуулганд оруулж хэлэлцэх эсэх асуудлаар санал хураахад 58,1 хувиар гишүүд хэлэлцэхийг дэмжсэн байна.

2011.10.21.

Монголын эрчим хүчний ассоциацаас хуулийн төслийн талаар 3-р цахилгаан станцын хурлын зааланд хэлэлцүүлэг явуулж УИХ-ын зарим гишүүд болон эрчим хүчний салбарын төлөөлүүд оролцов.

2011.11.23.

УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэж нэгдсэн хуралдаанд оруулахаар болжээ. .

2011.12.02.

УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

2011.12.06

УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийж чуулганы нэгдсэн хуралдаанаар батлуулахаар шилжүүлэв.

2011.12.09

УИХ-ын нэгдсэн хуралдаанаар Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталжээ.

Дүгнэж үзэхэд, хоёр жил шахам үргэлжилсэн уг хуулийн төслийн хэлэлцүүлгийн үйл явцыг албан ёсоор эхлүүлж олон нийтийн оролцоог хангахыг оролдсон боловч тэр нь хангалттай байж чадсангүй. Энэ хугацааны сонин хэвлэл ба телевизүүдийн нийтлэл, нэвтрүүлгийн мониторингийн мэдээллийг шүүж үзэхэд хэлэлцүүлэг ямар үе шатанд байгаа нь тодорхойгүй, урсгалаараа явагдаж өнгөрсөн байна.

Сүүлийн жилүүдэд эрчим хүчний салбарын бодлогын шинжтэй томоохон өөрчлөлтүүд нээлттэй хийгдэх хандлагатай болсон ч хөндлөнгийн оролцоо нь гол төлөв тус салбарын мэргэжлийн байгууллага, хүмүүсийн хүрээгээр хязгаарлагдаж байна.

Эрчим хүчний салбарын хууль, тогтоомж, бодлогын шинэчлэлийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэдэг боловч үйл явдлын мэдээлэл зонхилж, зөвлөлдөх үйл явц аль шатандаа яваа буюу хэзээ эхэлсэн, хэзээ дуусах, хэрхэн оролцож болох нь мэдэгдэхгүй байв. Ялангуяа иргэд, олон нийтийг оролцуулах оновчтой төлөвлөгөө, зохион байгуулалт үгүйлэгдлээ.

Эрчим хүчний салбарын яам, агентлагуудыг авч үзвэл зөвхөн Эрчим хүчний зохицуулах газарт 2005 онд батлагдсан “Олон нийтийн хэлэлцүүлэг явуулах журам” байдаг бөгөөд зөвхөн зохицуулалтын ил тод байдлыг хангах, түүнд олон нийтийн оролцоог дэмжих, тэдний санал бодлыг Эрчим хүчний зохицуулах газраас шийдвэр гаргахад тусгахад чиглэсэн байна. Тэгвэл салбарын нийт бодлого боловсруулах, шинэчлэхэд тус тусын үүрэгтэй ЭБЭХЯ ба Эрчим хүчний газарт тийм тусгай журам алга байв.

ЭБЭХЯ болон ЭХГ-ын аль алинд нь өөрсдийн гүйцэтгэсэн дүн шинжилгээ, судалгаа, техникийн зөвлөлийн хурлын баримт, протокол, санал зөвлөмжүүдийг олон нийтэд ил тод, нээлттэй түгээх механизм бүрэлдэн тогтоогүй байна.

Сүүлийн жилүүдэд эрчим хүчний салбарын бодлогын шинжтэй томоохон өөрчлөлтүүд нээлттэй хийгдэх хандлагатай болсон ч хөндлөнгийн оролцоо нь гол төлөв тус салбарын мэргэжлийн байгууллага, хүмүүсийн хүрээгээр хязгаарлагдаж байна. Жишээлбэл, “Түлш, эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг нийтэд ил тод болгоогүй, олон нийтийн хэлэлцүүлэг явуулаагүй өнгөрчээ. Эрчим хүчний хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг ил тод болгож хэвлэл мэдээллээр дамжуулан олон нийтэд хүргэж санал авахыг зарласны зэрэгцээ Монгол улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимаар хэлэлцүүлсэн боловч нийгмийн бусад хэсэг,

олон нийтийн зүгээс хэрхэн оролцсоныг нотлох судалгаа, мэдээлэл бидэнд олдсонгүй. Салбарын яам, агентлагуудын зүгээс эрчим хүчний бодлогын асуудлаар зөвлөлдөх иргэний нийгэм, төрийн бус байгууллагаар бараг бүх тохиолдолд Эрчим хүчний ассоциаци, Эрчим хүчний инженерүүдийн холбоо зэрэг мэргэжлийн буюу шууд хамаатай бүтцийг ойлгож, тэдэнтэй зөвлөлдөж байгаа нь учир дутагдалтай юм.

УИХ-ын 2009 оны 5-р сарын 14-ны 38-р тогтоолоор баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2012 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэл”-д эрчим хүчний салбарын бодлоготой холбоотой эрх зүйн дараах хоёр баримт бичгийг батлан хэрэгжүүлж эхлэхээр заасан юм. Үүнд:

1. “Хийн хангамжийн байгууламжийн аюулгүй ажиллагааг хангах, хийн хангамжийн ажил, үйлчилгээ эрхлэлтийг оновчтой тодорхой болгох, аюулгүй ажиллагааны хариуцлагыг өндөрсгөх болон үйлдвэрлэл ахуйд хийг ашиглах зах зээлийг нээх эрх зүйн орчинг бүрдүүлэх, хийн түлшний салбарт төр, иргэн хуулийн этгээдийн оролцоо, тэдгээрийн хооронд үүсэх харилцааг хуулиар зохицуулах”.

Одоогоор ЭБЭХ-ний сайдын 2010 оны 4-р сарын 29-ны 100 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс “Хийн хангамжийн тухай” хуулийн төслийг боловсруулаад байна. Харамсалтай нь манайд эрчим хүчний хангалт, хэрэглээний цоо шинэ түвшин, соёлыг шаардах энэ хуулийн төслийн талаар иргэд, юуны өмнө хэрэглэгчид огт мэдэхгүй, яриа хэлэлцүүлэг өрнүүлэхгүй, сэтгэл зүйн болон бусад талаар бэлтгэгдэхгүй байна.

2. “Эрчим хүчний зохистой хэрэглээг зохицуулах, үр ашиггүй зарцуулалтыг бууруулах, эрчим хүчний үр ашигтай хэрэглэх, түүнд төрийн байгууллагын зүгээс хяналт тавих, дэмжихтэй холбогдсон харилцааг зохицуулах”

Одоогоор Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн төслийн анхны хувилбарыг боловсруулжээ.

Хуулийн төслийн талаар 2010 оны 10 дугаар сард ДЦС-4 ТӨХК дээр болсон хэлэлцүүлэгт ЭБЭХЯ, ЭХГ, ЭХЗГ, эрчим хүчний үйлдвэр, компаниуд, эрчим хүчний ассоциаци зэрэг байгууллагын төлөөлөл оролцжээ. Гэтэл бас л зөвхөн салбарын байгууллага, компаниуд, мэргэжилтнүүдийн хүрээнд явагдсанаас болж нийт хэрэглэгчид маш бага мэдээлэлтэй буюу огт мэдээлэлгүй, наад зах нь энэ төслийг нь өнөөдөр хаанаас олж үзэх нь тодорхойгүй байна.

Салбарын шинэтгэлийн баримт бичигт байгаль орчны нөлөөллийн асуудлыг хангалттай тусгаж шийдвэр гаргахдаа зайлшгүй харгалзах хүчин зүйл болгох талаар зарим ахиц дэвшил гарч байгаа боловч ажлын байрны нөлөөллийг авч үзэх, үнэлэх, түүний дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээний механизм хараахан алга байгааг нэмж хэлэх нь зүйтэй.

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ:

Ил тод, нээлттэй байдал, хариуцлага (БҮЯ24 - БҮЯ29)

Эрчим хүчний салбарт хувийн хэвшлийн оролцоо аажмаар нэмэгдэж байна. 2010 оны хоёрдугаар сард Концессын тухай хууль батлагдсанаар энэ үйл явц улам түргэсэх, ялангуяа гадаад дотоодын хөрөнгө оруулагчдыг татах эрх зүйн нөхцөл бүрдэж байна.

Гэхдээ бие даасан эрчим хүч үйлдвэрлэгчдийн талаарх бодлогыг хэрхэн боловсруулж байгаа нь ил тод биш байна. Жишээлбэл, Ухаахудагийн дулааны цахилгаан станцыг байгуулах шийдвэр нь салбарын бодлоготой хэр уялдсан нь тодорхойгүй, үүнээс болж түүний цаашдын хүчин чадал, өргөтгөлийн асуудал маргаантай хэвээр үлдсэнийг баримт, мэдээлэл харууллаа.

Эрчим хүчний салбарт хувийн хэвшлийн үйлчилгээ үзүүлэгчийг анх 2003 онд “Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчид хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг нэг багц болгон нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар худалдсан нь одоогоор хувьчлалын бараг цорын ганц жишээ юм. Ингэж худалдах шийдвэрийг хэрхэн гаргасан нь зарим талаар тодорхойгүй ч уралдаант шалгаруулалтын үйл явц өөрөө хангалттай ил тод байжээ.

Эрчим хүчний салбар урьдын адил татаастай байгаа. Орлого багатай бүлэгт зориулж эрчим хүчний үнийг доогуур түвшинд барих, алслагдсан аймаг сумын иргэдийг эрчим хүчинд холбохын тулд үр ашиг багатай ч хамаагүй эрчим хүчний дэд бүтэц татах зэрэг нь юуны өмнө улс төрийн шийдвэр байдаг бөгөөд УИХ, эсвэл Засгийн газраас үүрэг, чиглэл өгсний дагуу салбарын яамнаас боловсруулж цааш хэрэгждэг гэдэг нь ойлгогдож байна. Харин УИХ-ын 72-р тогтоол гарснаар сард 150 кВт.ц хүртэл хэрэглээтэй айл өрхөд борлуулах цахилгааны үнийг бага түвшинд үлдэгээд их хэрэглээтэй айл өрх, байгууллагын тарифийг үе шаттайгаар нэмэгдүүлэх замаар 2014 он гэхэд эрчим хүчний салбар алдагдалгүй ажиллах эрх зүйн орчинг бий болгожээ.

Манай улсын эрчим хүчний салбарт хэрэгжиж байгаа олон улсын байгууллагууд, тухайлбал, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Олон улсын хөгжлийн агентлаг, мөн Японы улсын Засгийн газрын тусламжаар хэрэгжиж байгаа техникийн тусалцааны төслүүд нь тухайн байгууллагын жишиг стандартын дагуу танилцуулгын хэмжээнд хангалттай ил тод байлаа. Гэхдээ эдгээр төслийн хүрээнд хийгдсэн судалгааны тайлан, дүгнэлт, зөвлөмжийг хэрхэн ашиглаж ямар үр дүнд хүрсэн тухай мэдээлэл ховор байна.

*Орлого багатай
бүлэгт зориулж
эрчим хүчний үнийг
доогуур түвшинд
барих, алслагдсан
аймаг сумын
иргэдийг эрчим
хүчтэй болгохын
тулд үр ашиг
багатай ч хамаагүй
эрчим хүчний дэд
бүтэц татах зэрэг
нь юуны өмнө улс
төрийн шийдвэр
байдаг.*

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН АСУУДЛУУД: Олон нийтийн оролцоо, бодлого, төлөвлөлт, үнэлгээ (БҮЯЗО - БҮЯЗ6)

Эрчим хүчний салбар дахь сайн засаглалын шалгуур бол бодлогын шинжтэй шийдвэр гаргаж хэрэгжүүлэхдээ байгаль орчин ба нийгмийн нөлөөллийг заавал харгалзаж үнэлдэг, сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн төлөх буюу нөхөн сэргээх арга хэмжээ авдаг үр дүнтэй механизм юм.

Өнөөдөр тодорхой төсөл, хөтөлбөрүүд дээр байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг заавал хийж гүйцэтгэх хууль дүрэмтэй боловч түүний чанар, бодит байдалд хэр нийцэж байгааг хөндлөнгөөс үнэлэх явдал ихээхэн орхигджээ. Нийгмийн янз бүрийн нөлөөллийг харгалзах талаар тодорхой нөхцөл шаардлага алга байна. Эрчим хүчний барилга байгууламжаас үүдэлтэй байгаль, нийгмийн асуудлууд гомдол саналын хэмжээнд яригдаад өнгөрч байна.

Дөргөн болон Тайширын усан цахилгаан станцуудыг төлөвлөх болон барих шатанд олон нийттэй зөвлөлдөх системтэй хүчин чармайлт гаргаагүй нь нэр бүхий УИХ-ын 3 гишүүнээс БОАЖЯ-ны болон ЭБЭХЯ-ны сайдуудад тавьсан нээлттэй асуулгаас тодорхой харагдлаа. Гишүүд өөрсдийн асуулгадаа “...Тайширын усан цахилгаан станц /УЦС/ 2007 онд баригдаж, голын усыг боон усан сандаа ус хуримтлуулж эхэлсэнээс хойшхи хугацаанд УЦС-ын далангаас доошоо гарах усны гарц нь эрс багасаж / 6.33 м³/сек-ийн оролттой ус 0.55 м³/сек-ийн гаралттай болж багассан нь хэмжилтээр тогтоогдсон байна./ Завхан гол 50-60 км урсаад тасарч элсэнд шургах болсноос энэ голын сав дагуух нутагт нутаглаж, идээшдэг олон арван мянган хүн, олон зуун мянган малыг сүүлийн 3 жилийн турш ус, бэлчээрийн гачаалд оруулж, ихээхэн зутрааж байгаагийн гадна энэ бүс нутагт цөлжилт, хуурайшилтын үйл явц эрчимжиж, улмаар байгаль орчны тэнцвэрт байдал алдагдан ихээхэн доройтож байгаа талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр удаа дараа мэдээлж байгаагийн гадна иргэд, сонгогчид сэтгэл зовинон тус бүс нутгаас сонгогдсон Улсын Их Хурлын гишүүний хувьд надад хандаж, санал, хүсэлтээ илэрхийлсээр байгаа билээ...” гээд УЦС-ын хүн ам байгаль орчинд үзүүлэх нөлөө хийгдсэн эсэх, улмаар дээр үүсээд буй асуудлаар ямар арга хэмжээ авах гэж байгаа талаар УИХ-д нээлттэй танилцуулга хийхийг хүсчээ.

Өнөөдөр тодорхой төсөл, хөтөлбөрүүд дээр байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг заавал хийж гүйцэтгэх хууль дүрэмтэй боловч түүний чанар нь бодит байдалд хэр нийцэж байгааг хөндлөнгөөс үнэлэх явдал ихээхэн орхигджээ.

Кэйс 4:

Улаанбаатар хотод V цахилгаан станцыг барьж байгуулах шийдвэр гаргахдаа олон нийтийн оролцоог хангасан нь

Сүүлийн жилүүдэд нийслэл Улаанбаатар хотын хүн амын тоо түргэн нэмэгдэж эрчим хүчний чадлын дутагдалд орох хандлагатай болсон, эрчим хүчний системийн горимыг тохируулахад ихээхэн хүндрэлтэй, айл өрхийн ихэнх нь дулааны шугам сүлжээнд холбогдоогүй гэр хороололд амьдарч өвлийн улиралд нүүрс түлж байгаагаас агаарын бохирдол гамшгийн хэмжээнд хүрч хүн амын эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж байгаа тул олон жилийн турш ярьсны эцэст ДЦС-5-ыг байгуулах шийдвэрийг албан ёсоор гаргасан билээ. Гэхдээ түүнийг Улаанбаатар хотын дотор, одоо ажиллаж байгаа хуучин 3-р цахилгаан станцын дэргэд байгуулах болсон нь ихээхэн маргаан дэгдээсэн юм.

Тус станцын байгаль орчны нөлөөлөх байдлын анхан шатны үнэлгээ хийсэн тайлангаас үзэхэд ДЦС-5 төслийн олон нийтийн санал авах анхны зөвлөгөөнийг Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ ба техник эдийн засгийн судалгаа хийх үе шатанд буюу 2010 оны 12-р сард Улаанбаатар хотод санал асуулгын хэлбэрээр явуулжээ. Энэ уулзалт нь станцын байршил, хэмжээ, хүчин чадал, техникийн нөхцөл зэргийн тухай олон нийтийн хандлагыг тодорхойлоход чиглэгдэж нийт 28 оролцогчид хариултын сонголт бүхий санал асуулгын хуудсыг тарааж 100 хувь бөглүүлэхэд оролцогчдын 71.4 хувь нь нааштай хандаж эерэг, 28.6 хувь нь төслийг хэрэгжүүлэхийн эсрэг санал өгчээ. Гэхдээ уг уулзалтанд оролцсон 28 хүний 22 нь төрийн байгууллагын ажилтнууд, бусад 6 нь судлаачид байсан ба тэндхийн оршин суугч иргэд байгаагүй.

Хоёр дахь ээлжийн олон нийтийн уулзалт зөвлөгөөнийг 3 ба 5-р сард зохион байгуулж судалгааны эхний үр дүн, байгаль орчны бохирдлыг бууруулах арга хэмжээ, эхний зөвлөгөөний үеэр гарсан асуулт, дэвшүүлсэн санал зөвлөмжийн талаар танилцуулаад санал асуулга явуулахад оролцогчдын 76 хувь нь ДЦС-3-ийг түшиглан барихыг дэмжсэн бол 18 хувь нь эсрэг саналтай байжээ. Санал асуулгад нийт 73 хүн хамрагдсанаас 48 хувь нь төрийн албан хаагч, 23 хувь нь бизнес эрхлэгч, 4 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид байсан ба нийт оролцогчдын 96 хувь нь ДЦС-3-ийн ойролцоо дүүрэгт ажиллаж амьдардаг хүмүүс байжээ.

Энэ бол дээр дурдсан тайлангаас бидний олж авсан мэдээлэл юм. Өнгөцхөн харахад олон нийт, мэргэжлийн хүмүүсээс судалгаа авч тэдэнтэй зөвлөлдсөн мэт боловч маш явцуу, нэгэнт шийдчихсэн байршил зэргийг тэдний нэрээр баталгаажуулахыг оролдсон гэж дүгнэхээс өөр аргагүй байна. Түүнээс хойш ДЦС-5-ын байршил байгаль орчин болон бусад талаасаа маш их шүүмжлэлд өртөж дахин өөрчлөгдөхөөр байгаа нь үүнийг нотолж байна.

Эрчим хүчний салбарын байгаль орчны нөлөөллийг бууруулах үр дүнтэй бөгөөд ирээдүйтэй арга зам Монгол орны хувьд сэргээгдэх эрчим хүч гэдэгтэй бүгд санал нийлдэг.

Ер нь эрчим хүчний ихэнх төсөл, хөтөлбөрийн БОНБУ-ний тайлан ил тод бус байгаагаас олон нийт энэ талын мэдээллийг олж авч, санал бодлоо илэрхийлэхэд хүндрэл учирч байна

Эрчим хүчний салбарын байгаль орчны нөлөөллийг бууруулах үр дүнтэй бөгөөд ирээдүйтэй арга зам Монгол орны хувьд сэргээгдэх эрчим хүч гэдэгтэй бүгд санал нийлдэг.

1999 онд хөдөөг цахилгаанаар хангах “100000 нарны гэр” үндэсний хөтөлбөр, мөн 2005 онд “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр”-ийг тус тус баталжээ. Тус хөтөлбөрт “Монгол Улсын эрчим хүчний хангамжид сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлж, эрчим хүчний хангамжийн бүтцийг сайжруулах, хөдөөг цахилгаанжуулахад сэргээгдэх эрчим хүчийг өргөн ашиглах замаар экологийн тэнцвэртэй байдлыг хангах, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино” гэсэн маш зүйтэй зорилт дэвшүүлсэн билээ.


Хөтөлбөрийн нэгдүгээр үе шат 2005-2010 он, харин хоёрдугаар үе шат нь 2011-2020 оныг тус тус хамаарч байна. 2010 он гэхэд улсын эрчим хүчний нийт үйлдвэрлэлийн 3-5%-ийг, 2020 он гэхэд 20-25 %-ийг сэргээгдэх эрчим

хүч ашиглан үйлдвэрлэхээр тооцоолжээ. Харамсалтай нь хэрэгжилт хангалтгүй байгаа юм.

2007 онд Сэргээгдэх эрчим хүчний тухай хуультай болсноор сэргээгдэх эрчмийн нөөцийг ашиглан экологийн цэвэр эрчим хүчийг хөгжүүлэхэд дэмжлэг болохуйц үнэ, тарифыг хуулиар хатуу тогтоож, энэ хууль батлагдснаас хойш 10-аас доошгүй жилийн хугацаанд тогтвортой мөрдөнө гэж зааж өгчээ. Гэтэл уг хуулийг хэрэгжүүлэх талаар эрчим хүчний салбарын яамны зүгээс өнгөрсөн хугацаанд үр дүнтэй ажиллаж чадахгүй байна. Тус яамны сэргээгдэх эрчим хүчний асуудал хариуцсан хэлтэс, мөн яамны харьяанд байсан сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв (агентлаг хэлбэртэй)-ийг тус тус татан буулгасныг ухралт болсон гэсэн шүүмжлэлийг мэргэжлийн хүмүүс хэлж байна. Мөн сэргээгдэх эрчим хүчний санг зохих ёсоор бүрдүүлж ажиллуулахгүй байна.

Зураг 1.

Бодлогын үйл явцын үнэлгээ (0-5 оноогоор)



БОДЛОГЫН ҮЙЛ ЯВЦЫН ЗӨВЛӨМЖҮҮД

Монгол Улсын эрчим хүчний засаглалын үнэлгээний хүрээнд тус салбарын бодлогын үйл явцыг судлан үнэлгээ хийж дүгнэлт өгсний үндсэн дээр дараах зөвлөмжүүдийг гаргаж байна.

Нэг

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх чиг үүргийн хүрээнд өнгөрсөн жилүүдэд эрчим хүчний салбарын хууль, тогтоомж, бодлогын баримт бичгүүдийг хэлэлцэн баталж ирсэн практикийг дүгнэж үзэх, цаашид энэ үйл явцыг хэрхэн илүү нээлттэй, олон талын оролцоотой болгох талаар шинэ арга зам, боломжийг эрж хайх хэрэгтэй байна.

Тухайлбал, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд “Байнгын, дэд хороо тодорхой асуудлын

талаар эрдэмтэд, шинжээчид, сонирхлын бүлэг, иргэд, төрийн болон төрийн бус байгууллагын санал сонсох, мэдээлэл авах зорилгоор дараахь журмаар нээлттэй сонсгол /цаашид “сонсгол” гэх/ зохион байгуулж болно” гэж заагаад уг сонсголыг хэрхэн явуулахыг зохицуулсан байдаг.

Парламентын нээлттэй сонсгол нь жирийн уулзалт, хэлэлцүүлэг, мэтгэлцээнээс ихээхэн ялгаатай бөгөөд парламентын гишүүд шийдвэр гаргахад нь шаардлагатай гэж үзсэн асуултуудыг өөрсдөө тавьж бусад талуудын байр суурийг нарийн дэс дарааллаар сонсдог, энэ утгаараа маш сайн судалгаа, нотолгоо гаргахыг шаарддаг механизм юм. Одоогоор ийм сонсгол эрчим хүчний асуудлаар огт явагдаагүй байна. Иймээс олон нийт төдийгүй мэргэжлийн хүмүүс, бүр шийдвэр гаргагчдын дунд ихээхэн маргаан дэгдээгээд байгаа дулааны 5-р цахилгаан станцын байршил, Сэлэнгэ мөрөн дээр барих усан цахилгаан станцын байгаль орчны нөлөөлөл зэрэг сэдвээр нээлттэй сонсгол явуулахыг уриалж байна. Энэ нь эрчим хүчний салбарын бодлогын шинэчлэл, томоохон шийдвэр гаргах үйл явцад бүх нийтийн анхаарлыг хандуулж татан оролцуулах, парламентийн хэлэлцүүлгийг илүү чанартай, хариуцлагатай болгох маш чухал ач холбогдолтой юм.

Хоёр

УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны бүрэлдэхүүнд багтдаг эрчим хүчний мэргэжилтэй, эсвэл энэ асуудлаар мэргэшсэн буюу илүү анхаардаг гишүүдэд түшиглэн эрчим хүчний бодлогын асуудлаар төвлөрч ажиллах УИХ-ын албан бус бүтцийг бий болгож салбарын зүгээс дэмжин ажиллаж болох юм. (УИХ-ын гишүүд сайн дураар зохион байгуулалтанд орсон жишээ бий. Тухайлбал, ногоон бүлэг, бие даагчдын зөвлөл, эмэгтэйчүүдийн бүлэг гэх мэт. Мөн уул уурхайн асуудлаар албан ёсны дэд хороо байгуулах санал гарч байгаа болно).

Ингэвэл тус салбарыг хамаарах тусдаа бүтэцгүй манай парламентын хувьд эрчим хүчний асуудлыг “хариуцах эзэнтэй” болгож УИХ-ын үйл ажиллагааны анхаарлын төвд байнга байлгах ач холбогдолтой. Бас эрчим хүчний хууль, тогтоол, бодлогын баримт бичиг, томоохон шийдвэр гаргахыг санаачилж өргөн барих, хэлэлцүүлгийн явцад урьдчилсан бэлтгэл, мэдлэг мэдээлэлтэй, ажил хэрэгчээр ханддаг илүү олон гишүүнтэй болно гэсэн үг юм.

Нөгөө талаар эрчим хүчний салбарын бодлогын шинэчлэлийн баримт бичгийг хэлэлцэж баталдаг УИХ-ын байнгын хорооны гишүүд болон ажлын албаны ажилтнуудыг эрчим хүчний бодлогын хэлэлцүүлгийн өмнө болон явцад УИХ-ын дэргэдэх судалгааны төвийн гүйцэтгэсэн судалгааны материалаар хангахын зэрэгцээ эрчим хүчний асуудлаар болж байгаа хурал, семинар, хэлэлцүүлэг зэрэг арга хэмжээнд тогтмол оролцуулж байх шаардлагатай нь харагдлаа. Энэ нь хууль боловсруулах ажлын хэсгийн гишүүдэд ч мөн адил хамаарна.

Гурав

Монгол Улсын эрчим хүчний салбарт сайн засаглалыг тогтоох үндсэн нөхцөл бол аливаа шийдвэр гаргах үйл явцыг бодитойгоор ил тод, нээлттэй болгох явдал юм. Энэ нь салбарын өдөр тутмын үйл амьдрал, хурал семинар, ёслолын арга хэмжээ, амжилт ололт, мөн тулгамдсан асуудлын талаар сайд, дарга, албан тушаалтнуудын ярилцлага, телевизийн нэвтрүүлэг, сурталчилгааны танилцуулга, хэвлэл зэргээр хязгаарлагдах ёсгүй.

Цаашид бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцыг олон нийтэд илүү хүртээмжтэй байдлаар мэдээлэх шинэ механизм буюу аргачлалыг шинээр боловсруулж гаргах шаардлагатай болжээ. Энэ нь мэдээлэл, үйл явцыг ил тод болгох хуваарь, дараалал, цаг хугацаа, арга хэлбэр, загварыг нэгбүрчлэн заасан журам байх ёстой. Ингэхдээ хариуцах байгууллага, албан тушаалтан, тэдний үүрэг, хариуцлагыг орхигдуулж болохгүй. Эхний ээлжинд ингэж журамлаад түүнийгээ хэрэгжүүлж чадсаны үндсэн дээр эрчим хүчний салбарт ил тод, нээлттэй байдал соёл болж хэвшинэ гэж бид үзэж байна.

Дөрөв

Эрчим хүчний салбарын бодлого шийдвэр, ялангуяа үнэ тариф, эрчим хүчний хэмнэлт зэрэг асуудлаар олон нийтэд үнэн зөв мэдээлэл өгөх, бодитой ойлголт төлөвшүүлэх талаар нэлээд хүчин чармайлт гаргаж байгаа хэдий ч эрчим хүчний талаархи хэвлэл мэдээллийн нийтлэл, нэвтрүүлэгт нуршсан яриа, дээрээс доош чиглэсэн хандлага зонхилж, нээлттэй хаалганы өдөр зэрэг арга хэмжээнүүд гол төлөв Сүхбаатарын талбай, эсвэл тухайн яам, агентлагийн байрнаас төдийлөн холдохгүй, захын гэр хороолол, тэр тусмаа хөдөө орон нутагт хүртээмжгүй байна.

Эрчим хүчний салбар нь эдийн засаг, бизнес, үйлдвэрлэл, технологийг багтаасан нарийн түвэгтэй цогц учраас янз бүрийн онцлогтой хэрэглэгчид, нөлөөлөлд шууд өртдөг орон нутгийн иргэд, мөн эмзэг бүлгийнхэнд хандсан, хамтран ажиллах замаар эрчим хүчний барилга байгууламж, сэргээгдэх эрчим хүчний УЦС, салхин цахилгаан станц зэрэгт хандах хандлагыг эерэг болгох, харилцан ойлголцох, улмаар тэдний дэмжлэгийг хүлээхэд чиглэсэн цоо шинэ арга зүйг боловсруулах нь зүйтэй. Энэ чиглэлээр гадаад орнуудын шилдэг, сайн туршлагууд бий. Эрчим хүчний хэрэглэгчдэд үйлчлэх төвүүдийн зарим үйл ажиллагааг ч энэ зүгт чиглүүлэх боломж бий.

Тав

2005 онд батлагдсан Эрчим хүчний зохицуулах газрын “Олон нийтийн хэлэлцүүлэг явуулах журам”-ын жишгээр ЭБЭХЯ ба Эрчим хүчний газрын аль аль нь төстэй журмыг цаг алдалгүй боловсруулан гаргаж хэрэгжүүлэх нь зүйтэй.

Зургаа

Салбарын яам, агентлагын зүгээс эрчим хүчний бодлогын асуудлаар зөвлөлддөг иргэний нийгмийн хүрээг зөвхөн салбарын мэргэжлийн болон бизнес, зарим судалгааны байгууллагаар хязгаарлахгүйгээр эдийн засаг, эрдэм шинжилгээ, төрөл бүрийн мэргэжлийн холбоод, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, хэвлэл мэдээлэл, бас нутгийн удирдлага, орон нутгийн төрийн бус байгууллага, иргэдийг татан оролцуулж байх нь зүйтэй.

Үүнээс хойшхи эрчим хүчний бүх хууль, бодлогын баримт бичгийн хэлэлцүүлгийг ил тод, нээлттэй байдлыг бүрэн хангасны үндсэн дээр олон нийтийн бодитой оролцоотойгоор явуулна гэдэгт найдаж байна.

Долоо

Сүүлийн үед нийслэл Улаанбаатар хотод барьж байгуулахаар төлөвлөсөн 5-р цахилгаан станцын байршил эцэслэн шийдэгдэхгүй удаж байгаагаас уг асуудал УИХ, Засгийн газар, салбарын яам, агентлагийн хүрээнээс хальж эрдэмтэн судлаачид, янз бүрийн мэргэжлийн болон төрийн бус байгууллагууд, олон нийтийн анхаарлыг татаж ихээхэн маргаан дэгдээж эхлээд байна. Байгаль орчны сөрөг нөлөөллийн хувьд ч маш тодорхойгүй байгаа учраас ард иргэдэд зөв ойлгуулах, итгэл төрүүлэх шаардлага улам хурцаар тавигдаж байна.

Энэ бүгдийг харгалзан уг станцыг хэдийгээр барьж байгуулах шийдвэр хэдийнэ гарч гүйцэтгэх компанийн сонгон шалгаруулалт явагдаж байгаа ч ийм шийдвэр гаргахдаа ашигласан баримт бичиг, судалгаа, үнэлгээг нээлттэй болгох шаардлагатай байна. Энэ нь хожим гарч болзошгүй байгаль орчин, нийгмийн болон бусад сөрөг нөлөөллийг багасгах, эрсдэлийг бууруулах, цаашилбал олон нийтийн дэмжлэгийг авахад тустай байх нь эргэлзээгүй.

Иймд юуны өмнө ДЦС-5-ын асуудлаар өргөн хүрээтэй цуврал хэлэлцүүлэг зохион байгуулахыг тус салбарын эрдэмтэд, судлаачид, мэргэжлийн болон бусад байгууллагуудад санал болгож байна.

Найм

ЭБЭХЯ болон Эрчим хүчний газарт тус салбар дахь байгаль орчны нөлөөллийн асуудлыг хариуцсан тодорхой механизм бий болгох нь зүйтэй. Энэ нь эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээний байгаль орчны нөлөөллийн үнэлгээ болон байгаль орчны стандартыг боловсруулахад шаардагдах технологи, эдийн засгийн судалгааны материалаар хангах, тэдгээрийг яам, газрын баримт бичиг, шийдвэрт тусгаж хэрэгжүүлэх ажлыг зохицуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий тусгайлсан нэгж (хэлтэс, алба гэх мэт)-ийг хэлж байна. Гэхдээ юуны өмнө хариуцсан ажилтныг бий болгохоос эхлэх нь зүйтэй. Мөн нийгмийн нөлөөллийн асуудлыг ч ажил үүрэгт нь хамтатгах боломжтой.

Ес

Эрчим хүчний бодлого, түүний шинэчлэлийн асуудал нь зөвхөн тус салбарын албан тушаалтан, мэргэжилтнүүд, бас улс төрчдийн хэрэг биш тул нийгмийн бусад хэсэг, бүлгийн оролцоо, дэмжлэгийг бий болгох, үүний тулд хамгийн түрүүнд мэдээллийн ил тод, нээлттэй байдал буюу хэлэлцүүлгийн талбарыг санал болгож байна. Энэ нь юуны өмнө эрчим хүчний салбарын тухай олон нийтэд зориулсан портал сайт байж болох юм. Одоо байгаа яам, агентлаг, төрийн өмчит компаниудын болон “Эрчим хүчний портал” (<http://www.energy.mn>) зэрэг сайтууд нь салбар, байгууллагын үйл ажиллагааг танилцуулж сурталчлах үндсэн зорилготой учраас энэ шаардлагыг хангаж чадахгүй юм.

Олон нийтэд зориулсан портал сайт нь улс орны амьдралд суурь ач холбогдолтой энэ салбарын нөхцөл байдал, тулгамдсан асуудлыг олон нийтийн анхаарлын төвд байнга байлгаж, ингэснээрээ эрчим хүчний засаглалыг илүү нээлттэй, олон талын оролцоотой, сайн засаглалын үндсэн зарчмуудад нийцүүлэн хөгжүүлэх нэг механизм гэж үзэж байна.

Энэ нь нэг талаас мэдээллийн төв, нөгөө талаас хэлэлцүүлгийн талбар байх юм. Тус салбарын удирдлага, албан тушаалтан, инженер техникийн ажилтан, ажиллагсдаас эхлээд судлаачид, эрдэмтэд, эрчим хүч хэрэглэгчид, иргэд, олон нийт, бас хэвлэл мэдээллийнхний зүгээс эрчим хүчний салбарын мэдээллийг чөлөөтэй олж авах боломжийг бүрдүүлж, баримт бичиг, хууль тогтоомжийн үзэл баримтлал, лавлах материал, гадаадын туршлага, хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, шийдвэрийн төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, төслийн бичвэр, түүний хувилбарууд, орж байгаа өөрчлөлтүүд, хөндлөнгийн үнэлэлт дүгнэлт, хэлэлцүүлгийн зар, хуваарь, мэргэжлийн болон олон нийтийн хэлэлцүүлгийн материал, тэдгээрээс гарсан саналуудыг байршуулж өргөн олон нийтэд хүртээмжтэй байхаар зохион байгуулах хэрэгтэй.

Алслагдсан аймаг, сумд болон төв суурин газрын захын хорооллын иргэд Интернэтэд холбогдож мэдээлэл авах боломж хязгаарлагдмал байдаг хэдий ч тухайн орон нутгийн төр, захиргааны болон иргэний нийгмийн байгууллагууд уг портал сайтаас авсан мэдээллийг тэдэнд хүргэж цаашилбал гарын авлага, материал бэлтгэж тараах, яриа танилцуулга хийх, санал асуулга явуулах замаар эрчим хүчний салбарын аливаа үйл явцад хүн бүр идэвхтэй оролцох өргөн боломж нээгдэнэ гэж бид үзэж байна.

ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ ЯВЦ: ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ ЯВЦЫН ТОДОРХОЙЛОЛТ

Эрчим хүчний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үнэ тарифыг хянаж батлах, тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон хэрэглэгчдийн эрх ашгийг тэнцвэртэй хамгаалах, үйлдвэрлэгч, хэрэглэгчийн хүрээнд шударга өрсөлдөөнийг бий болгох нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн шийдвэр гаргаж хяналт тавих, маргааныг шийдвэрлэх үйл ажиллагаа юм.

ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ ЯВЦЫН ХУУЛЬ, ЖУРАМ, ЭРХ ЗҮЙН БУСАД БАРИМТ БИЧГҮҮД

Өнөөдөр Монгол улсад эрчим хүчний зохицуулалтын үйл явцыг зохицуулсан дараах хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүд хүчин төгөлдөр үйлчилж байна.

Монгол Улсын хууль:

1. Эрчим хүчний тухай хууль
2. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
3. Иргэний хууль
4. Захиргааны хариуцлагын тухай хууль
5. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль
6. Ашигт малталын тухай хууль
7. Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль
8. Өрсөлдөөний тухай хууль

Засгийн газрын тогтоол

1. Засгийн газрын 263-р тогтоол - Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм, Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм, Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм
2. Засгийн газрын 83-р тогтоол - Эрчим хүчний зохицуулах газрын дүрэм
3. Засгийн газрын 233-р тогтоол - Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам, Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, жилд байгуулах элэгдлийн хэмжээ

Улсын дээд шүүхийн тайлбар:

1. Монгол Улсын дээд шүүхийн 26-р тогтоол. “Эрчим хүчний тухай хуулийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай” (2006.05.29)

Сайдын тушаал:

- Аймаг нийслэлийн зохицуулах зөвлөлийн гишүүнийг томилох тухай
- Төвлөрсөн дулаан хангамжийн дүрэм
- Дулааны эрчим хүчийг дэмжих, тооцох дүрэм
- Эрчим хүчний зохицуулалтын үйлчилгээний хөлс тооцох аргачлал
- Монгол Улсын дээд шүүхийн тогтоол:
- Эрчим хүчний тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай
- ЭХЗГ-ын Зохицуулагчдын зөвлөлийн тогтоол:
- Тусгай зөвшөөрөл эзэмшигч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм
- Зохицуулах зөвлөлийн хуралдааны журам
- Эрчим хүчний зохицуулах газарт хандсан гомдол, маргааныг бүртгэх, шийдвэрлэх журам”
- Олон нийтийн хэлэлцүүлэг явуулах журам
- Тарифын саналыг хянан шалгах журам
- Цахилгааны спот зах зээлийн дүрэм
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааны рейтинг тогтоох аргачлал
- Цахилгааны өрсөлдөөнт зах зээлийн түр дүрэм
- Дулааны эрчим хүчний төлбөр тооцооны журам
- Хэрэгцээний халуун усыг халаасан дулааны төлбөрийг шинэчлэн тогтоох тухай
- Эмзэг бүлгийн тариф мөрдөх журам

ЗОХИЦУУЛАХ БҮТЭЦ:

Эрх мэдэл, ил тод байдал, хараат бус байдал, чадавхи
(ЗҮЯ01 - ЗҮЯ14)

Монгол Улсад эрчим хүчний салбарт зохицуулалтын бие даасан бүтэц байдаг нь Эрчим хүчний зохицуулах хороо юм.

2001 онд Монгол Улсын Эрчим хүчний тухай хуулиар тогтоосон эрх, үүрэгтэй ЭХЗГ-ыг байгуулан эрчим хүчний салбарыг зах зээлийн харилцаанд шилжүүлэхэд чиглэсэн үнэ тарифыг тогтоож мөрдүүлэх, тусгай зөвшөөрөл олгох зэрэг олон заавар журмыг шинээр боловсруулан мөрдөж эхэлснээр эрчим хүчний зохицуулалт бодит зүйл болж чаджээ. Ингэснээр тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын тарифын орлого нэмэгдэж, их болон урсгал засвар хийх хөрөнгийн эх үүсвэрийн нилээд хэсгийг орлогоороо нөхөх боломжтой болсон, ажиллагсадын цалин хөлсийг нэмэгдүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх боломж бүрдсэн, богино хугацаат өр авлага буурсан, улсын төсөвт төвлөрүүлэх татварыг нэмэгдүүлсэн зэрэг үр дүн гарчээ. Салбарын санхүү, эдийн засгийн чадавхи сайжирч эрчим хүчний салбарт хувийн хөрөнгө оруулалт хийх таатай орчин зохих хэмжээнд бүрдэж эхэлсэн байна.

Эрчим хүчний зохицуулах хорооны эрх зүйн баримт бичгүүдэд үнэлгээ хийхэд тус институцийн бүтэц, эрх мэдэл, зохицуулагчдын хараат бус байдлын үзүүлэлтүүд нэлээд өндөр үнэлгээ авсан юм. Иймээс Монгол Улсад эрчим хүчний зохицуулалтын механизм хөгжилтэй орнуудын жишгээр бүрэлдэн тогтож, үйл ажиллагааны эрх зүйн орчин бүрдсэн, зохицуулах байгууллага нь зохих чадавхитай гэж дүгнэж байна.

Гэтэл бодит байдал дээр хараат бус байх энэ боломжийг хангалтгүй ашиглаж ирсэн байна. 2011 оны 10-р сард ЭБЭХ-ний дэд сайд Т.Энхтайваны “Өнөөдөр хэдийгээр Эрчим хүчний зохицуулах газар нь Засгийн газраас хараат бус ажиллана гэж хуулиндаа заасан боловч яг хууль, эрх зүйн хувьд Засгийн газраас хараат хэвээр байгаа” гэж хэлсэн дүгнэлт нотолж байна.

Харин 2012 оны 12-р сард УИХ-аас нэмэлт өөрчлөлт оруулсан Эрчим хүчний тухай хуулиар тус байгууллагыг Эрчим хүчний зохицуулах хороо болгон өргөжүүлж зохицуулагчдын тоог тав болгож хөндлөнгийн төлөөллөөр өргөжүүлсэн нь тус байгууллагын хараат бус байдлыг илүү баталгаажуулах зорилготой гэж албаны хүмүүс тайлбарлаж байна. Үнэхээр тийм болсон эсэхийг эцэслэн дүгнэхэд тодорхой хугацаа шаардлагатай.

2001-2012 онд эрчим хүчний гурван зохицуулагчтай байж гол төлөв эрчим хүчний салбарт удирдах ажил хийж байсан хүмүүсийг томилж байсан бол 2012 оноос дараах хүмүүс томилогдоод байна.

1. ЭХЗХ-ны дарга Т.Цэрэнпүрэв.
Урьд нь Эрчим хүчний удирдах газар, Эрчим хүчний Диспетчерийн үндэсний төвд, мөн салбарын яамны төрийн нарийн бичгийн дарга, эрчим хүчний бодлогын газрын даргаар ажиллаж байсан.
2. ЭХЗХ-ны зохицуулагч Н.Мягмарсүрэн
Урьд нь дулааны 3-р цахилгаан станцад инженер, цех, хэлтсийн дарга, гүйцэтгэх захирлаар, мөн Эрчим хүчний зохицуулах газрын даргаар ажиллаж байсан.

*Монгол Улсад эрчим хүчний
зохицуулалтын механизм
хөгжилтэй орнуудын
жишгээр бүрэлдэн тогтож,
үйл ажиллагааны эрх зүйн
орчин бүрдсэн, зохицуулах
байгууллага нь зохих
чадавхитай гэж дүгнэж
байна.*

3. ЭХЗХ-ны зохицуулагч Д.Бассайхан
Ховд аймгийн Хөшөөтийн нүүрсний уурхай, Дархан хотын дулааны цахилгаан станцад, Цахилгаан шугам сүлжээний газарт албаны дарга, дарга, “Улаанбаатар Цахилгаан Түгээх Сүлжээ” ТӨХК, “Төвийн Бүсийн Цахилгаан Дамжуулах Сүлжээ” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан.

Дээрх гурван зохицуулагч орон тооны бөгөөд Монгол Улсын Ерөнхий сайдын 2012 оны 4-р сарын 3-ны өдрийн захирамжаар 4 жилийн хугацаатай томилогдон ажиллаж байна.

4. ЭХЗХ-ны зохицуулагч Д.Чулуунбаатар
Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн нэгдсэн холбоонд ерөнхий нарийн бичгийн даргаар ажилладаг.

5. ЭХЗХ-ны зохицуулагч Д.Жаргалсайхан
Нийтлэлч, ТВ-ийн “Дефакто” зохиогчийн нэвтрүүлэг хөтлөгч.

Сүүлийн хоёр зохицуулагч орон тооны биш бөгөөд Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар хоёр жилийн хугацаатай томилогджээ. Д.Жаргалсайханыг Худалдаа, аж үйлдвэрийн танхимын саналыг үндэслэн томилсон нь эрчим хүчний компаниудын төлөөлөл гэж ойлгогдож байна. Харин Д.Чулуунбаатарын хувьд хуулинд зааснаар хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн төлөөлөл бөгөөд Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн нэгдсэн холбоонд ерөнхий нарийн бичгийн дарга юм. Гэтэл энэ нийгэмлэгийн статус, эрчим хүч хэрэглэгчдийг ямар зарчмаар төлөөлдөг, “Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн үндэсний холбоо” гэдэг байгууллагатай нэг, эсвэл өөр болох эсэх нь тодорхойгүй байна.

2012 оны эхээр болсон энэ сонгон шалгаруулалтыг авч үзэхэд нээлттэй байж чадаагүй, явцыг олон нийтэд зарлаагүй, эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн төв байгууллага болох ЭБЭХЯ-ны үзэмжээр шийдвэрлэгдсэн нь харагдаж байна.

Эрчим хүчний тухай хуулинд ЭХЗХ-ны эрх үүргийг нэгбүрчлэн тодорхойлж, ялангуяа үнэ тогтоох, тусгай зөвшөөрөл олгох асуудлыг хамгийн сайн тусгасан байна. Тухайлбал, үнэ, тариф тогтоох талаар 23 зүйл заасан байх бөгөөд үүнд тариф тогтоох зарчим, тариф, гэрээний үнэ гэсэн үндсэн чиглэлүүдийг хуулиар тогтоож өгчээ.

Эрчим хүчний зохицуулах байгууллагын нийгмийн болон байгаль орчны нөлөөллийг авч үздэг, шийдвэр гаргахдаа холбоотой эрх мэдэл, чиг үүргийг судалж үзэхэд ЭХЗХ-нд тийм бүтэц, хариуцсан хэлтэс, алба, санхүүгийн эх үүсвэр байхгүй. Гэхдээ энэ нь дээрх асуудлыг авч үздэггүй, орхигдсон гэж үзэх нь учир дутагдалтай. Үүний хуулинд өөр механизмаар зохицуулсан байдаг. Юуны өмнө тус байгууллагаас эрчим хүчний салбарт тусгай зөвшөөрөл олгох нэг шалгуур нь Байгаль орчны асуудал хариуцсан яамнаас хийлгэдэг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (БОНБҮ)-ний тайлан юм. Мөн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөө биелүүлээгүй буюу байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд тусгай зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт оруулах шинэчлэх, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох эрхийг эдэлдэг.

Эрчим хүчний тухай хуулинд ЭХЗХ-ны эрх үүргийг нэгбүрчлэн тодорхойлж, ялангуяа үнэ тогтоох, тусгай зөвшөөрөл олгох асуудлыг хамгийн сайн тусгасан байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиар эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалтын төслүүдийн үнэлгээг БОАЖЯ ба аймаг, нийслэлийн ЗДТГ-ууд дараах ангиллаар хариуцан зохион байгуулдаг.

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар
<ul style="list-style-type: none"> - 1 МВт-аас илүү хүчин чадал бүхий эрчим хүчний станц - 35 кв-аас илүү хүчдэл бүхий цахилгаан дамжуулах шугам - дулааны шугам - усан цахилгаан станц - төмөр зам - нисэх буудал - улс, хот хоорондын зам - улс хот хоорондын холбоо 	<ul style="list-style-type: none"> - 1 МВт хүртэл хүчин чадал бүхий эрчим хүчний станц - 35 кв хүртэл хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам - тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд дамжуулах дулааны шугам - орон нутгийн чанартай зам, холбоо

Энэхүү үнэлгээ 2 үе шаттай хэрэгждэг

Үе шат	Шийдвэр
Төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ	Нарийвчилсан үнэлгээ хийх эсэхийг шийдвэрлэнэ.
Төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг эрх бүхий мэргэжлийн компаниар хийлгэнэ.	Төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хянаж батална.

Энэ ажлыг зохион байгуулах процедурийг хуулиар нарийвчлан зохицуулсан байдаг. Ерөнхий үнэлгээг хийж тус яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газрын дарга батална.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг эрх бүхий мэргэжлийн компаниуд хийж гүйцэтгэдэг. Одоогоор Монгол Улсад энэ эрхийг авсан 70 орчим компани үйл ажиллагаа явуулж байна.

Мөн тус яамны дэргэд байгуулагдсан Цэвэр хөгжлийн механизм (ЦХМ)-ын үндэсний товчоо нь НҮБ-ын уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцийн хүрээнд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахтай холбоотойгоор янзбүрийн салбар, тэдгээрийн дотор эрчим хүчний салбарт хамаарах төслүүдэд үнэлгээ өгдөг бас нэг механизм юм. Тус товчооны үнэлгээний хороо өнөөдөр 15 гишүүнтэй эрчим хүчний салбараас Эрдэс баялаг, эрчим хүчний яам, мөн Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв, Монголын эрчим хүчний ассоциаци, Шинжлэх ухаан, технологийн их сургууль (Эрчим хүчний сургууль)-ийн төлөөлөл багтаж байна. Одоогоор эрчим хүчний салбарын нэлээд төсөл үнэлгээнд хамрагдаж батламж бичиг авсан буюу батлуулахаар өргөн мэдүүлжээ.

Эндээс үзэхэд эрчим хүчний салбарын зохицуулалтын хүрээнд сэргээгдэх ба сэргээгддэггүй эрчим хүчний эх үүсвэр, барилга байгууламж, шугам сүлжээг барьж байгуулах төсөл хөтөлбөрийн хэрэгжүүлэх зөвшөөрөл олгож шийдвэр гаргахын өмнө байгаль орчны нөлөөллийг

*Сүүлийн жилүүдэд
эрчим хүчний
шинэ эх үүсвэр
байгуулахтай
холбоотой
зарим томоохон
шийдвэр гаргахад
хөндлөнгийн нөлөө
орсон тохиолдол
ажиглагдсан болно.*

үнэлэх эрх зүйн болоод зохион байгуулалтын механизм манайд бүрдсэн гэж үзэж байна. Энэ механизмын байгаль орчны холбогдолтой элементүүд Эрчим хүчний зохицуулах газарт биш Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон орон нутгийн засаг захиргааны мэдэлд байна.

Гэхдээ сүүлийн жилүүдэд эрчим хүчний шинэ эх үүсвэр байгуулахтай холбоотой зарим томоохон шийдвэр гаргахад хөндлөнгийн нөлөө орсон тохиолдол ажиглагдсан болно.

Жишээлбэл, Өмнөговь аймгийн Цогтцэций суманд Таван толгойн нүүрсний орд газарт “Энержи ресурс” ХХК-ын Ухаа худгийн 18 МВт-ын ДЦС-ыг байгуулах тусгай зөвшөөрлийг олгох томоохон шийдвэр гаргасныг Монгол Улсын эрчим хүчний системийн хөгжлийн бодлоготой уялдаагүй гэсэн шүүмжлэл мэргэжлийн хүмүүс, судлаачдын зүгээс гарч байна.

Хөвсгөл аймгийн Могойн голын нүүрсний уурхайг түшиглүүлэн байгуулахаар төлөвлөөд байсан ДЦС-ыг улс төрийн гэж болох шалтгаанаар байрлалыг нь өөрчилж Завхан аймгийн Тэлмэн суманд байгуулах шийдвэр гаргасан юм. Үүнээс болж Могойн голын нүүрсийг тээвэрлэж хүргэх үед хүнд даацын машинууд газрын хөрсийг их хэмжээгээр эвдэхээр байна.

Мөн Улаанбаатарт барихаар төлөвлөж байгаа ДЦС-5-ын төслийг санал болгохдоо байгаль орчны нөлөөллийн асуудлыг дутуу тооцоолсон тухай шүүмжлэл мэргэжлийн хүмүүс, олон нийтийн зүгээс гарч байна.

Нөгөө талаар эрчим хүчний зохицуулах үйл явцад нийгмийн нөлөөллийг үнэлж шийдвэр гаргахдаа харгалзах эрх зүйн механизм тийм ч тодорхой бус байна. Энд нийгмийн нөлөөлөл гэдэгт зөвхөн үнэ тарифын өсөлт, түүний хэрэглэгчид, ялангуяа эмзэг бүлгийнхэнд үзүүлэх сөрөг нөлөөллийг авч үзэхээс биш ажлын байр, хөдөлмөрийн нөхцөл, орон байр зэрэг бусад нөлөөллийг орхигдуулж байгаа нь учир дутагдалтай юм. Энэ чиглэлээр Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамтай хамтран ажиллах механизм тодорхойгүй байна.

ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ ЯВЦ:

Үндэслэл, ил тод байдал, олон нийтийн оролцоо (ЗҮЯ15- ЗҮЯ27)

2001 оноос эхлэн эрчим хүчний салбарыг зах зээлийн харилцаанд үе шаттайгаар шилжүүлэн эрчим хүчний үнэ тарифын зохицуулалтын улстөр, гүйцэтгэх засаглалаас хараат байдлыг арилгаж, эрчим хүчний үйлдвэрүүд, дамжуулах түгээх сүлжээг эдийн засгийн хувьд бие даасан тогтолцоонд шилжүүлэх, эрчим хүчний үйлдвэрлэгч болон хэрэглэгчдийн эрх ашгийг тэнцвэртэй хангах эрх зүйн болон тогтолцооны үндэс суурийг тавьсан юм. Зохицуулах байгууллагаас эрчим хүчний тариф тогтоох философи, тодорхой аргачлал нь үйлдвэрлэгчид ба хэрэглэгчдийн эрх ашгийг тэнцвэртэй хангах зарчим дээр тулгуурлаж хийгдсэн гэж үзэж байна.

Гэхдээ үүний хэрэгжилт өнгөрсөн жилүүдэд нэлээд шүүмжлэлтэй тулгарч байжээ. Тарифын философи, аргачлалын дагуу тооцож гаргасан тарифыг албан ёсоор баталж мөрдөх болоход хөндлөнгийн буюу олон нийтэд таалагдах гэсэн улс төрийн нөлөө хэт орж үүнийг эрчим хүч

*2010 оны 12 дугаар сард
“Түлш, эрчим хүчний
салбарын талаар
авах зарим арга хэмжээний
тухай” 72-р тогтоол
батлагдсанаар ахуйн
цахилгааны үнэ, тарифыг
шатлалтай болгосон. Энэ нь
бага хэрэглээтэй айл өрхөд
борлуулах цахилгааны үнийг
бага түвшинд үлдээгээд
хэрэглээ ихсэхийн хэрээр үе
шаттайгаар нэмэгдүүлнэ
гэсэн үг юм.*

үйлдвэрлэгчдийн эрх ашгийг хохироож ирсэн гэж салбарын зүгээс үздэг байна. Жишээлбэл, 2001 оны эцэст тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн болон хэрэглэгчдийн эрчим хүчний тарифыг нэмсэн нь хэрэглэгчид, тэдний эрх ашгийг хамгаалдаг төрийн бус байгууллагуудын зүгээс эсэргүүцэлтэй тулгармагц санаачлагыг улс төрчид гартаа авч УИХ-аас ажлын хэсэг томилогдон уг шийдвэрийг шалгаж дүгнэлт гаргаснаар зохицуулагчдын зөвлөл нь гаргасан шийдвэрээ цуцалж байжээ.

Үүнээс ЭХЗГ сургамж авч үнэ тариф батлах үйл ажиллагаанд нарийвчилсан дүн шинжилгээ хийх, олон нийтэд ил тод болгох, тариф батлах үе шатуудыг тодорхой болгох талаар дүрэм журам гаргаж мөрдүүлж 2002 оноос хойш үнэ тарифыг нэлээд дуулиантайгаар хэд хэдэн удаа нэмсэн ч төдийлөн үр дүнтэй байж чадаагүй гэж үздэг. Учир нь зохицуулалтын уян хатан байдал урьдын адил муу, цахилгаан эрчим хүчний үнийн өөрчлөлтийг индексжүүлэх хэлбэрээр ойр ойрхон хугацаанд бага багаар хийдэггүй, цахилгааны үнийг нэмэх шийдвэрийг хэрэглэгчдийн хувьд гэнэт гаргадгийн улмаас олон нийтийн дургүйцлийг төрүүлэх, улс төржих зэрэг сөрөг үр дагаварыг буй болгож, улмаар нийт үнийн өсөлт, инфляцид нөлөөлж байжээ. Бас нийгмийн сэтгэл зүйд хүндээр тусахаас сэргийлж цахилгаан эрчим хүчний үнийг нэмэх шийдвэрийг зарим тохиолдолд зуны цагт, тухайлбал, улсын баяр наадмын өмнөхөн гаргаж байсан нь төр засгийн зүгээс хэрэглэгчдийг мэхлэх оролдлого хэмээн үзэж байжээ.

Тэгсэн хэрнээ эрчим хүчний үнэ тарифыг оновчтой шинэчилж чадахгүй байна, үүнд гол саад тогтор нь Засгийн газар үнэ нэмэх сонирхолгүй, хэрэглэгчдэд илүү ашигтай байдлаар үнэ тарифыг тогтоож ирсэн хэмээн тус салбарын удирдлагууд шүүмжилсэн хэвээр, тодруулбал, иргэдийн орлого бага, ядуурал их байна гэдэг нэрийн дор эрчим хүчний үнийг нэмэхээс байнга татгалзаж ирсэн хэрнээ тэр үнийн зөрүүгээс үүссэн алдагдлыг татаас хэлбэрээр эрчим хүчний салбарт олгож байгаагүйн улмаас эрчим хүчний салбар өөрөө алдагдалтай ажиллаж, улмаар хөрөнгө оруулалт, их засвар, техникийн шинэчлэлээ хийж чадахгүй байна гэдэг байв.

Харин 2008 оноос хойш үнэ тарифын шинэчлэл эрчимтэй явагдаж байгааг хэлэх хэрэгтэй. Эхлээд 2008 оны 11-р сарын 11-нд ЭХЗГ-ын зохицуулагчдын зөвлөлийн 176-р тогтоолоор Төвийн бүсийн эмзэг бүлгийн тарифыг баталж 2009 оны 1-р сарын 1-ээс мөрдөж эхэлжээ. Ингэснээр эмзэг бүлгийнхэн жирийн хэрэглэгчдээс бараг хоёр дахин хямд үнэтэй цахилгаан эрчим хүч хэрэглэх болжээ.

Дараа нь 2010 оны 12-р сард “Түлш, эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай” 72-р тогтоол батлагдсанаар ахуйн цахилгааны үнэ, тарифыг шатлалтай болгосон. Энэ нь бага хэрэглээтэй айл өрхөд борлуулах цахилгааны үнийг бага түвшинд үлдээгээд хэрэглээ ихсэхийн хэрээр үе шаттайгаар нэмэгдүүлнэ гэсэн үг юм. Ингэхдээ айл өрх бүрийн сарын хэрэглээний 150 кВт.ц-ийг одоогийн мөрдөж байгаа үнэ тарифыг индексжүүлэн тооцож, түүнээс дээшхи хэрэглээ болон үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын эрчим хүчний үнэ, тарифыг бодит өртгөөр тооцох, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад чадлын тариф нэвтрүүлэх,

*Баримт мэдээллээс
харахад, сүүлийн
жилүүдэд эрчим
хүчний үнэ,
тарифыг
тасралтгүй
нэмэгдүүлж иржээ.
Гэхдээ эмзэг
бүлгийн хэрэглээнд
хөнгөлөлттэй
тарифыг тусд нь
нэвтрүүлж, үүнийгээ
олон нийтэд нэлээд
сайн сурталчилсан
учраас нийгэмд
бухимдал үүсгэх нь
харьцангуй багассан
гэж үзэж байна.*

эрчим хүчний салбарын компаниудыг 2014 оноос эхлэн зах зээлийн зарчимд шилжүүлэн ажиллуулах бодлого, зохион байгуулалтын арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран авч хэрэгжүүлэхээр заажээ. Өөрөөр хэлбэл 2014 он гэхэд эрчим хүчний салбар алдагдалгүй ажиллах эрх зүйн орчинг бий болсон.

Уг тогтоолоос хойш цахилгаан эрчим хүчний үнэ тарифт үе үе өөрчлөлт орсоор байна.

2011 оны 5-р сарын 1-нээс эхлэн ЭХЗГ-аас төвийн бүсийн хэрэглэгчдэд борлуулах цахилгаан эрчим хүчний үнэ тарифыг 5.3-25% хүртэл нэмэгдүүлсэн юм. Ингэхдээ айл өрхөд хэрэглээгээ зохицуулах замаар цахилгааны төлбөрөө бууруулах боломжийг олгох, үүний тулд шөнийн цагийн эрчим хүчний хэрэглээг дэмжих зорилгоор тарифыг өдрийн цагийнхаас 2 дахин бага байх, хэмнэлтийг дэмжих зорилгоор ахуйн хэрэглэгчдийн сарын хэрэглээний түвшингээс хамаарсан буурах шатлалтай тариф, нийгмийн эмзэг бүлгийн хэрэглэгчдийг үнийн өсөлтийн дарамтаас хамгаалах зорилгоор эмзэг бүлгийн тарифыг шинэчлэн тогтоожээ.

Мөн оны 10-р сарын 2-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар Улаанбаатар хотод агаарын чанарыг сайжруулах бүсэд хамрагдан цахилгаан халаагуур хэрэглэж байгаа өрхийн цахилгааны /зөвхөн ахуйн хэрэглээний зориулалтаар хэрэглэсэн/ үнийг хүйтний улирлын үргэлжлэх хугацаа, цахилгааны шөнийн тариф мөрдөгдөх хугацаатай уялдуулан (хүйтний улиралд оройн 18 цагаас өглөөний 09 цаг хүртэл нийт 15 цаг) 50 хувиар бууруулах шийдвэр гаргажээ. Ингэснээр өмнө нь үйлчилж байсан хугацаа даруй 6 цагаар уртасч, үнийн тариф 2 дахин хямдарсан.

Баримт мэдээллээс харахад, сүүлийн жилүүдэд эрчим хүчний үнэ, тарифыг тасралтгүй нэмэгдүүлж иржээ. Гэхдээ эмзэг бүлгийн хэрэглээнд хөнгөлөлттэй тарифыг тусанд нь нэвтрүүлж, үүнийгээ олон нийтэд нэлээд сайн сурталчилсан учраас нийгэмд бухимдал үүсгэх нь харьцангуй багассан гэж үзэж байна.

Ер нь орлого багатай бүлэгт зориулж эрчим хүчний үнийг доогуур түвшинд барих, цаашилбал алслагдсан аймаг, сум, дүүргийн айл өрхийг эрчим хүчинд холбохын тулд үр ашиг багатай ч хамаагүй эрчим хүчний шинэ эх үүсвэр барьж, дэд бүтэц татах зэрэг нь нэлээд тохиолдолд улс төрийн шийдвэр байдаг бөгөөд УИХ, эсвэл Засгийн газраас үүрэг, чиглэл өгсний дагуу салбарын яамнаас уг асуудлыг боловсруулж, улмаар ЭХЗГ-аар дамжуулан хэрэгжүүлж ирсэн гэж ойлгогдож байна.

Үүнийг ЭХЗХ-ноос аливаа шийдвэр гаргасан үндэслэлээ бүрэн гүйцэт тайлбарлах боломжгүй, улмаар шийдвэр гаргах үйл явц хаалттай, олон нийтийн оролцоо маш хангалтгүй явж ирсний нэг гол шалтгаан гэж үзлээ. Тус байгууллага нэлээд сайн вэб сайт ажиллуулдаг, гаргасан шийдвэрээ харьцангуй шуурхай мэдээлдэг боловч шийдвэр гаргахаас өмнөх буюу аж ахуйн нэгж, байгууллагуудаас ямар зөвшөөрөл хүссэн, түүний үндэслэл, танилцуулга, техник, эдийн засгийн үндэслэл, БОНБУ, зохицуулах хороогоор хэрхэн авч хэлэлцсэн, ямар шатанд яваа, нутгийн иргэд, олон нийтийн байр суурь зэрэг явцын мэдээллийг нээлттэй

*Үнэ тарифын
зохицуулалтын ил тод
байдал зохих хэмжээнд
хангагдаж чадахгүй байна.*

болгохгүй, зөвхөн шийдвэр гаргасныхаа дараа мэдээлдэг. Энэ утгаараа үнэ тарифын зохицуулалтын ил тод байдал зохих хэмжээнд хангагдаж чадахгүй байна.

ЭХЗХ-нд нууц, хаалттай баримт бичиг байхгүй гэдгийг тус байгууллагын ажилтнууд нотолж байгаа боловч зохицуулагчдын хурлын тэмдэглэл нээлттэй биш байна. “Зохицуулагчдын зөвлөлийн хуралдааны журам”, “ЭХЗГ-т хандсан гомдол, маргааныг бүртгэх, шийдвэрлэх журам”, “Олон нийтийн хэлэлцүүлэг явуулах журам”-д зааснаас харахад, зохицуулах үйл ажиллагаа нь нээлттэй бөгөөд зохицуулагчдын зөвлөлийн хурлын талаар мэдээлэл авах, олон нийтийн хэлэлцүүлэгт оролцож, санал хүсэлтээ гаргаж шийдвэрлүүлэх, тухайлбал өргөтгөсөн хуралд оролцох боломжтой байхаар заасан боловч чухам яаж оролцож болох талаар тодорхой заагаагүй бөгөөд өнгөрсөн хугацаанд иргэд хэрхэн оролцсон тухай мэдээлэл алга байна.

Ийм нөхцөлд ЭХЗХ-ны зохицуулагчдын зөвлөлд зөвлөх үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагаа анхаарал татаж байна. Уг зөвлөл нь Монгол улсын Эрчим хүчний тухай хуулийн дагуу зохицуулагчдын зөвлөлөөс хэрэглэгч, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эрх ашгийг хөндсөн аливаа асуудлыг шийдвэрлэхэд зөвлөгөө өгөх, хэрэглэгч, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийг төлөөлөн байр сууриа илэрхийлэх зорилготойгоор 2002 онд байгуулагджээ. Зөвлөлийн үйл ажиллагааг зөвлөлийн хурлаас сонгогдсон дарга удирдаж нарийн бичгийн даргын үүргийг ЭХЗГ-ны мэргэжилтэн гүйцэтгэдэг. Хамгийн сүүлд ЭХЗГ-ын Зохицуулагчдын зөвлөлийн даргын 2010 оны 12-р сарын 20-ны өдрийн тушаалаар дараах хүмүүсийг баталжээ. Үүнд:

Зөвлөлийн дарга:

Х.Ганбаатар Монголын ажил олгогч эздийн холбооны гүйцэтгэх захирал

Зөвлөлийн нарийн бичгийн дарга:

Д.Наранцэцэг Эрчим хүчний зохицуулах газрын хүний нөөц, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн

Зөвлөлийн гишүүд:

Х.Амгаланбаатар Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооны дэд ерөнхийлөгч

Д.Дэлгэрмаа “ЖЕНКО” группын гүйцэтгэх захирал

Ц.Тэрбиш Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын ажилтан

Хууль хяналт, зохицуулалтын газрын мэргэжилтэн

Б.Цэвээн - “ДЦС-4” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал

Ч.Саранжав “УБЦТС” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал

Д.Бямба-Очир “УБДС” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал

Д.Дашзэвэг ОСНААГ-ын дарга

Гэхдээ тус зөвлөл өнгөрсөн хугацаанд хэрхэн ажилласан, хэлэлцсэн асуудал, ямар байр суурь илэрхийлсэн талаар мэдээлэл ил тод биш байна. Бүрэлдэхүүнийг холбогдох байгууллага, хүмүүстэй зөвшилцсөний үндсэн дээр бүрдүүлдэг гэж байгаа боловч энэ үйл явц бас хаалттай, тэднийг хэрхэн дэвшүүлж сонгосон тухай мэдээлэл бас алга байна.

Эрчим хүчний зохицуулалтын үйл явцыг хэрэглэгчид, төрийн бус байгууллагуудаас гадна салбарын удирдлага, мэргэжилтнүүд, эрчим хүчний компани, аж ахуйн нэгж, байгууллагуудын зүгээс байнга шүүмжилдэг. “Өнгөрсөн жилүүдэд шинээр гарч ирсэн Засгийн газрууд Монгол улсын нийгэм эдийн засгийн хөгжил дорой байна, хүмүүсийн орлого бага байна гэдэг нэрийн дор эрчим хүчний үнийг нэмэхээс байнга татгалзаж ирсэн. Эрчим хүчний үнийг барьж ирсэн хэрнээ тэр үнийн зөрүүгээс үүссэн алдагдлыг татаас хэлбэрээр эрчим хүчний салбарт олгож байгаагүй. Тэгэхээр эрчим хүчний салбар өөрөө алдагдалтай ажиллаад тухайн жилдээ хийх ёстой их засвар, техник, зохион байгуулалтынхаа ажлыг хийж чадахгүй болсон” гэж ЭБЭХ-ний дэд сайд Т.Энхтайван ярьсныг болон бусад олон жишээг татаж болох юм.

Гэтэл үүний цаана эрчим хүчний салбар, компаниуд үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, өртөг зардлыг хямдруулах, үргүй зардлыг бууруулах талаар ямар боломж байгаа талаар дорвитой яриа хөөрөө өрнөхгүй байна. Олон нийтийн дунд тус салбарыг Монгол Улсад олгож гаднын зээл тусламжийн нэлээд хувийг авч зарцуулсан, худалдан авалт, тендерийг маш өндөр өртөгтэйгээр явуулдаг, ажиллагсдын дундаж цалин өндөр, нийгмийн хамгаалал, шагнал урамшуулал бусад салбараас хэт түрүүлсэн гэсэн ойлголт нийгэмд түгээмэл байна.

ЭБЭХЯ, ЭХГ, ЭХЗХ болон салбарын компани, аж ахуйн нэгжүүд эрчим хүчний үнэ, тариф болон салбарын бодит байдлыг ойлгуулах талаар нэлээд ажил зохиож байгаа ч эрчим хүчний асуудлаар олон нийтийн мэдлэг, боловсрол хангалтгүй хэвээр байна. Үүний шалтгаан нь ийм чадавхийг бүрдүүлэх, сургалт сурталчилгаа зохион байгуулах ажил хангалтгүй байгаагаас илүүтэйгээр эрчим хүчний зохицуулах үйл явцад иргэний нийгэм болон иргэдийн оролцоо сул байгаатай холбоотой гэж үзлээ. Нэгэнт оролцоо сул учраас ЭХЗХ-ны мэдээлэл хэдийгээр ил тод байдаг боловч тэр мэдээ тайлан, аргачлал болон бусад бичиг баримтыг сайн дураараа очоод үзэж танилцаж байгаа хүний тоо маш хангалтгүй байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АСУУДЛУУД:

Зарчим, гүйцэтгэх үүрэг, тайлагнал (ЗҮЯ28 - ЗҮЯ32)

ЭХЗХ-ноос боловсруулж гаргасан дүрэм журмыг үзэхэд тариф тогтоох үйл явцыг нарийвчилсан дүн шинжилгээний үндсэн дээр явуулах хууль эрх зүйн орчныг бүрдүүлсэн гэж дүгнэж болохоор байна. Үнэ тарифын сөрөг нөлөөллийг бууруулах хамгийн үр дүнтэй арга зам бол индексжүүлэх, мөн зохицуулах байгууллагын хараат бус байдлыг бэхжүүлэх явдал юм. Эрчим хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль энэ зорилгод үйлчилж байна гэж үзлээ.


ЭХЗХ-ны бүхий л үйл ажиллагаа, тэдгээрийн дотор тусгай зөвшөөрөл олгох асуудал нэлээд сайн журамлагдсан боловч тусгай зөвшөөрөл эзэмшихийг хүссэн хуулийн этгээдийн өргөдлийг хянах, шийдэх шалгуур үзүүлэлтүүдийн талаархи заалт маш бүрхэг байна. Тухайлбал, тусгай

зөвшөөрлийг санхүүгийн чадавхитай, тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан буюу явуулах боломжтой хуулийн этгээдэд олгох гэсэн заалтууд нь маш ерөнхий, үүнийг нарийвчилсан шалгуур үзүүлэлтүүд байхгүй.

ЭХЗГ нь тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааг хянах, үнэлэлт, дүгнэлт өгөх зорилгоор тэдгээрийн үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг сар, улирал бүр, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилтийн тайланг жил бүр авч үнэлэлт, дүгнэлт өгч, хяналт тавин ажилладаг. Ялангуяа эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын рейтингийг хагас жил, жилээр тогтоож зарладаг нь анхаарал татаж байна.

Зураг 2.

Зохицуулах үйл явцын үнэлгээ (0-5 оноогоор)



ЗОХИЦУУЛАХ ҮЙЛ ЯВЦЫН ЗӨВЛӨМЖҮҮД

Нэг

Эрчим хүчний зохицуулах хорооны таван зохицуулагчийг (орон тооны гурав, орон тооны бус хоёр) томилох үйл явцыг ил тод, нээлттэй болгож юуны өмнө Худалдаа, аж үйлдвэрийн танхим ба Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгээс орон тооны бус хоёр зохицуулагчид нэр дэвшүүлэх журмыг илүү тодорхой болгож, ингэхдээ хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг гэдгийг статус нь тодорхойгүй ганц байгууллагаар төлөөлүүлэхгүй байх, бусад ижил төстэй байгууллагуудтай зөвлөлдөх, сонгох шалгуурыг нарийвчлах, хуулийн дагуу Ерөнхий сайдад батлуулахаар өргөн барьсан нэр дэвшигч буюу дэвшигчдийг зарлаж байх зэрэг ил тод байдлын наад захын шаардлагуудыг хангах ёстой.

Хоёр.

ЭХЗХ-ны зохицуулагчдын зөвлөлд зөвлөх үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг холбогдох байгууллага, хүмүүстэй зөвшилцсөний үндсэн дээр бүрдүүлдэг гэж байгаа боловч хэрхэн зөвшилцсөн, нэр дэвшүүлж томилсон тухай мэдээлэл алга байгааг дэлгэх шаардлагатай.

Хуулинд зааснаар тус зөвлөлийг тэнцүү төлөөллөөр бүрдүүлэх ёстой тусгай зөвшөөрөл эзэмшигч ба хэрэглэгч гэсэн ойлголтуудыг тодруулж талуудын жигд төлөөлөл, ялангуяа хэрэглэгчид тэр тусмаа эцсийн хэрэглэгчид болон орон нутгийн оролцоог хангах нь зүйтэй байна. Тус зөвлөл одоогоор найман хүнтэй байгааг нэмэгдүүлэх боломж хуулинд бий гэж үзэж байна. Зөвлөлийг шинэчлэх буюу өргөжүүлэхдээ олон нийтэд мөн адил ил тод зарлаж хэрэглэгчдийн болон олон нийтийн бусад байгууллагуудын зүгээс нэр дэвшүүлэх боломжийг олгох зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна.

Цаашдаа ус зөвлөлийн хуралдааныг тогтсон хуваарийн дагуу тогтмол явуулж байх, хэлэлцсэн асуудал, хуралдааны тэмдэглэл, ЭХЗХ-нд хандаж гаргасан санал, зөвлөмжүүдийг олон нийтэд ил тод болгох, тэдгээрийн нөлөөлөл, үр дүнг тайлагнах процедурийг Олон нийтийн зөвлөлийн журманд оруулж шинээр боловсруулж гаргахыг санал болгож байна.

Гурав

Эрчим хүчний тухай хуулийн “Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах байгууллага эрчим хүчний хангамж, мөрдөж байгаа үнэ, тарифын үндэслэлд олон нийтийн хяналт тавина” гэсэн заалтыг хэрэгжүүлэх үр дүнтэй механизм бий болгохын тулд тус салбар дахь иргэний нийгмийн байгууллагуудын идэвх санаачлагыг өрнүүлэх шаардлагатай байна. Юуны өмнө тус хорооноос зохицуулагчдын хурлыг зөвхөн зарлаад орхих биш төрийн бус байгууллагуудыг нэр зааж буюу ээлж дараалан урьж оролцуулж хэвшихийг санал болгож байна.

Дөрөв

Сонирхогч хуулийн этгээд эрчим хүчний салбарт тусгай зөвшөөрөл авахаар ЭХЗХ, аймаг, нийслэлийн зохицуулах хороонд өргөдөл гаргаснаас эхлээд зөвшөөрөл олгох, эсвэл эрчим хүчний үнэ тарифт өөрчлөлт оруулах санал боловсруулахаас эхлээд шийдвэр гаргаж зарлах хүртэлх бүхий л үйл явцын туршид ил тод, нээлттэй байдлыг хангах хэрэгтэй. Энэ бол эрчим хүчний зохицуулалтад олон нийт, хэрэглэгчдийн оролцоог бий болгох үндсэн нөхцөл гэж үзэж байна. Онцолж хэлэхэд, ЭХЗХ-ны хуралдааны тэмдэглэлийг нээлттэй болгож олон нийтийн зүгээс хяналт тавих, байр сууриа илэрхийлж байх боломжийг хангах цаг болсон байна.

Тав

Эрчим хүчний шинэ эх үүсвэр байгуулах, шугам сүлжээ татах, үнэ тарифт өөрчлөлт оруулахад нөлөөлж ирсэн улс төрчид, улс төрийн намуудын сонгуулийн амлалт, түүнд хөтлөгдсөн Засгийн газрын дарамт шахалтыг багасгахад чиглэсэн үр дүнтэй механизмыг бий болгох шаардлагатай. Энэ нь аливаа шийдвэрийн талаар мэргэжлийн байгууллага, судлаачдын өргөн оролцоотой хэлэлцүүлэг өрнүүлэх замаар ил тод, нээлттэй байдал, олон нийт, хэрэглэгчдийн оролцоо, дэмжлэгийг хангасан нөхцөлд хэрэгжих боломжтой юм.

Тухайлбал, зохицуулалтын шийдвэр гаргах үйл явцыг ил тод болгохдоо зөвхөн хурлын зарыг нийтэлж, дараачийн үйл явцыг алгасаад зөвхөн гарсан шийдвэрийг мэдээлснээр хязгаарлаж байгааг өөрчилж тухайн шийдвэр гаргах үйл явцыг бүхэлд нь, тухайлбал, шийдвэр гаргахад ашигласан танилцуулга, судалгаа, хөндлөнгийн санал дүгнэлт, хэлэлцүүлгийн явцыг эхнээс нь дуустал нээлттэй болгож, хуралдааны тэмдэглэлийг хүссэн этгээд үзэж танилцах боломжоор хангах нь чухал байна. Мөн тодорхой хүчин чадлаас дээш, жишээлбэл 10МВт-аас дээш хүчин чадалтай эрчим хүчний эх үүсвэр барих, мөн хэрэглэгчдийн тариф нэмэгдүүлэх шийдвэр гаргахдаа тухайн орон нутгийн иргэдэд танилцуулж хэлэлцүүлэг өрнүүлдэг байх журмыг Эрчим хүчний зохицуулах хорооноорс гаргах нь зүйтэй гэж үзэж байна.

Зургаа

Эрчим хүчний зохицуулах хороо нь эрчим хүчний үйлдвэрлэл, барилга байгууламж болон хэрэглээнээс байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг өөрөө шууд үнэлж дүгнэдэггүй, энэ эрх үүрэг БОАЖЯ ба орон нутгийн засаг захиргаанд хамаардаг хэдий ч цаашид тус байгууллагад байгаль орчны нөлөөллийн асуудлаархи үнэлгээ, дүгнэлтэнд цаг алдалгүй илүү анхаарал хандах, олон нийт, ялангуяа нутгийн иргэдийн санал хүсэлтийг харгалзаж тэдэнтэй хамтран ажиллахад чиглэсэн зохих чадавхи, механизмыг бий болгох нь зүйтэй. Ийм шаардлага байгаа нь Улаанбаатар хотод 5-р цахилгаан станц, түүнийг барьж байгуулахаар сонгож авсан байрлалуудыг тойрсон маргаан хэлэлцүүлгээс харагдаж байна. Томоохон цахилгаан станц, ялангуяа сүүлийн үед шинээр баригдаж байгаа усан болон салхин цахилгаан станцын төслүүд энэ чиглэлээр бүр тодорхой ажиллах шаардлагатай.

Долоо

Эрчим хүчний салбарт үнэ тарифыг зах зээлийн зарчмаар тогтоохгүй, хүчээр барьж ирсний улмаас эрчим хүчний компаниудын санхүү, эдийн засгийн чадавхи хангалтгүй, алдагдалтай ажилладаг тухай талаар байнга гардаг шүүмжлэлд олон өнцгөөс нухацтай хандах хэрэгтэй.

Эрчим хүчний үнэ тарифт өөрчлөлт оруулах ээлжит зохицуулалтын өмнө тооцоо судалгаа хийхдээ эрчим хүчний үйлдвэрлэл, түгээлт эрхэлдэг компани, аж ахуйн нэгжүүд өөрийн өртөг зардал, үргүй зардал, алдагдлаа

бууруулах талыг орхигдуулахгүй байх, тийм хөшүүрэг бий болгоход чиглэсэн механизм бүрдүүлэхийг анхаарах ёстой. Монополь салбарын хувьд энэ нь онцгой ач холбогдолтой юм.

Юуны өмнө өртөг зардлын мэдээлэл, гаднын зээл тусламжийн зарцуулалт, худалдан авалт, тендерийн үйл ажиллагааны явц, үр дүнг олон нийт, судлаачдад байнга нээлттэй болгох нь эхний алхам байх болно. Тэгвэл хөрөнгө, мөнгөтэй холбоотой янз бүрийн алдаа дутагдал, үрэлгэн байдал, үр ашиг муутай зарцуулалтыг багасгах хөшүүрэг болохын зэрэгцээ олон нийтийн дунд байдаг хардлага сэрдлэг, зөв буруу ойлголтуудыг залруулах ач холбогдолтой.

Үүний хажуугаар эрчим хүчний үр ашигтай хэрэглээ, хэмнэлтийн асуудлыг хүчтэй ярьж эхлэх цаг болжээ. Одоо боловсруулж байгаа Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлж эхлэхийг уриалж байна.

Найм

Сүүлийн жилүүдэд эрчим хүчний салбарт хувийн хэвшлийн оролцоо аажмаар нэмэгдэж, концессын гэрээгээр бие даасан олон эх үүсвэр, барилга байгууламж бий болохын зэрэгцээ УИХ-ын 72-р тогтоолын дагуу эрчим хүчний компаниудыг 2014 оноос зах зээлийн харилцаанд бүрэн шилжүүлж алдагдалгүй ажиллуулахаар шийдвэрлэсэн нөхцөлд ялангуяа үнэ тарифын зохицуулалтын механизмыг үргэлжлүүлэн боловсронгуй болгох нь зайлшгүй юм.

Үүний тулд хамгийн түрүүнд Монгол Улс дахь эрчим хүчний үнэ тарифын зохицуулалтын тогтолцоо, шийдвэр гаргадаг журам, процедур, өмнөх жилүүдэд үнэ тарифт өөрчлөлт оруулсан үйл явдлуудын түүх, сургамжийг үнэлж дүгнэхийн зэрэгцээ ойрын жилүүдийн нөхцөл байдал, чиг хандлага, шаардагдах арга хэмжээ, үе шатуудыг УИХ-ын 72-р тогтоолын заалтуудтай уялдуулан тодорхойлох хэрэгтэй байна.

Үүнийг олон нийт, эцсийн хэрэглэгчид, ялангуяа эмзэг бүлгийнхэн, хөдөө орон нутгийн иргэдэд гарын авлага, танилцуулга болон бусад хэлбэрээр хүргэж одооноос танилцуулж ойлгуулах, гарч болзошгүй аливаа хүндрэл бэрхшээл, тэдгээрийг шийдвэрлэх арга замуудыг хамтран хэлэлцэх, тийм механизмыг бий болгох талаар өргөн хүрээтэй ажил өрнүүлэхийг санал болгож байна.



Асуулгын хариултууд:
**БОДЛОГЫН
ҮЙЛ ЯВЦ**



БҮЯ1. ХУУЛЬ ТОГТООХ ХОРООНЫ ЭРХ ЗҮЙН ЧАДАМЖ

Чанарын элементүүд	Тайлбар
Мэдлэг олох боломж	T Эрчим хүчний салбарын асуудлыг хамаардаг УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны гишүүд нь цахилгаан эрчим хүчний салбарын бодлогын чанартай асуудалтай холбоотой баримт бичгүүдийг олж авах, тэдгээрийг хянаж судлах боломж нь хангалттай байдаг.
Мэдлэгээ сайжруулах боломж	Y Хорооны гишүүдэд зориулсан тусгайлсан сургалт, семинар явуулдаггүй. Мэдлэгээ сайжруулах боломж бий боловч ихэнх гишүүд асуудалд мэргэжлийн гэхээсээ илүү байгаа мэдээлэлдээ тулгуурлан ханддаг.
Санхүүгийн эх сурвалж	T Одоогоор хорооны дэргэд бие даасан тусдаа судалгааны нэгж байхгүй. Харин УИХ-ын тамгын газрын дэргэд Судалгааны төв байдаг бөгөөд хорооны гишүүдийн хүссэн мэдээлэл болон хүссэн судалгааг хариуцан хийдэг байна. Санхүүжилт нь УИХ-ын төсвөөс гардаг.
Эрх мэдэл	T Эрчим эрчим хүчтэй холбоотой эрх зүйн баримт бичгийг хэлэлцэхдээ шаардлагатай тодруулга болон лавлагааг холбогдох яам, зохицуулагч болон хэрэгжүүлэгч агентлагуудаас гаргуулан авдаг. Мөн цахилгаан эрчим хүчний хуулийг боловсруулагч ажлын хэсгийнхнээс шаардлагатай мэдээллийг гаргуулж авах эрх мэдэл хангалттай байдаг. Тухайлбал, байнгын хорооны гишүүн тухайн салбарын сайдаас сонирхсон асуултаа бичгээр шууд гаргуулж авах бүрэн эрх мэдэлтэй.

Тайлбарын үргэлжлэл:

Одоогоор Монгол Улсын хууль тогтоох дээд байгууллага болох УИХ-д эрчим хүчний салбарын асуудлыг дагнаж хариуцсан тусдаа байнгын хороо байхгүй бөгөөд энэ асуудал Эдийн засгийн байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд багтдаг. Тус байнгын хороо нь нийт 24 багц асуудал хариуцан ажилладаг ба түүний нэг багц нь "түлш эрчим хүч" юм.

2008-2012 онд тус байнгын хорооны гишүүнээр З.Алтай, Х.Бадамсүрэн, Д.Балдан-Очир, Б.Батбаяр, Н.Батбаяр, Ж.Батсуурь, Я.Батсуурь, Г.Батхүү, Ц.Баярсайхан, Р.Буд, С.Бямбацогт, Л.Гантөмөр, Д.Ганхуяг, Д.Дамба-Очир, Ц.Дашдорж, Д.Зоригт, Д.Одхүү, Р.Раш, А.Тлейхан, Д.Тэрбишдагва, Ц.Цэнгэл нарын 21 гишүүн харьяалагддагаас эрчим хүчний салбарын мэргэжилтэй болон тус салбарт ажиллаж байсан Батж.Батбаяр, Д.Дамба-Очир, А.Тлейхан, Ц.Цэнгэл нарын дөрвөн гишүүн, мөн Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт өөрөө багтдаг. Энэ нь байнгын хорооны нийт гишүүдийн 20 орчим хувийг эзэлж байна. Монгол Улсын парламент нийт 76 гишүүнтэйг харгалзвал хангалттай биш гэж хэлэхэд хэцүү. Ялангуяа А.Тлейхан, Ц.Цэнгэл нар орон нутгийн тойргоос сонгогдсон ч салбарынхантайгаа байнгын холбоотой байж ямар нэг хэмжээгээр салбарын төлөөлөл болж ажилласан юм.

Эдийн засгийн байнгын хорооны үйл ажиллагааг хангадаг ажилтнуудын дунд эрчим хүчний мэргэжлийн хүн байхгүй, харин УИХ-ын тамгын газрын судалгааны төвд нэг хүн байна.

УИХ-ын гишүүд Эрчим хүчтэй холбоотой эрх зүйн баримт бичгийг хэлэлцэхдээ шаардлагатай тодруулга болон лавлагааг холбогдох яам, хэрэгжүүлэгч агентлаг болон зохицуулагчаас гаргуулан авдаг. Тухайлбал, байнгын 2011 онд Эрчим хүчний хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийн үеэр хорооны гишүүн тухайн салбарын сайдаас сонирхсон асуултаа бичгээр шууд гаргуулж авах эрх мэдлээ хэд хэдэн удаа ашиглажээ.

Үнэлгээ:	Сонгох:
Хамаарахгүй/ үнэлээгүй	–
Хууль тогтоох хороогоор дамжуулан хяналт тавих механизм байхгүй эсвэл хороо байгаа ч чанарын дөрвөн элементийн алийг ч хангаагүй	Доод _
Хууль тогтоох хороогоор дамжуулан эрх зүйн хяналт тавих механизм байгаа ч чанарын зөвхөн нэг элементийг хангасан	Доодоос-дунд _
Хууль тогтоох хороогоор дамжуулан эрх зүйн хяналт тавих механизм байгаа ч чанарын үзүүлэлтийн зөвхөн хоёр элементийг хангасан	Дунд _
Хууль тогтоох хороогоор дамжуулан эрх зүйн хяналт тавих механизм байгаа ч чанарын үзүүлэлтийн зөвхөн гурван элементийг хангасан	Дундаас дээш ✓

Хууль тогтоох хороогоор дамжуулан эрх зүйн хяналт тавих механизм Дээд _
байгаа ч чанарын үзүүлэлтийн бүх дөрвөн элементийг хангасан

Мэдээллийн эх сурвалж: -УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны дарга Д.Зоригтод албан бичиг явуулаад албан ёсоор хариу аваагүй боловч түүний дагуу янз бүрийн эх сурвалжаас цуглуулсан мэдээлэл
-УИХ-ын <http://www.parliament.mn> вэб сайт
-Хууль, эрх зүйн мэдээллийн www.legalinfo.mn сайт
-ЭБЭХЯ-нд явуулсан албан бичгийн дагуу тус яамны Эрчим хүчний бодлогын газрын орлогч дарга Д.Пүрэвбаяртай хийсэн ярилцлага
-Эрчим хүчний газарт явуулсан албан бичгийн хариу

Нэмэлт мэдээлэл: ЭБЭХЯ-нд явуулсан албан бичгийн хариу
ЭБЭХЯ-ны Эрчим хүчний бодлогын газрын орлогч дарга Д.Пүрэвбаяртай хийсэн ярилцлага
Эрчим хүчний газарт явуулсан албан бичгийн хариу

БҮЯ2. ЭРЧИМ ХҮЧНИЙ ХУУЛЬ ТОГТООХ ХОРООНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДЛУУДЫГ ҮНЭЛЭХ ЧАДАВХИ

Чанарын элементүүд	Тайлбар
Хамаарах мэдлэг, чадавхи	Ү Хорооны гишүүдийн эзэмшсэн дээд боловсрол болон ажлын туршлага зэргийг судлахад байгаль орчны чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн гишүүн Эдийн засгийн байнгын хороо төдийгүй Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны аль алинд нь байхгүй, харин энэ салбарт ажиллаж байсан гишүүн нэг, одоогийн Байгаль орчин, аялал жуулчлалын сайд (2012 оны 2-р сар хүртэл), мөн Ногоон намын төлөөлөл нэг тус тус байна.
Тусгайлан томилсон албан тушаалтан	Ү Одоогийн бүтцээр хууль тогтоох дээд байгууллага буюу парламентийн гишүүд нь 7 байнгын хороо, 1 түр хороо, 8 дэд хороонд харьяалагдан хууль боловсруулах батлах үйл ажиллагаанд оролцож байна. Эдийн засгийн байнгын хороо болон байгаль орчин хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооны аль алинд нь цахилгаан эрчим хүчний байгаль орчны асуудлыг тусгайлан хариуцсан албан тушаалтан, ажилтан байхгүй. Мөн эрчим хүчний салбарын бодлого, үйл ажиллагааны хүрээнд байгаль орчны асуудлыг шийдвэрлэхэд оролцох тодорхой үүрэг хүлээсэн гишүүн албан ёсоор байхгүй.
Тусгайлан зориулсан санхүүгийн нөөц эх үүсвэр	Ү Байгаль орчны асуудлаар судалгаа, шалгалт хийхэд зориулсан төсвийн тусгай эх үүсвэр байхгүй ба харин хорооны гишүүд байгаль орчны тодорхой асуудлаар УИХ-ын тамгын газрын дэргэдэх Судалгааны төвд захиалга өгөн хийлгэдэг.
Байгаль орчны асуудлуудаар өөрсдийн мэдлэгийг сайжруулах байдал	Ү Хорооны гишүүдэд зориулсан сургалт семинар явуулах механизм байдаггүй. Харин гишүүдийн туслахуудад зориулсан сургалт семинар явагддаг хэдий ч байгаль орчны чиглэлийн сургалт семинар байгаагүй.

Тайлбарын үргэлжлэл:

Эрчим хүчний салбарын бодлогод хамаарах байгаль орчны асуудлыг Эдийн засгийн байнгын хорооны хариуцсан 25 багц болон Байгаль орчин хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооны 17 багц эрхлэх асуудлын хүрээний аль алинд нь тусгайлан заагдаагүй байна. Гэхдээ эрчим хүчний бодлого боловсруулах, хууль тогтоомжийн төслийг хэлэлцэх шатанд Байгаль орчны асуудал эрхэлсэн байнгын хороогоор оруулах боломжтойгоос гадна нэлээд гишүүнд хоёуланд нь зэрэг хамрагддаг юм.

УИХ-ын Тамгын газрын захиргаа, боловсон хүчний хэлтсийн үйл ажиллагааны чиглэлд УИХ-ын гишүүдэд бус харин Тамгын газрын ажилтнууд болон гишүүдийн туслахууд, бие төлөөлөгч-туслахуудын мэдлэг чадварыг дээшлүүлэх, давтан сургах, гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, олон улсын байгууллага, их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран гадаад, дотоод сургалтууд зохион байгуулах асуудал орсон байна. Гэхдээ эрчим хүчний асуудлаар сургалт хийгдсэн эсэх тухай мэдээлэл бидэнд олдоогүй.

Байнгын хорооны гишүүдэд зориулсан сургалт семинар явуулах механизм байхгүй байгаа нь эрчим хүчний зэрэг нарийн түвэгтэй хууль тогтоомжийн чанарт нөлөөлөх магадлалтай. Мөн Байнгын хорооны зүгээс санаачлан эрчим хүч, байгаль орчны чиглэлээр олон нийтийн хэлэлцүүлэг явуулаагүй байна.

Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй	-
Хамаарах хууль тогтоомжийн хороо нь байгаль орчны асуудалд үнэлгээ хийх чадавхитай холбоотой ямар нэгэн элементийг хангаагүй.	Доод ✓
Хамаарах хууль тогтоомжийн хороо нь байгаль орчны асуудалд үнэлгээ хийх чадавхитай холбоотой нэг элементийг хангасан.	Дунд _
Хамаарах хууль тогтоомжийн хороо нь байгаль орчны асуудалд үнэлгээ хийх чадавхитай холбоотой хоёр болон түүнээс дээш тооны элементийг хангасан.	Дээд _

Мэдээллийн эх сурвалж: -УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны дарга Д.Зоригтод албан бичиг явуулаад албан ёсоор хариу аваагүй боловч түүний дагуу янз бүрийн эх сурвалжаас цуглуулсан мэдээлэл
-ЭБЭХЯ-нд явуулсан албан бичгийн дагуу тус яамны Эрчим хүчний бодлогын газрын орлогч дарга Д.Пүрэвбаяртай хийсэн ярилцлага
-Эрчим хүчний газарт явуулсан албан бичгийн хариу
-УИХ-ын <http://www.parliament.mn> вэб сайт
-Хууль, эрх зүйн мэдээллийн www.legalinfo.mn сайт

Нэмэлт мэдээлэл:

БҮЯЗ. ЭРЧИМ ХҮЧНИЙ ХУУЛЬ ТОГТООХ ХОРООНЫ НИЙГМИЙН АСУУДЛУУДЫГ ҮНЭЛЭХ ЧАДАВХИ

Чанарын элементүүд	Тайлбар
Хамаарах мэдлэг, чадавхи	T УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооноос Эрчим хүчний салбарт хамаарах нийгмийн асуудлыг авч үзэх гишүүдийн мэдлэг, чадавхи хангалттай түүнийг боловч үр дүндтэй ашиглах механизм бүрэлдээгүй гэж үзлээ.
Тусгайлан томилсон албан тушаалтан	Y Эдийн засгийн байнгын хороо болон УИХ-ын нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд эрчим хүчний салбарт хамаарах нийгмийн асуудлыг хариуцах үүрэг хүлээсэн гишүүн, тусгайлан томилсон албан тушаалтан байхгүй.
Тусгайлан зориулсан санхүүгийн нөөц эх үүсвэр	Y Тусгайлан эх үүсвэр байхгүй. Шаардлагатай тохиолдолд УИХ-ын нийт төсвөөс гаргах боломжтой
Нийгмийн асуудлуудаар өөрсдийн мэдлэгийг сайжруулах байдал	Y Хорооны гишүүдэд зориулсан сургалт семинар явуулах механизм байдаггүй. Харин гишүүдийн туслахуудад зориулсан сургалт семинар явагддаг хэдий ч нийгмийн чиглэлээр сургалт семинар байгаагүй.
<p>Тайлбарын үргэлжлэл:</p> <p>Эрчим хүчний салбарын бодлогод хамаарах нийгмийн хүчин зүйл, нөлөөллийн асуудал УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны 25 багц болон Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны 10 багц эрхлэх асуудлын хүрээний аль алинд нь тусгайлан заагдаагүй байна. Гэхдээ нийгмийн асуудал бол Монгол улсад эрх барьж буй улс төрийн намуудын бодлогын цөм учраас УИХ-ын гаргаж байгаа эрчим хүчний бодлогод эрчим хүчний салбарт хамаарах нийгмийн асуудал, шаардлагууд зохих тусгалаа олдог.</p>	
Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй	-
Хамаарах хууль тогтоомжийн хороо нь нийгмийн асуудалд үнэлгээ хийх чадавхитай холбоотой ямар нэгэн элементийг хангаагүй.	Бага _
Хамаарах хууль тогтоомжийн хороо нь нийгмийн асуудалд үнэлгээ хийх чадавхитай холбоотой нэг элементийг хангасан.	Дунд ✓
Хамаарах хууль тогтоомжийн хороо нь нийгмийн асуудалд үнэлгээ хийх чадавхитай холбоотой хоёр болон түүнээс дээш тооны элементийг хангасан.	Өндөр _
Мэдээллийн эх сурвалж:	<ul style="list-style-type: none"> - УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны дарга Д.Зоригтод албан бичиг явуулаад албан ёсоор хариу аваагүй боловч түүний дагуу янз бүрийн эх сурвалжаас цуглуулсан мэдээлэл - ЭБЭХЯ-нд явуулсан албан бичгийн дагуу тус яамны Эрчим хүчний бодлогын газрын орлогч дарга Д.Пүрэвбаяртай хийсэн ярилцлага - Эрчим хүчний газарт явуулсан албан бичгийн хариу - УИХ-ын http://www.parliament.mn вэб сайт - Хууль, эрх зүйн мэдээллийн www.legalinfo.mn сайт
Нэмэлт мэдээлэл:	

БҮЯ4. ХУУЛЬ ТОГТООХ ХОРООНЫ ЗҮГЭЭС ЭРЧИМ ХҮЧНИЙ ЧИГЛЭЛЭЭР ҮР ДҮНТЭЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ

Чанарын элементүүд	Тайлбар
Ашиг сонирхлыг зарлах	Т УИХ-ын гишүүд тухайн байнгын хорооны гишүүн болохоос өмнө цахилгаан эрчим хүчний салбар дахь өөрсдийн арилжааны ашиг сонирхлыг нийтэд зарласан байх эрх зүйн орчин саяхан болтол бүрдээгүй, тиймээс зарладаггүй байсан гэж ойлгож болно. Гишүүд жил бүр Авлигатай тэмцэх газарт гаргаж өгдөг хөрөнгө, орлогын мэдүүлэгт гэр бүлийн буюу хувь эзэмшдэг компанийн нэрийг зарладаг боловч тэр нь эрчим хүчний салбарт хамаарах эсэх, хэрвээ тийм бол ямар хэмжээнд гэдэг нь тодорхойгүй байдаг. Харин 2012 онд баталсан “Нийтийн албанд нийтийн болон хувийн сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль” хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээр өөрийн ашиг сонирхолын зөрчлийг ил тод, нээлттэй зарлах эрх зүйн орчин нь бүрдэж байна.
Үйл ажиллагааны идэвх	Т Эдийн засгийн байнгын хороо нь 2008-2011 оны хооронд нийт 124 удаа хуралдсанаас 2008 онд 26, 2009 онд 33, 2010 онд 34, 2011 онд 31 удаа хуралджээ. Үүнээс эрчим хүчний салбарын холбогдолтой 10 гаруй асуудлыг авч хэлэлцсэн байна. Томоохноос дурдвал, Цөмийн энергийн тухайн хуулийн төсөл (2009), Эрчим хүчний төслийн нэмэлт санхүүжилтын зээлийн хэлэлцээрийн төсөл (2009), Түлш эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төсөл (2010), Төрийн өмчийг 2010-2012 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай УИХ-ын тогтоолын төсөл (2011), Эрчим хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл (2011) гэх мэт. Мөн 2008 онд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг батлахдаа Эрдэс баялаг, эрчим хүчний сайдыг хэлэлцэн томилжээ.
Үндэслэл тайлан	Т Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулинд байнгын хороогоор хэлэлцсэн хуулийн төслийн талаарх санал дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулах гишүүнийг томилдог ба танилцуулагч нь үндсэн санал, шүүмж, дүгнэлтийн талаар тоймлон нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэгтэй. Энэхүү санал дүгнэлт нь хуралдааны тэмдэглэлт багтаж вэб сайт дээр нээлттэй байдаг.
Идэвхтэй үйл ажиллагаа явуулагч хороо	Ү Жишээ (кейс) Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2011 оны 10-р сарын 4-нд Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцсэн хуралдааны протоколыг үзэхэд дараахь дүр зурагтай байна. Хуулийн төслийн талаархи төсөл санаачлагчийн илтгэлийг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт танилцуулсан ба гишүүдийн асуултанд хариулахаар яам, агентлагийн холбогдох албан тушаалтнууд иржээ. Гэхдээ төсөл санаачлагчийн илтгэлтэй холбогдуулан байнгын хорооны гишүүдээс нэг ч асуулт, санал гараагүй байна. Энэхүү хэлэлцүүлэгт байнгын хорооны 21 гишүүнээс 11 нь буюу 52.3 хувийн ирцтэйгээр оролцсон ба Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэе гэсэн санал хураахад 8 гишүүн зөвшөөрч, 3 гишүүн татгалзаж олонхийн саналаар оруулахаар болжээ. Мөн сөрөг хүчнийг төлөөлсөн нэг гишүүн оролцсон байна. Эндээс Эрчим хүчний салбарын тулгуур баримт бичгийг боловсруулахад хорооны гишүүдийн идэвхи чармайлт хангалттай биш байсныг харж болохоор байна.
Олон нийтийн хэлэлцүүлэг	Ү Байнгын хорооны зүгээс олон нийтийн хэлэлцүүлгийг нэг ч удаа зохион байгуулаагүй байна.

Хороонд илгээсэн баримт бичгүүдийн ил тод байдал	Ү	Байнгын хороонд илгээсэн иргэдийн санал хүсэлт болон гишүүдийн санаачилгаар захиалан хийлгэсэн судалгаа УИХ-ын вэб сайт дээр нээлттэй тавигддаггүй. Харин иргэн хүсвэл УИХ-ын тамгын газрын дэргэдэх номын сан болон бичиг хэргийн архиваас бичиг баримт болон судалгааны ажлын хэвлэмэл эхийг үзэх боломжтой байдаг.
Хорооны тайлангийн ил тод байдал	Т	Нууцын зэрэглэлтэй асуудлыг эс тооцвол байнгын хорооны хуралдааны дэлгэрэнгүй болон хураангуй тэмдэглэл, тайланг www.parliament.mn вэб сайтаас хэсэг хугацааны дараа татан авч үзэх боломжтой учраас нээлттэй ил тод байдаг гэж дүгнэв.
Гүйцэтгэх түвшний тайлан	Т	Байнгын хороодын гишүүдийн хүссэн материал болон нэмэлт судалгааг гишүүдэд бичгээр тарааж өгдөг ба мөн iPad дээр нь цахим хэлбэрээр хуулж өгдөг байна. Жишээ нь УИХ-ын гишүүн Д.Балдан-Очироос Эрдэс баялаг эрчим хүчний яамны сайдад хандаж тавьсан асуулгын хариултыг бичгээр өгснөөс гадна УИХ-ын нэгдсэн хуралдаан дээр тайлбарлан хариулжээ.

Тайлбарын үргэлжлэл:

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцсэн Эдийн засгийн байнгын хорооны хуралдаан дээр гишүүдийн идэвх хангалтгүй байсан боловч чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд нийт гишүүд маш идэвхтэй оролцсоныг хуралдааны тэмдэглэлээс харж болно.

Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй / Үнэлгээ хийгээгүй	_
Хууль тогтоох хорооны зүгээс хянах механизм байхгүй эсвэл тухайн үйл явц нь үр дүнтэй үйл ажиллагааны нэг ч элементийг хангаагүй	Доод _
Цахилгаан эрчим хүчний салбарыг хянадаг хууль тогтоох хороо байгаа бөгөөд үр дүнтэй үйл ажиллагааны нэгээс хоёр элементийг хангасан	Доодоос дунд _
Цахилгаан эрчим хүчний салбарыг хянадаг хууль тогтоох хороо байгаа бөгөөд үр дүнтэй үйл ажиллагааны гурваас дөрвөн элементийг хангасан	Дунд ✓
Цахилгаан эрчим хүчний салбарыг хянадаг хууль тогтоох хороо байгаа бөгөөд үр дүнтэй үйл ажиллагааны таваас зургаан элементийг хангасан	Дундаас өндөр _
Цахилгаан эрчим хүчний салбарыг хянадаг хууль тогтоох хороо байгаа бөгөөд үр дүнтэй үйл ажиллагааны долоогоос найман элементийг хангасан	Өндөр _
Мэдээллийн эх сурвалж:	2011 оны 10-р сарын 4-нд УИХ-ын эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцсэн протокол
Нэмэлт мэдээлэл:	

БҮЯ5. ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ/ГАЗРЫН БОЛОВСОН ХҮЧНИЙ БОДЛОГО

Чанарын элементүүд	Тайлбар
Шалгуур үзүүлэлт тодорхой байх	Т Энэ асуултыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Эрчим хүчний газрын жишээн дээр хариулав. Тус газрын даргын тушаалаар батлагдсан ажлын байрны тодорхойлолтын дагуу Төрийн албаны тухай хуулийн хүрээнд сонгон шалгаруулалт явуулж шалгарсан хүнийг Төрийн албаны зөвлөлөөс нэр дэвшүүлсний дагуу сул орон тооны албан тушаалд томилдог.
Урьдчилан таамаглах боломжтой хугацаа	Т Үүнийг Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, байгууллагын дотоод журмын дагуу зохицуулдаг. Ажилтнуудын тухайн албан тушаалд ажиллах хугацаа нь тодорхой/урьдчилан тогтоогдсон байх, хугацаа нь дуусахаас өмнө ажлаас чөлөөлөхтэй холбоотой сайтар боловсруулсан шалгуурыг дээрх хуулиуд болон дотоод журамд хангалттай зааж өгчээ.
Ашиг сонирхлыг зарлах	Т Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйл “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүрэг”-т : “...төрийн албан тушаалд томилогдмогц өөрийн өмчийн байдлын талаар мэдэгдэж, өмчийн байдалд орсон өөрчлөлт, орлогын талаар зохих байгууллагад мэдээ өгч байх...” гэж заасан боловч яам/газрын албан тушаалтнууд цахилгаан эрчим хүчний салбар дахь өөрсдийн өмнөх болон одоогийн холбоо буюу хамаарах компанид хувь эзэмшдэг эсэх эсвэл ажил эрхлэлт/арилжаа болон зөвлөх хэлбэрээр хамааралтай эсэхийг зарлах үүргийг хүлээгээгүй байна. Харин ч эсрэгээрээ 14 дүгээр зүйл буюу Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг эрхийн 14.1.7-д “...хууль тогтоомжоор хориглоогүй, албан тушаалынхаа ашиг сонирхолд харшлахгүй арга хэлбэрээр хувийн аж ахуйгаа гардан эрхлэх, аж ахуйн нэгжийнхээ үйл ажиллагааг өөрийн итгэмжлэгдсэн хүнээр хөтлүүлэх зэргээр орлого олох...” эрхийг хуульчилж өгсөн нь нэг талаас ах дүү хамаатан садныхаа нэр дээр компани байгуулан мэдээллийн давуу байдлаа ашиглан бизнес хийх боломжийг бүрдүүлж өгчээ. Харин 2012 онд баталсан “Нийтийн албанд нийтийн болон хувийн сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль” хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээр ашиг сонирхолын зөрчлөө ил тод, нээлттэй зарлах эрх зүйн орчин нь бүрдэж байна.
Ашиг сонирхлын зөрчилдөөний журам	Т Төрийн албаны тухай хууль, Төрийн нууцын тухай хууль, байгууллагын дотоод журмыг мөрддөг. Энэ хуулийн Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйлийн 15.1.13-д “... хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол төрийн албаны төв байгууллага зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан үүргээ гүйцэтгэхийг зогсоосон өдрөөс хойш 2 жилийн дотор сүүлийн 5 жилийн хугацаанд эрхэлж байсан ажил, албан тушаалынхаа дагуу шууд холбоотой ажилладаг байсан хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид албан тушаал эрхлэх.” гэж заасан байна. Энд 2 зүйл тодорхой бус, бүрхэг байгаа нь уг хуулийн заалтыг бодит амьдрал дээр хэрэгждэг эсэхэд эргэлзээ төрүүлж байгаа юм. Нэгдүгээрт, шууд холбоотой ажилладаг аж ахуйн нэгж гэж юуг хэлж байгаа болон шууд бус холбоотой аж ахуйн нэгжид алиныг хамааруулж ойлгох. Хоёрдугаарт уг аж ахуйн нэгжид албан тушаал эрхлэх эсвэл ажиллах 2 юугаараа ялгаатай болох нь тодорхойгүй байна. Гэхдээ 2012 онд баталсан “Нийтийн албанд нийтийн болон хувийн сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль” хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээр байдал өөрчлөгдөх боломж нээгдэж байна.

Тайлбарын үргэлжлэл:

Энэ асуултыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Эрчим хүчний газрын жишээн дээр хариулсан болно. Яам/агентлагын ажилтнууд цахилгаан эрчим хүчний салбар дахь өөрсдийн арилжааны ашиг сонирхлыг нийтэд зарласан байх эрх зүйн орчин саяхан болтол Монгол улсад бүрдээгүй байв. Хэдийгээр хөрөнгө, орлогын мэдүүлэг авдаг ч энэ нь ашиг сонирхлын зөрчлийг тодруулах гэхээсээ авлигын асуудлыг тодорхойлоход гол зорилго нь чиглэгджээ. Тиймээс энэ салбарт ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчид эрчим хүчний салбар дахь өөрсдийн ашиг сонирхолыг нийтэд зарладаггүй гэж ойлгож болно. Харин 2012 онд батлагдан хэрэгжиж эхэлсэн “Нийтийн албанд нийтийн болон хувийн сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-иар дээр дурдсан асуудлууд шийдэгдэх нөхцөл бүрдэж байна.

Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй / Үнэлгээ хийгээгүй	_
Цахилгаан эрчим хүчний яам/газрын боловсон хүчний бодлого нь чанарын ямар нэгэн элементийг хангаагүй	Доод _
Цахилгаан эрчим хүчний яам/газрын боловсон хүчний бодлого нь чанарын нэг элементийг хангасан	Доодоос дунд _
Цахилгаан эрчим хүчний яам/газрын боловсон хүчний бодлого нь чанарын хоёр элементийг хангасан	Дунд
Цахилгаан эрчим хүчний яам/газрын боловсон хүчний бодлого нь чанарын гурван элементийг хангасан	Дундаас өндөр _
Цахилгаан эрчим хүчний яам/газрын боловсон хүчний бодлого нь чанарын бүх дөрвөн элементийг хангасан	Өндөр ✓
Мэдээллийн эх сурвалж:	-Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг - Эрчим хүчний газарт явуулсан албан бичгийн хариу -ЭБЭХЯ-нд явуулсан албан бичгийн дагуу тус яамны Эрчим хүчний бодлогын газрын орлогч дарга Д.Пүрэвбаяртай хийсэн ярилцлага

Нэмэлт мэдээлэл:

БҮЯ6. ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ЧИГЛЭЛЭЭР ХҮЛЭЭХ ҮҮРГИЙН ТОДОРХОЙ, ИЛ ТОД БАЙДАЛ

Чанарын элементүүд	Тайлбар
Тодорхойлсон байгаль орчны үүрэг, хариуцлагууд	<p>Ү Судалгааны багаас ЭБЭХЯ ба Эрчим хүчний газарт байгаль орчны чиглэлээрх үүрэг хариуцлагаа тодорхойлно уу гэсэн асуултад дараах хариултыг өгсөн юм. Тухайлбал, Эрчим хүчний газарт байгаль орчин, нийгмийн үүрэг, хариуцлагын талаар:</p> <p>-эрчим хүчний үйлдвэрлэлээс байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн хэмжээний стандартыг боловсруулах батлуулах, мөрдөх ажлыг зохион байгуулах,</p> <p>-нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамжийн дүрэм, эрчим хүчний барилга байгууламж, тоног төхөөрөмжийн угсралт, засвар, ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрэм, журам батлах, хэрэглэгчийн зэрэглэлийг тогтоох,</p> <p>-цахилгаан, дулаан хэрэглэх болон эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм, дамжуулах сүлжээний хамрах хүрээг тогтоох,</p> <p>-Эрчим хүчний үйлдвэрлэлийн байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээ болон нарийвчилсан үнэлгээ,</p> <p>-Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах, хяналт тавих ажлын зардлыг төлөвлөж, хэрэгжүүлэх талаар ажиллаж, хэрэгжилтийг төрийн захиргааны төв байгууллага болон бусад холбогдох байгууллагуудад тайлагнаж ажилладаг”.</p> <p>Хариултын дагуу ЭБЭХЯ ба Эрчим хүчний газрын үйл ажиллагааны чиглэлийг судлахад ЭБЭХЯ нь 7 газар хоёр хэлтэстэй, Эрчим хүчний газар нь 10 хэлтэстэй байснаас цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээний байгаль орчны нөлөөллийн үнэлгээ болон байгаль орчны стандартыг боловсруулдаг үүрэг чиглэл бүхий хэлтэс газар байхгүй, энэхүү чиг үүрэг аль хэлтэс, газарт харьяалагддаг нь тодорхой бус байна.</p>
Бусад байгууллагуудтай хамтран ажиллах	<p>Т Эрчим хүчний газар нь байгаль орчны асуудлаар бусад байгууллага, зохицуулагч нартай хамтын ажиллагаатай байдаг. Жишээлбэл, Дөргөн, Тайширын усан цахилгаан станцын байгаль орчны нөлөөлийг бууруулах талаар хамтран ажиллах гэрээ байгуулан гарах зардлыг төлөвлөн ажиллажээ. Дулааны цахилгаан станцууд байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээ хийлгэн холбогдох арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлж байна. Эрчим хүчний салбарын хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг ЭХГ-ын даргаар батлуулан хэрэгжүүлж байна.</p>
Вебсайт болон орон нутгийн салбарууд дээрх мэдээллийн хүртээмж	<p>Ү Гүйцэтгэх байгууллагын байгаль орчны чиглэлээр хүлээх хариуцлагыг дурдсан баримт бичгүүдийг вебсайт, олон нийтийн мэдээллийн төвүүд/ номын сангаас авах боломжтой гэж холбогдох байгууллага (Эрчим хүчний газар)-аас бичгээр хариулсан боловч олон нийтэд нээлттэй вэбсайт дээр тавигдаагүй байна.</p>
Байнгын тайлан	<p>Ү Эрчим хүчний салбарын үйл ажиллагааны байгаль орчны нөлөөллийн талаарх мэдээллийг төрийн болон төрийн бус байгууллагуудад тайлагнадаг. Эрчим хүчний салбарын үйл ажиллагааны талаарх мэдээлэл олон нийтэд нээлттэй. Эдгээр мэдээллийг холбогдох веб сайтуудаас авч болно. Эдгээр тайланд эрчим хүч үйлдвэрлэхэд хэрэглэж буй түлшний төрөл, хүлэмжийн хийн ялгаруулалтын талаар бодит мэдээлэл бүрэн байдаг” гэж хариулсан боловч үүнд хэрэглэж буй түлшний төрлүүд, хүлэмжийн хийн ялгаруулалт, усны экосистемд үзүүлж буй нөлөөлөл зэргийг багтаасан байнгын тайлан байхгүй байна.</p>

Эмзэг бүлэгт хүрч ажиллах	T	Эрдэс баялаг, эрчим хүчний яамны вэб сайт дээр иргэд, хэрэглэгчдээс санал хүсэлт, гомдлыг хүлээн авах журам тавигдсан ба иргэдээс санал хүсэлт авах линк-ийг ажилуулж байна. Мөн цахилгаан эрчим хүчний газрын үүрэг, хариуцлагын талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, вэб сайт, ялангуяа эрчим хүчний салбарын нээлттэй хаалганы өдөр зэрэг олон нийтийн арга хэмжээгээр дамжуулан нийгмийн янз бүрийн бүлэгт чиглэсэн мэдээ мэдээллээр хангадаг.
Үнэлгээ:		Сонгох:
Боломжгүй / Үнэлгээ хийгээгүй		-
Байгаль орчны чиглэлээр хүлээх үүргийн аль нэг элемент хангагдаагүй		Доод _
Байгаль орчны чиглэлээр хүлээх үүргийн нэг элемент хангагдсан		Доодоос дунд _
Байгаль орчны чиглэлээр хүлээх үүргийн хоёр элемент хангагдсан		Дунд ✓
Байгаль орчны чиглэлээр хүлээх үүргийн хоёр элемент хангагдсан		Дундаас өндөр _
Байгаль орчны чиглэлээр хүлээх үүргийн дөрөв болон түүнээс дээш тооны элемент хангагдсан		Өндөр_
Мэдээллийн эх сурвалж:		-Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг - Эрчим хүчний газарт явуулсан албан бичгийн хариу -ЭБЭХЯ-нд явуулсан албан бичгийн дагуу тус яамны Эрчим хүчний бодлогын газрын орлогч дарга Д.Пүрэвбаяртай хийсэн ярилцлага
Нэмэлт мэдээлэл:		

БҮЯ7. ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН НИЙГМИЙН ЧИГЛЭЛЭЭР ХҮЛЭЭХ ҮҮРГИЙН ТОДОРХОЙ, ИЛ ТОД БАЙДАЛ

Чанарын элементүүд	Тайлбар
Нийгмийн хариуцлагуудыг тодорхойлох	T Эрчим хүчний газар нь Эрдэс баялаг, эрчим хүчний яамнаас гаргасан бодлого, чиглэлд үндэслэн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, гадаад дотоодын зээл тусламжаар хэрэгжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээний судалгаа хийх, үндэслэл боловсруулах, үнэлэлт дүгнэлт өгөх, эрчим хүчний хөгжлийн судалгаа хийх, шинэ эх үүсвэрийн ТЭЗҮ боловсруулах, шинэ дэвшилтэд техник, технологийг судалж нэвтрүүлэх, эрчим хүчний үйлдвэрүүдийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, эрчим хүчний алдагдал бууруулахад чиглэсэн төсөл арга хэмжээ боловсруулах, нар, салхи, ус, биомасс болон газрын гүний дулааныг ашиглах нөөцийн судалгаа хийх, сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж, техникийн ашиглалт, үйлчилгээний норм норматив, стандарт боловсруулах, байгаль орчинд халгүй эрчим хүчний шинэ эх үүсвэр, техник технологи судалж нэвтрүүлэх зэрэг үндсэн чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Ядуу иргэдэд зориулан цахилгааны зардлыг доогуур байлгахад туслах бодлогыг Эрчим хүчний зохицуулах газрын баталсан эмзэг бүлгийн цахилгаан эрчим хүчний үнэ тарифаар зохицуулдаг.
Бусад байгууллагуудтай хамтран ажиллах	T Мөн Эрчим хүчний газар нь Геологи, уул уурхай, эрчим хүчний ажилчдын үйлдвэрчний эвлэл (ГҮҮЭХАҮЭ)-тэй салбарын ажиллагсадын нийгмийн хариуцлагын асуудлаар тогтмол хамтран ажилладаг. Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах санамж бичиг үйлдсэний дагуу хамтран ажиллаж байна.

Вебсайт болон орон нутгийн салбарууд дээрх мэдээллийн хүртээмж	Ү	Эрчим хүчний газрын нийгмийн хариуцлагын тухай баримт бичгүүд вебсайт, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд хэвлэгдэн тархаж байгаа гэж хариулсан боловч энэ талаарх мэдээлэл вэбсайтад тавигдаагүй, ямар хэвлэл мэдээллээр цацагдсан нь тодорхойгүй байна.
Байнгын тайлан	Ү	Жил бүрийн тайлан гардаг боловч энэ нь олон нийтэд ил тод бус байдаг Эрчим хүчний салбарын үйл ажиллагааны нийгмийн нөлөөлөл, үр дүнг олон нийтэд тогтмол тайлагнадаг тухай мэдээлэл байхгүй.
Эмзэг бүлэгт хүрч ажиллах	Ү	Нийгмийн эмзэг бүлэг, хөдөө орон нутгаас шилжин ирж, хотын захын дүүргүүдэд амьдарч байгаа иргэдэд мэдээлэл өгөхөд чиглэсэн системтэй үйл ажиллагааны тухай мэдээлэл олдоогүй.
Үргэлжлэл тайлбар:		
Үнэлгээ:		Сонгох:
Боломжгүй / Үнэлгээ хийгээгүй		–
Аль нэг элемент хангагдаагүй		Доод _
Нэг элемент хангагдсан		Доодоос дунд _
Хоёр элемент хангагдсан		Дунд ✓
Гурван элемент хангагдсан		Дундаас өндөр ✓
Дөрөв болон үүнээс дээш тооны элемент хангагдсан		Өндөр _
Мэдээллийн эх сурвалж:		-Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг - Эрчим хүчний газарт явуулсан албан бичгийн хариу -ЭБЭХЯ-нд явуулсан албан бичгийн дагуу тус яамны Эрчим хүчний бодлогын газрын орлогч дарга Д.Пүрэвбаяртай хийсэн ярилцлага
Нэмэлт мэдээлэл:		

БҮЯ8. ГҮЙЦЭТГЭХ ТҮВШНИЙ БАЙГУУЛЛАГЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДЛЫГ ҮНЭЛЭХ ЧАДАВХИ

Чанарын элементүүд	Тайлбар
Тусгайлан зориулсан санхүүгийн нөөц эх үүсвэр	Ү Байхгүй. Шаардлагатай тохиолдолд төсвийн ерөнхийлэн захирагчийн шийдвэрээр санхүүжүүлж хийлгэдэг.
Хамаарах мэдлэг чадвар	Т Эрчим хүчний газарт боловсон хүчин болон мэдлэг чадварыг байгаль орчны асуудлаар ашиглах бүрэн бололцоотой бөгөөд тодорхой асуудлуудыг судлах, шийдвэрлэхэд оролцон ажиллаж байгаа. Мөн байгаль орчны асуудал хариуцсан болон эрүүл мэнд, ус, хөдөөгийн хөгжил/хөдөө аж ахуй, газрын тос/байгалийн хий, нефтийн зэрэг салбарыг хариуцсан байгууллагуудтай тодорхой чиглэлээр ажлын хэсэг байгуулан хамтран ажиллажээ.
Тусгайлан томилсон албан тушаалтан	Ү Эрчим хүчний салбарын бодлого, үйл ажиллагааны хүрээний байгаль орчны асуудлыг хариуцсан ажилтан байхгүй
Байгаль орчны асуудлуудаар өөрсдийн мэдлэгийг сайжруулах байдал	Ү Энэ талын тогтмол сургалтын систем байхгүй байна

Үргэлжлэл тайлбар:

ЭБЭХЯ болон Эрчим хүчний газарт эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээний байгаль орчны нөлөөллийн үнэлгээ болон байгаль орчны стандартыг боловсруулдаг үүрэг чиглэл бүхий хэлтэс газар байхгүй, байгаль орчны асуудлыг тусгайлан хариуцсан мэргэжилтэн байхгүй. Тухайлбал, ЭБЭХЯ-нд төслийн байгаль орчны үнэлгээ хариуцсан нэгж (хэлтэс/газар) байхгүй байгаа нь энэ талын мэдээллийг боловсруулах, олон нийтэд түгээх, энэ асуудлаар тус яам ба БОАЖЯ-ны хоорондын ажлын уялдаа холбоонд сайнаар нөлөөлөхгүй байна.

Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй	-
Хамаарах гүйцэтгэх байгууллага нь байгаль орчны асуудалд үнэлгээ хийх чадавхитай холбоотой ямар нэгэн элементийг хангаснаа илтгэн харуулаагүй.	Доод ✓
Хамаарах гүйцэтгэх байгууллага нь байгаль орчны асуудалд үнэлгээ хийх чадавхитай холбоотой нэг элементийг хангасан.	Дунд _
Хамаарах гүйцэтгэх байгууллага нь байгаль орчны асуудалд үнэлгээ хийх чадавхитай холбоотой хоёр болон түүнээс дээш тооны элементийг хангасан.	Өндөр _
Мэдээллийн эх сурвалж:	-Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг - Эрчим хүчний газарт явуулсан албан бичгийн хариу -ЭБЭХЯ-нд явуулсан албан бичгийн дагуу тус яамны Эрчим хүчний бодлогын газрын орлогч дарга Д.Пүрэвбаяртай хийсэн ярилцлага

Нэмэлт мэдээлэл:

БҮЯ9. ГҮЙЦЭТГЭХ ТҮВШНИЙ БАЙГУУЛЛАГЫН НИЙГМИЙН АСУУДЛЫГ ҮНЭЛЭХ ЧАДАВХИ

Чанарын элементүүд	Тайлбар
Тусгайлан зориулсан санхүүгийн нөөц эх үүсвэр	Ү Эрчим хүчний газарт нийгмийн асуудлаар судалгаа, шалгалт хийхэд зориулан төсвийн тусгай эх үүсвэр байхгүй
Хамаарах мэдлэг чадвар	Т Эрчим хүчний газарт боловсон хүчин болон мэдлэг чадварыг нийгмийн асуудлаар ашиглах боломжтой. Гүйцэтгэх байгууллагаас нийгмийн асуудал хариуцсан байгууллага болон эрүүл мэнд, ус, хүйсийн тэгш байдал, хөдөөгийн хөгжил/хөдөө аж ахуй, боловсрол зэрэг салбаруудыг хариуцсан байгууллагатай хамтран ажиллах тогтсон систем байхгүй. Харин нийгмийн асуудал хариуцсан байгууллагуудтай тодорхой чиглэлээр ажлын хэсэг байгуулан хамтран ажиллаж байна.
Тусгайлан томилсон албан тушаалтан	Т Эрчим хүчний салбарын бодлого, үйл ажиллагааны хүрээний нийгмийн асуудлыг хүний нөөцийн мэргэжилтэн хариуцдаг. Энэ ажилтан эрчим хүчний салбарын ажиллагсадын сургалт, хөдөлмөрийн нөхцөл, эрүүл ахуй, нийгмийн бусад асуудлыг хамаарч байна.
Нийгмийн асуудлуудаар өөрсдийн мэдлэгийг сайжруулах байдал	Ү Тухайн хэрэгжүүлж буй төсөл нийгмийн тодорхой бүлэг болон орон нутгийн оршин суугчдад хэрхэн нөлөөлж болох талаарх мэргэжил дээшлүүлсэн сургалтууд явагдаагүй.

Үргэлжлэл тайлбар:

Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй / Үнэлгээ хийгээгүй	-

Хамаарах гүйцэтгэх байгууллага нь нийгмийн асуудалд үнэлгээ хийх чадавхитай холбоотой ямар нэгэн элементийг хангаснаа илтгэн харуулаагүй.	Доод _
Хамаарах гүйцэтгэх байгууллага нь нийгмийн асуудалд үнэлгээ хийх чадавхитай холбоотой нэг элементийг хангасан.	Дунд _
Хамаарах гүйцэтгэх байгууллага нь нийгмийн асуудалд үнэлгээ хийх чадавхитай холбоотой хоёр болон түүнээс дээш тооны элементийг хангасан.	Өндөр ✓
Мэдээллийн эх сурвалж:	-Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг - Эрчим хүчний газарт явуулсан албан бичгийн хариу -ЭБЭХЯ-нд явуулсан албан бичгийн дагуу тус яамны Эрчим хүчний бодлогын газрын орлогч дарга Д.Пүрэвбаяртай хийсэн ярилцлага
Нэмэлт мэдээлэл:	

БҮЯ10. ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ/ГАЗРЫН ЖИЛИЙН ТАЙЛАН

Чанарын элементүүд	Тайлбар
Санхүүгийн тайлан	T ЭБЭХЯ-ны санхүүгийн тайланг тус яамны Санхүү Хөрөнгө оруулалтын газраас гаргадаг ба эрхлэх асуудлын хүрээний харьяа төсөвт байгууллага, төслүүдийн санхүүгийн тайланг шалган хүлээн авч, Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын багцын 2009 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг гарган 2010 оны 2 дугаар сарын 10-ны дотор Сангийн яам, Үндэсний аудитын газарт тус тус хүргүүлэн хянуулж баталгаажуулжээ. Үндэсний аудитын газраас журмын аргачлалын дагуу зөрчилгүй гэсэн дүгнэлт гаргасан бөгөөд УИХ-аар хэлэлцүүлэхэд холбогдох мэдээллээр яамны удирдлагыг хангаж ажилласан байна. Энэхүү тайланд яамны үйл ажиллагаанд төсвөөс хэдий хэмжээний хөрөнгө зарцуулсаныг харуулан ч нийт зарцуулалтыг захиргаа/байрны зардал, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээнийллагаанд төсвөөс хэдий хэмжээний хөрөнгө зарцуулсаныг харуулан ч нийт зарцуулалтыг захиргаа/байрны зардал, тоног төхөөрөмж, зөвлөх ийн
Ахиц дэвшил гарах	T Тайлангууд нь өнгөрсөн жилийн хугацаанд яамнаас гаргасан бодлогын санаачилга/ шийдвэрийн хүрээнд гарсан ахиц дэвшлийн тойм, мөн цаашдын санаачилгууд, төслүүд болон шийдвэрүүдийн чиглэл зэргийг багтаажээ.
Хүртээмж хялбар байх	Y ЭБЭХЯ болон ЭХГ-ын тайлан гарсанаасаа хойш нэг сарын дотор вебсайт дээр электрон хэлбэрээр, нэрлэсэн зардлаараа үнэлэгдэн хэвлэмэл байдлаар олон нийтэд ил тод байдлаар тавигдаагүй байна.
Орон нутгийн хэл	T Тайлан нь Монгол хэл дээр бичигдсэн.
Тайлбарын үргэлжлэл:	
Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй / Үнэлгээ хийгээгүй	_
Цахилгаан эрчим хүчний яам нь жилийн тайлан гаргадаггүй эсвэл гаргасан тайлан нь тайлангийн чанарын шаардлагад нийцээгүй	Доод _
Цахилгаан эрчим хүчний яамны жилийн тайлан нь тайлангийн чанарын нэг элементэд нийцсэн	Доодоос дунд _
Цахилгаан эрчим хүчний яамны жилийн тайлан нь тайлангийн чанарын хоёр элементэд нийцсэн	Дунд _

Цахилгаан эрчим хүчний яамны жилийн тайлан нь тайлангийн чанарын гурван элементэд нийцсэн *Дундаас өндөр ✓*

Цахилгаан эрчим хүчний яамны жилийн тайлан нь тайлангийн чанарын бүх дөрвөн элементэд нийцсэн *Өндөр _*

Мэдээллийн эх сурвалж: -ЭБЭХЯ-нд явуулсан албан бичгийн дагуу тус яамны Эрчим хүчний бодлогын газрын орлогч дарга Д.Пүрэвбаяртай хийсэн ярилцлага
-Эрчим хүчний газарт явуулсан албан бичгийн хариу
-ЭБЭХЯ-ны санхүү, хөрөнгө оруулалтын газрын тайлан
-Эрдэс баялаг, эрчим хүчний салбарын 2009-2010 оны ажлын үр дүнгийн тойм

Нэмэлт мэдээлэл:

БҮЯ11. ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ/ГАЗРЫН ЗӨВЛӨХ ХОРОО

Чанарын элементүүд	Тайлбар
Үүрэг тодорхой байх	T Эрчим хүчний газрын дэргэд салбарын техникийн зөвлөл ажиллаж эрчим хүчний салбарын техник технологийн шинэчлэл, шинэ технологи нэвтрүүлэх, горим ажиллагааг шүүн хэлэлцэж, батлах чиглэлээр ажилладаг ба өөрийн эрхийн хүрээнд шийдвэр гаргаж эрчим хүчний салбарын хэмжээнд мөрдүүлдэг. Хэлэлцсэн асуудлынхаа дагуу зохих шийдвэр гаргаж ЭБЭХЯ-нд танилцуулдаг.
Тэнцвэртэй бүрэлдэхүүн	T Техникийн зөвлөлийн гишүүдэд эрчим хүчний үйлдвэрүүдийн техникийн асуудал эрхэлсэн дэд захирлууд, салбарын эрдэмтэд, ШУТИС-ын Эрчим хүчний их сургуулийн багш, профессорууд, зураг төслийн байгууллагын ажилтан, зөвлөх инженерийн төлөөлөл оролцсон байдаг.
Санхүүгийн нөөц эх үүсвэр	T Үйл ажиллагааны зардал, урамшууллыг байгууллагын төсвөөс гаргадаг ба хангалттай хэмжээнд байдаг.
Байнгын уулзалтууд	T Хуваарийн дагуу тогтмол хийгддэг.
Тэмдэглэлүүдийг олон нийтэд нээлттэй болгох	Y Техникийн зөвлөлийн хурал нь хэлэлцсэн асуудлаар гаргасан шийдвэрээ олон нийтэд нээлттэй ил тод байлгаж чадахгүй байна.
Баримт бичгүүдийг олон нийтэд нээлттэй болгох	Y Техникийн зөвлөлийн хурлын баримт бүрэн нээлттэй байдаг гэж ЭХГ-аас хариулсан боловч энэ нь вэбсайтад байхгүй, олон нийтэд ил тод бус байсан.
Гүйцэтгэх байгууллагын зүгээс өгсөн ил тод хариу	Y Техникийн зөвлөлийн хурлын шийдвэрийг эрчим хүчний үйлдвэрүүд, хуулийн этгээдүүд хэрэгжүүлсэн талаараа холбогдох байгууллага, ЭХГ-т тайлагнадаг боловч энэ талын мэдээллийг олон нийтэд ил тод байдлаар вэбсайтад тавиагүй байна.

Тайлбарын үргэлжлэл:

Эрчим хүчний газрын техникийн зөвлөлөөс гадна ЭБЭХЯ-ны дэргэд шинжлэх ухаан, техникийн зөвлөл ажилладаг. Тэдний хийж гүйцэтгэсэн зарим ажлын дурдвал,

-Одоо ОХУ-д хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа, гэхдээ 2014 он хүртэл монгол хэлнээ орчуулан боловсруулах норматив баримт бичгийн жагсаалтыг гарган ЭХГ-ын техникийн зөвлөл, ЭБЭХЯ-ны ШУТЗ-ийн хурлаар оруулан хэлэлцүүлж баталсан байна.

-Олон улсын байгууллага, Европын холбооны гишүүн орнууд болон ОХУ-ын стандартыг эх орондоо нутагшуулах чиглэлээр судалгаа хийж, цаашид орчуулан боловсруулах шаардлагатай стандартуудын жагсаалт, шаардагдах төсвийг гарган асуудлыг шийдвэрлүүлэхээр ЭБЭХЯ-нд албан тоотоор хүргүүлжээ.

-Эрчим хүчний 11 нормативын баримт бичгийг хянан засварлаж байгаа, 3 баримт бичгийг засварлан ЭБЭХЯ-д хүргүүлсэн, 2 баримт бичгийг ЭХГ-ын ШУТЗ-өөр оруулж дэмжигдэн ЭБЭХЯ-ны ШУТЗ-өөр оруулахаар холбогдох материалыг бэлдсэн.

-Эрчим хүчний системийн хамгаалалт ба автоматикийн микропроцессорын байгууламжид тавигдах техникийн үндсэн шаардлагын стандарт боловсруулж дуусгасан.

-Говийн бүсийн ашигт малмал, аж үйлдвэрийн өсөх нэмэгдэж байгаа цахилгаан эрчим хүчний хэрэгцээг хангах техник, эдийн засгийн үндэслэл нь ЭХГ-ын салбарын техникийн зөвлөлөөс дэмжигдэн ЭБЭХЯ-ны ШУТЗ-өөр оруулахаар холбогдох материалыг ЭБЭХЯ-д хүргүүлсэн.

-“Цайдам энержи” ХХК-ийн Цайдам нуурын нүүрний ордыг түшиглэн 270 МВт-ын ДЦС-ыг барих ТЭЗҮ-ийн саналтай танилцан дүгнэлт гаргаж газрын ШУТЗ-өөр оруулсан гэх мэт.

Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй / Үнэлгээ хийгээгүй	–
Кейс дээр дурдагдсан зөвлөх хороо нь үр дүнтэй үйл ажиллагааны аль ч элементийг хангаагүй	Доод _
Кейс дээр дурдагдсан зөвлөх хороо нь үр дүнтэй үйл ажиллагааны нэг элементийг хангасан	Доодоос дунд _
Кейс дээр дурдагдсан зөвлөх хороо нь үр дүнтэй үйл ажиллагааны хоёроос гурван элементийг хангасан	Дунд
Кейс дээр дурдагдсан зөвлөх хороо нь үр дүнтэй үйл ажиллагааны дөрвөөс таван элементийг хангасан	Дундаас өндөр_✓
Кейс дээр дурдагдсан зөвлөх хороо нь үр дүнтэй үйл ажиллагааны зургаагаас долоон элементийг хангасан	Өндөр _
Мэдээллийн эх сурвалж:	-ЭБЭХЯ-нд явуулсан албан бичгийн дагуу ЭБЭХЯ-ны Эрчим хүчний бодлогын газрын орлогч дарга Д.Пүрэвбаяртай хийсэн ярилцлага -Эрчим хүчний газарт явуулсан албан бичгийн хариу -ЭБЭХЯ-ны Санхүү хөрөнгө оруулалтын газрын тайлан -Эрдэс баялаг эрчим хүчний салбарын 2009-2010 оны ажлын үр дүнгийн тойм
Нэмэлт мэдээлэл:	

БҮЯ12. ТУСГАЙ ТӨЛӨВЛӨЛТ, БОДЛОГЫН АГЕНТЛАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

Чанарын элементүүд	Тайлбар
Төлөвлөлтийн байгууллагатай зөвлөлдөх шаардлага	Т Өнөөдөр эрчим хүчний салбарын төлөвлөлтийн асуудлыг ЭБЭХЯ хариуцаж байна. Гэхдээ ЭБЭХЯ-нд тусгай төлөвлөлт, бодлогын агентлаг гэж байхгүй. Харин макро түвшинд ЭБЭХЯ-ны төлөвлөсөн ажлууд болон төслүүд нь МУ-ын төлөвлөлтийн байгууллага болох Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо болон Сангийн яамнаас санал авдаг байна. Харин салбарын түвшинд ЭБЭХЯ-ны Эрчим хүчний бодлогын газар нь салбарын бодлого төлөвлөлтийг хариуцан ажилладаг байна. Иймд макро түвшинд ҮХШХ болон Сангийн яаманд ажлаа танилцуулж зөвшилцдөг бол салбарын түвшинд яамны харьяа хэрэгжүүлэгч агентлаг, төвүүд нь Эрчим хүчний бодлогын газартай зөвлөлдөж ажлаа явуулдаг байна.
Гүйцэтгэх байгууллагын хариуг үнэлэх механизм	Т Салбарын түвшинд Эрчим хүчний бодлогын газраас хэрэгжүүлэгч агентлагуудын гүйцэтгэлийг үнэлж тайландаа тусгадаг бол макро түвшинд төлөвлөлтийн байгууллага болон яам хоёрын хооронд шаардлага, санал, зөвлөмжийг хэрхэн биелүүлсэн болон хэрэгжүүлснийг үнэлэх тодорхой механизм алга байна.
Мэдээлэл авах эрх мэдэл	Т Эрчим хүчний бодлогын газар нь харьяа холбогдох хэрэгжүүлэгч агентлагууд болон газруудаас мэдээллийг түргэн шуурхай авах эрх мэдэл нь хангалттай байдаг. Бодлого төлөвлөлтийн газрын хэмжээнд тодорхой зарим чиглэлээр багаар ажиллах, бусад яам, газруудаас боловсруулагдсан бичиг баримт, албан бичигт санал өгөх, мэдээллээр хангах, иргэд албан байгууллагуудын хүсэлт, саналд хариу өгөх, зохицуулах, биеэр ирж мэдүүлсэн гомдлыг барагдуулах, бусад семинар, ярилцлагуудад оролцох зэрэг дотоод арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлдэг.
Хангалттай нөөц эх үүсвэр	Ү Макро түвшинд ҮХШХ-ноос төслийн техник эдийн засгийн үндэслэлийг хийлгэх судалгааныг төслийг санхүүжүүлж байжээ. Харин ЭБЭХЯ-ны хувьд суурь судалгаа шинжилгээ хийх төсөв байдаггүй байна.
Үйл ажиллагааны ил тод байдал	Ү Макро түвшинд ҮХШХ ч тэр, ЭБЭХЯ-ны аль алинд нь өөрсдийн гүйцэтгэсэн дүн шинжилгээ, судалгаа, санал зөвлөмжүүд зэргийг олон нийтэд ил тод, нээлттэй түгээх механизм дүрэм журманд нь байхгүй байна.
Зөвлөлдөх үйл явц	Т Эрчим хүчний хуульд нэмэлт өөрчлөлт оруулах болон ДЦС-5 төслийн хүрээнд холбогдох мэргэжилтнүүд, судлаачид, олон нийтийн дунд хэлэлцүүлэг явуулж, санал зөвлөмжийг авчээ.
Үргэлжлэл тайлбар:	
Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй / Үнэлгээ хийгээгүй	–
Тусдаа төлөвлөлтийн байгууллага байхгүй эсвэл байгаа агентлаг нь чанарын ямар ч элементийг хангаагүй	Доод _
Тусдаа төлөвлөлтийн байгууллага байгаа бөгөөд зөвхөн нэг чанарын элементийг хангаж байгаа	Доодоос дунд _
Тусдаа төлөвлөлтийн байгууллага байгаа бөгөөд чанарын хоёроос гурван элементийг хангаж байгаа	Дунд ✓
Тусдаа төлөвлөлтийн байгууллага байгаа бөгөөд чанарын дөрвөн элементийг хангаж байгаа	Дундаас өндөр _

Тусдаа төлөвлөлтийн байгууллага байгаа бөгөөд чанарын таваас зургаан элементийг Өндөр _ хангаж байгаа

Мэдээллийн эх сурвалж: -ЭБЭХЯ-нд явуулсан албан бичгийн хариу
-ЭБЭХЯ-ны Эрчим хүчний бодлогын газрын орлогч дарга Д.Пүрэвбаяртай хийсэн ярилцлага
-Эрчим хүчний газарт явуулсан албан бичгийн хариу
-ЭБЭХЯ-ны Санхүү хөрөнгө оруулалтын газрын тайлан
-Эрдэс баялаг эрчим хүчний салбарын 2009-2010 оны ажлын үр дүнгийн тойм

Нэмэлт мэдээлэл:

БҮЯ13. ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЧАДАВХИ

Чанарын элементүүд	Тайлбар
Техник-эдийн засгийн дүн шинжилгээний чадавхи	T Хэд хэдэн төрийн бус байгууллага эрчим хүчний салбарын мэргэжлийн хүмүүсээс бүрддэг тул техник-эдийн засгийн дүн шинжилгээ хийх бүрэн чадвартай.
Идэвхтэй оролцоо болон стратегийн чадавхи	T Эдгээр байгууллагууд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг бөгөөд шинэ бодлого, хууль тогтоомжийн төсөл боловсруулах, хэлэлцэхэд идэвхтэй оролцдог.
Байгаль орчин болон нийгмийн нөлөөллийн талаар ИНБ-уудын дүн шинжилгээ	Y Дээр дурдсанаас өөр, тус салбарт шууд хамаардаггүй иргэний нийгмийн бусад байгууллагууд аливаа бодлоын байгаль орчны болон нийгмийн нөлөөлөлд үнэлэлт дүгнэлт хийх чадвартай боловч эрчим хүчний бодлого, шийдвэрийн нөлөөллийн талаар ажиллаж эхлээгүй байна.
Эмзэг бүлгийнхэн болон орон нутгийн түвшинд дэмжлэг үзүүлэх	Y Орон нутгийн иргэд, эмзэг бүлгийнхэнд дэмжлэг үзүүлэх талаар идэвхтэй ажилладаггүй.
Байнгын суралцах чадавхи	T Иргэний нийгмийн бүх байгууллага байнга суралцаж байдаг.
Сүлжээ	Y Эрчим хүчний салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд сүлжээний зохион байгуулалтанд орж хараахан чадаагүй байна.
Өргөн хүрээний итгэлцэл	Y Сүлжээ болж хамтран ажиллаагүй учраас итгэлцэл хангалтгүй байна гэж үзлээ.

Тайлбарын үргэлжлэл.

Одоогоор эрчим хүчний салбарт үйл ажиллагаа явуулдаг дараах ТББ-ууд байна. Үүнд,
- Эрчим хүчний хөгжлийн ассоциаци (Тэргүүн Б.Жигжид)
- Монголын эрчим хүчний ассоциаци (Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Сүхбаатар)
- Монголын Сэргээгдэх Эрчим Хүчний холбоо (Ерөнхийлөгч Б.Бат)
- Монголын эрчим хүчний ассоциаци (Гүйцэтгэх захирал Г.Пүрэвдорж. Утас: 99092150)
- "Сэргээгдэх эрчим хүчний мэдлэгийн төв" ТББ
- Эрчим хүчний инженерүүдийн холбоо (Ерөнхийлөгч Р.Ганжуур)
- Монголын салхины эрчим хүчний ассоциаци (Гүйцэтгэх захирал Э.Мягмардорж)
- Эрчим хүч, геологи, уул уурхайн ҮЭ-ийн холбоо (Дарга С.Ганболд)
- Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо (Гүйцэтгэх захирал Х.Ганбаатар)

Үнэлгээ:

Сонгох:

Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй

-

ИНБ-ууд нь бодлого боловсруулахад идэвхтэй оролцдог ч чанарын элементүүдийн нэгийг ч хангаагүй	Доод _
ИНБ-ууд нь бодлого боловсруулахад идэвхтэй оролцдог ч чанарын элементүүдийн нэгээс хоёрыг хангасан	Доодоос дунд _
ИНБ-ууд нь бодлого боловсруулахад идэвхтэй оролцдог ч чанарын элементүүдийн гурваас дөрвийг хангасан	Дунд ✓
ИНБ-ууд нь бодлого боловсруулахад идэвхтэй оролцдог ч чанарын элементүүдийн таваас зургааг хангасан	Дундаас өндөр _
ИНБ-ууд нь бодлого боловсруулахад идэвхтэй оролцдог ба чанарын бүх долоон элементийг хангасан	Өндөр _
Мэдээллийн эх сурвалж:	Иргэний нийгмийн байгууллагуудын танилцуулга, эрчим хүчний асуудлаархи хэлэлцүүлгийн тэмдэглэл
Нэмэлт мэдээлэл:	

БҮЯ14. ЭРЧИМ ХҮЧНИЙ ХУУЛИЙН АСУУДЛААР ХУУЛЬ ТОГТООХ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ЧАНАР

Чанарын элементүүд	Тайлбар
Хэлэлцүүлгийн хугацаа	Т “Түлш эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 72-р тогтоолын хууль тогтоох хэлэлцүүлгийн хугацаа уг тогтоолын төсөл УИХ-д өргөн баригдсанаас хойш 2010 оны 10-12 сар буюу хоёр сар, харин Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хууль тогтоох хэлэлцүүлгийн хугацаа 2011 оны 04-12 сар буюу найман сар байжээ. Хангалттай гэж дүгнэлээ.
Гишүүдийн оролцоо	Т Хуралдааны ирцын мэдээллээс үзэхэд дээрх тогтоол болон хуулийн төслийг хэлэлцсэн байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд УИХ-ын 76 гишүүнээс 50 буюу түүнээс олон гишүүн оролцож 65,7 %-иас дээш байсан нь кворумаас харьцангуй илүү юм. Хангалттай гэж дүгнэлээ.
Санал гаргагчдын бүрэлдэхүүн	Т Дээрх тогтоол болон хуулийн төслийг хэлэлцсэн УИХ-ын нэгдсэн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлээс үзэхэд асуулт тавьж, санал гаргасан гишүүдийн олонхи МАН-ын гишүүд байгаа боловч энэ нь УИХ дахь эрх баригч МАН ба АН-ын суудлын харьцаатай ерөнхийдөө тохирч байна. Шаардлага хангасан гэж үзлээ.
Тэмдэглэл нээлттэй/ хүртээмжтэй эсэх	Т Дээрх тогтоол болон хуулийн төслийг хэлэлцсэн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэл 14-21 хоногийн дотор УИХ-ын вэб сайтад тавигджээ. Харин байнгын хороодын хуралдаан нээлттэй явагддаг боловч тэмдэглэл хүртээмжтэй биш. Шаардлага хангасан гэж үзлээ.

Тайлбарын үргэлжлэл:

Дээрх хоёр шийдвэрийг хэлэлцэж баталсан үйл явц нь тус салбарын урьд өмнөх бодлогын шийдвэрүүдийг гаргасан үйл явцуудтай харьцуулахад илүү нээлттэй, олон нийтийн анхаарлын төвд байх болсныг хэлэх хэрэгтэй. Гэхдээ жигд биш байна.

2010 оны 12-р сард гаргасан “Түлш, эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж хэлэлцүүлэх ажил харьцангуй богино хугацаанд, ажлын хэсэг байгуулснаас хойш тооцоход хэдхэн сар үргэлжилж олон нийтийн зүгээс байр сууриа илэрхийлэх боломж хязгаарлагдмал байжээ. Тэгвэл 2011 оны 12-р сард батлагдсан Эрчим хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж хэлэлцүүлэх үйл явц 2010, 2011 оны туршид бүтэн хоёр жилийн турш үргэлжилжээ.

Үнэлгээ:

Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй

Эрх зүйн баримт бичгийг хууль тогтоох байгууллага батлалгүйгээр гаргасан (тушаал/ерөнхийлөгчийн зарлиг гэх мэт хэлбэрээр)

Эрх зүйн баримт бичгийг хууль тогтоох байгууллагаар хэлэлцэгдэн гарсан ч үр дүнтэй хэлэлцүүлэг явуулах нэг л элементийг хангасан

Эрх зүйн баримт бичгийг хууль тогтоох байгууллагаар хэлэлцэгдэн гарсан ч үр дүнтэй хэлэлцүүлэг явуулах хоёр элементийг хангасан

Эрх зүйн баримт бичгийг хууль тогтоох байгууллагаар хэлэлцэгдэн гарсан, үр дүнтэй хэлэлцүүлэг явуулах гурван элементийг хангасан

Эрх зүйн баримт бичгийг хууль тогтоох байгууллагаар хэлэлцэгдэн гарсан ба үр дүнтэй хэлэлцүүлэг явуулах бүх дөрвөн элементийг хангасан

Мэдээллийн эх сурвалж: УИХ-ын чуулганы дараах өдрүүдийн нэгдсэн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлүүд. Үүнд:
2010.12.02-ны Пүрэв гаригийн нэгдсэн хуралдааны тэмдэглэл.
2010.12.03-ны Баасан гаригийн нэгдсэн хуралдааны тэмдэглэл
2010.12.09-ны Пүрэв гаригийн нэгдсэн хуралдааны тэмдэглэл
2011.10.14-ны Баасан гаригийн нэгдсэн хуралдааны тэмдэглэл
2011.10.20-ны Пүрэв гаригийн нэгдсэн хуралдааны тэмдэглэл
2011.12.02-ны Баасан гаригийн нэгдсэн хуралдааны тэмдэглэл
2011.12.09-ны Баасан гаригийн нэгдсэн хуралдааны тэмдэглэл

Нэмэлт мэдээлэл:

БҮЯ15. ЭРЧИМ ХҮЧНИЙ БОДЛОГО, ШИНЭТГЭЛИЙГ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛЭЭР МЭДЭЭЛЭХ ҮЙЛ ЯВЦЫН ЧАНАР

Чанарын элементүүд	Тайлбар
Хэвлэл мэдээллээр гарсан тоо	Ү Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2011 оны 12-р сарын 9-ны Баасан гаригт УИХ-аар баталжээ. Энэ өдрөөс өмнөх гурав ба дараах 3 хоногийг (дараачийн хоёр өдөр амралтын буюу сонин гардаггүй өдөр байсан тул хойшлуулж авав) оруулаад нийт 7 хоногийн хугацаанд хамгийн олон хувь ширхэгтэй "Өнөөдөр", "Өдрийн сонин" сонины нийт 14 дугаарыг нэгбүрчлэн судалж үзэхэд уг хуулийг хэлэлцэж байгаа болон баталсантай холбоотой ямар ч мэдээ, нийтлэл гараагүй байна.
Хэвлэл мэдээллээр гарсан мэдээллийн чанар	Ү Нэгэнт мэдээ, нийтлэл гараагүй тул мэдээллийн чанарыг үнэлэх боломжгүй
Мэдээллийн тэнцвэр	Ү Нэгэнт мэдээ, нийтлэл гараагүй тул мэдээллийн чанарыг үнэлэх боломжгүй

Үргэлжлэл тайлбар:

Сүүлийн жилүүдэд гарсан эрчим хүчний салбарын бодлогын шинэчлэлийн ач холбогдолтой хамгийн чухал үйл явц бол Эрчим хүчний хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг УИХ-аар баталсан явдал юм.

Уг хуулийн төслийг боловсруулж 2010 оны 1-р сард олон нийтээр хэлэлцүүлэхээр зарласнаар хойш Засгийн газрын хуралдаанаар оруулж УИХ-д өргөн барьсан, УИХ-ын байнгын хороод болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцсэн явцыг хэвлэл мэдээллийн хэрэгслүүд тухай бүр мэдээлж сурвалжилж ирсэн боловч Үнэлгээний зааврын дагуу авч үзсэн, уг хуулийн төслийг баталсан 12-р сарын 9-ны өмнөх ба дараах 3 хоногийг багтаасан долоо хоногт бусдаас олон хувь ширхэгээр хэвлэгддэг “Өнөөдөр” ба “Өдрийн сонин”-уудад уг хуулийн холбогдолтой нэг ч мэдээ, нийтлэл гараагүй байлаа.

Хэрвээ телевизүүд болон Интернэтийн сайтуудыг мөн хугацаанд авч үзвэл УИХ-ын чуулганы хуралдааны тухай мэдээ, сурвалжлагуудад Эрчим хүчний хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцэж баталсан тухай орсон байна. Гэхдээ энэ нь үнэлгээний асуултанд хамаарахгүй

Мөн хувь ширхэг нь доогуур “Зууны мэдээ”, “Өдрийн шуудан”, “Өглөөний сонин”, “Үндэсний шуудан” сонинуудын тухайн өдрийн дугааруудыг авч үзэхэд ч зөвхөн хууль батлагдсан тухай товч мэдээ нийтэлснээс хэтрээгүй байгаа тул ерөнхий дүр зургийг өөрчлөгдөхгүй юм.

Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй	✓
Хэвлэл мэдээллээр гарсан байдал нь чанарын нэг ч элементийг хангаагүй	Доод _
Хэвлэл мэдээллээр гарсан байдал нь чанарын нэгээс хоёр элементийг хангасан	Дунд _
Хэвлэл мэдээллээр гарсан байдал нь чанарын бүх гурван элементийг хангасан	Өндөр _
Мэдээллийн эх сурвалж:	Олон хувиар гардаг өдөр тутмын “Өнөөдөр”, “Өдрийн сонин” сонины 2011 оны 12-р сарын 6-14 өдрүүдийн дугаарт Эрчим хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахтай холбоотой мэдээ, бусад нийтлэл гараагүй. Энэ үе бол Эрчим хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг УИХ хэлэлцэж байсан үе болно.
Нэмэлт мэдээлэл:	

БҮЯ16. БОДЛОГО БОЛОВСРУУЛАХАД ОЛОН НИЙТ ОРОЛЦОХ ҮЙЛ ЯВЦЫН ИЛ ТОД БАЙДАЛ

Чанарын элементүүд	Тайлбар
Шийдвэрээ хариуцах байдал	T Эрчим хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт, оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг Эрдэс баялаг, эрчим хүчний яамнаас зохион байгуулж байгаа нь зар мэдээллээс тодорхой байсан болно.
Шийдвэр гаргах тодорхой цаг хугацаа	Y Хуулийн төслийг хэзээ өргөн барих, ямар хугацаанд эцэслэн батлах талаар тодорхой мэдээлэл өгч байгаагүй.
Санал бодлоо илэрхийлэх тодорхой цаг хугацаа	Y Хуулийн төсөлд олон нийтээс ямар хугацаанд санал авч дуусгахыг тодорхой заагаагүй байсан
Санал бодлыг хариуцах байдал	Y Олон нийтийн санал бодлыг хэнд хэрхэн уламжлах, төсөлд хэрхэн тусгасан талаар эргэж мэдээлэл өгөх тухай дурдаагүй
Зөвлөлдөх үйл явцыг баримтжуулах	Y Ямар ямар саналууд ирж байгаа болон ирсэн, хэлэлцсэн талаар олон нийтэд мэдээлэл өгч байгаагүй болно.

Үйл явцын талаарх мэдээллийг цаг тухайд нь түгээх	Ү	Санал авах буюу зөвлөлдөх үйл явцыг урьдчилж мэдээлэхгүйгээр шууд зарласан байна.
Үйл явцын талаарх мэдээллийг өргөн хүрээнд түгээх	Т	Хуулийн төслийн хэлэлцүүлэг явагдаж байгаа тухай мэдээллийг юуны өмнө олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон Интернэтийн сайтуудаар өгч олон нийтэд үе үе өгч байсан болно.
Үйл явцын талаарх мэдээллийг тусгайлан түгээх	Ү	Хуулийн төслийн хэлэлцүүлгийн тухай мэдээллийг үйл явцын нөлөөнд өртөж буй бүлэгт буюу интернетэд холбогдох боломжгүй бүлэгт тусгайлан түгээсэн тухай нотолгоо байхгүй.
Тайлбарын үргэлжлэл: Эрчим хүчний салбарын аливаа хэлэлцүүлгийн явцад гарсан саналуудыг ЭБЭХЯ-наас цуглуулан нэгтгэж протоколдоод ажлын хэсэгт гаргаж өгдөг талаар яамны ажилтнууд хэлж байв. Гэхдээ үүнийг нотолсон тэмдэглэл, энэ ажлын зохион байгуулах механизм алга байна. Эрчим хүчний зохицуулагчдын зөвлөлийн 2005 оны 72 дугаар тогтоолоор баталсан "Олон нийтийн хэлэлцүүлэг явуулах журам" байдаг боловч эрчим хүчний салбарын бодлогын шинжтэй хэлэлцүүлэгт шууд хамаарахгүй байна. Эрчим хүчний салбарын тулгамдсан асуудал болон хуулийн төслийн талаар сонин хэвлэлээр гарсан хэлэлцүүлгийн материалыг үзэхэд гол төлөв яам, агентлаг, мэргэжлийн байгууллага, хүмүүсийн дунд өрнөсөн уулзалт, эрдэм шинжилгээний хурал, зөвлөлгөөн байдаг нь хэлэлцүүлгийн түвшин өндөр байсны нэг нотолгоо боловч өргөн олон нийт, эрчим хүч хэрэглэгчдийн байр суурь үгүйлэгдэж байлаа.		
Үнэлгээ:		Сонгох:
Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй		-
Үнэлгээнд хамрагдсан бодлогын үйл явц нь чанарын аль нэг элементийг хангаагүй		Доод _
Үнэлгээнд хамрагдсан бодлогын үйл явц нь чанарын нэгээс хоёр элементийг хангасан		Доодоос дунд ✓
Үнэлгээнд хамрагдсан бодлогын үйл явц нь чанарын гурваас дөрвөн элементийг хангасан		Дунд _
Үнэлгээнд хамрагдсан бодлогын үйл явц нь чанарын таваас зургаан элементийг хангасан		Дундаас өндөр _
Үнэлгээнд хамрагдсан бодлогын үйл явц нь чанарын нэгээс зургаагаас долоон элементийг хангасан		Өндөр _
Мэдээллийн эх сурвалж:		- ЭБЭХЯ-нд явуулсан албан бичгийн дагуу тус яамны Эрчим хүчний бодлогын газрын орлогч дарга Д.Пүрэвбаяртай хийсэн ярилцлага -Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг - Эрчим хүчний газарт явуулсан албан бичгийн хариу -2010-2011 оны хэвлэл мэдээллийн нийтлэл, нэвтрүүлгийн мониторингийн архив.
Нэмэлт мэдээлэл:		

БҮЯ17. БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛИЙН ҮНДЭС, ЗОРИЛТЫГ ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭХ НЬ

Чанарын элементүүд	Тайлбар
Баримт бичиг олдох цар хүрээ	Ү Э болон Эрчим хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг ил тод болгож сурталчилсан ба 2011.05.23-наас УИХ-ын вэб сайтад байршуулжээ. Мөн эрчим хүчний салбарын бодлого, түүний янз бүрийн хувилбарыг үнэлж цэгнэх үндэс болсон бодлогын болон эрх зүйн баримт бичгүүд ЭБЭХЯ ба Эрчим хүчний газрын вэб сайтуудад байна. Гэхдээ сонирхогч талуудаас ирүүлсэн санал, өөр байр суурийг харуулсан мэдээлэл байгаагүй учраас бүрэн гэж үнэлэх боломжгүй юм. (Тайлбарын үргэлжлэлийг үзнэ үү)
Мэдээлэл авах боломж	Т Вэб сайтад байрлуулсан учраас хялбар авах боломжтой байв.
Цаг алдалгүй танилцах боломж	Т Вэб сайтад тогтмол байршуулсан учраас цаг алдалгүй авах боломжтой байв
Өргөн хүрээний сонирхогчид мэдээлэлтэй танилцах боломж	Ү Зөвхөн вэб сайтад тогтмол байршуулсан, өөр сувгийг ашиглаагүй учраас өргөн олон нийтэд бүрэн хүртээлтэй гэж үзэх боломжгүй.
Тайлбарын үргэлжлэл:	
<p>Хуулийн төслийг хэлэлцэж батлах үйл явцыг ил тод байдлыг хангах зорилгоор УИХ-ын вэб сайтад тухайн хуулийн үзэл баримтлал, хуулийн төслөөс гадна дараах баримт бичгүүдийн гарчгууд, тухайлбал “Төсөлтэй холбоотой судалгаа, лавлагаа, тооцоо, бусад мэдээлэл” гэсэн гарчгууд бүхий хуудас байдаг, түүнд Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг байршуулсан боловч хэлэлцүүлгийн хугацаанд уг хуулийн холбогдолтой ямар нэгэн нэмэлт мэдээлэл тавигдаагүй болно. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Төслийн үзэл баримтлал, танилцуулга 2. Төсөлтэй холбоотой судалгаа, лавлагаа, тооцоо, бусад мэдээлэл [мэдээлэл байхгүй] 3. Ажлын хэсэг байгуулсан тухай УИХ-ын болон Байнгын хорооны тогтоол [мэдээлэл байхгүй] 4. Хууль санаачлагчийн илтгэл [мэдээлэл байхгүй] 5. Төслийн талаарх харьяалах Байнгын хорооны дүгнэлт [мэдээлэл байхгүй] 6. Төслийн талаарх Нам, эвслийн бүлэг, бусад Байнгын хороодын дүгнэлт [мэдээлэл байхгүй] 7. Байнгын хорооны зөвлөхийн дүгнэлт [мэдээлэл байхгүй] 8. ЭЗХТХ-ийн зөвлөхийн хууль зүйн дүгнэлт [мэдээлэл байхгүй] 9. Анхны хэлэлцүүлгээр гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол [мэдээлэл байхгүй] 10. Эцсийн хэлэлцүүлэгт оруулсан төсөл [мэдээлэл байхгүй] 11. Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Байнгын хорооны танилцуулга [мэдээлэл байхгүй] 12. Эцсийн хэлэлцүүлгээр гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол [Мэдээлэл байхгүй. Хуулийн төсөл цааш хэлэлцэгдээгүй] 13. Танилцуулахаар тараасан эцсийн найруулга [Мэдээлэл байхгүй] 14. Батлагдсан хууль, тогтоолтой холбогдуулан гаргасан хууль, тогтоол [Мэдээлэл байхгүй] 15. Ерөнхийлөгчийн хориг, түүнийг хэлэлцсэн тухай мэдээлэл [Мэдээлэл байхгүй] 	
Үнэлэмж:	Сонгох:
Хамааралгүй / үнэлгээ өгөөгүй	–
Бодлогын шийдвэр гаргах үндэс болсон суурь баримт бичгийн талаар мэдээлэл байхгүй	Доод _
Олон нийтэд түгээж буй мэдээлэл нь чанарын үзүүлэлтийн нэгээс хоёр элементийн шаардлагыг хангасан	Дунд ✓
Олон нийтэд түгээж буй мэдээлэл нь чанарын үзүүлэлтийн гурваас-дөрвөн элементийн шаардлагыг хангасан	Дээд

Мэдээллийн эх сурвалж: - УИХ-ын www.parliament.mn вэб сайт
 - ЭБЭХЯ-нд явуулсан албан бичгийн хариу, тус яамны Эрчим хүчний бодлогын газрын орлогч дарга Д.Пүрэвбаяртай хийсэн ярилцлага
 - Эрчим хүчний газарт явуулсан албан бичгийн хариу
 - www.mmre.gov.mn/ <http://www.mmre.energy.mn/>
 - www.ea.energy.mn

Нэмэлт мэдээлэл:

БҮЯ18. ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООНЫ ҮЙЛ ЯВЦЫН ҮР ДҮНТЭЙ БАЙДАЛ

Чанарын элементүүд	Тайлбар
Оролцооны тоо хэмжээ	T Уг хуулийн төслийн хэлэлцүүлэг хоёр жил шахам үргэлжилж үнэлгээний асуулгын шалгуур болох 10-аас дээш санал ирсэн нь тодорхой.
Оролцооны цар хүрээ	Y Хуулийн төсөлд эрчим хүчний салбарынхаас гадна олон нийтийн сонирхлыг хамгаалсан ТББ, үйлдвэрчний эвлэл, хэрэглэгчдийн бүлэг болон фермерүүд зэрэг салбарын бүлгээс санал ирүүлсэн тухай мэдээлэл буюу нотолгоо байхгүй.
Олон нийтийн оролцооны тойм	Y Байхгүй
Олон нийтийн оролцоонд өгсөн хариу	Y Байхгүй

Тайлбарын үргэлжлэл:

Жишээлбэл, 2011 оны 2-р сард Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Түлш, эрчим хүчний бодлогын дэд зөвлөлөөс “Иргэний танхим”-д “Монголын түлш, эрчим хүчний салбарын хөгжлийн бодлогын баримт бичгүүд, тэдгээрийн хэрэгжилт болон цаашдын зорилтын тухай” нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж багц санал гаргажээ. Мөн МЭХА, Монголын эрчим хүчний инженерүүдийн холбооны удирдах зөвлөл төрийн өмчит болон хувийн хэвшлийн 30 шахам байгууллага, компанийн 700 гаруй инженер, албан хаагчид, ажилчидтай уулзаж ярилцах, санал бодлоо солилцох ажлыг зохион байгуулснаар нийт 20 зүйл бүхий саналыг ЭБЭХЯ-нд хүргүүлсэн байна. Мөн Эрдэс баялаг, эрчим хүчний салбарын “Нээлттэй хаалганы өдөр”-ийг 11 дүгээр сарын 18-ний өдөр орон даяар зохион байгуулж Эрдэс баялаг, эрчим хүчний яам болон Эрчим хүчний газар тус бүрт болсон “Нээлттэй хаалганы өдөр”-өөр хуулийн холбогдолтой саналууд гарч байжээ. Мөн ЭБЭХЯ-ны Эрчим хүчний бодлогын газрын орлогч дарга Д.Пүрэвбаяр “Бид олон нийтийн саналыг багцлаад протоколдоод холбогдох албан тушаалтанд өгдөг” тухай хэлсэн болно. Гагцхүү дээрх болон бусад саналуудыг хэрхэн хүлээж авч бодлогын шийдвэрт тусгасан тухай мэдээлэл буюу нотолгоо алга байна.

Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй / Үнэлгээ хийгээгүй	_
Бодлогын үйл явц нь чанарын нэг ч элементийг хангаагүй.	Доод _
Бодлогын үйл явц нь чанарын нэг л элементийг хангасан.	Доодоос дунд ✓
Бодлогын үйл явц нь чанарын хоёр элементийг хангасан.	Дунд _
Бодлогын үйл явц нь чанарын гурван элементийг хангасан.	Дундаас өндөр _
Бодлогын үйл явц нь чанарын бүх дөрвөн элементийг хангасан.	Өндөр _
Мэдээллийн эх сурвалж:	- ЭБЭХЯ-нд явуулсан албан бичгийн дагуу тус яамны Эрчим хүчний бодлогын газрын орлогч дарга Д.Пүрэвбаяртай хийсэн ярилцлага - Эрчим хүчний газарт явуулсан албан бичгийн хариу.

Нэмэлт мэдээлэл:

БҮЯ19. САЛБАРЫН ШИНЭТГЭЛИЙН ХУУЛЬ, БОДЛОГОД БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДЛЫГ ХАРГАЛЗАН ҮЗСЭН НЬ

Чанарын элементүүд	Тайлбар
Суурь баримт бичгүүдэд тусгагдсан эсэх	Т Төрөөс эрчим хүчний салбарын талаар баримтлах бодлогын суурь баримт бичгүүд болон Эрчим хүчний салбарын мастер төлөвлөгөөнд байгаль орчны асуудал тодорхой хэмжээгээр тусгагдсан.
Шинэтгэлийн бодлого, хуульд тусгагдсан эсэх	Т 2011 оны 12-р сард нэмэлт өөрчлөлт оруулсан Эрчим хүчний тухай хуулинд байгаль орчны холбогдолтой нэлээд заалт хэвээр үлдсэн буюу нэмэгдсэн байна.
Эрчим хүчний салбарын шууд нөлөөллийг бууруулсан эсэх	Т Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Мянганы хөгжлийн зорилт, Монгол Улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр, Монгол Улсын эрчим хүчний тогтвортой хөгжлийн стратеги /2002-2010 он/ зэрэг төрийн бодлогын баримт бичгүүдэд сэргээгдэх эрчим хүчийг ашиглах нь манай улсын эрчим хүчний салбарын тэргүүлэх чиглэлийн нэг болгон хөгжүүлэхээр онцлон заасан байна. “Монгол Улсын нэгдсэн систем хөтөлбөр”-ийн хүрээнд өнөөдрийн байдлаар манай улсын 331 сумын 305 нь цахилгаан дамжуулах шугамаар төвлөрсөн системд холбогдсон ба 20 сумыг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр тус тус цахилгаан эрчим хүчээр хангаад байна. “100000” нарны гэр хөтөлбөр”-ийн хүрээнд авч хэрэгжүүлсэн ажлын үр дүнд 80 орчим мянган малчин айл өрх нарын цахилгаан эх үүсгүүртэй болсон бөгөөд дахин 20 мянган эх үүсгүүрийг малчдад олгох ажлыг зохион байгуулж байна. Өнөөдрийн байдлаар сэргээгдэх эрчим хүчний суурилагдсан хүчин чадал нь Дөргөний усан цахилгаан станц ашиглалтад орсноор нийт суурилагдсан чадлын 2,65 хувийг эзлэж байна. Тайширын УЦС өнөөдөр туршилтын байдлаар ажиллаж байгаа хэдий ч Говь-Алтай аймгийн төвийн зарим хэсэг болон Тайшир, Жаргалан сумдыг цахилгаан эрчим хүчээр хангаж байна. Дээрх төсөл хөтөлбөрүүд хэрэгжсэнээр агаарт ялгарах нүүрсхүчлийн хий болон хүлэмжийн хийг бууруулах, эрчим хүчний хэмнэлттэй технологийг нэвтрүүлэхэд хувь нэмэр болсон.
Байгаль орчны нөлөөллийн дэлхий нийтийн болон эдийн засгийн үр дүн	Ү Үүнийг үнэлж тооцоолсон тухай мэдээлэл алга байна.

Тайлбарын үргэлжлэл:

2011 оны 11-р сард Эрчим хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахын өмнө байгаль орчны асуудлыг тусад нь бүлэг болгон оруулах саналыг төрийн бус байгууллагуудаас гаргаж байсан хэдий ч энэ нь хуульд тусгалаа олоогүй юм. Гэхдээ байгаль орчны нөлөөлөл, түүнийг үнэлэх, харгалзах, сөрөг нөлөөллийг бууруулах талаар дараах хэд хэдэн заалт орсныг хэлэх хэрэгтэй. Жишээлбэл,

12.5. Иргэн, хуулийн этгээд байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй, хүн амын хэвийн амьдралд хохирол учруулахааргүй аргаар зөвхөн өөрийн хэрэгцээг хангах зорилгоор 1.5 МВт хүртэл хүчин чадалтай эрчим хүчний эх үүсвэр, түүний дамжуулах, түгээх шугам барих, ашиглахад тусгай зөвшөөрөл авахгүй.

24.3. Тусгай зөвшөөрөл олгогч дараахь үндэслэлээр түүнийг хүчингүй болгоно:

24.3.5. байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөө биелүүлээгүй буюу байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн;

у; шинэчлэгдэж гараагүй учраас

24.5. Тусгай зөвшөөрлийн хүчингүй болсон нь түүнийг эзэмшигч хуулийн этгээдийн байгаль орчныг нөхөн сэргээх болон бусад үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

25.1.11. үйл ажиллагаагаа эхлэхээс өмнө байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг эрх бүхий байгууллагаар хийлгэх, байгаль хамгаалах, нөхөн сэргээх жил бүрийн төлөвлөгөө боловсруулж, холбогдох байгууллагаар батлуулж мөрдөх гэх мэт.

Төрөөс эрчим хүчний салбарын талаар баримтлах бодлогын суурь баримт бичгүүд болон эрчим хүчний салбарын мастер төлөвлөгөө шинэчлэгдэж гараагүй учраас цаг үеийн шаардлагаас хоцорч байгаль орчны асуудал салбарын хэмжээнд алсын хараатай авч үзэхэд сөргөөр нөлөөлж байна.

Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй	-
Салбарын шинэтгэлийн явцад байгаль орчны асуудлыг харгалзан үзсэн байдал нь чанарын нэг ч элементийг хангаагүй	Доод _
Салбарын шинэтгэлийн явцад байгаль орчны асуудлыг харгалзан үзсэн байдал нь чанарын нэг элементийг хангасан	Доодоос дунд
Салбарын шинэтгэлийн явцад байгаль орчны асуудлыг харгалзан үзсэн байдал нь чанарын хоёр элементийг хангасан	Дунд _
Салбарын шинэтгэлийн явцад байгаль орчны асуудлыг харгалзан үзсэн байдал нь чанарын гурван элементийг хангасан	Дундаас өндөр ✓
Салбарын шинэтгэлийн явцад байгаль орчны асуудлыг харгалзан үзсэн байдал нь чанарын дөрөв болон түүнээс дээш тооны элементийг хангасан	Өндөр _
Мэдээллийн эх сурвалж:	-ЭБЭХЯ-нд явуулсан албан бичгийн дагуу тус яамны Эрчим хүчний бодлогын газрын орлогч дарга Д.Пүрэвбаяртай хийсэн ярилцлага -Эрчим хүчний газарт явуулсан албан бичгийн хариу -Санхүү хөрөнгө оруулалтын газрын тайлан -Эрдэс баялаг эрчим хүчний салбарын 2009-2010 оны ажлын үр дүнгийн тойм -ЭБЭХЯ-ны жилийн тайлан -Эрчим хүчний газрын жилийн тайлан

Нэмэлт мэдээлэл:

БҮЯ20. ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН БОДЛОГЫН ӨӨРЧЛӨЛТ, САЛБАРЫН ШИНЭТГЭЛЭЭС ХАМААРАХ АЖЛЫН БАЙР БУУРАХ ЯВДЛЫН ҮНЭЛГЭЭ

Чанарын элементүүд	Ү	Тайлбар
Ажил эрхлэлтэд үзүүлэх сөрөг нөлөөний үнэлгээ	Ү	Албан ёсоор тусгайлсан үнэлгээ явуулдаггүй.
Шинэтгэлийн үйл ажиллагааг явуулахаас өмнө үнэлгээг явуулсан эсэх	Ү	Үгүй. УИХ-ын 72-р тогтоол ба Эрчим хүчний тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулахын өмнө тийм үнэлгээ хийгээгүй.
Сөрөг нөлөөллийг бууруулах	Ү	Ажлын байр цөөрснөөс болж үүсэх сөрөг нөлөөллийг дахин сургах, нөхөн төлбөр олгох зэргээр бууруулах арга хэмжээний талаар дурдагдаагүй байна.
Асуудлыг шийдэхэд туслалцаа үзүүлэх	_	Тийм арга хэмжээний талаар алга байна.
<p>Үргэлжлэл тайлбар:</p> <p>Сүүлийн хоёр жилийн дотор гарсан УИХ-ын 72-р тогтоол, шинэчлэн батлагдсан Эрчим хүчний тухай хууль, бусад баримт бичгүүдэд эрчим хүчний салбарын бодлогын өөрчлөлт, салбарын шинэтгэлийн явцад гарч болох нийгмийн сөрөг нөлөөлөл, тэр дундаа ажлын байранд үзүүлэх нөлөөллийг үнэлэх, түүний мөрөөр авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг багтаасан аргачлал, механизм хараахан алга байна.</p>		
Үнэлгээ:		Сонгох:
Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй		_
Шинэтгэлээс үүдэн ажил эрхлэлтэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ нь чанарын нэг ч элементийг хангаагүй		Доод ✓
Хамгийн том эрчим хүч ханган нийлүүлэгч нь чанарын нэг элементийг хангасан		Доодоос дунд _
Шинэтгэлээс үүдэн ажил эрхлэлтэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ нь чанарын хоёр элементийг хангасан		Дунд _
Шинэтгэлээс үүдэн ажил эрхлэлтэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ нь чанарын гурван элементийг хангасан		Дундаас өндөр _
Шинэтгэлээс үүдэн ажил эрхлэлтэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ нь чанарын бүх дөрвөн элементийг хангасан		Өндөр _
Мэдээллийн эх сурвалж:		<ul style="list-style-type: none"> - ЭБЭХЯ-нд явуулсан албан бичгийн дагуу тус яамны газрын орлогч дарга Д.Пүрэвбаяртай хийсэн ярилцлага - Эрчим хүчний газарт явуулсан албан бичгийн хариу - Санхүү хөрөнгө оруулалтын газрын тайлан - Эрдэс баялаг эрчим хүчний салбарын 2009-2010 оны ажлын үр дүнгийн тойм - Эрчим хүчний газрын жилийн тайлан - ЭБЭХЯ-ны жилийн тайлан
Нэмэлт мэдээлэл:		

БҮЯ21. БИЕ ДААСАН ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАЛААРХ БОДЛОГЫГ ИЛ ТОД БАЙДЛААР ТОДОРХОЙЛОХ

Чанарын элементүүд	Тайлбар
Хууль тогтоох байгууллага батлах	Т Монгол Улсын эрчим хүчний салбарт хувийн хөрөнгө оруулалт хийх эрх зүйн орчин аажмаар бүрдэж байна. Хамгийн сүүлд 2010 онд Концессын тухай хууль болон УИХ-ын 72 дугаар тогтоол батлагдаж үнэ тарифийг чөлөөлөх шийдвэр гарсан нь чухал түлхэц өгсөн байна.
Бодлого боловсруулах үеэрх олон нийтийн оролцоо/ зөвлөлдөөн	Ү Бие даасан эрчим хүчний бодлогын асуудлаар олон нийтийн оролцоог тусгайлан хангасан хэлэлцүүлэг болж байгаагүй
Өрсөлдөөнт сонгон шалгаруулалт	Ү Одоохондоо явагдаагүй. Цаашид концессын хуулийн дагуу явагдана гэж ойлгогдож байна.
Эрэлтийн дүн шинжилгээг хангалттай хэмжээнд гүйцэтгэх	Т Монгол улсын хэмжээнд болон бүс нутгуудад эрчим хүчний эрэлт хэрэгцээ ойрын ирээдүйд хэрхэн өсөн нэмэгдэх талаар хангалттай олон судалгаа, прогноз бий.
Эрчим хүч худалдан авах гэрээг ил тод болгосон байх	Ү Эрчим хүч худалдан авах гэрээний ерөнхий нөхцлүүдийг урьдчилсан ил тод болгоогүй
Санхүүгийн нөлөөллийн дүн шинжилгээ хийх	Ү Бие даасан эрчим хүч үйлдвэрлэгчээс худалдан авах гэрээ нь тарифт ямар нөлөө үзүүлэхийг нарийвчилсан дүн шинжилгээ одоогоор хийгдээгүй
Төслийг батлахаас өмнө хангалттай хэмжээнд олон нийтийн зөвлөлдөх үйл ажиллагааг явуулсан байх	Ү Бие даасан эрчим хүч үйлдвэрлэгчийн талаарх бодлогыг тусгайлан ил тод болгож олон нийтээр хэлэлцүүлээгүй

Тайлбарын үргэлжлэл:

Сүүлийн үед эрчим хүчний салбарт хувийн хэвшлийг оролцоог дэмжих үзэл баримтлал бодлогын баримт бичгүүдэд тусгалаа олсон боловч энэ талаар тодорхой шийдвэр гаргах үйл явц олон нийт болон мэргэжлийн хүмүүст нэлээд хаалттай байсны нэг жишээ бол Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт Ухаахудагийн ДЦС юм.

Анх Засгийн газрын 2008-2012 оны мөрийн хөтөлбөрт Тавантолгойн орд газрыг түшиглэн их хүчин чадалтай дулааны цахилгаан станцыг барьж байгуулах асуудлыг хэрэгжүүлээр тусгагдаж, тухайлбал, Засгийн газрын 2009 оны 320 дугаар тогтоолоор баталсан “Засгийн газраас эхний ээлжинд хэрэгжүүлэх томоохон төслийн жагсаалт”-д 400.0 сая ам.долларын төсөвт өртөг бүхий “Тавантолгойн цахилгаан станц” төслийг 2010-2015 онд хэрэгжүүлэхээр тусгаж улмаар судалгаа, ТЭЗҮ боловсруулах ажил хийгдэж байсан боловч янз бүрийн шалтгаанаар саатаж үүний оронд Тавантолгойн зөвхөн нэг хэсэг болох Ухаанхудагийг түшиглэн хувийн хэвшлийн цахилгаан станц баригдсан юм. Энэ үйл явдал хэрхэн өрнөснийг сонирхвол,

2009 оны 12-р сар:

“Энержи Ресурс” ХХК-ийн Ухаахудгийн коксжих нүүрсний орд газрыг түшиглэн 12 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станцыг барихаар болсон талаар анх зарлаж уг станц нь Ухаа худгийн нүүрсний уурхай, шинээр баригдах нүүрс боловсруулах үйлдвэр болон уурхайн хотхоныг эрчим хүчээр хэрэглээг хангахад зориулагдсан гэж мэдээлж байв.

2010 он:

Тус станцын хүчин чадлын талаар зөрөөтэй мэдээлэл гарч байв. Тухайлбал: “Тавантолгойн ордын Ухаахудагийн хэсгийн коксжих нүүрсний уурхайг түшиглэн 12+50МВт хүчин чадалтай дулааны цахилгаан станц барьж байгуулах ТЭЗҮ-г “MCS интернейшнл” ХХК боловсруулж, салбарын Шинжлэх ухаан, техникийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэв”. Бас нэг мэдээ: -“Тавантолгойн Ухаа худгийн коксжих нүүрсний уурхайг түшиглүүлэн 12 МВт хүчин чадалтай дулааны цахилгаан станц барьж байгуулах ТЭЗҮ-ийг “MCS интернейшнл” ХХК боловсруулан салбарын ШУТЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдэж зураг төслийг хийжээ”

2011 он

Тавантолгойн Ухаа худагт хувийн хөрөнгө оруулалтаар 12+50МВт-ын, өөр нэг мэдээгээр 18 МВт-ын ДЦС барих тусгай зөвшөөрөл олгосны дагуу барилга угсралтын ажил явагдаж байгаа тухай мэдээлж байв.

2011 оны 09-р сар

Өмнөговь аймгийн Цогцэций суманд Ухаахүдгийн 18 МВт-ын хүчин чадал бүхий ДЦС ашиглалтанд орж албан ёсны нээлтийн арга хэмжээ болов.

Гэхдээ энэ станцын асуудал маргаантай, эргэлзээтэй хэвээр байгааг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэлээс харж болох юм.

2011.10.25.

УИХ-ын гишүүн Д.Дамба-Очир:

-Сайдыг ирсэн дээр нэг юм тодруулаадах уу? Бид нарт, УИХ-ын гишүүдэд ийм мэдээлэл өгөөч. Бид нарын бодож байгаа, өөрийн чинь хэлээд байгаа зөрөөд байна л даа. Таван толгой гэхэд 50 МВт-ын хүчин чадалтай хэрэглэх хэрэгцээ байгаа гэж яриад байгаа шүү дээ. Жишээлбэл. Би мэдэхгүй байна. Оюу Толгой гэхэд 450 гэж ярьж байгаа. MCS Ухаа худаг дээр 20-ийнх гэлүү, 35-ынх ч гэлүү нэг станц барьж байгаа гэсэн. Гэх мэтчилэнгээр ингээд бодлоготой, бодлогогүй нь мэдэгдэхгүй яваад байх юм болов уу, үгүй юм болов уу гэж асуугаад байгаа нь энэ байхгүй юу.

ЭБЭХ-ны сайд Д.Зоригт:

-Яг өнөөдрийн байдлаар бол Дамба-Очир гишүүн ээ, 18 МВт-ын тусгай зөвшөөрөлтэй эх үүсвэр Ухаа худаг дээр байгаа. Өөр юм байхгүй. Тэр бол ерөөсөө 18 МВт-ын. Өргөтгөлийн зөвшөөрөл бид нар өгөхгүй. Яагаад өгөхгүй гэж байгаа вэ гэхээр энэ уснаасаа ч болоод тэр, бусад юмнаасаа болоод тэр яг энэ Таван толгой дээр түшиглэж, нэг том максимумыг нь хүртэл станц барья гэж байгаа.

2011.12.20

УИХ-ын гишүүн А.Тлейхан:

-Сүүлийн үед шинэ цахилгаан станц барих тухай хүн бүр ярьдаг боллоо. Монгол Улсын нэгдсэн системийн хөтөлбөр гэж бий. Энэ бол төрийн бодлого. Энэ салбарыг хөгжүүлэх үндсэн төрийн бодлого нь Монгол Улсын нэгдсэн шинэчилсэн хөтөлбөр. Энд байхгүй байгаа зарим станцуудыг барина гэж яриад байх юм. Тухайлбал, Оюу толгой цахилгаан станц барих тухай асуудал яриад байх юм. Оюу толгой цахилгаан станц барих заалт энэ төрийн бодлогод байхгүй ээ. Үнэхээр барих гээд байгаа юм бол төрийн бодлогод өөрчлөлт хийж байж л барих ёстой... Монгол Улсын нэгдсэн системийн хөтөлбөр гэж энэ салбарын хөгжлийг тодорхойлсон тийм том тогтоол байгаа. 2007 онд нэмэгдэл өөрчлөлт орсон. Энэ тогтоолд байхгүй зарим цахилгаан станцыг барина гэж яригдаад байгаа юм билээ.

Үнэлгээ:

Сонгох:

Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй

Бие даасан эрчим хүч үйлдвэрлэгчтэй холбоотой үйл явц нь чанарын нэг ч элементийг хангаагүй

Доод _

Бие даасан эрчим хүч үйлдвэрлэгчтэй холбоотой үйл явц нь чанарын нэгээс хоёр элементийг хангасан

Доодоос дунд ✓

Бие даасан эрчим хүч үйлдвэрлэгчтэй холбоотой үйл явц нь чанарын гурваас дөрвөн элементийг хангасан

Дунд _

Бие даасан эрчим хүч үйлдвэрлэгчтэй холбоотой үйл явц нь чанарын дөрвөөс таван элементийг хангасан

Дундаас өндөр _

Бие даасан эрчим хүч үйлдвэрлэгчтэй холбоотой үйл явц нь чанарын зургаагаас долоон элементийг хангасан

Өндөр _

Мэдээллийн эх сурвалж:

“Түлш, эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай” 72-р тогтоол
Концессын тухай хууль
УИХ-ын чуулганы 2011 оны 10-р сарын 25-ны хуралдааны тэмдэглэл
УИХ-ын чуулганы 2011 оны 12-р сарын 20-ны хуралдааны тэмдэглэл

Нэмэлт мэдээлэл:

БҮЯ22. ЗӨВЛӨХ АЖИЛЛУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ ОЛОН НИЙТЭД НЭЭЛТТЭЙ БАЙСАН ЭСЭХ

Чанарын элементүүд:	Тайлбар:
Зөвлөх үйл ажиллагааны нарийвчилсан мэдээлэл	Ү Эрчим хүчний салбарын шинэтгэлийн асуудлаар зөвлөх үйл ажиллагааны нарийвчилсан мэдээлэл ил тод байдаг гэж хариулсан боловч зөвлөхийн гүйцэтгэх ажлын тодорхойлолт нь гэрээт ажил эхлэхээс өмнө олон нийтэд анхны хүсэлт гаргангуут л шууд өгөгдөж байгаагүй, мөн яамны вебсайтаас цаг тухайд нь олж авах боломжгүй байсан.
Эцсийн тайлангийн талаарх нарийвчилсан мэдээлэл	Т Зөвлөхийн гаргасан эцсийн тайланг авч үзэх хүсэлтээ гарган авч танилцах бүрэн боломжтой.
Зөвлөхийн тайлан дээр санал гаргах	Ү Зөвлөх үйлчилгээний гэрээ нь Сангийн яамнаас баталсан жишгийн дагуу хийгддэг.
Олон нийтийн гаргасан саналыг судлан үзэх шаардлага	Т Улаанбаатарын дулаан цахилгааны шинэ эх үүсвэрийн ТЭЗҮ, мөн энэ эх үүсвэрийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангаас харж болно.
Үргэлжлэл тайлбар:	
Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй	–
Зөвлөх ажиллуулахтай холбоотой мэдээллийн ил тод байдал нь чанарын нэг ч элементийг хангаагүй	Доод _
Зөвлөх ажиллуулахтай холбоотой мэдээллийн ил тод байдал нь чанарын нэг элементийг хангасан	Доодоос дунд _
Зөвлөх ажиллуулахтай холбоотой мэдээллийн ил тод байдал нь чанарын хоёр элементийг хангасан	Дунд ✓
Зөвлөх ажиллуулахтай холбоотой мэдээллийн ил тод байдал нь чанарын гурван элементийг хангасан	Дундаас өндөр _
Зөвлөх ажиллуулахтай холбоотой мэдээллийн ил тод байдал нь чанарын бүх дөрвөн элементийг хангасан	Өндөр _
Мэдээллийн эх сурвалж:	-ЭБЭХЯ-нд явуулсан албан бичгийн дагуу тус яамны газрын орлогч дарга Д.Пүрэвбаяртай хийсэн ярилцлага -Эрчим хүчний газарт явуулсан албан бичгийн хариу -Санхүү хөрөнгө оруулалтын газрын тайлан -Эрдэс баялаг эрчим хүчний салбарын 2009-2010 оны ажлын үр дүнгийн тойм -Эрчим хүчний газрын жилийн тайлан -ЭБЭХЯ-ны жилийн тайлан
Нэмэлт мэдээлэл:	

БҮЯ23. БОДЛОГЫН ЗЭЭЛ ОЛГОЖ БҮЙ ХАНДИВЛАГЧИЙН ОРОЛЦООНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

Чанарын үзүүлэлтийн элементүүд	Т	Тайлбар
Бодлого, байр суурийн ил тод байдал	Т	Эрчим хүчний салбарт зээл олгож байгаа хандивлагчдийн бодлого, байр суурийн талаарх мэдээлэл нийтэд хүртэмжтэй байдаг.
Тавьсан нөхцөлийн ил тод байдал	Т	Зээлийг ашиглаж байх хугацаанд тухайн зээлийг олгох болон түүнтэй холбоотой заавал биелүүлэх нөхцөлийг харуулсан баримт материалыг олон нийтийн хүртээл болгодог.
Олголтын ил тод байдал	Т	Бүрэн нээлттэй
Үнэлгээний механизмийн ил тод байдал	Т	Сонирхсон этгээдэд хүртээлтэй.
Тайлбарын үргэлжлэл:		
Үнэлгээ:		Сонгох:
Хамааралгүй/ үнэлээгүй		–
Бодлогын зээлийн ашиглалт чанарын үзүүлэлтийн шалгуур элементийг огт хангаагүй.		Доод _
Бодлогын зээлийн ашиглалт чанарын үзүүлэлтийн шалгуур элементийн нэг – ийг хангасан.		Доодоос дунд _
Бодлогын зээлийн ашиглалт чанарын үзүүлэлтийн шалгуур элементийн хоёр – ыг хангасан.		Дунд _
Бодлогын зээлийн ашиглалт чанарын үзүүлэлтийн шалгуур элементийн гурав – ыг хангасан.		Дундаас дээд _
Бодлогын зээлийн ашиглалт чанарын үзүүлэлтийн шалгуур элементийн дөрөв – ийг хангасан.		Дээд ✓
Мэдээллийн эх сурвалж:		<ul style="list-style-type: none"> -ЭБЭХЯ-нд явуулсан албан бичгийн дагуу тус яамны газрын орлогч дарга Д.Пүрэвбаяртай хийсэн ярилцлага -Эрчим хүчний газарт явуулсан албан бичгийн хариу -Санхүү хөрөнгө оруулалтын газрын тайлан -Эрдэс баялаг эрчим хүчний салбарын 2009-2010 оны ажлын үр дүнгийн тойм -Эрчим хүчний газрын жилийн тайлан -ЭБЭХЯ-ны жилийн тайлан
Нэмэлт мэдээлэл:		

БҮЯ24. ТЕХНИКИЙН ТУСЛАЛЦААНЫ ХҮРЭЭНД ХАНДИВЛАГЧ БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦООНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

Чанарын элементүүд	Тайлбар
Техникийн туслалцаа нарийвчилсан мэдээллийн ил тод байдал	T Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Олон улсын хөгжлийн агентлаг, Японы улсын Засгийн газрын тусламжаар хэрэгжиж байгаа техникийн туслалцааны төслийн мэдээлэл танилцуулгын хэмжээнд хангалттай ил тод байдаг.
Үйл ажиллагааны гарцуудын ил тод байдал	T Олон улсын хандивлагч байгууллагуудаас санхүүжүүлж буй төслүүдийн хувьд үйл ажиллагааны журам, ялангуяа байгаль орчны болон нийгмийн нөлөөллийг үнэлэх шаардлагатайг нэлээд хатуу тусгаж өгдөг ба энэ нь олон нийтэд ил тод нээлттэй байдаг.
Олон нийтэд түгээх үйл ажиллагаа	Y Төслийн хэрэгжүүлэх эхлэх үед олон нийтийн мэдээллийн хэрэгслээр болон вэб сайтад тавьж сурталчилдаг. Гэхдээ хэрэгжилтийн явц, ялангуяа эцсийн үр дүнгийн мэдээлэл хангалттай биш.
Тайлбарын үргэлжлэл: Техникийн туслалцаагаар хэрэгжсэн буюу хэрэгжиж байгаа зарим томоохон төслүүд: -Улаанбаатар хотын цахилгаан эрчим хүчний найдвартай ажиллагааг хангах зорилгоор 12.0 сая ам.долларын өртөг бүхий “Эрчим хүчний нэмэлт санхүүжилтийн зээлийн хэлэлцээрт” Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны төлөөлөл гарын үсэг зуржээ. -Дэлхийн банк, Олон улсын хөгжлийн агентлагийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр түгээх сүлжээний алдагдал бууруулах “Эрчим хүчний төсөл”-ийг 2001 оноос хэрэгжүүлсэн бөгөөд Улаанбаатар хотын гэр хороолол болон 9 аймгийн (Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Дорнод, Өмнөговь, Сүхбаатар, Увс, Ховд, Хөвсгөл) төвийн цахилгаан түгээх сүлжээ хамруулсан байна. -Монгол Улс, Азийн хөгжлийн банктай 2010-2015 онуудад хамтран ажиллах стратегийн баримт бичгийг боловсруулж, харилцан ойлголцлын санамж бичигт Сангийн сайд, Азийн хөгжлийн банкны Монгол дахь суурин төлөөлөгч (Адриан Руденберг) нар гарын үсэг зурж баталгаажуулсан. Энэхүү баримт бичигт тэргүүлэх салбараар тээвэр, хот байгуулалт, боловсрол, эрүүл мэнд болон эрчим хүчний салбарыг сонгож, улмаар 2010-2013 онуудад Азийн хөгжлийн банкнаас нийт 530.0 сая ам.долларын санхүүжилт олгох бөгөөд үүний 200.0 сая ам.долларыг Азийн хөгжлийн сангаас, 184.0 сая ам.долларыг ердийн эх үүсвэрийн сангаас (2012 оноос эхлэн), 146.0 сая ам.долларыг бүс нутгийн хөгжлийн сангаас тус тус олгохоор тохирч, жилд 6.0 сая ам.долларын техникийн туслалцаа үзүүлэхээр болжээ. - Японы Засгийн газрын ерөнхий буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “Нарны эрчим хүч үйлдвэрлэх замаар цэвэр эрчим хүчний технологи нэвтрүүлэх” төслийн протоколд Монгол Улсын Сангийн яам, Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яам, Иргэний нисэхийн ерөнхий газар ба Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагын төлөөлөгчид нар гарын үсэг зуржээ.	
Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй	–
Техникийн туслалцааны хүрээнд хандивлагч байгууллагын оролцооны ил тод байдалчанарын нэг элементийг хангаж байгаа.	Доод _
Техникийн туслалцааны хүрээнд хандивлагч байгууллагын оролцооны ил тод байдал чанарын хоёр элементийг хангаж байгаа.	Дунд ✓
Техникийн туслалцааны хүрээнд хандивлагч байгууллагын оролцооны ил тод байдалчанарын бүх гурван элементийг хангаж байгаа.	Дээд
Мэдээллийн эх сурвалж:	Мэдээллийг ЭБЭХЯ ба Эрчим хүчний газрын жилийн тайлангаас олж авсан болно.
Нэмэлт мэдээлэл:	

БҮЯ25. БИЕ ДААСАН ЭРЧИМ ХҮЧ ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН БОДЛОГО/ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДАЛ

Чанарын элементүүд	Тайлбар
Өрсөлдөөнт сонгон шалгаруулалт	Ү Ухаахудагийн ДЦС барьж байгуулах тухайд өрсөлдөөнт сонгон шалгаруулалт явагдаагүй
Цахилгаан эрчим хүч худалдан авах гэрээг ил тод болгосон байх	Ү Ил тод болгоогүй
Эрэлтийн дүн шинжилгээг хангалттай хэмжээнд гүйцэтгэх	Т Ухаахудагийн ДЦС-ын хувьд ТЭЗҮ, бусад баримт бичгийн хүрээнд хийгдсэн гэж ойлгогдож байна.
Санхүүгийн нөлөөллийн дүн шинжилгээ хийх	Т Ухаахудагийн ДЦС-ын хувьд ТЭЗҮ, бусад баримт бичгийн хүрээнд хийгдсэн гэж ойлгогдож байна.
Төслийг батлахаас өмнө хангалттай хэмжээнд олон нийтийн зөвлөлдөх үйл ажиллагааг явуулсан байх	Ү Ухаахудагийн ДЦС ба Салхитын салхин цахилгаан станцын төслийг батлахаас өмнө олон нийттэй зөвлөлдөөгүй.

Үргэлжлэл тайлбар:

Сүүлийн жилүүдэд эрчим хүчний салбарт хувийн томоохон хөрөнгө оруулалт хийгдэж анх удаа төрийн биш, хувийн өмчийн цахилгаан станц ашиглалтанд орсон нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь “Энержи ресурс” компанийн Ухаахудагийн ДЦС юм.

Уг станцыг байгуулахтай холбоотой шийдвэр гаргаж хэрэгжүүлсэн үйл явцын харууль

2009 он.

Тавантолгойн ордын Ухаахудагийн хэсгийн коксжих нүүрсний уурхайг түшиглэн 12+50МВт хүчин чадалтай дулааны цахилгаан станц барьж байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг “MCS интернейшнл” ХХК боловсруулж, ЭБЭХЯ-ны шинжлэх ухаан, техникийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулжээ.

2009:

Ухаахудагийн ДЦС-ын зураг төслийг боловсруулав.

2009:

Эрчим хүчний зохицуулагчдын зөвлөлийн ээлжит хуралдаанаас “Энержи Ресурс” ХХК-ийн Ухаа худгийн коксжих нүүрсний орд газрыг түшиглэн 12 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц барих тусгай зөвшөөрлийг “Юнайтэд Пауэр” ХХК-д өгсөн байна. “Юнайтэд Пауэр” ХХК нь “Энержи Ресурс” ХХК-ийн охин компани болох “Энержи Ресурс Майнинг” ХХК болон “Хангад Эксплорэйшн” ХХК компаниудын хамтын хөрөнгө оруулалттай юм. Станцыг барьж байгуулахад нийтдээ 25.1 сая ам.доллар шаардагдах бөгөөд таван сая ам.долларийг өөрсдийн хөрөнгөөр, үлдэх 80 хувь буюу 20,1 сая ам.долларийг гадны зээлээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байв.

2010:

Ухаахудагийн ДЦС-ийг барьж байгуулах ажил эхлэв. Энэ ажлыг “М-Си-Эс Интернэйшнл” ХХК хариуцан гүйцэтгэж зураг төслийг Хятад улсын Chengdu Engineering Co., Ltd компани хийсэн байна.

2011 оны 9-р сар.

ЭБЭХЯ-ны төрийн нарийн бичгийн дарга Т.Цэрэнпүрэв, “Ухаа худаг дээр 62 МВт-ын хүчин чадалтай станц барихаас 12 МВт-ынхнь баригдаад дуусч байна” гэж мэдэгдэв.

2011 оны 9-р сар.

Ухаахудагийн цахилгаан станц ашиглалтад оров. Тус станцын технологийн бүхий л шийдэл Дэлхийн Банк болон олон улсын байгууллагуудаас батлан гаргасан байгаль орчны стандартад бүрэн нийцэж байгаа бөгөөд н140 гаруй ажлын байр шинээр бий болсны 30 орчим хувьд орон нутгийн иргэд болсныг мэдээлэв.

2011.10.25.

УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаан дээр ЭБЭХ-ний сайд Д.Зоригт “Яг өнөөдрийн байдлаар 18 МВт-ын тусгай зөвшөөрөлтэй эх үүсвэр Ухаа худаг дээр байгаа. Өргөтгөлийн зөвшөөрөл бид өгөхгүй. Яагаад гэхээр энэ уснаасаа, бусад юмнаасаа болоод тэр” гэж мэдэгджээ.

2012.04.10:

ЭБЭХЯ-ны төрийн нарийн бичгийн дарга Т.Цэрэнпүрэв сурвалжлагчийн асуултанд хариулахдаа ““Энержи ресурс” компани Ухаа худагт 18 МВт-ын станц ашиглалтад оруулж байна, яваандаа хүчин чадлыг нь өргөтгөхөөр төлөвлөж байгаа юм билээ” гэжээ.

Мөн Ухаахудагийн ДЦС-аас гадна монголын “Ньюком” компани Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт 50 МВт-ын хүчин чадалтай “Салхитын салхины цахилгаан станцыг барьж байна. Саяхан энэ цахилгаан эрчим хүчийг худалдах, худалдан авах гэрээнд гарын үсэг зуржээ.

Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй	
Бие даасан эрчим хүч үйлдвэрлэгчийн кейс судалгаа нь чанарын ямар ч элементийг хангаагүй	Доод _
Бие даасан эрчим хүч үйлдвэрлэгчийн кейс судалгаа нь чанарын нэг элементийг хангасан	Доодоос дунд _
Бие даасан эрчим хүч үйлдвэрлэгчийн кейс судалгаа нь чанарын хоёр элементийг хангасан	Дунд ✓
Бие даасан эрчим хүч үйлдвэрлэгчийн кейс судалгаа нь чанарын гурваас дөрвөн элементийг хангасан	Дундаас дээд _
Бие даасан эрчим хүч үйлдвэрлэгчийн кейс судалгаа нь чанарын бүх таван элементийг хангасан	Дээд _
Мэдээллийн эх сурвалж:	-Ухаахудагийн ДЦС-ын танилцуулга - Салхитын салхин цахилгаан станцын танилцуулга - УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны хуралдааны протокол
Нэмэлт мэдээлэл:	

БҮЯ26. ХУВИЙН ХЭВШЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧДИЙГ ИЛ ТОД СОНГОН АВСАН ЭСЭХ

Чанарын элементүүд	Тайлбар
Санал ирүүлэх урилгын ил тод байдал	Т Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 14 дүгээр тогтоолыг үндэслэн “Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчид хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг нэг багц болгон нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар худалдахаар Төрийн өмчийн хорооны 2003 оны 454 дүгээр тогтоолоор шийдвэрлэсний дагуу нээлттэй уралдаант шалгаруулалтын зарыг 2003 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн “Өдрийн сонин”, “Үнэн”, “Өнөөдөр” зэрэг сонин хэвлэлээр зарласан.
Санал ирүүлэгчдэд өгсөн баримт бичиг олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй байсан эсэх	Т Тендерийн зар мэдээ, журамд заасны дагуу Төрийн өмчийн хорооны Өмч хувьчлалын газар урьдчилсан шалгаруулалтыг хийсэн бөгөөд эдгээр өргөдлүүд бүгд тэнцэж тендерийн оролцогч болсон. Тендер оролцогч бүрт тендерийн баримт бичиг болох Компанийн тухай ерөнхий мэдээлэл, “Уралдаант шалгаруулалтын журам”, “Худалдан авах гэрээний төсөл”-ийг хүргүүлж, “Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК дээр дүн шинжилгээ хийх бололцоогоор хангасан. Гэрээний төслийн талаар саналаа гаргаж гэрээнд тусгах боломж олгосон болно. Мөн оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 17.00 цагт тендерт оролцох саналаа 2 оролцогч “Магнайтрейд” ХХК, “Хасвуу” ХХК ирүүлсэн байна.

Шийдвэрийн шалгуур үзүүлэлт болон үйл явц	Т	<p>Сонгон шалгаруулалт хийх Шинжээчдийн багийг Санхүү, эдийн засгийн яам, Дэд бүтцийн яамтай зөвшилцөн Төрийн өмчийн хорооны даргын тушаалаар байгуулсан.</p> <p>Гишүүд 2 компанийн техникийн саналд тендерийн журмын дагуу үнэлгээ, хийсэн.</p> <p>1.Тендерт оролцогч бизнесийн чадавхи, санхүүгийн байдал, ажлын туршлага /40 оноо/</p> <p>2.“Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-д хэрэгжүүлэхээр санал болгож буй бизнес төлөвлөгөөний чанар, бодит байдал, Засгийн газраас тавьж буй хувьчлалын зорилгыг хүлээн авч тусгасан байдал /дээд оноо 50/</p> <p>Үүнд: дэд үзүүлэлтүүд болон</p> <p>а/ үндсэн үйл ажиллагааны чиглэл, хөрөнгийн зориулалтыг өөрчлөхгүйгээр хэвийн ажиллуулж, цахилгаан эрчим хүч түгээх, ханган үйл ажиллагааг боловсронгуй болгох /0-20 оноо/</p> <p>б/ компанийн үйл ажиллагааны түвшинг бууруулахгүй байх, үр ашгийг дээшлүүлэх, өргөтгөх, хөрөнгө оруулалт хийж компанийн техник технологийг шинэчлэх /0-20 оноо/</p> <p>в/ өр авлагыг барагдуулах /0-10 оноо/</p> <p>3.Ажиллагсад учрах эрсдлийг бууруулах / ажлын байрын хэвийн нөхцлийг сайжруулах, ажиллагсадын хөдөлмөр эрхлэлтийн баталгааг хангах, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас тахир дутуу болж хөдөлмөрийн чадваргүй болсон ажиллагсад олгох нөхөн төлбөрийг хөдөлмөрийн хууль тогтоомжийн дагуу олгох г.м /дээд оноо 10/</p>
---	---	---

Шийдвэр гаргахад хийсэн өөрчлөлт	Т	<p>Тендерийн журмын дагуу 2 шат санхүүгийн саналыг нийтийн өмнө нээхэд хамгийн их үнийн саналыг “Хасвуу” ХХК ирүүлсэн байлаа. Техникийн болон Санхүүгийн саналаар ялагч болсон “Хасвуу” ХХК-тай “Худалдан авах худалдах гэрээ”-г байгуулж төлбөр хугацаандаа хийгдсэн тул хувьцааг өмчлөх эрхийг шилжүүлж, компанийг хүлээлгэн өгсөн.</p>
----------------------------------	---	---

Тайлбарын үргэлжлэл:
Энэ асуултыг Эрчим хүчний салбарт хувийн хэвшлийн үйлчилгээ үзүүлэгчийг анх удаа буюу 2003 онд “Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчид хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг нэг багц болгон нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар худалдсан жишээн дээр хариулав.

Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй / Үнэлгээ хийгээгүй	–
Байгаль орчны зөвшөөрлийн эрх мэдлийн талаар ил тод байдал байхгүй	Доод _
Хувийн хэвшлийн оролцоо чанарын ямар нэг ч элементийг хангаагүй	Доодоос дунд
Хувийн хэвшлийн оролцоо чанарын нэг элементийг хангасан	Дунд _
Хувийн хэвшлийн оролцоо чанарын хоёр элементийг хангасан	Дундаас дээд _
Хувийн хэвшлийн оролцоо чанарын гурав болон түүнээс элементийг хангасан	Дээд ✓
Мэдээллийн эх сурвалж:	Төрийн өмчийн хороонд явуулсан албан бичгийн хариу
Нэмэлт мэдээлэл:	

БҮЯ27. ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ/САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

Чанарын элементүүд:	Тайлбар:
Нээлттэй байлгах болон арга зүйд тодотгол хийх	T Компанийн тайлан тэнцэл хөрөнгийн өөрчлөлтүүдийг цаг хугацаанд нь тусгахын хамт өөрийн хөрөнгө болон хувьцааны хэмжээ өөрчлөгдсөн тохиолдолд Эрчим хүчний хувь нийлүүлэгчдийн хурлаар оруулж хэлэлцүүлэн баталгаажуулж, Үнэт цаасны хороо болон Хөрөнгийн биржид бүртгүүлж ирсэн байна. Компанийн үндсэн хөрөнгөд "Итгэлт-Аудит" ХХК хөрөнгийн үнэлгээ хийжээ.
Аргачлалын хэрэглээг тайлбарлах	T Төрийн өмчийн хорооны 2003 оны 2/908 тоот албан бичгээр хөрөнгийн үнэлгээнд залруулга, бизнес үнэлгээ хийлгэх тухай "Итгэлт Аудит" мэдэгдсэн байна. Мөн үнэлгээ хийлгэх тухай хөрөнгийн үнэлгээний 4 газарт мэдэгдэж албан тоот хүргүүлсэн. Дээрх үнэлгээний компаниуд нь үнэлгээ хийх хугацаа, арга болон үнийн саналаа ирүүлсэн байна. Хөрөнгийн үнэлгээний компаниуд нь нилээд хугацааны турш өөр өөрсдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж ирсэн бөгөөд үнэлгээндээ зах зээлийн жишиг арга, орлогын арга гэх мэт аргуудыг хэрэглэсэн байна.
Бие даасан үнэлгээ	T Үнэлгээний компаниудын ирүүлсэн саналыг авч үзэн шалгаруулалт явуулахад "Итгэлт-Аудит" ХХК шалгарсан байна. "Итгэлт-Аудит" ХХК 3 аргаар үнэлгээ хийжээ. Үүнд: 1. Мөнгөн гүйлгээний урсгалыг хорогдуулах арга 2. Хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ 3. Тохируулга хийсэн цэвэр активын үнэлгээ Эдгээр хийсэн аргуудаас гадна Засгийн газрын 84 дүгээр тогтоолоор баталсан "Худалдах доод үнэ тогтоох журам"-д заасан үнэлгээ аргуудаар тооцож үзсэн байна. Энэ аргууд нь 1. Хувьчлагдах хөрөнгийн хэмжээний арга 2. Сүүлийн 3 жилийн татварын дараах ашгийн арга 3. Хувьцааны нэрлэсэн үнээр тооцох арга болно. Ингэж олон аргаар тооцооор "Итгэлт-Аудит" ХХК-ийн үнэлгээний санал болгосон аргуудаас 1 болон 3 аргад ач холбогдол өгч үнэ тогтоосон байна.
Тоймыг олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй болгосон байх	Y Олон нийтэд хүртээмжтэй байдлаа хүргээгүй
<p>Үргэлжлэл тайлбар: Үүнийг мөн "Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчид хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг уралдаант шалгаруулалтын аргаар худалдсан жишээн дээр хариулав.</p>	
Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй	–
Хөрөнгийн үнэлгээний үйл явц нь чанарын аль ч элементийг хангаагүй	Доод _
Хөрөнгийн үнэлгээний үйл явц нь чанарын нэг элементийг хангасан	Доодоос дунд _
Хөрөнгийн үнэлгээний үйл явц нь чанарын хоёр элементийг хангасан	Дунд _
Хөрөнгийн үнэлгээний үйл явц нь чанарын гурван элементийг хангасан	Дундаас дээд ✓
Хөрөнгийн үнэлгээний үйл явц нь чанарын бүх дөрвөн элементийг хангасан	Дээд _
Мэдээллийн эх сурвалж:	Төрийн өмчийн хороонд явуулсан албан бичгийн хариу
Нэмэлт мэдээлэл:	

БҮЯ28. ТАТААСЫГ БИЙ БОЛГОЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

Чанарын элементүүд:	Тайлбар:
Ил тодын шалгуур	T Төрийн зүгээс татаас олгох нь улсын төсвийг баталдаг УИХ-ын эрх хэмжээний асуудал гэдэг нь олон нийтэд тодорхой байдаг. Үүнийг жил бүр Монгол Улсын нэгдсэн төсвийн хүрээнд шийдвэрлэж байна. Улсын төсөв батлагдсан даруйдаа олон нийтэд нээлттэй болдог
Татаас олгох шийдвэрийн үндэслэл	T Татаас олгох асуудлыг ЭБЭХЯ ба Сангийн яамнаас судлан үзэж боловсруулаад Засгийн газрын хурлаар хэлэлцэж Улсын Их Хуралд өргөн барьж хэлэлцүүлэн шийдвэрлэж иржээ.
Хяналт, тайлан мэдээлэл	Y Тайлан мэдээлэл байгаа гэж хариулсан боловч энэ талаар олон нийтэд ил тод мэдээлж вэбсайт дээр тавиагүй байна.
Үнэлгээ	–
Тайлбарын үргэлжлэл:	
Үнэлгээ:	Сонгох:
Хамааралгүй/үнэлээгүй	–
Үнэлгээ хийсэн татаасын хөтөлбөр чанарын шалгуур үзүүлэлтийн нэгч элементийг хангаагүй	Доод _
Үнэлгээ хийсэн татаасын хөтөлбөр чанарын шалгуур үзүүлэлтийн нэг элементийг хангасан	Доодоос дунд
Үнэлгээ хийсэн татаасын хөтөлбөр чанарын шалгуур үзүүлэлтийн хоёр элементийг хангасан	Дунд ✓
Үнэлгээ хийсэн татаасын хөтөлбөр чанарын шалгуур үзүүлэлтийн гурван элементийг хангасан	Дундаас дээд _
Үнэлгээ хийсэн татаасын хөтөлбөр чанарын шалгуур үзүүлэлтийн бүх дөрвөн элементийг хангасан	Дээд
Мэдээллийн эх сурвалж:	<ul style="list-style-type: none"> -ЭБЭХЯ-нд явуулсан албан бичгийн дагуу тус яамны газрын орлогч дарга Д.Пүрэвбаяртай хийсэн ярилцлага -Эрчим хүчний газарт явуулсан албан бичгийн хариу -Санхүү хөрөнгө оруулалтын газрын тайлан -Эрдэс баялаг эрчим хүчний салбарын 2009-2010 оны ажлын үр дүнгийн тойм -Эрчим хүчний газрын жилийн тайлан -ЭБЭХЯ-ны жилийн тайлан
Нэмэлт мэдээллүүд:	

БҮЯ29. ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ТӨСЛҮҮДЭД БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЭРХИЙН ЧАДАМЖ, ЭРХ ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭ ТОВ ТОДОРХОЙ БАЙХ НЬ

Чанарын элементүүд:	Т	Тайлбар:
Эрх мэдэл, эрх хэмжээний тухай заалтууд	Т	Эрчим хүчний тухайн хуулийн 20.3-т заасны дагуу эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрлийг авахын тулд Байгаль орчинд нөлөөлөх үнэлгээний тухай хуулийн 4 зүйлийн 4.1-д заасны дагуу уг хуулийн хавсралтанд заасан ангиллаар БОАЖЯ эсвэл аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хандаж байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэдэг.
Эрх мэдлийг хэрхэн хуваарилах нь тов тодорхой байх	Т	Уг үнэлгээний хүрээнд эхний ээлжинд ерөнхий үнэлгээ хийгддэг бөгөөд төслийн байршлын онцлог, хүчин чадлын үзүүлэлт, ашиглалтын технологийн онцлог зэргээс хамаарч үнэлгээний хуулийн 4 дүгээр зүйлийн 4.6-д заасан дүгнэлтийн аль нэгийг гаргах бөгөөд нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж ерөнхий үнэлгээний дүгнэлт гарсан тохиолдолд энэ чиглэлийн эрх бүхий мэргэжлийн байгууллагаар нарийвчилсан үнэлгээ хийлгэж, тайлан боловсруулан БОАЖЯ-ны байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний асуудлыг зохицуулах комиссын хурлаар хэлэлцүүлдэг. Уг үнэлгээний тайланд холбогдох орон нутгийн иргэдийн саналыг авсан байх, мөн харьяалах сум, дүүргийн ИТХ-аас санал авсан байх шаардлагууд тавигддаг.
Зөвшөөрөл олгосон тухай цаг алдалгүй мэдээлэх	Т	Энэхүү үнэлгээний тайланг хүлээн авсан байгууллага олон нийтэд мэдээлэх талаар үнэлгээний хуулийн 7 дугаар зүйлийн 7.5-д заасны дагуу 30 хоногийн дотор вэб сайтаар мэдээлдэг.
Дэлгэрэнгүй мэдээлэл өгөх	Ү	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай дэлгэрэнгүй мэдээллийг Байгаль орчны үндэсний мэдээллийн сангийн http://geodata.mne-ngic.mn хаягаар орж, гэхдээ зөвхөн хүсэлт гаргасны дагуу авах боломжтой. Дан ганц эрчим хүчний салбараар гаргадаггүй харин, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу хүн ам, сонирхогч аж ахуйн нэгж байгууллагыг мэдээллээр хангаж ажилладаг.
Мэдээлэл авахад хялбар байх	Ү	Байгаль орчны үнэлгээний талаар зөвхөн хүсэлт гаргасны үндсэнд мэдээлэл авах боломжтой учраас хялбар биш.
Хүртэмжтэй форматтай байх	Ү	Товхимол, зурагт хуудас, мэдээлийн хуудас зэрэг хүртэмжтэй хэлбэрээр авах боломжгүй.
Тайлбарын үргэлжлэл: ЭБЭХЯ-нд төслийн байгаль орчны үнэлгээ хариуцсан нэгж (хэлтэс/газар) байхгүй байгаа нь энэ талын мэдээллийг олон нийтэд түгээх, мэдээлэл олж авахад хүндрэл учруулж байна. Мөн БОАЖЯ болон ЭБЭХЯ-ны хоорондын уялдаа холбоо хангалтгүй.		
Үнэлгээ:		Сонгох:
Хамааралгүй/ үнэдээгүй		-
Эрчим хүчний салбарын төслүүдэд байгаль орчны үнэлгээний зөвшөөрөл олгох эрхийн чадамж, эрх хэмжээний хүрээ тодорхой бус		Доод _
Эрхийн чадамж, эрх хэмжээний хүрээнд чанарын үзүүлэлтийн нэг элементийг хангасан		Доодоос-Дунд _
Эрхийн чадамж, эрх хэмжээний хүрээнд чанарын үзүүлэлтийн хоёр элементийг хангасан		Дунд _
Эрхийн чадамж, эрх хэмжээний хүрээнд чанарын үзүүлэлтийн гурван элементийг хангасан		Дундаас-Дээд _

Эрхийн чадамж, эрх хэмжээний хүрээнд чанарын үзүүлэлтийн дөрөв түүнээс илүү элементийг хангасан

Дээд ✓

Мэдээллийн эх сурвалж: -Эрчим хүчний тухай хууль (2012)
- Байгаль орчинд нөлөөлөх үнэлгээний тухай хууль (1998,2001)
-БОАЖЯ-нд явуулсан албан бичгийн хариу
-ЭБЭХЯ-нд явуулсан албан бичгийн дагуу тус яамны ажилтнуудтай хийсэн ярилцлага
-Эрчим хүчний газарт явуулсан албан бичгийн хариу
-Эрчим хүчний газрын жилийн тайлан
-ЭБЭХЯ-ны жилийн тайлан

Нэмэлт мэдээлэлүүд:

БҮЯЗО. БАЙГАЛЬ ОРЧНЫ МИНИМУМ СТАНДАРТЫГ ТОГТООХОД ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО

Чанарын элементүүд:	Тайлбар:
Стандартуудын үндэс суурь	T Орон нутагт дэд бүтцийн хөгжлийн төсөлд ерөнхий үнэлгээг хийхдээ "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хуулийн хавсралтанд, нэг МВ хүртэл хүчин чадалтай цахилгаан станц, 35 кВ хүртэл хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам, тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд дамжуулах дулааны шугам, орон нутгийн чанартай зам болон холбооны төслүүдэд хийнэ гэж заажээ.
Олон нийтийн зөвлөлдөх үйл явцын талаарх нотолгоо	T Стандартыг тогтоохдоо холбогдох байгууллага, хүмүүсээс санал авч, шүүмж хийлгэн салбар хороогоор хэлэлцүүлдэг. Энэ салбар хороонд олон нийтийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл байдаг.
Олон нийтийн оролцооны механизмын олон талт байдал	Y Олон нийтийн санал авах, сонсгол явуулах, судалгаа хийх зэрэг олон янзын арга хэлбэрийг одоогоор ашигладаггүй.
Олон нийтийн гаргасан саналыг хэрхэн тусгасан талаар тайлагнах	Y Холбогдох эрх бүхий байгууллагаас байгаль орчны стандартын асуудлаар олон нийтээс гарсан саналыг захиалгчид мэдэгдэн хэрхэн шийдвэрлэх талаар хамтын шийдвэр гаргадаг, Дөргөн, Тайширын усан цахилгаан станц барих явцад тодорхой асуудлуудыг шийдвэрлэсэн гэж хариулсан боловч үүнийг батлах мэдээлэл олдоогүй.
Даган мөрдөж буй талаар тайлагнах	Y Эрчим хүчний салбар нь байгаль орчны үйл ажиллагааны стандартыг хэр хэмжээнд даган мөрдөж байгаагаа жил тутамд тайлагнадаг гэж эрх бүхий байгууллагаас хариулсан боловч тухайн жилд гаргасан тайлан болон уг байгууллагын вэб сайтаас тайлагнасан мэдээллийг олж авч чадаагүй. Тухайн чиглэлийн төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан холбогдох стандартын дагуу хийж гүйцэтгэх ажлын нарийвчилсан төлөвлөгөөг батлуулж, уг төлөвлөгөөний дагуу хийсэн ажлын талаар жил бүр яам, холбогдох газруудад тайлагнаж ажилладаг. Уг мэдээллийг зөвхөн яам, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт ирүүлдэг нь олон нийтэд ил тод биш, байгаль орчны стандартыг мөрдөж ажилласан эсэхэд хяналт тавих бололцоо олгодоггүй байна.
Үргэлжлэл тайлбар:	
Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй	-

Цахилгааны салбарын минимум стандартыг тогтоогоогүй	Доод _
Цахилгааны салбарын төсөл, үйл ажиллагааны минимум стандарт хууль, бодлого болон журмуудад тусгагдсан. Тэдгээр нь хоёроос цөөн чанарын элементийг хангасан	Доодоос дунд ✓
Цахилгааны салбарын төсөл, үйл ажиллагааны минимум стандарт хууль, бодлого болон журмуудад тусгагдсан. Тэдгээр нь хоёроос гурван чанарын элементийг хангасан	Дунд _
Цахилгааны салбарын төсөл, үйл ажиллагааны минимум стандарт хууль, бодлого болон журмуудад тусгагдсан. Тэдгээр нь чанарын дөрвөн элементийг хангасан	Дундаас дээд _
Цахилгааны салбарын төсөл, үйл ажиллагааны минимум стандарт хууль, бодлого болон журмуудад тусгагдсан. Тэдгээр нь чанарын бүх таван элементийг хангасан	Дээд _
Мэдээллийн эх сурвалж:	<ul style="list-style-type: none"> - Байгаль орчинд нөлөөлөх үнэлгээний тухай хууль (1998,2001) -БОАЖЯ-нд явуулсан албан бичгийн хариу -ЭБЭХЯ-нд явуулсан албан бичгийн дагуу тус яамны ажилтнуудтай хийсэн ярилцлага -Эрчим хүчний газарт явуулсан албан бичгийн хариу -Эрчим хүчний газрын жилийн тайлан -ЭБЭХЯ-ны жилийн тайлан
Нэмэлт мэдээлэл:	

БҮЯЗ1. БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ БОДЛОГЫГ БОЛОВСРУУЛАХАД ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО

Чанарын элементүүд:	Тайлбар:
Олон хандлагуудын харгалзан үзсэн эсэх	<p>Т Үнэлгээний удирдамжинд энэ асуултын шалгуур болгосон 1.хосолсон байдлаар эрчим хүч үйлдвэрлэх, 2.эрэлтийн талын удирдлага, 3.цахилгааны хэмнэлттэй компаниудыг үүсгэх, 4.сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт төв шугам холбогдсон, 5.сэргээгдэх эрчим хүчний технологийг дэлгэрүүлсэн, 6.дулаан/хатуу түлшний технологийг сайжруулсан, 7.бүх цахилгаан станц дээр бохирдол хянах үйл ажиллагааг сайжруулсан, 8.дамжуулах, түгээх сүлжээний алдагдлыг бууруулсан зэрэг хандлагуудаас манай улс ихэнхийг нэвтрүүлэхээр ажиллаж байгаа. Эдгээрээс хамгийн их хүчин чармайлт гаргаж байгаа нь сэргээгдэх эрчим хүч юм.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Мянганы хөгжлийн зорилт, Монгол Улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр, Монгол Улсын эрчим хүчний тогтвортой хөгжлийн стратеги /2002-2010 он/ зэрэг баримт бичгүүдэд сэргээгдэх эрчим хүчийг манай улсын эрчим хүчний салбарын тэргүүлэх чиглэлийн нэг болгон хөгжүүлэхээр заасан байна.</p> <p>“Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр”-ийн хүрээнд өнөөдрийн байдлаар манай улсын 331 сумын 305 нь цахилгаан дамжуулах шугамаар төвлөрсөн системд холбогдсон ба 20 сумыг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр тус тус цахилгаан эрчим хүчээр хангаад байна.</p> <p>“100000” нарны гэр хөтөлбөр”-ийг хэрэгжүүлсний үр дүнд 80 орчим мянган малчин айл өрх нарын цахилгаан эх үүсгүүртэй болсон бөгөөд дахин 20 мянган эх үүсгүүрийг малчдад олгох ажлыг зохион байгуулж байна. Дөргөний усан цахилгаан станц ашиглалтад орсон. Тайширын УЦС туршилтын байдлаар ажиллаж Говь-Алтай аймгийн зарим хэсэг, сумдыг эрчим хүчээр хангаж байна.</p>

Зөвлөлдөх үйл явцын талаарх нотолгоо	Т	Сэргээгдэх эрчим хүчний үндэсний форумыг 2008 оноос жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг. 2011 оны сүүлчээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Түлш, эрчим хүчний бодлогын дэд зөвлөлөөс “Нарны эрчим хүчийг ашиглах нь” сэдвийг Иргэний танхимаар хэлэлцүүлж зөвлөмж гаргасан байна.
Нөлөөнд автаж буй олон нийттэй зөвлөлдөх системтэй хүчин чармайлт	Ү	Эрчим хүчний барилга байгууламж, ялангуяа усан цахилгаан станцын нөлөөнд автаж болзошгүй хүмүүстэй зөвлөлдөх хүчин чармайлт гаргаагүй, тийм механизм байхгүй. .
Олон тооны нийтийн оролцооны механизмуудыг ашигласан эсэх	Ү	Олон нийтийн сонгол хэлэлцүүлэг хийх, бичгээр санал авах зэрэг оролцооны олон янзын механизмуудыг ашиглахгүй байна.
Үргэлжлэл тайлбар: Дөргөн болон Тайширын усан цахилгаан станцуудыг барихдаа нөлөөнд автаж буй олон нийттэй зөвлөлдөх системтэй хүчин чармайлт гаргаагүй нь ихээхэн шүүмжлэлд өртөж байна.		
Үнэлгээ:	Сонгох:	
Боломжгүй / Үнэлгээ хийгээгүй	–	
Байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай удирдлага, технологийн сонголтуудыг харгалзан үзээгүй	Доод _	
Байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай удирдлага, технологийн сонголтуудыг харгалзан үзсэн байдал нь чанарын нэг элементийг хангасан	Доодоос дунд _	
Байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай удирдлага, технологийн сонголтуудыг харгалзан үзсэн байдал нь чанарын хоёр элементийг хангасан	Дунд ✓	
Байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай удирдлага, технологийн сонголтуудыг харгалзан үзсэн байдал нь чанарын гурван элементийг хангасан	Дундаас дээд _	
Байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай удирдлага, технологийн сонголтуудыг харгалзан үзсэн байдал нь чанарын дөрвөн элементийг хангасан	Дээд _	
Мэдээллийн эх сурвалж:	-БОАЖЯ-нд явуулсан албан бичгийн хариу -Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр, Монгол Улсын эрчим хүчний тогтвортой хөгжлийн стратеги /2002-2010 он/ -Эрчим хүчний газарт явуулсан албан бичгийн хариу -Эрчим хүчний газрын жилийн тайлан -ЭБЭХЯ-ны жилийн тайлан -Монголын Инженерүүдийн Холбооноос УИХ-ын даргад явуулсан нээлттэй захидал	
Нэмэлт мэдээлэл:		

БҮЯЗ2. БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДЛЫГ САЛБАРЫН ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД БАГТААСАН НЬ

Чанарын элементүүд	Тайлбар
Байгаль орчны асуудлыг харгалзан үзсэн	T Эрчим хүчний салбарын хөгжлийн хэтийн төлөв, стратегийг тодорхойлсон сүүлийн үеийн баримт бичгүүдэд байгаль орчны асуудалд нэлээд ач холбогдол өгч, үйл ажиллагааны чухал хүчин зүйлүүдийн нэг гэж үзсэн байна. Харин эрчим хүчний салбарын ерөнхий (мастер) төлөвлөгөөнд маш бага тусгагдсан байна.
Үзүүлэх нөлөөллийг цогц байдлаар харгалзан үзсэн	Y Цогц байдлаар авч үзэх хандлага дутагдалтай.
Олон тооны нийтийн оролцооны механизм хэрэглэсэн	Y Салбарын хөгжлийн төлөвлөгөөний төсөлд санал авахдаа хэлэлцүүлгээс олон янзын оролцооны механизмыг ашигласан тухай мэдээлэл байхгүй.
Олон тооны оролцогч талуудаас санал бодлыг нь авах системтэй хүчин чармайлтыг гаргасан	Y Гаргаагүй. Ялан эмзэг болон үйл ажиллагааны нөлөөнд өртөх хамгийн магадлалтай бүлгээс саналыг нь авах талаар дорвитой анхаараагүй.
Гарсан саналуудын нийтэд нээлттэй болгосон	Y Ямар саналууд гарсныг нээлттэй болгоогүй_
Гарсан саналуудыг эцсийн шийдвэрт хэрхэн тусгасан талаар эргэн тайлагнасан	Y Тайлагнаагүй.
Тайлбарын үргэлжлэл: Эрчим хүчний салбарын үндэсний хэмжээний төлөвлөгөө гэж бид юуны өмнө Эрчим хүчний салбарын ерөнхий (мастер) төлөвлөгөөг авч үзлээ. Анх 1996 онд Эрчим хүчний мастер төлөвлөгөө, дараа нь 2001 онд Эрчим хүчний төлөвлөлтийн хүчин чадлыг бэхжүүлэх (мастер төлөвлөгөө) гарснаас хойш арваад жил өнгөрсөн тул одоо Азийн хөгжлийн банкны төслөөр 2025 он хүртэл хугацаатай боловсруулахаар ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.	
Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй	-
Хамгийн сүүлд боловсруулсан эрчим хүчний салбарын хөгжлийн төлөвлөгөөнд байгаль орчны асуудлыг шууд тусгаагүй.	Доод
Цахилгааны салбарын хөгжлийн төлөвлөгөөнд байгаль орчны асуудалд анхаарсан байдал нь чанарын нэг элементийг хангасан	Доодоос дунд ✓
Цахилгааны салбарын хөгжлийн төлөвлөгөөнд байгаль орчны асуудалд анхаарсан байдал нь чанарын хоёр элементийг хангасан	Дунд _
Цахилгааны салбарын хөгжлийн төлөвлөгөөнд байгаль орчны асуудалд анхаарсан байдал нь чанарын гурван элементийг хангасан	Дундаас дээд
Цахилгааны салбарын хөгжлийн төлөвлөгөөнд байгаль орчны асуудалд анхаарсан байдал нь чанарын дөрөв болон түүнээс дээш тооны элементийг хангасан.	Дээд _

Мэдээллийн эх сурвалж:

- Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2008-2012),
-Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр,
-Монгол Улсын эрчим хүчний тогтвортой хөгжлийн стратеги /2002-2010 он/
-Эрчим хүчний салбарын удирдах ажилтны зөвлөгөөн дээр ЭБЭХЯ-ны ЭХБГ-ын дарга Т.Цэрэнпүрэвийн тавьсан илтгэл
- Эрчим хүчний төлөвлөлтийн хүчин чадлыг бэхжүүлэх (мастер) төлөвлөгөө (2001)
- Эрчим хүчний салбарын мастер төлөвлөгөөг шинэчлэх төслийн удирдагч Ц.Оюунгэрэлийн яриа.

Нэмэлт мэдээлэл:

БҮЯЗЗ. БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУЛЬ, БОДЛОГО, ҮЙЛ ЯВЦЫН ЦОГЦ БАЙДАЛ

Чанарын элементүүд:	Тайлбар:
Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ хийх шаардлага	Т Эрчим хүчний тухай хуулийн 20.3-т заасны дагуу эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрлийг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг үндэслэн олгох, 25.1.11 үйл ажиллагаагаа эхлэхээс өмнө байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг эрх бүхий байгууллагаар хийлгэх, байгаль хамгаалах, нөхөн сэргээх жил бүрийн төлөвлөгөө боловсруулж, холбогдох байгууллагаар батлуулж мөрдөх зэрэг шаардлагуудыг тусгасан байдаг. Орон нутагт дэд бүтцийн хөгжлийн төсөлд ерөнхий үнэлгээг хийхдээ “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн хавсралтын дагуу 1 мВ хүртэл хүчин чадалтай цахилгаан станц, 35 кВ хүртэл хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам, тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд дамжуулах дулааны шугам, орон нутгийн чанартай зам болон холбооны төслүүдэд хийх шаардлага тавигддаг.
Нийгмийн нөлөөллийн үнэлгээний зааварчилгаанууд	Ү Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийхтэй холбоотой журам, аргачлалд энэ талаар тусгагдсан байдаг. Харин эрчим хүчний салбарын бодлого, дүрэм журамд энэ асуудал албан ёсоор тусгагдсан журам заавар хараахан байхгүй. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний талаар эх хэл дээр боловсруулан гаргасан ном, аргачлал, гарын авлага дутагдалтай, нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий аж ахуйн нэгжүүд өөрсдийн ажилдаа баримтлах нэгдсэн арга зүй байхгүй зэргийг харгалзан “Байгаль орчны үнэлгээ эрхлэгчдийн холбоо” ТББ-аас “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачилсан заавар” гарын авлагыг боловсруулж гаргасан.
Стратегийн үнэлгээний зааварчилгаа	Ү “Байгаль орчны үнэлгээ эрхлэгчдийн холбоо” ТББ нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний гарын авлагадаа Байгаль орчны стратегийн үнэлгээний зааварчилгааг оруулсан хэдий ч, одоогоор Монгол Улсад аль ч чиглэлийн бодлого хөтөлбөрт стратегийн үнэлгээ хийх хууль эрх зүйн орчин бүрдээгүйтэй холбоотой энэ чиглэлээр ажил хийгдээгүй байна.
Стратегийн үнэлгээ хийгдсэн эсэх	Ү Хийгдээгүй. Одоо эрчим хүчний салбарын мастер төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж байна. Энэ ажлын нэг хэсэг нь байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг тогтоох ажил юм.

Тайлбарын үргэлжлэл: 2011 онд Эрчим хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар хэлэлцэх үеэр байгаль орчны асуудлыг тусад нь бүлэг болгож оруулах санал гарч байсан ч хүлээж аваагүй юм. Одоогоор эрчим хүчний салбарын байгаль орчны үнэлгээтэй холбоотой тусгайлсан журам, зааврууд албан ёсоор батлагдаж гараагүй байна.	
Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй	–
Үндэсний болон цахилгааны салбарын түвшний хууль, бодлого байгаа бөгөөд үүнд цахилгааны салбарын үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг заасан, чанарын нэг элементийг хангаж байгаа	Доод ✓
Үндэсний болон цахилгааны салбарын түвшний хууль, бодлого байгаа бөгөөд үүнд цахилгааны салбарын үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг заасан, чанарын хоёроос гурван элементийг хангаж байгаа	Дунд _
Үндэсний болон цахилгааны салбарын түвшний хууль, бодлого байгаа бөгөөд үүнд цахилгааны салбарын үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг заасан, чанарын дөрвөн элементийг хангаж байгаа	Дээд _
Мэдээллийн эх сурвалж:	Эрчим хүчний тухай хууль (2011) Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (1998,2001) “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачилсан заавар” (2009 он)
Нэмэлт мэдээлэл:	

БҮЯЗ4. ЭРЧИМ ХҮЧНИЙ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭГ ГАРГАХАД ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО

Чанарын элементүүд:	Тайлбар:
Судалгааны шатанд олон нийтийн оролцоо	T Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.8, 7 дугаар зүйлийн 7.3, Байгаль орчны сайдын 2006 оны 119 дүгээр тушаалаар батлагдсан “ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний комиссын журам”-д нарийвчилсан үнэлгээний тайланд төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн нутгийн иргэдийн саналыг авсан байх шаардлагуудыг тусгасан байдаг. Бүх чиглэлийн төслийн БОНБУ-нд санал авдаг журамтай.
Олон нийтийн оролцоог хангах нэгээс илүү механизм ашигласан	T 2010 онд Улаанбаатар хотод ДЦС-5 барихтай холбоотойгоор хийгдсэн БОНБУ-ийн анхан шатны үнэлгээний материалыг үзэхэд, төсөлд хэрэгжих нутаг дэвсгэрийн нутгийн иргэдийн саналыг асуулга бөглүүлэх, яриа таниулга хийх, иргэдийг оролцуулсан уулзалт хийх зэрэг байдлаар авсан байна.
Санал бодлоо өгөх хангалттай хугацаа	T Санал асуулгыг хоёр үе шаттайгаар авсан учраас санал бодлоо өгөх хангалттай хугацаа байсан гэж үзлээ.
БОНБУ-ний илтгэлийг олон нийтийн хүртээл болгох	Y Судалгааны тайланд үнэлгээний анхан шатны болон эцсийн тайланг дараах хэлбэрээр олон нийтэд түгээнэ, тухайлбал, ЭБЭХЯ ба БОАЖЯ-д тайланг хүргүүлэх, АХБ-ны www.adb.org сайтад англи хэл дээр байршуулах гэснээс харахад олон нийтэд хүртээл болгох тал дээр учир дутагдалтай, зөвхөн тухайн салбарын яамдуудад танилцуулснаар хязгаарлажээ. Бас зөвхөн англи хэл дээр тавьж байгаа мэдээллийг олж хүртэх боломжийг хязгаарлаж байна.

Олон нийттэй зөвлөлдөх удирдамж чиглэл	T	Байгаль орчны асуудлуудыг цаг тухайд нь үр дүнтэй шийдвэрлэх, төслийн жигд, амжилттай хэрэгжилтийг хангахын тулд төслийн түвшин дэх Гомдол барагдуулах механизм (ГБМ)-ийн удирдамжыг боловсруулсан байна. Тухайлбал, энэ удирдамжинд зааснаар төсөлтэй холбоотой ноцтой санал гомдлыг 3 долоо хоногийн дотор барагдуулж хариуг нь өгнө гэж заажээ.
БОНБУ-ний талаарх олон нийтийн санал бодлыг нийтэд зарлах	Y	Нийтэд зарлаагүй.
БОНБУ-ний илтгэлийн эцсийн хувилбарт олон нийтийн санал бодлыг авч үзсэн байх	T	ДЦС-5 төслийн БОНБ-ийн үнэлгээний эцсийн хувилбарт олон нийтээс авсан санал, зөвлөмж шүүмжийг тодорхой хэмжээгээр тусгасан ч олон нийтийн гэхээсээ илүү мэргэжилтэн, судлаачдын санал зөвлөмж давамгайлж байна.
Тайлбарын үргэлжлэл:		
Үнэлгээ:		Сонгох:
Хамаарахгүй / үнэлээгүй		–
БОНБУ-ний илтгэл чанарын үзүүлэлтийн альч элементийг хангаагүй		Доод _
БОНБУ-ний илтгэл чанарын үзүүлэлтийн нэгээс-хоёр элементийг хангасан		Доодоос дунд
БОНБУ-ний илтгэл чанарын үзүүлэлтийн гурваас-дөрвөн элементийг хангасан		Дунд _
БОНБУ-ний илтгэл чанарын үзүүлэлтийн таваас-зургаан элементийг хангасан		Дундаас дээд ✓
БОНБУ-ний илтгэл чанарын үзүүлэлтийн бүх долоон элементийг хангасан		Дээд _
Мэдээллийн эх сурвалж:		“Төр хувийн хэвшлийн түншлэлийг ашиглаж Улаанбатаар хотыг нүүрстөрөгч бага ялгаруулдаг эрчим хүчээр хангах төслийн эцсийн тайлан” Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (1998,2001)
Нэмэгдэл мэдээлэл:		

БҮЯЗ5. ТОДОРХОЙ ТӨСЛИЙН НӨЛӨӨНД АВТАЖ БУЙ ХҮМҮҮС ТӨСЛИЙГ БАТЛАХ/ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХТОЙ ХОЛБООТОЙ ЭРХЭЭ ЭДЭЛЖ БУЙ ЦАР ХҮРЭЭ


Чанарын элементүүд:	Тайлбар:
Шаардагдах үйл явц/зааварчилгааг ханган зөвлөлдөх үйл явцыг гүйцэтгэсэн	T Говь-Алтай аймагт Тайширын УЦС, Ховд аймагт Дөргөний УЦС-ыг барьж байгуулсан жишээн дээр авч үзэхэд, Тайширын УЦС-ыг барих явцад Завхан гол тасарсан газарт худаг гаргаж малчдын усны асуудлыг шийдвэрлэжээ. Ховд аймаг Дөргөний УЦС-ын доод хэсэгт буусан айлуудад усанд автах талаар таниулан сурталчилж, хөрөнгө гарган нүүлгэн шилжүүлэх ажлыг хэрэгжүүлсэн байна. Харин томоохон хот суурин газарт Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах, ард иргэдийг эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх хүрээнд хамгаалалтын зурваст суурьшуулахгүй байх талаар мэдлэг олгох сурталчилгааны үйл ажиллагааг байнга явуулж байна.
Мэдлэг олгох системтэй үйл ажиллагааг явуулсан	Y Улаанбаатар хотын дулаан цахилгааны шинэ эх үүсвэр барих газар чөлөөлөхийн тулд 7 аж ахуйн нэгж, 2 айлын газрыг чөлөөлөхөөр байгаа юм. Одоогоор эдгээр аж ахуйн нэгж болон айлуудтай уулзалт хийж учир байдлыг ухуулж буй боловч илүү гүнзгий ойлголт өгөх, мэдлэг олгох талаар системтэй ажиллахгүй байна гэж үзлээ.
Оролцооны нэгээс илүү тооны механизмыг ашигласан	T Дээр дурдсан төслийн янз бүрийн үе шатанд энэ төслийн шууд нөлөөнд өртөх ард иргэдтэй тэдний болон төсөл хэрэгжүүлэгчдийн санаачлагаар ирүүлж, эсвэл газар дээр нь очиж уулзах, танилцуулга тараах зэрэг хэд хэдэн хэлбэрийг зэрэг ашиглаж байна.
Чөлөөтэй, урьдчилсан, мэдээлэл бүхий зөвшөөрөлтэй зөвлөлдөх үйл явцыг гүйцэтгэх	Y Одоогоор ийм журам, процедур тогтоогүй байна.
Үргэлжлэл тайлбар:	
Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй	-
Төслийн нөлөөнд автаж буй хүмүүст хандахтай холбоотой нэг буюу түүнээс доош тооны элемент хангагдсан	Доод _
Төслийн нөлөөнд автаж буй хүмүүст хандахтай холбоотой хоёр элемент хангагдсан	Дунд ✓
Төслийн нөлөөнд автаж буй хүмүүст хандахтай холбоотой гурав буюу түүнээс дээш тооны элемент хангагдсан	Дээд _
Мэдээллийн эх сурвалж:	“Төр хувийн хэвшлийн түншлэлийг ашиглаж Улаанбатаар хотыг нүүрстөрөгч бага ялгаруулдаг эрчим хүчээр хангах төслийн эцсийн тайлан” БОАЖЯ-нд явуулсан албан бичгийн хариу Эрчим хүчний газарт явуулсан албан бичгийн хариу Эрдэс баялаг эрчим хүчний салбарын 2009-2010 оны ажлын үр дүнгийн тойм Эрчим хүчний газрын жилийн тайлан ЭБЭХЯ-ны жилийн тайлан
Нэмэлт мэдээлэл:	

БҮЯЗ6. ЦАХИЛГААНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖТЭЙ ХОЛБООТОЙ ШИЙДВЭР ГАРГАЛТАД ОРОЛЦОХ БАЙДАЛ

Чанарын элементүүд:	Т	Тайлбар:
Нэгээс илүү тооны зөвлөлдөх үйл явцыг хийсэн байх	Т	Төвийн эрчим хүчний нэгдсэн системд холбогдоогүй аймаг, сум, багийн иргэд, тэднийг төлөөлсөн албан тушаалтнууд дээш хүсэлт явуулах, УИХ-ын гишүүд, иргэдийн хурлын төлөөлөгчидтэй уулзалт хийх үеэр хүсэлт тавих, энэ хэр боломжтой, хэзээ хэрэгжүүлэх талаар хариулт өгөх, цааш хэрхэн уламжилж хөөцөлдсөн талаар эргэж мэдээлэх зэргээр зөвлөлдөх үйл явц янз бүрийн хэлбэрээр нэлээд хэдэн жилийн хугацаанд үргэлжилдэг болно.
Нийгэм эдийн засгийн эмзэг бүлгийнхэнтэй зөвлөлдөх системтэй хүчин чармайлт гаргасан байх	Т	Дээрх зөвлөлдөх үйл явцын хүрээнд хоёр талаасаа маш их идэвх чармайлт гаргадаг.
Олон нийтийн оролцооны хоёроос дээш тооны механизмыг хэрэгжүүлэх	Т	Янз бүрийн арга хэлбэрийг ашигладаг.
Олон нийтийн саналыг харгалзан үзэх	Ү	Орон нутгийн иргэдын санал хүсэлтийг хэрхэн шийдвэрлэсэн талаар тэдэнд албан хариуг өгч, санал хүсэлтийг шийдвэрлэсэн талаарх мэдээллыг холбогдох байгууллагуудад хүргэхийн зэрэгцээ эрчим хүчинд холбосон, шинэ эх үүсвэр байгуулсан бол улс орон даяар маш өргөн сурталчилдаг.
<p>Тайлбарын үргэлжлэл:</p> <p>Улс төрийн намууд болон улс төрийн сонгуульд нэр дэвшигчид эрчим хүчний найдвартай эх үүсвэр байхгүй, төвийн эрчим хүчний системд холбогдоогүй орон нутгийн сонгогчдийг эрчим хүчтэй болгох талаар мөрийн хөтөлбөрт тусган амлалт өгдөг ба сонгуулийн дараа түүнийг хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг Засгийн газрын мөрийн хөтөлбөр, хөрөнгө оруулалтыг жагсаалтанд тусгадаг. Бас албан тушаалтнуудыг дагуулан явж газар дээр нь үзүүлэх, үүрэг даалгавар өгөх зэргээр нөлөөлж ажилладаг. Бас нэг жишээ. "...Эрчим хүчинд холбох ажлыг юуны өмнө сонгогчдын хүсэлтийн дагуу хийж гүйцэтгэдэг гэж хэлж болно. Бид МАХН-ын "Ард түмнээ сонсоё" аяны хүрээнд Баянхонгор аймгийн Шинжинст сум, Дорнод аймгийн Матад сум, Өмнөговь аймгийн Манлай сум зэргээр УИХ-ын гишүүд болон сайдуудтай хамт явж иргэдтэй хийсэн уулзалтанд оролцож, нөхцөл байдалтай газар дээр нь танилцсаны үр дүнд эрчим хүчний нэгдсэн системд холбох төлөвлөгөөнд оруулахаар болсон" гэж яамны ажилтан ярьж байсан юм.</p>		
Үнэлгээ:		Сонгох:
Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй		–
Цахилгааны хүртээмжийг өргөтгөх шийдвэр гаргалт нь чанарын аль ч элементийг хангаагүй		Доод _
Цахилгааны хүртээмжийг өргөтгөх шийдвэр гаргалт нь чанарын хоёр элементийг хангасан		Дунд _
Цахилгааны хүртээмжийг өргөтгөх шийдвэр гаргалт нь чанарын гурав болон түүнээс дээш тооны элементийг хангасан		Дээд ✓
Мэдээллийн эх сурвалж:		Засгийн газрын мөрийн хөтөлбөр (2008-2012) ЭБЭХЯ-нд явуулсан албан бичгийн дагуу хийсэн ярилцлага Эрчим хүчний газарт явуулсан албан бичгийн хариу Эрдэс баялаг эрчим хүчний салбарын 2009-2010 оны ажлын үр дүнгийн тойм ЭБЭХЯ-ны жилийн тайлан
Нэмэлт мэдээлэл:		



Дөрөвдүгээр цахилгаан станц, 2011 он. Гэрэл зургийг Ц.Батбаатар



Асуулгын хариултууд:
**ЗОХИЦУУЛАЛТЫН
ҮЙЛ ЯВЦ**



ЗҮЯ1. ЗОХИЦУУЛАЛТЫН ШИЙДВЭР ГАРГАДАГ ИНСТИТУЦИЙН БҮТЭЦ


Тайлбар:

Монгол Улсад зохицуулалтын шийдвэр гаргадаг институци нь Эрчим хүчний зохицуулах хороо (ЭХЗХ) юм. Монгол Улсын эрчим хүчний тухай хуулийн дагуу Монгол Улсад Эрчим хүчний зохицуулах газрыг 2001 онд байгуулжээ. 2011 оны 12-р сарын 09-ний өдөр УИХ-аас Эрчим хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсны дагуу Засгийн газрын 2012 оны 2-р сарын 15-ны өдрийн 49 дугаар тогтоолоор Эрчим хүчний зохицуулах газар гэж байсныг Эрчим хүчний зохицуулах хороо болгон өөрчлөн байгуулжээ.

Эрчим хүчний тухай хуулинд өөрчлөлт орсноор ЭХЗХ-ын удирдлага нь орон тооны гурав, орон тооны бус хоёр зохицуулагчаас бүрдэх Зохицуулагчдын зөвлөл, Тусгай зөвшөөрлийн алба, Үнэ тарифын алба, Эрх зүй мэдээлэл захиргааны алба гэсэн бүтэцтэйгээр ажиллаж байна.

Зохицуулах хорооны дарга, орон тооны хоёр зохицуулагчийг эрчим хүчний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний, орон тооны бус хоёр зохицуулагчийг Худалдаа, аж үйлдвэрийн танхим, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн саналыг тус тус үндэслэн Ерөнхий сайд анхны томилгоог 2, 4, 6 жилээр, цаашид 3 жилийн хугацаагаар томилно. Томилолтын хугацааг нэг удаа сунгаж болно.

ЭХЗГ-ын бүтэц зохион байгуулалт:



Үнэлгээ:	Сонгох:
Үл хамаарах/ үнэлээгүй	–
Зохицуулалтын тухай шийдвэрийг яам дотроо гүйцэтгэх засаглалын шийдвэр гаргадаг ердийн журмын дагуу гаргадаг	Доод _
Зохицуулалт хийх тухай шийдвэрийн ихэнхийг яам дотроо гүйцэтгэх засаглалын шийдвэр гаргадаг ердийн журмын дагуу гаргадаг. Гэвч яаманд нэгэнт гаргасан ноцтой шийдвэрийг (тарифыг шинэчлэх, зөвшөөрөл олгох зэрэг) хэрэгжүүлэх үүрэгтэй тусгай нэгж, эсвэл тусгай үүрэг бүхий тасаг эсвэл хэсгийг яаман дотроо байгуулсан бол	Дунд _
Зохицуулалтын талаарх шийдвэр, хяналтын үүрэг хүлээсэн бие даасан / тусгай зохицуулалтын байгууллага байгаа бол	Дээд ✓
Мэдээллийн эх сурвалж:	Эрчим хүчний тухай хууль, ЭХЗГ-ийг байгуулсан шийдвэр, ЭХЗГ-ын жил бүрийн тайлан -2003-2010 он, www.erc.mn (2012 оны 2-р сар хүртэл www.era.energy.mn гэхдээ тус сайтын архив нээлттэй байна)
Нэмэлт мэдээлэл:	Эрчим хүчний зохицуулах газрын товч танилцуулга -2011 он

ЗҮЯ2. ЗОХИЦУУЛАГЧ АГЕНТЛАГИЙН ЭРХ МЭДЭЛ (AUTHORITY)

Чанарын элементүүд:	Тайлбар:	
Эрх мэдэл		
Мэдээлэл, нотолгоо	✓	Бүрэн боломжтой
Судалгаа	✓	Бүрэн боломжтой
Шийдвэрийг хэрэгжүүлэх	✓	Бүрэн боломжтой
Тушаал зөрчигсдөд ногдуулах шийтгэл	✓	Бүрэн боломжтой
Практик		
Эрх мэдлээ хэрэгжүүлэх	✓	Бүрэн боломжтой
Тайлбарын үргэлжлэл:		
<p>Эрчим хүчний тухай хуулиар ЭХЗХ-ны эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл ажиллагааг зохицуулах чиг үүргийг тодорхой зааж өгсөн ба уг хууль, Эрчим хүчний зохицуулах хорооны дүрэм болон тэндээс батлан хэрэгжүүлж байгаа дүрмүүдийн хүрээнд Зохицуулагч агентлагийн эрх мэдэл бүрэн хүрэлцээтэй байна.</p> <p>Тус хороо жил тутам тайлангаа гаргаж www.erc.mn цахим хуудсанд тавьснаас үзэхэд эрх мэдлээ бүрэн хэрэгжүүлж ажиллаж ирсэн байна. Жишээлбэл, ЭХЗГ-ын 2010 онд эрчим хүчний үнэ тариф, зохицуулалттай холбоотой 9 онцлох ажлыг хийжээ. Үүнд, Монгол Улсын эрчим хүчний салбарт чухал ач холбогдолтой шийдвэр болох УИХ-ын 72 дугаар тогтоолыг гаргахад шаардлагатай Түлш, эрчим хүчний салбарын санхүү-эдийн засгийн чадавхийг сайжруулах, эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр судалгаа явуулж, холбогдох баримт бичгүүдийг боловсруулан холбогдох материал, танилцуулгыг бэлтгэж гаргажээ. Мөн тус газраас Төвийн бүсийн эрчим хүчний хэрэглэгчдэд борлуулах цахилгаан, дулааны үнэ тарифын өөрчлөлтийн хэтийн төлөв, баримтлах чиглэлийг боловсруулжээ.</p> <p>Монгол Улсын Их хурал, Засгийн газраас эрчим хүчний зохицуулах байгууллагын хараат бус байдлыг хангахад чиглэсэн бодлого баримталж байгаа Эрчим хүчний тухай хуулинд оруулсан нэмэлт өөрчлөлтүүд тухайлбал, зохицуулах зөвлөлийг хороо болгож өргөтгөн зохицуулагчдын тоог 5 болгож нэмсэн зэрэг заалтуудаас харагдаж байна.</p>		
Үнэлгээ:	Сонголт:	
хамаарахгүй/үнэлээгүй	–	
Зохицуулагч агентлаг эрх мэдлийн чанарын үзүүлэлтийн аль ч элементийг хангаагүй	Доод _	
Зохицуулагч агентлаг эрх мэдлийн чанарын зүүлэлтийн нэгээс-хоёр элементийг хангасан	Доодоос дунд_	
Зохицуулагч агентлаг эрх мэдлийн чанарын үзүүлэлтийн гурван элементийг хангасан	Дунд _	
Зохицуулагч агентлаг эрх мэдлийн чанарын үзүүлэлтийн бүх гурван элементийг хангасан	Дундаас дээд _	
Зохицуулагч агентлаг эрх мэдлийн чанарын үзүүлэлтийн бүх дөрвөн үзүүлэлтийг хангасан, түүнчлэн энэ эрх мэдлийн практик ажиллагааны чанарын элементүүдийг хангаж байгаа.	Дээд ✓	

Мэдээллийн эх сурвалж:	Энэ судалгааны ажлын зөвлөх, ЭХЗГ-ын зохицуулагчдын зөвлөлийн дарга Р.Ганжууртай уулзаж дэлгэрэнгүй зөвлөлдөв. Монгол Улсын эрчим хүчний тухай хууль, ЭХЗГ-ийг байгуулсан шийдвэр, ЭХЗГ-ын жил бүрийн тайлан -2003-2010 он, www.erc.mn (www.era.energy.mn)
Нэмэлт мэдээлэл:	Эрчим хүчний зохицуулах газрын товч танилцуулга. 2011 он Эрчим хүчний тухай хууль Түлш, эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай 2010 оны 12 -р сарын 09 өдрийн УИХ-ын 72 дугаар тогтоол

ЗҮҮЗ. ЗОХИЦУУЛАХ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ХЭМЖЭЭ (JURISDICTION)

Чанарын элементүүд:	Тайлбар:
Тайлбар:	ЭХЗГ нь Зохицуулалтын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль тогтоомжуудын хүрээнд ажлаа явуулах бүрэн боломжтой байна. ЭХЗХ нь Монгол Улсын Эрчим хүчний тухай хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл олгох, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох эрхтэй бөгөөд мөн хуулиар эрчим хүчний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, түүнийг олгоходоо 5 МВт-аас дээш хүчин чадалтай эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрснөөр ЭХЗГ олгодог байна. (Цахилгаан, дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, эрчим хүчний барилга байгууламж барих эрхийг олгосон Тусгай зөвшөөрөл г.м.) Гэхдээ эрчим хүчний зохицуулагч нар болон бусад хүмүүстэй ярилцаж байхад дараах асуудлыг Эрчим хүчний тухай хуулин дахь ЭХЗХ-ны эрх үүрэгт оруулаагүйг тэмдэглэж байна. Үүнд: Өндөр хүчдлийн дамжуулах шугам сүлжээ шинээр байгуулах тухай тусгай зөвшөөрлийг олгох эрхийг олгоогүй байна. Тухайлбал, горимын шаардлага хангахгүй Баруун-Урт - Чойбалсангийн 110 кВ-ын шугамыг байгуулахад ЭХЗГ-ын оролцоо байгаагүй байсан гэж үзэж байв. Мөн сэргээгдэх эрчим хүчний үнэ, тарифыг сэргээгдэх эрчим хүчний тухай хуулинд урьдчилан тогтоож өгснөөр ЭХЗХ-ны үнэ тариф тогтоох үүргийг энэ хэсэгт хязгаарлажээ.
Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй	_
Зохицуулах байгууллагын үүргийг тодорхой болгоогүй, эрхийн нь хувьд ихээхэн зөрүүтэй ойлголтууд байгаа	Доод _
Зохицуулах байгууллагын үүргийг тодорхой болгосон ч гурваас дээш тооны гол үүргийг нь ноогдуулаагүй	Доодоос дунд _
Зохицуулах байгууллагын үүргийг тодорхой болгосон ч хоёр гол үүргийг нь ноогдуулаагүй орхигдуулсан	Дунд _
Зохицуулах байгууллагын үүргийг тодорхой болгосон ч нэг гол үүргийг нь ноогдуулаагүй орхигдуулсан	Дундаас дээд ✓
Зохицуулах байгууллагын үүргийг тодорхой болгосон, бүх гол үүргийг нь бүрэн ноогдуулсан	Дээд _
Мэдээллийн эх сурвалж:	Монгол Улсын Эрчим хүчний тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор баталсан ЭХЗГ-ын дүрэм, ЭХЗГ-ын зохицуулагчдын зөвлөлийн батлан гаргасан журмууд Сайдын тушаал, Монгол Улсын дээд шүүхийн тогтоол, ЭХЗГ-ын Зохицуулагчдын зөвлөлийн тогтоолууд www.erc.mn (www.era.energy.mn)

Нэмэлт мэдээлэл:	Эрчим хүчний зохицуулах газрын товч танилцуулга -2011 он Эрчим хүчний статистик үзүүлэлтүүд -2010 / Улаанбаатар, ЭХЗГ -74 х. Эрчим хүчний хэрэглэгчдэд зориулсан зөвлөмж / Улаанбаатар, ЭХЗГ -80 х.
------------------	--

ЗҮЯ4. ЗОХИЦУУЛАХ БАЙГУУЛЛАГЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮҮРГИЙН ЦАР ХҮРЭЭ БОЛОН ИЛ ТОД БАЙДАЛ

Чанарын элементүүд:	Тайлбар:
Үүргийн цар хүрээ	
Үүрэгт байгаль орчны асуудал тусгагдсан эсэх	✓ ЭХЗГ-ын дүрмийн 3-р зүйлд “Газар нь үйл ажиллагаандаа Эрчим хүчний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, энэхүү дүрмийг удирдлага болгох бөгөөд Монгол Улсын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, үндэсний аюулгүй байдал, төрөөс байгаль орчин болон эрчим хүчний үйлдвэрлэл хангамжийн талаар баримталж байгаа бодлогод нийцсэн үйл ажиллагаа явуулна” гэж зааж өгчээ.
Онцлог үүргүүд	– ЭХЗХ нь тусгай зөвшөөрөл хүссэн сонирхогч этгээдэд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх шаардлага тавьдаг.
Мэдээлэл нээлттэй болгох	
Засгийн газрын хэвлэлд нийтлэх	– ЭХЗГ-ын дүрмийг 2001 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын 86–р тогтоолоор баталж “Төрийн мэдээлэл” болон албан ёсны эмхэтгэлд нийтлэгдэж байсан эсэх тодорхойгүй.
Вебсайт дээр тавих	✓ Энэ дүрмийг ЭХЗГ-ын вебсайт дээр тавиагүй, харин ЭХГ-ын Вебсайт дээр тавьсан байв. Эрчим хүчний тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль болон бусад заавар журмыг тавьсан байлаа.
Бага зардал	– ЭХЗГ нь байгаль орчны үүрэг, хариуцлагатай холбоотой баримт бичгүүдийг товхимол, зурагт хуудас, мэдээллийн хуудас, нийгмийн чанартай реклам гэх мэт олон нийтэд үнэгүй эсвэл бага үнээр хүртээмжтэй болгох талаар гарсан материалыг олж үзээгүй.
Олон төрлийн форматаар хүртээмжтэй байх	– ЭХЗГ нь Эрчим хүчний үйлдвэрүүдийг байгаль орчны асуудлыг онцгойлон авч үзэж иргэд болон иргэний нийгмийн бүлгийнхэн ашиглах болох форматаар түгээх ажлыг хийхгүй байна.
Өргөн хүрээнд түгээх	– ЭХЗГ нь өөрийн байгаль орчинтой холбоотой үүрэг хариуцлагын талаарх мэдээллийг олон төрлийн хэвлэл мэдээллээр (төрийн байгууллагууд, номын сан, интернет, радио, сонин гэх мэт) түгээх ажлыг хийхгүй байна.
Байгаль орчны асуудлыг төлөөлсөн бүлгүүд	– Зохицуулагч нар нь өөрийн байгаль орчинтой холбоотой үүрэг, хариуцлагын талаарх мэдээллийг түгээх системтэй хүчин чармайлтыг байгаль орчны асуудлаар (сэргээгдэх эрчим хүч, цахилгааны хэмнэлт, цахилгаан үйлдвэрлэлээс агаарын чанарт үзүүлэх нөлөө зэрэг) ажиллаж буй сонирхлын бүлэгт түгээх ажлыг хангалттай хийхгүй байна.

Үргэлжлэл тайлбар:

Эрчим хүчний тухай хуульд “Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэсний үндсэн дээр олгоно” гэж хуульчилсан байна. Сонирхогч хуулийн этгээд тусгай зөвшөөрөл авах тухай өргөдлөө ЭХЗГ буюу аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлд гаргахдаа байгаль орчныг хамгаалахтай холбоотой дараах баримт бичгийг хавсаргасан байх ёстой. Үүнд:

-Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ;

-Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө;

-Монгол Улсын хувьд Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны дүгнэлт

Эдгээрийг үндэслэн ЭХЗГ-аас тусгай зөвшөөрөл олгодог байна.

Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй	–
Чанарын ямар ч элементийг хангаагүй	Доод _
Байгаль орчны үүрэгтэй холбоотой чанарын нэг элемент хангагдсан. Мэдээлэл нээлттэй болгох чиглэлээр хоёроос доош тооны элемент хангагдсан	Доодоос дунд ✓
Байгаль орчны үүрэгтэй холбоотой чанарын хоёр элемент хангагдсан. Гэхдээ мэдээлэл нээлттэй болгох чиглэлээр хоёроос доош тооны элемент л хангагдсан	Дунд _
Байгаль орчны үүрэгтэй холбоотой чанарын хоёр элемент хангагдсан. Гэхдээ мэдээлэл нээлттэй болгох чиглэлээр гурав болон түүнээс дээш тооны элемент л хангагдсан.	Дундаас дээд _
Байгаль орчны үүрэгтэй холбоотой чанарын хоёр элемент хангагдсан. Мөн мэдээлэл нээлттэй болгох чиглэлээр дөрөв болон түүнээс дээш тооны элемент хангагдсан.	Дээд _
Мэдээллийн эх сурвалж:	
Нэмэлт мэдээлэл:	

ЗҮЯ5. ЗОХИЦУУЛАХ БАЙГУУЛЛАГЫН НИЙГМИЙН ХАМААРАЛТАЙ ҮҮРГИЙН ЦАР ХҮРЭЭ БОЛОН ИЛ ТОД БАЙДАЛ

Чанарын элементүүд:	Тайлбар:
Үүргийн цар хүрээ	
Үүрэгт нийгмийн асуудал тусгагдсан эсэх	<p>✓ ЭХЗГ-ын эрхэм зорилго нь эрчим хүч үйлдвэрлэгч үйлдвэрлэгч ба хэрэглэгчийн эрх тэнцүү харилцан ашигтай харилцааг зохицуулах явдал юм. Энэ байдал Монгол Улсын Эрчим хүчний тухай хууль, ЭХЗГ-ын дүрэм, эдгээртэй нийцүүлэн гаргасан заавар журмаар дамжин хэрэгжиж байна.</p> <p>Эрчим хүчний тухай хуулийн 9.1-д зааснаар тусгай зөвшөөрөл олгох, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох; тариф тогтоох аргачлал боловсруулах, тарифын бүтэц тодорхойлох, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тарифыг хянаж батлах, шалгах, нийтлэх; эрчим хүчний хэрэглээг хамгийн бага өртгөөр хангах чадавхийг бүрдүүлсэн, зохих ашгийн түвшин бүхий үнэ, тарифын тогтолцоог бий болгох; тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг шийдвэрлэх; хэрэглэгчийн зэрэглэлтэй уялдуулан эрчим хүчний хангамжийн найдвартай байдал, хангагчаас хэрэглэгчид үзүүлэх үйлчилгээний түвшинг тодорхойлох, хэрэгжилтийг хянах; зохицуулалтгүй хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хэрэглэгчтэй байгуулсан гэрээг бүртгэх зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.</p> <p>ЭХЗГ-ын дүрэмд “Газрын үндсэн зорилго нь Эрчим хүчний тухай хуульд заасны дагуу эрчим хүчний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тарифыг хянаж батлах, тусгай зөвшөөрөл эзэмшигчид, хэрэглэгчдийн эрх ашгийг тэнцвэртэй хамгаалах, үйлдвэрлэгч, хангагчийн хүрээнд шударга өрсөлдөөнийг бий болгох нөхцөлийг бүрдүүлэхэд оршино” гэжээ.</p> <p>Эндээс үзвэл ЭХЗГ-ын үүрэгт нийгмийн асуудал бүхэлдээ тусгагдсан байна.</p>
Онцлог үүргүүд	<p>✓ Тарифыг цахилгаан, дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх болон хангах үйл ажиллагаа тус бүрээр тогтооно.</p> <p>Үйл ажиллагааны бодит өртөг, зардалд тулгуурлах;</p> <p>Цахилгаан, дулааны хангалтад хэрэглэгчдээс тавих шаардлагатай уялдуулан хэрэглэгчийн зэрэглэл тус бүрээр өртөг, зардлыг хуваарилах;</p> <p>Эрчим хүчний хэрэглээг зохицуулах боломжтой байх;</p> <p>Үнийн тогтвортой байдлыг хангах;</p> <p>Цахилгаан, дулааны тарифын бүтэц хэрэглэгчид ойлгомжтой, энгийн байх;</p>
Мэдээлэл нээлттэй болгох	
Засгийн газрын хэвлэлд нийтлэх	<p>✓ Эрчим хүчний тухай хууль нээлттэй байдаг.</p> <p>ЭХЗГ-ын дүрмийг 2001 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын 86 –р тогтоолоор баталжээ.</p>
Вебсайт дээр тавих	<p>✓ Эрчим хүчний тухай хууль нэмэлт өөрчлөлтийн хамт www.legalinfo.mn сайтад байршсан.</p> <p>ЭХЗГ-ын дүрмийг тус байгууллагын www.era.energy.mn сайтад тавиагүй байв. ЭХЗХ болсны дараа www.erc.mn сайтад бас тавиагүй байна.</p>
Бага зардал	<p>✓ ЭХЗГ нь өөрийн тогтоосон эрчим хүчний үнэ тарифыг товхимол, зурагт хуудас, мэдээллийн хуудсаар олон нийтэд үнэгүй хүргэж байна. Энд тус газрын зохион байгуулсан эрдэм шинжилгээний хурлын тухай ном товхимол, мөн жил бүрийн үйл ажилгааны тайлан, бусад сурталчилгааны материалаас харж болно.</p> <p>Харин нийгмийн чанартай реклам гэх мэт зүйлээр ард иргэдэд мэдээллийг бага хүргэж байна.</p>

Олон төрлийн форматаар хүртээмжтэй байх	✓	Зохицуулах байгууллагын нийгмийн үүрэг, хариуцлагыг дурдсан баримт бичгүүдийг иргэд болон иргэний нийгмийн бүлгийнхэн ашиглах болох форматаар түгээх (товхимол, зурагт хуудас, мэдээллийн хуудас, нийгмийн чанартай реклам гэх мэт) ажил хангалтгүй байна.
Нийгмийн асуудлыг төлөөлсөн бүлгүүд	–	Зохицуулах байгууллага нь өөрийн нийгмийн асуудалтай холбоотой үүрэг, хариуцлагын талаар эмзэг бүлэгт (орон нутгийн иргэд, эмэгтэйчүүдийн байгууллага, бага орлоготой хэрэглэгч нар) мэдээллийг түгээх системтэй хүчин чармайлтыг сонирхлын бүлэгт түгээх ажил хангалтгүй байна. Тухайлбал, олон эмэгтэйчүүдийн байгууллага зэрэг олон нийтийн байгууллагууд энэ талаар бага мэдлэгтэй байлаа. Зөвхөн ҮЭ-ийн байгууллага зохих хэмжээнд мэдэж байв.

Үргэлжлэл тайлбар:

Олон нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх талаар: ЭХЗГ-аас 2008 онд “Төвийн бүсийн эмзэг бүлгийн тарифыг мөрдөх журам”, 2005 онд “Цахилгаан хангамжийн тасалдлыг бүртгэх тогтоох журам” зэрэг хэд хэдэн журмыг гаргаж зохицуулалтын ажилдаа мөрджээ.

2010 оны 10-р сарын 1-нд ЭХЗГ болон Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар (ШӨХТГ) харилцан ойлголцолын санамж бичиг гаргаж Эрчим хүчний салбар дахь өрсөлдөөнийг зохицуулах, Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч зүй ёсны монополь байдалтай аж ахуй эрхлэгчийн үнэ тарифыг хянах, зөвшөөрөл олгох, батлах, эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч зүй ёсны монополь байдалтай аж ахуй эрхлэгчийн бараа бүтээгдэхүүний тоо, хэмжээний өөрчлөлтийг хянаж, зохицуулалт хийх;

Эрчим хүч хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, Эрчим хүчний тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулинд заасан эрх үүргийн хүрээнд шаардлагатай мэдээ мэдээлэл солилцох, харилцан туршлагаасаа хуваалцах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, ажил төрлийн уулзалт зохион байгуулах, хэрэглэгчдэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах зэрэг асуудлуудаар цаашид хамтарч ажиллахаар болжээ.

Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй	–
Чанарын аль ч элемент хангагдаагүй	Доод _
Нийгмийн үүргийн талаарх нэг элемент хангагдсан. Мэдээлэл нээлттэй болгох талаарх чанарын нэг ч элемент хангагдаагүй	Доодоос дунд _
Нийгмийн үүргийн талаарх хоёр элемент хангагдсан. Мэдээлэл нээлттэй болгох талаарх чанарын хоёроос бага тооны элемент хангагдсан	Дунд _
Нийгмийн үүргийн талаарх хоёр элемент хангагдсан. Мэдээлэл нээлттэй болгох талаарх чанарын гурав болон түүнээс дээш тооны элемент хангагдсан	Дундаас дээд ✓
Нийгмийн үүргийн талаарх хоёр элемент хангагдсан. Мэдээлэл нээлттэй болгох талаарх чанарын дөрөв болон түүнээс дээш тооны элемент хангагдсан	Дээд _
Мэдээллийн эх сурвалж:	Эрчим хүчний тухай хуулийн 21.2.6 ба 21.2.7 зүйл
Нэмэлт мэдээлэл:	2001 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын 86 –р тогтоол Могойн голын ДЦС-ын ТЭЗҮ-ийг ЭХГ-ын техникийн зөвлөлийн хурлаар хэлэлцсэн тухай протокол Монгол Улсын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль Зүй ёсны монополь байдалтай аж ахуй эрхлэгчийг тогтоох журам

ЗҮЯ6. ЗОХИЦУУЛАГЧ НАРЫН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ

Чанарын элементүүд:	Тайлбар:
Сонгон шалгаруулах үйл явцын хараат бус байдал	– Сонгон шалгаруулалт хараат бус байж чадахгүй байна. Тухайлбал, Эрчим хүчний тухай хуулийн 8.3-р зүйлд “Зохицуулагчдын зөвлөлийн дарга, зохицуулагчийг эрчим хүчний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Ерөнхий сайд анхны томилгоог 2, 4, 6 жилээр, цаашид 6 жилийн хугацаагаар, тэдгээрийн бүрэн эрхийн хугацаа нь 2 жилийн зөрөөтэйгээр дуусгавар болж байхаар томилно. Томилолтын хугацааг нэг удаа сунгаж болно” гэсэн заалтын баримталж иржээ. Зохицуулагч нарыг томилохдоо Эрчим хүчний салбарын үйлдвэрүүдэд удирдах ажил хийж байсан хүмүүсийг сонгон авч ирсэн байна. Эрчим хүчний тухай хуулинд 2011 онд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр “Зохицуулах хорооны дарга, орон тооны хоёр зохицуулагчийг эрчим хүчний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний, орон тооны бус хоёр зохицуулагчийг Худалдаа, аж үйлдвэрийн танхим, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн саналыг тус тус үндэслэн Ерөнхий сайд анхны томилгоог 2, 4, 6 жилээр, цаашид 3 жилийн хугацаагаар томилно. Томилолтын хугацааг нэг удаа сунгаж болно” гэжээ.
Сайтар тодорхойлсон үйл явц	✓ Сонгон шалгаруулалт ил тод явагддаггүй байна. Сонгон шалгаруулалтыг Эрчим хүчний салбарын асуудал эрхэлсэн төрийн төв байгууллага (тухайлбал, өнөөдөр Эрдэс баялаг, эрчим хүчний сайд) шийдэж байна. Өнөө хир нийт 10 зохицуулагчийг томилон ажиллуулсан байх бөгөөд эдгээр хүмүүс эрчим хүчний салбарт удирдах ажил хийж байсан туршлагатай, чадварлаг мэргэжилтнүүдээс сонгож авсан байна.
Нэр дэвшигч нарын ил тод байдал	– Нэр дэвшигчийг олон нийтэд ил тод байдлаар танилцуулдаггүй байна. Зөвхөн Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн төв байгууллага буюу яамны үзэмжээр шийдвэрлэдэг асуудал болж иржээ.
Бүрэлдэхүүн болон шалгаруулалт тэнцэх шалгуур үзүүлэлтүүд	– Эрчим хүчний тухай хуулинд ерөнхий заажээ. ЭХЗГ-ын дүрэмд хэрхэн заасан нь тодорхойгүй. Түлш, эрчим хүчний сайдын 2005 оны 29-р тушаалаар баталсан “Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлийн гишүүнийг томилох, ажиллах журам” гэж бий.
Ялгаатай ажиллах хугацаа	✓ Эрчим хүчний тухай хуулинд 2011 онд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр “Зохицуулах хорооны дарга, орон тооны хоёр зохицуулагчийг эрчим хүчний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний, орон тооны бус хоёр зохицуулагчийг Худалдаа, аж үйлдвэрийн танхим, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн саналыг тус тус үндэслэн Ерөнхий сайд анхны томилгоог 2, 4, 6 жилээр, цаашид 3 жилийн хугацаагаар томилно. Томилолтын хугацааг нэг удаа сунгаж болно” гэжээ.

Үргэлжлэл тайлбар: ЭХЗГ-ын зохицуулагч нарыг дээрх чанарын элемент болох таван үзүүлэлтийг бүгдийг хангасан байдлаар сонгон шалгаруулалт хийдэггүй байна. Гэсэн хэдий ч Эрчим хүчний салбарт чухал ач холбогдолтой ажил үүрэг гүйцэтгэж байсан шилдэг мэргэжилтнүүдийг зохицуулагчаар сонгон авч ажиллуулж байсан байна.

Зохицуулагч нар	Ажилласан хугацаа	Зохицуулагч болохын өмнө хийж байсан ажил үүрэг
Р.Ганжуур	2001-2010	Эрчим хүчний газрын орлогч дарга
2 Г.Дамдинсүрэн	2001-2003 2003-2009	ТЭХЯ-нд мэргэжилтэн, газрын орлогч дарга
3 Б.Мөнхөө	2001-2003	АНУ-д Эрдэс баялгийн эдийн засгийг чиглэлээр магистрт суралцсан.
4 Д.Балдорж	2003-2004	Зохицуулагч Б.Мөнхөөгийн 4 жилийн үлдсэн хугацаанд ажилласан. ТЭХЯ-д үнэ тариф, үр ашиг хариуцсан ахлах мэргэжилтэн
5 Ц.Түмэнцогт	2004-2005	ДБЯ-д мэргэжилтэн
6 Р.Мягмар	2005-2010	ЭХЗГ-т мэргэжилтэн
7 Ч.Саранжав	2009-2010	ТЭХЯ-нд газрын дарга
8 Н.Мягмарсүрэн	2010- одоо	Улаанбаатар ДЦС-3-ийн гүйцэтгэх захирал
9 Д.Бассайхан	2010- одоо	Улаанбаатарын Цахилгаан түгээх сүлжээ ХК болон Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ ХК-ний гүйцэтгэх захирал
10 Б.Жанцай	2010- одоо	ЭХЗГ-т мэргэжилтэн

Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй	–
Зохицуулах байгууллагын гишүүдийг сонгон шалгаруулах үйл явц нь чанарын нэг элементэд нийцсэн	Доод _
Зохицуулах байгууллагын гишүүдийг сонгон шалгаруулах үйл явц нь чанарын хоёр элементэд нийцсэн	Доодоос дунд ✓
Зохицуулах байгууллагын гишүүдийг сонгон шалгаруулах үйл явц нь чанарын гурван элементэд нийцсэн	Дунд _
Зохицуулах байгууллагын гишүүдийг сонгон шалгаруулах үйл явц нь чанарын дөрвөн элементэд нийцсэн	Дундаас дээд _
Зохицуулах байгууллагын гишүүдийг сонгон шалгаруулах үйл явц нь чанарын бүх таван элементэд нийцсэн	Дээд _
Мэдээллийн эх сурвалж:	Монгол Улсын эрчим хүчний тухай хууль ЭХЗГ-ын дүрэм Түлш, эрчим хүчний сайдын 2005 оны 29-р тушаалаар баталсан “Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлийн гишүүнийг томилох, ажиллах журам”.
Нэмэлт мэдээлэл:	Эрчим хүчний төрийн захиргааны төв байгуулага болон Зохицуулагчаар ажиллаж байсан хүмүүстэй ярилцаж мэдээлэл авсан болно. Мөн Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн төв байгууллагад ажиллаж байсан удирдах хүмүүс Б.Жигжид /Дэд бүтцийн яамны сайд, 2000-2004 он/, Ц.Сүхбаатар /Дэд бүтцийн яамны Эрчим хүчний бодлого зохицуулалтын газрын дарга, 2000-2003, 2004-2007 он/, Р.Ганжуур /ЭХЗГ-ын Зохицуулах зөвлөлийн дарга, 2001-2010 он/, Н.Мягмарсүрэн /2010 оноос/, Б.Жанцай /2010 оноос/, Д.Бассайхан /2010 оноос/ нарын зэрэг хүмүүстэй уулзаж ярилцсан болно.

ЗҮЯ7. ЗОХИЦУУЛАГЧ НАР АЛБАН ЁСНЫ АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛДӨӨНӨӨС СЭРГИЙЛЭХ НЬ

Чанарын элементүүд:	✓	Тайлбар:
Санхүүгийн сонирхол	✓	Зохицуулагч нартай уулзаж ярилцахад өөрсдөө болон ойр дотны хүмүүс нь эрчим хүчний салбарт бизнес эрхэлдэггүй гэж мэдэгдсэн болно. ЭХЗГ-ын зохицуулагчдын зөвлөлөөс хэд хэдэн тогтоол гаргаж мөрдүүлжээ. Үүнд: ЭХЗГ-ын хөдөлмөрийн дотоод журам (шинэчилсэн) ЭХЗГ-ын ажилтан албан хаагчийн ёс зүйн дүрэм ЭХЗГ-ын орон сууцны асуудлыг шийдвэрлэх журам ЭХЗГ-ын шагнал урамшууллын журам
Түдгэлзэх хугацаа	–	Зохицуулах байгууллагын гишүүд нь эрхийнх нь хугацаа дууссанаас хойш тодорхой хугацааны туршид цахилгааны салбарт ажил эрхлэх / зөвлөгөө өгөхийг хорьсон заалт байхгүй байна. Харин ЭХЗГ-ын ажилтан албан хаагчийн ёс зүйн дүрэмд “Багшлах, эрдэм шинжилгээний ажил, мэргэжлийн чиглэлээр судалгаа хийхээс бусад ажил үүрэг давхар эрхэлж болохгүй, Зохицуулах газарт эрхэлж буй ажил, ажил албан тушаал нь түүний бусад гадуур эрхэлж буй ажлаас нэн тэргүүнд тавигдана” гэжээ.
Дахин сонгогдохыг хориглох	✓	Зохицуулагч нарын дахин сонгогдох талаар Эрчим хүчний тухай хуулийн 8.3-р зүйлд “томилолтын хугацааг нэг удаа сунгаж болно” гэж хуульчилсан байна.
Зохицуулах байгууллагад бусдыг төлөөлөхийг хориглох	✓	ЭХЗГ-ын ажилтан албан хаагчийн ёс зүйн дүрэмд тодорхой зарчим баримтлахыг тусгаж өгчээ.
Тайлбарын үргэлжлэл: Дээр дурдсан дүрэм журмууд эрчим хүчний зохицуулагчид биш, эрчим хүчний зохицуулах хорооны ажилтнуудад зориулсан гэдэг нь харагдаж байна. Гэхдээ 2012 оны 1-р сарын 19-нд батлагдсан “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн заалтууд эрчим хүчний зохицуулагчдад шууд хамаарна гэж ойлгогдож байна.		
Үнэлгээ:		Сонгох:
Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй		–
Хүчинтэй хэрэгжиж буй хууль, тогтоомж, журам нь зохицуулах байгууллагын гишүүдийг ашиг сонирхлын зөрчилдөөнөөс сэргийлэх шууд элементийг агуулаагүй		Доод _
Хүчинтэй хэрэгжиж буй хууль, тогтоомж, журам нь зохицуулах байгууллагын гишүүдийг ашиг сонирхлын зөрчилдөөнөөс сэргийлэх дөрвөн элементийн нэг элементийг агуулсан		Доодоос дунд _
Хүчинтэй хэрэгжиж буй хууль, тогтоомж, журам нь зохицуулах байгууллагын гишүүдийг ашиг сонирхлын зөрчилдөөнөөс сэргийлэх дөрвөн элементийн хоёр элементийг агуулсан		Дунд _
Хүчинтэй хэрэгжиж буй хууль, тогтоомж, журам нь зохицуулах байгууллагын гишүүдийг ашиг сонирхлын зөрчилдөөнөөс сэргийлэх дөрвөн элементийн гурван элементийг агуулсан		Дундаас дээд ✓
Хүчинтэй хэрэгжиж буй хууль, тогтоомж, журам нь зохицуулах байгууллагын гишүүдийг ашиг сонирхлын зөрчилдөөнөөс сэргийлэх бүх дөрвөн элементийг агуулсан		Дээд _

Мэдээллийн эх сурвалж:	Монгол Улсын эрчим хүчний тухай хууль ЭХЗГ-ын зохицуулагчдын зөвлөлийн тогтоол:		
	Журмын нэр	Огноо	Дугаар
	ЭХЗГ-ын хөдөлмөрийн дотоод журам (шинэчилсэн)	2010.04.16	112
	ЭХЗГ-ын ажилтан албан хаагчийн ёс зүйн дүрэм	2010.11.30	141
	ЭХЗГ-ын орон сууцны асуудлыг шийдвэрлэх журам	2006.07.06	75
	ЭХЗГ-ын шагнал урамшуулалын журам	2010.12.16	146
Нэмэлт мэдээлэл:	“Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль		

ЗҮЯ8. ЗОХИЦУУЛАГЧДЫН ХАРААТ БУС БАЙДАЛ

Чанарын элементүүд:	Тайлбар:
Тодорхой заасан хугацаа	✓ 2012 он хүртэл Монгол Улсын Эрчим хүчний тухай хуулийн 8.3-р зүйлд “Зохицуулагчдын зөвлөлийн дарга, зохицуулагчийг эрчим хүчний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Ерөнхий сайд анхны томилгоог 2, 4, 6 жилээр, цаашид 6 жилийн хугацаагаар, тэдгээрийн бүрэн эрхийн хугацаа нь 2 жилийн зөрөөтэйгээр дуусгавар болж байхаар томилно. Томилолтын хугацааг нэг удаа сунгаж болно” гэсэн заалт үйлчилжээ. Харин 2012 онд 8.3-р зүйлд “Зохицуулах хорооны дарга, орон тооны хоёр зохицуулагчийг эрчим хүчний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний, орон тооны бус хоёр зохицуулагчийг Худалдаа, аж үйлдвэрийн танхим, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн саналыг тус тус үндэслэн Ерөнхий сайд анхны томилгоог 2, 4, 6 жилээр, цаашид 3 жилийн хугацаагаар томилно. Томилолтын хугацааг нэг удаа сунгаж болно” гэсэн өөрчлөлт орсон байна. . Аймаг нийслэлийн зохицуулах зөвлөлийн гишүүнийг томилох, ажиллах журамд зохицуулах зөвлөлийн гишүүний нэгээс доошгүй нь тодорхой албан тушаалтан буюу эрчим хүчний улсын байшаагч байхаар зааж өгсөн байна. Зохицуулах зөвлөлийн гишүүн үндсэн албан тушаалаасаа чөлөөлөгдвөл зохицуулах зөвлөлийн гишүүнээс шууд чөлөөлөгдөнө гэж заажээ.
Санхүүгийн бие даасан байдал	✓ Эрчим хүчний тухай хуулийн 8.6-д “Зохицуулах хороо нь тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон болон тусгай зөвшөөрөл эзэмшигчид үзүүлсэн зохицуулалтын үйлчилгээний төлбөрөөр санхүүжинэ” гэжээ. Мөн ЭХЗГ-ын дүрмэнд Зохицуулагчдын зөвлөл нь батлагдсан төсвийг захиран зарцуулах эрхтэй, үүрэгтэй байхаар зааж өгчээ.
Хүний нөөцөд анхаарах	✓ ЭХЗГ-ын дүрмэнд Зохицуулагчдын зөвлөл нь тус газрын албаны даргыг томилох, чөлөөлөх эрхтэй байхаар зааж өгсөн байна. ЭХЗГ-ын өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулагчдын зөвлөлийн дарга удирдах бөгөөд тус газрын ажилтнуудын: ажил үүргийн хуваарийг тогтоох, томилох, чөлөөлөх, хариуцлага хүлээлгэх, цалин хөлсийг тогтоох, шинжээч мэргэжилтнүүдийг татан оролцуулах, гэрээгээр шинжээч авч ажиллуулах Зохицуулагчдын зөвлөлд зөвлөх үүрэг бүхий хэрэглэгч, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тэнцүү тооны төлөөллөөс бүрдсэн орон тооны бус зөвлөлтэй байж болно гэсэн байна.

Үргэлжлэл тайлбар:

Эрчим хүчний тухай хуулиас бусад дүрэм журмууд нь эрчим хүчний зохицуулагчдад шууд хамаарахгүй, иймээс тэдний хараат бус байдал төдийлөн сайн зохицуулагдаагүй байна. Харин 2012 оны 1-р сарын 19-нд батлагдсан “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн заалтууд эрчим хүчний зохицуулагчдад шууд хамаарсан тодорхой зохицуулалт болох юм.

Өнгөрсөн хугацаанд зохицуулагчдын хараат бус байдал ямар байсныг нотлохын тулд тэдний өөрчлөгдсөн шалтгааныг судлах нь зүйтэй гэж үзлээ. 2012 оныг хүртэл нийтдээ 10 зохицуулагч томилогдон ажиллажээ.

	Зохицуулагч нар	Томилогдон ажиллах хугацаа	Ажилласан хугацаа	Зохицуулагчаас өөрчлөгдсөн шалтгаан
1	Р.Ганжуур	6 жил	2001-2010	ЭБЭХЯ-ын дарамт шахалт нөлөөлсөн.
2	Г.Дамдинсүрэн	2 жил 6 жил	2001-2003 2003-2009	Хугацаа дууссан.
3	Б.Мөнхөө	4 жил	2001-2003	Өөрийн саналаар гарсан.
4	Д.Балдорж		2003	Хугацаа дууссан.
5	Ц.Түмэнцогт	4 жилийн үргэлжлэл	2004-2005	Хугацаа дууссан.
6	Р.Мягмар		2005-2010	ЭБЭХЯ-ын дарамт шахалт нөлөөлсөн.
7	Ч.Саранжав		2009-2010	Өөр ажилд шилжсэн тул өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн
8	Н.Мягмарсүрэн	6 жил	2010- одоо	Ажиллаж байгаа.
9	Д.Бассайхан		2010- одоо	Ажиллаж байгаа.
10	Б.Жанцай		2010- одоо	Ажиллаж байгаа.

Хоёр тохиолдолд зохицуулагчийг ЭБЭХЯ-ны шахалтаар өөрчилсөн гэж үзэж болох юм.

Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй / Үнэлгээ хийгээгүй	–
Зохицуулах бүтцийн бие даасан байдал нь чанарын нэг ч элементийг хангаагүй/ нэгийг л хангасан	Доод _
Зохицуулах бүтцийн бие даасан байдал нь чанарын хоёр элементийг хангасан	Дунд _
Зохицуулах бүтцийн бие даасан байдал нь чанарын гурван элементийг хангасан	Дээд ✓
Мэдээллийн эх сурвалж:	Зохицуулагч нар болон хөндлөнгийн хүмүүстэй уулзаж ярилцсан болно.
Нэмэлт мэдээлэл:	

ЗҮЯ9. ДАВЖ ЗААЛДАХ МЕХАНИЗМ

Чанарын элементүүд:	Тайлбар:
Ямар ч тал шийдвэрийг давж заалдаж болно	✓ Эрчим хүчний зохицуулах газарт хандсан гомдол маргааныг бүртгэх, шийдвэрлэх журамд зааснаар ЭХЗГ ба тусгай зөвшөөрөл эзэмшигч (ТЗЭ)-ийн хооронд, мөн хэрэглэгч ба тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хооронд үүссэн маргаантай асуудлыг өөрийн бүрэн эрхийн хүрээнд дараах 3 арга замаар шийдвэрлэдэг байна. 1. Эрчим хүчний байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлыг харьяалах байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлж биелэлтэд нь хяналт тавина. 2. Шууд шийдэх гомдол, маргаантай асуудлыг хүлээн авсан алба шийдвэрлэх ба бусад албадууд хамтран ажиллаж туслалцаа үзүүлнэ. 3. ЭХЗГ-ын Зохицуулагчдын зөвлөлийн хурлаар шийдвэрлэх.
Үйл явц буруу байсан үндэслэлээр давж заалдах боломж	✓ Эрчим хүчний зохицуулах газарт хандсан гомдол маргааныг бүртгэх, шийдвэрлэх журамд “Хэрэв хэрэглэгч саналыг хүлээн авахаас татгалзаж, өөрийн саналыг сэргүүлэн тавибал ЭХЗГ-ын ажилтан нь зуучлан, талууд харилцан буулт хийх боломж, эсвэл харилцан хүлээн зөвшөөрөх дараачийн саналыг боловсруулна” гэжээ.
Бие даасан үндэслэлээр давж заалдах боломж	✓ “Эрчим хүчний зохицуулах газарт хандсан гомдол маргааныг бүртгэх, шийдвэрлэх журам”
Давж заалдах механизм нь дор хаяад нэг кейс дээр эцсийн шийдвэрт нөлөөлсөн байх	– “Эрчим хүчний зохицуулах газарт хандсан гомдол маргааныг бүртгэх, шийдвэрлэх журам”
<p>Үргэлжлэл тайлбар:</p> <p>Монгол Улсын Эрчим хүчний тухай хуулийн 9.1.6. мөн 14-р заалт, Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16-р зүйлийн 1 дэхь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан ЭХЗГ-ын дүрмийн 12.3 дугаар заалтуудыг үндэслэн боловсруулж, “Эрчим хүчний зохицуулах газарт хандсан гомдол маргааныг бүртгэх, шийдвэрлэх журам”-ыг 2005 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн ЭХЗГ-ын зохицуулагчдын зөвлөлийн 71 дүгээр тогтоолоор баталжээ. Энэхүү журмыг ЭХЗГ нь мөрдөж байна.</p> <p>Монгол Улсын Эрчим хүчний тухай хуулиар ЭХЗГ-д олгосон бүрэн эрхэд тухайлбал, тус хуулийн 9.1.6-д “Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг харьяаллын дагуу шийдвэрлэх” гэж хуульчилж өгчээ.</p> <p>ЭХЗГ-ын Зохицуулагчаар ажиллаж байсан хүмүүстэй уулзаж “Давж заалдах механизм” талаар ярилцахад хоёр удаа ЭХЗГ-ыг захиргааны хэргийн шүүхэд өгсөн тохиолдол гарсан ба тус шүүхээс зохицуулах зөвлөлийн шийдвэр хууль бус нь тогтоогдохгүй байна гэж үзжээ.</p>	
Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй / Үнэлгээ хийгээгүй	–
Зохицуулах байгууллагын тушаал, шийдвэрийг бусад эрх бүхий байгууллага, шүүхийн өмнө хянан үзэх, давж заалдах боломжгүй	Доод _
Зохицуулах байгууллагын тушаал, шийдвэрийг хянан үзэх, давж заалдах боломж нь чанарын нэг элементийг хангасан	Доодоос дунд _
Зохицуулах байгууллагын тушаал, шийдвэрийг хянан үзэх, давж заалдах боломж нь чанарын хоёр элементийг хангасан	Дунд _
Зохицуулах байгууллагын тушаал, шийдвэрийг хянан үзэх, давж заалдах боломж нь чанарын гурван элементийг хангасан	Дундаас дээд ✓

Зохицуулах байгууллагын тушаал, шийдвэрийг хянан үзэх, давж заалдах боломж нь чанарын бүх дөрвөн элементийг хангасан	Дээд _
Мэдээллийн эх сурвалж:	ЭХЗГ-ын эрх зүй, мэдээлэл, захиргааны албаны ажилтнуудтай уулзаж ярилцаж мэдээлэл ав. Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр 2011 оны 03 сарын 10 өдөр Дугаар 85
Нэмэлт мэдээлэл:	ЭХЗГ-ын зохицуулагч асан Р.Ганжуур нартай уулзаж ярилцав.

ЗҮЯ10. ШҮҮХ БОЛОН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛОН НИЙГМИЙН НЭХЭМЖЛЭЛИЙГ АВЧ ХЭЛЭЛЦЭХ БАЙДАЛ

Чанарын элементүүд:	Тайлбар:
Заавал даган мөрдөх шийдвэр	_ Ингэж хэлэлцсэн баримт жишээ (кейс) байхгүй учраас хариулах боломжгүй.
Хараат бус байдал	_ Ингэж хэлэлцсэн баримт жишээ (кейс) байхгүй учраас хариулах боломжгүй.
Салбарын онцлог бүхий асуудлыг шийдэх чадавхи	_ Ингэж хэлэлцсэн баримт жишээ (кейс) байхгүй учраас хариулах боломжгүй.
Талуудад мэдээлэл хүртээмжтэй байх	_ Ингэж хэлэлцсэн баримт жишээ (кейс) байхгүй учраас хариулах боломжгүй.
Нэхэмжлэлийн тодорхой үндэслэл	Ингэж хэлэлцсэн баримт жишээ (кейс) байхгүй учраас хариулах боломжгүй.
Хохирогч талын статус	Ингэж хэлэлцсэн баримт жишээ (кейс) байхгүй учраас хариулах боломжгүй.
Үргэлжлэл тайлбар: Сүүлийн 5 жилд эрчим хүчний үйлдвэрлэлтэй холбоотой байгаль орчинд учруулсан хохирлын улмаас шүүхэд хандсан гомдол гаргасан баримт олдоогүй.	
Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй	✓
Шүүхийн болон захиргааны форум нь чанарын нэг чанарын элементийг хангасан	Бага _
Шүүхийн болон захиргааны форум нь чанарын нэгээс хоёр чанарын элементийг хангасан	Дунд _
Шүүхийн болон захиргааны форум нь чанарын гурав болон түүнээс дээш тооны чанарын элементийг хангасан	Өндөр_
Мэдээллийн эх сурвалж:	ЭХЗГ-ын эрх зүй, мэдээлэл, захиргааны албаны ажилтнуудтай уулзаж ярилцаж мэдээлэл авав.
Нэмэлт мэдээлэл:	ЭХЗГ-ын зохицуулагч асан Р.Ганжуур нартай уулзаж ярилцав.

ЗҮЯ11. ЗОХИЦУУЛАХ БАЙГУУЛЛАГЫН ГИШҮҮД БА АЖИЛЛАГСАДЫН СУРГАЛТЫН БАЙДАЛ

Чанарын элементүүд:	Тайлбар:
Тодорхой байдал	✓ ЭХЗГ-ын хөдөлмөрийн дотоод журамд “7.1.2. Ажилтан албан хаагчийн сургалтанд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, байгууллагын зардлаар сургалтад хамрагдах ажилтан албан хаагчтай сургалтын гэрээ байгуулна” гэжээ. Эндээс үзвэл тодорхой бодлоготой байна гэж үзэж болно. ЭХЗГ нь Зохицуулагч нар болон ахлах тушаалын ажилтан нарын сургалтад хамрагдах нийт цагийг тогтоогоогүй байна.
Олон сэдэвт сургалт	✓ ЭХЗГ-ын дотоод сургалтын төлөвлөгөөг гаргаж батлан мөрддөг байна. 2010 онд 9 чиглэлээр 11 хүн, 2011 онд 7 чиглэлээр 7 хүн, мөн нийт ажилтнуудыг сэдэвчилсэн сургалт явуулахаар тус тус төлөвлөн хэрэгжүүлжээ. Энэ төлөвлөгөө хэрэгжүүлэхэд 2010 онд 10,019,600 төг, 2011 онд 6,400,000 төг тус зарцуулахаар төлөвлөжээ. Мөн гадаад сургалтын зардлыг төлөвлөсөн байна.
Олон талт байдал	✓ ЭХЗГ-ын 2011 оны 10 зорилтын дотор “Эрчим хүчний зохицуулалт-10 жил” онол-практикийн бага хурал зохион байгуулахаар төлөвлөснөө 2011 оны 6-р сард хэрэгжүүлж нийт 19 илтгэл тавьж хэлэлцүүлсэн байна. Мөн эрчим хүчний салбарын үйл ажиллагаа, тулгарч буй хүндрэлтэй асуудлууд, тарифын хэтийн бодлогыг олон нийтэд нээлттэй болгох хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Хэрэгжилт тодорхойгүй.

Үргэлжлэл тайлбар:

ЭХЗГ-ыг байгуулсны дараагаар АНУ-ны ОУХА болон Дэлхийн банк, Солонгосын Койка байгууллага санхүүгийн дэмжлэгээр тус газрын мэргэжилтэн, зохицуулагч нарыг янз бүрийн сургалтад хамруулж байжээ.

2003 онд:

АНУ-ын ОУХА-аас нийт 6 удаагийн олон улсын хэмжээний зохицуулалтын сургалт, семинар, зөвлөлгөөн, хуралд 15 ажилтныг хамруулсан байна.

Эрчим хүчний зохицуулалтын дэлхийн II чуулганд Зохицуулагчдын зөвлөлийн дарга оролцсон.

Тайландын Бангкок хотноо болсон “Номхон далай, зүүн Азийн орнуудын зохицуулагчдын уулзалт”-д оролцсон байна.

2004 онд:

Эрчим хүчний зохицуулагчдын бүсийн ассоциаци (ERRA)-аас зохион байгуулсан “Эрчим хүчний зохицуулалт, хөрөнгө оруулалт”-ын III чуулган, “Тусгай зөвшөөрөл ба Өрсөлдөөний хороо”-ны хуралдаан, зуны сургалт зэрэг бүс нутгийн зохицуулалтын хурал, зөвлөлгөөн, семинаруудад оролцжээ. Төвийн бүсийн үйлдвэрлэгчдийн дунд өрсөлдөөний орчинг бий болгох ажлыг эхлүүлэхэд туршлага судлах зорилгоор тус газрын төлөөлөгчид адил төстэй эрчим хүчний систем бүхий Чили, Панам улсын зохицуулалтын туршлагыг газар дээр нь очиж судалжээ.

UNESCAP, Солонгосын Засгийн газраас зохион байгуулан Бангкок хотноо болсон Зүүн хойд Азийн эрчим хүчний хамтын ажиллагааны зөвлөлдөх уулзалтад оролцжээ.

Шведийн Олон улсын хөгжлийн агентлаг (SIDA)- аас зохион байгуулсан “Олон нийтийн үйлчилгээний удирдлага” олон улсын сургалт, “Эрчим хүчний компаниудын менежмент” оролцож Эрчим хүчний компаниудын эрсдлийн удирдлага, бүтцийн өөрчлөлтийн талаар мэдлэг олж олон улсын туршлага судалжээ. Мөн иргэдэд төр, олон нийтийн үйлчилгээг хүргэх, байгууллага болон салбарт өөрчлөлт хийх аргачлал, төсөл боловсруулах талаар мэдлэг мэргэжлээ дээшлүүлжээ.

2007 онд:

Олон улсын 9 төрлийн хурал зөвлөлгөөнд 11 ажилтан, 10 төрлийн сургалт семинарт 12 ажилтан давхардсан тоогоор хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүлжээ.

Зүүн өмнөд Ази, Номхон далайн орнуудын Дэд бүтцийн зохицуулагчдын форум (EAPIRF)- аас Жакарта хотноо зохион байгуулсан сургалт болон ээлжит 3 дугаар хуралдаанд оролцжээ.

2008 онд:

ERRA-ийн Ерөнхий ассамблей, жил тутмын ээлжит хуралдаан, Тусгай зөвшөөрөл/Өрсөлдөөний байнгын хороо ба Үнэ/Тарифын байнгын хорооны хуралдаануудад амжилттай оролцов.

“Түлш, эрчим хүчний салбарын хөгжил, бүтээн байгуулалт” сэдэвт эрдэм шинжилгээ онол-практикийн бага хурлыг ШУТИС-ийн ЭХИС-тай хамтран зохион байгуулжээ.

Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй.	–
Зохицуулах байгууллагын гишүүд, ажилтнууд сүүлийн 2 жил ямар нэгэн төрөлжсөн тусгай сургалтад хамрагдаагүй.	Доод _
Зохицуулах байгууллагын гишүүд, ажилтнууд сүүлийн 2 жил гурав болон гурваас бага тооны төрөлжсөн тусгай сургалтад хамрагдсан	Доодоос дунд _
Зохицуулах байгууллагын гишүүд, ажилтнууд сүүлийн 2 жил дөрөв болон дээш тооны төрөлжсөн тусгай сургалтад хамрагдсан боловч сургалтууд нь чанарын нэг элементийг хангаж байна.	Дунд _
Зохицуулах байгууллагын гишүүд, ажилтнууд сүүлийн 2 жил дөрөв болон түүнээс дээш тооны төрөлжсөн тусгай сургалтад хамрагдсан боловч сургалтууд нь чанарын хоёр элементийг хангаж байна.	Дундаас дээд ✓
Зохицуулах байгууллагын гишүүд, ажилтнууд сүүлийн 2 жил дөрөв болон дээш тооны төрөлжсөн тусгай сургалтад хамрагдсан боловч сургалтууд нь чанарын гурван элементийг хангаж байна.	Дээд _
Мэдээллийн эх сурвалж:	ЭХЗГ-ын жилийн тайлан Эрчим хүчний зохицуулах газрын сургалтын төлөвлөгөө 2010 он, 2011 он
Нэмэлт мэдээлэл:	Зохицуулагч нар, ажилтнуудтай уулзсан уулзалт ЭХЗГ-ын 2009-2010 оны зардлын төсөв, гүйцэтгэл, 2011 оны зардлын төсөв

ЗҮҮЯ12. ЗОХИЦУУЛАГЧИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДЛУУДЫГ ҮНЭЛЭХ ЧАДАВХИ

Чанарын элементүүд:	Тайлбар:
Тусгайлан зориулсан санхүүгийн нөөц эх үүсвэр	– ЭХЗГ-т тусгайлан байгаль орчны асуудалд зориулсан санхүүгийн эх үүсвэр байхгүй. Харин Байгаль орчин аялал жуулчлалын яаманд ийм арга хэмжээ, тухайлбал хяналт шалгалтанд зориулсан зохих хэмжээний санхүүгийн эх үүсвэр байдаг гэж ойлгож болно. Мөн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиар тусгай зөвшөөрөл хүсч байгаа компаниуд өөрсдөө хөрөнгө гаргаж экологийн үнэлгээ хийлгэдэг. Тодруулбал, 4.1-д “Шинээр байгуулах болон одоо ажиллаж буй үйлдвэр, үйлчилгээ, барилга байгууламж, тэдгээрийг шинэчлэх, өргөтгөх болон бусад хэлбэрээр байгалийн нөөц баялаг ашиглах төсөлд байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгэх бөгөөд энэхүү үнэлгээний хүрээнд төслийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг урьдчилан тогтоож дүгнэлт гаргана” гэж заажээ.
Хамаарах мэдлэг чадвар	– ЭХЗГ- байгаль орчны нөлөөллийг үнэлэх үүрэг хүлээдэггүй бөгөөд хариуцсан хэлтэс, алба байхгүй.
Тусгайлан томилсон албан тушаалтан	– ЭХЗГ-т байгаль орчны асуудлыг тусгайлан хариуцсан албан тушаалтан байхгүй. Гэсэн хэдий ч зохицуулагч нар тусгай зөвшөөрөл олгохдоо заавал авч үздэг шалгуурын нэг нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ юм.
Байгаль орчны асуудлуудаар өөрсдийн мэдлэгийг сайжруулах байдал	– ЭХЗГ-ын зохицуулагчид өөрсдийн байгаль орчинтой холбоотой мэдлэгээ дээшлүүлэхэд анхаарч ажилладаг гэж мэдэгдэж байна.
Үргэлжлэл тайлбар:	

Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй	✓
Хамаарах зохицуулах байгууллага нь байгаль орчны асуудалд үнэлгээ хийх чадавхитай холбоотой ямар нэгэн элементийг хангаснаа илтгэн харуулаагүй.	Доод _
Хамаарах зохицуулах байгууллага нь байгаль орчны асуудалд үнэлгээ хийх чадавхитай холбоотой нэг элементийг илтгэн харуулсан.	Дунд _
Хамаарах зохицуулах байгууллага нь байгаль орчны асуудалд үнэлгээ хийх чадавхитай холбоотой хоёр болон түүнээс дээш тооны элементийг хангасан.	Дээд _
Мэдээллийн эх сурвалж:	ЭХЗГ-ын жил бүрийн тайлан БОАЖЯ-ны Экологийн цэвэр технологи, шинжлэх ухааны хэлтсийн дарга А.Энхбаттай уулзсан уулзалт www.cdm-mongolia.com вэб сайт
Нэмэлт мэдээлэл:	Зохицуулагч нар болон ажилтнуудтай хийсэн уулзалт

ЗҮЯ13. ЗОХИЦУУЛАГЧИЙН НИЙГМИЙН АСУУДЛУУДЫГ ҮНЭЛЭХ ЧАДАВХИ

Чанарын элементүүд.	Тайлбар:
Тусгайлан зориулсан санхүүгийн нөөц эх үүсвэр	_ ЭХЗГ-ын 2009-2010 оны зардлын төсөв, гүйцэтгэл, 2011 оны зардлын төсвөөс үзэхэд нийгмийн асуудлаар тусгайлан судалгаа хийх зардал тусгагдаагүй байв.
Хамаарах мэдлэг чадвар	✓ ЭХЗГ-ын зохицуулагч нар болон үнэ тарифын алба, тусгай зөвшөөрлийн албаны дарга нартай уулзаж ярилцахад, зохицуулах газар нь хэрэглэгчдийн болон эрчим хүчнийхэний эрх ашгийн тэнцүү хадгалах зорилтыг тавин ажилладаг байна. Одоог хүртэл нийгмийн асуудлыг эн тэргүүнд тавьж ирсэн бөгөөд айл, өрхийн цахилгааны үнэ тарифыг бодит байдлаас ихээхэн доогуур тогтоож иржээ.
Тусгайлан томилсон албан тушаалтан	✓ ЭХЗГ-ын Үнэ тарифын алба 8 хүнтэй бөгөөд хэрэглэгчийн үнэ тарифын мэргэжилтэн нэг байна.
Нийгмийн асуудлуудаар өөрсдийн мэдлэгийг сайжруулах байдал	✓ ЭХЗГ-ын зохицуулагч нар болон ажилтнууд эрчим хүчний үнэ тариф иргэдэд хэр дарамт болж байгаа, хэрхэн зохицуулах талаар байнга судалж, талуудын байр суурийг сонсдог гэж мэдэгдэж байна.

Үргэлжлэл тайлбар:

Монгол Улсын эрчим хүчний тухай хуулийн 9.1.5-д ЭХЗГ нь “эрчим хүчний хэрэглээг хамгийн бага өртгөөр хангах чадавхийг бүрдүүлсэн, зохих ашгийн түвшин бүхий үнэ, тарифын тогтолцоог бий болгох” заагаад үнэ тариф тогтоох зарчмыг зааж өгсөн байна. Үүнд,

Үйл ажиллагааны бодит өртөг, зардалд тулгуурлах;

Цахилгаан, дулааны хангалтад хэрэглэгчдээс тавих шаардлагатай уялдуулан хэрэглэгчийн зэрэглэл тус бүрээр өртөг, зардлыг хуваарилах;

Эрчим хүчний хэрэглээг зохицуулах боломжтой байх;

Үнийн тогтвортой байдлыг хангах;

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн орлого нь түүний санхүүгийн чадавхи хэвийн байлгахуйц хэмжээнд байх;

Цахилгаан, дулааны тарифын бүтэц хэрэглэгчид ойлгомжтой, энгийн байх;

Эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах, диспетчерийн зохицуулалт хийх үйл ажиллагаанд техник, технологийн найдвартай ажиллагааны шаардлагад нийцүүлэн хамгийн бага өртгийн зарчмыг мөрдөх;

Өртөг нь сүүлийн жилүүдэд гарсан зардлын гүйцэтгэлд үндэслэгдсэн байх бөгөөд зардлын бүтэцд ирээдүйд оруулах хөрөнгө оруулалт, шинэчлэлийн зардалд бодогдох элэгдэл, хорогдлыг оруулахгүй байх.

2011 онд Засгийн газрын тохируулагч агентлаг - Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар / ШӨХТГ/-ын ажилтнууд Эрчим хүчний зохицуулах газрын мэргэжилтнүүд болон зарим тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагынханд танилцуулга хийж хоёр байгууллага цаашид хэрхэн хамтран ажиллах чиглэлээ тодорхойлж Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан. Эрчим хүчний үнэ тариф нь суурь шинж чанартай, бусад бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэд нөлөөлдөг тул үнэ тарифын асуудалд маш болгоомжтой хандах учиртай гэдэгт хоёр тал санал нэгдсэн байна.

Өрсөлдөөний тухай хуулиар эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч нь бараа бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнийн өөрчлөлтийн талаар ШӨХТГ-т мэдэгдэж зөвшөөрөл авах үүрэгтэй ба энэ үүргийг зөрчсөн аж ахуй эрхлэгчийг тухайн бараа бүтээгдэхүүний өмнөх жилийн борлуулалтын орлогын 3% хүртэл тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хууль бусаар олсон орлогыг хураах хариуцлага хүлээлгэдэг.

Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй / Үнэлгээ хийгээгүй	–
Хамаарах зохицуулах байгууллага нь нийгмийн асуудалд үнэлгээ хийх чадавхитай холбоотой ямар нэгэн элементийг хангаснаа илтгэн харуулаагүй.	Доод _
Хамаарах зохицуулах байгууллага нь нийгмийн асуудалд үнэлгээ хийх чадавхитай холбоотой нэг элементийг хангасан.	Дунд _
Хамаарах зохицуулах байгууллага нь нийгмийн асуудалд үнэлгээ хийх чадавхитай холбоотой хоёр болон түүнээс дээш тооны элементийг хангасан.	Дээд ✓
Мэдээллийн эх сурвалж:	ЭХЗГ-ийн орон тооны жагсаалт Өрсөлдөөний тухай хууль ЭХЗГ ба Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар (ШӨХТГ)-ын хооронд байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичиг

Нэмэлт мэдээлэл:

ЗҮЯ14. ЗӨВЛӨХ АШИГЛАХТАЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЛИЙН ОЛОН НИЙТЭД ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

Чанарын элементүүд:	Тайлбар:
Зөвлөх үйл ажиллагааны нарийвчилсан мэдээлэл нээлттэй байх	<p>✓ Эрчим хүчний тухай хуулийн 8.5-д “Зохицуулах хорооны дэргэд хэрэглэгч, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тэнцүү тооны төлөөллөөс бүрдсэн, зөвлөх үүрэг бүхий орон тооны бус зөвлөл байгуулж болно” гэж заасан байдаг.</p> <p>2011 оны 3-р сарын 1-ний ЭХЗГ-ын Зохицуулагчдын зөвлөлийн 3 дугаар тогтоолоор ЭХЗГ-ын Зохицуулагчдын зөвлөлд зөвлөх үүрэг бүхий “Орон тооны бус зөвлөлийн ажиллах журам”-ыг баталжээ. Энэ тогтоолыг 2011 онд ЭХЗГ-аас гаргасан Дүрэм, зааврын эмхтгэлд оруулсан байна. Харин тус байгууллагын www.erc.mn (www.era.energy.mn) сайтад тавигдаагүй</p>
Зөвлөхийн тайлан, зөвлөмжийн талаарх нарийвчилсан мэдээлэл нээлттэй байх	<p>– ЭХЗГ-ын жил бүрийн тайланд “Зохицуулагчдын зөвлөлд зөвлөх үүрэг бүхий Орон тооны бус зөвлөл”-ийн хийсэн ажлын талаар товч дурдсан байв. Тухайлбал, 2010 оны тайланд тэд 6 зөвлөмжийг гаргаж санал болгосон байв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> -Эрчим хүчний үнэ тариф нэмэгдүүлэхийг зарчмын хувьд дэмжиж байгаа бөгөөд эрчим хүчний үнэ тарифт валютын ханш, валютын нөлөөллийг тодорхой зааж ил тод дурьдах, энэ чиглэлээр тооцоогоо тодотгох; -Цалин нэмэгдүүлэх асуудал гаргаж байгааг зарчмын хувьд дэмжиж байна. Эрчим хүчний салбарын цалингийн өсөлтийг ялгавартай авч үзэн ур чадвартай ажилчдаа урамшуулах замаар цалингаа нэмж, хүний нөөцийн бодлогыг зөв гаргах; -Эрчим хүчний салбарын үйл ажиллагааны талаар гаргасан бодлого стратегийг зарчмын хувьд дэмжиж байна; -Эрчим хүчний салбарын үйл ажиллагааны талаар гаргасан бодлого, нөхцөл байдлаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр эрчимтэй сурталчлах ажлыг түлхүү хийх; -Эрчим хүчний салбарын хувьчлалын асуудал дээр анхаарч, эртнээс тооцож бодлого гарган, болгоомжтой хандахгүй бол энэ асуудал хүндрэлтэй гэдгийг зохицуулагчдын зөвлөл анхаарах; -Дулааны эрчим хүчний хувьд хүнээр юмуу өрхөөр тооцдог аргаасаа татгалзаж тоолууржуулах бодлого гаргаж судлах, тоолуур тавихад хүндрэлтэй бол төсөл хэрэгжүүлэх; <p>Энэ тайлан ЭХЗГ-ын www.era.energy.mn сайтад тавигдсан байв.</p>

Үргэлжлэл тайлбар:

Нэг.

ЭХЗГ-ын зөвлөхөөр Монгол Улсын Дэд бүтцийн сайд асан Б.Жигжид ажиллаж байна. Түүнтэй уулзаж ярилцахад Монгол Улсын эрчим хүчний зохицуулалтын бодлогын талаар өргөн мэдлэгтэй байсан ба цаашид хийвэл зохих ажлуудын талаар зохицуулагч нарт зөвлөдөг тухайгаа ярьсан. Түүний үзэж байгаагаар эрчим хүчний салбарт сайн засаглалыг бэхжүүлэхийн тулд одоо хүчин төгөлдөр байгаа хуулийн заалтуудыг бүх шатанд, ялангуяа дээд түвшинд ягштал биелүүлэх, эмзэг бүлгийн эрх ашиг нэрийн дор халамжийг хэтрүүлэхгүй байх, эрчим хүчний хэрэглэгч ба хөрөнгө оруулагчд[□]г урамшуулдаг болох, боловсон хүчний нөөц бүрдүүлэх, зохицуулагч нарыг томилдоггүй зарчмыг хэрэгжүүлэх шаардлагатай.

Хоёр.

Зохицуулах хорооны дэргэдэх орон тооны бус зөвлөлийг 2010 онд шинэчлэн байгуулж дараах төлөөллийг оруулсан байна.

1. Ажил олгогч эздийн холбооны гүйцэтгэх захирал /ТББ/

2. МҮЭ-ийн холбооны дэд ерөнхийлөгч /ТББ/

3. Женко группын гүйцэтгэх захирал /Хувийн компани/

4. Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын мэргэжилтэн /ЗГ-ын тохируулагч агентлаг/

5. ДЦС-4 ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Эрчим хүчний үйлдвэр/

6. УБЦТС ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Цахилгаан түгээх сүлжээ/

7. УБДС ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Дулаан түгээх сүлжээ/

8. ОСНААУГ-ын дарга /Нийслэл Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны харьяа байгууллага/

9. ЭХЗГ-ын мэргэжилтэн

Үнэлгээ:

Сонгох:

Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй

–

Зохицуулах байгууллагад туслалцаа үзүүлсэн зөвлөхийн талаарх нарийвчилсан мэдээллийг үйл ажиллагааны энгийн практик байдлаар нийтийн хүртээл болгоогүй (нэрнээс бусдыг)

Доод

Зөвлөх ашиглахтай холбоотой мэдээллийн олон нийтэд нээлттэй болгосон нь чанарын нэг элементийг хангасан

Дунд ✓

Зөвлөх ашиглахтай холбоотой мэдээллийн олон нийтэд нээлттэй болгосон нь чанарын хоёр элементийг хангасан

Дээд _

Мэдээллийн эх сурвалж:

ЭХЗГ-ын жил бүрийн тайлан
Дүрэм, зааврын эмхтгэл /ЭХЗГ 2011 он
www.era.energy.mn

Нэмэлт мэдээлэл:

Ажил олгогч эздийн холбооны гүйцэтгэх захирал Х.Ганбаатартай
уулзсан уулзалт
ЭХЗГ-ын зөвлөх Б.Жигжидтэй уулзсан уулзалт

ЗҮЯ15. ЗОХИЦУУЛАХ ҮЙЛ ЯВЦ БОЛОН ГАРГАСАН ШИЙДВЭРИЙН БИЕ ДААСАН ҮНДЭСЛЭЛИЙН ТОДОРХОЙ БАЙДАЛ

Чанарын элементүүд:	Тайлбар:
Үйл явцын тодорхой байдал	✓ ЭХЗГ (одоо ЭХЗХ) нь нарийвчлан бодож боловсруулсан бүтэцтэй, тодорхой журам, дүрэм, зааврын дагуу үйл ажиллагаа явуулдаг.
Шийдвэрийн бие даасан үндэслэлийн тодорхой байдал	✓ ЭХЗГ (одоо ЭХЗХ) нь хууль, эрх зүйн 50 гаруй баримт бичгийн хүрээнд ажилладаг байна.
<p>Үргэлжлэл тайлбар: ЭХЗГ-аас зохицуулагч нар болон ажилтнуудаа зориулан гарын авлага болох хууль тогтоолын хоёр эмхтгэл гаргаж зохицуулах үйл ажиллагаатай холбоотой Монгол Улсын хууль, Дээд шүүхийн тогтоол, Улсын Их хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол, сайдын тушаал, ЭХЗГ-ын зохицуулагчдын зөвлөлийн тогтоол, зэргийг багтаажээ. Тэдний ширээний ном юм.</p>	
Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй	✓
Зохицуулах байгууллагын үйл явц нь чанарын аль ч элементийг хангаагүй.	Доод _
Зохицуулах байгууллагын үйл явц нь чанарын нэг элементийг хангасан	Дунд _
Зохицуулах байгууллагын үйл явц нь чанарын хоёр элементийг хангасан	Дээд _
Мэдээллийн эх сурвалж:	ЭХЗГ-ын жил бүрийн тайлан Дүрэм, зааврын эмхтгэл /ЭХЗГ 2011 он www.era.energy.mn
Нэмэлт мэдээлэл:	“Эрчим хүчний зохицуулалт -10 жилд” (ЭХЗГ-ын 10 жилийн ойд зохиулан тус газрын ажиллаж ирсэн түүхэн тойм, онол практикийн бага хурлын илтгэлийн эмхтгэл), Улаанбаатар, 2011 он

ЗҮЯ16. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ХОЛБООТОЙ НЭХЭМЖЛЭЛД ЗОХИЦУУЛАХ БАЙГУУЛЛАГЫН ӨГӨХ ХАРИУ

Чанарын элементүүд:	Тайлбар:
Нэхэмжлэлийн хариуны тодорхой үндэслэл, тайлбарыг гарган өгсөн эсэх	– Одоогоор байгаль орчин болон нийгмийн асуудлаар ЭХЗГ-т ямар нэг нэхэмжлэлийг гаргаагүй. Харин үнэ тарифын зохицуулалт хийхээр гаргасан шийдвэрийг Засгийн газар болон салбарын яамнаас цуцлуулсан тохиолдол гарч байжээ.
Тодорхой тусгагдсан байгаль орчны болон нийгмийн үүргээ биелүүлсэн эсэх	– Эрчим хүчний шинэ эх үүсвэр барих тусгай зөвшөөрөл олгохдоо байгаль орчны болон эдийн засгийн үр ашиг зэрэг олон үзүүлэлтийг тусгасан ТЭЗҮ боловсруулж холбогдох газруудаар хэлэлцүүлж батлуулсан байхыг шаарддаг байна.
<p>Үргэлжлэл тайлбар:</p> <p>Эрчим хүчний салбараас хамаарсан байгаль орчин, нийгмийн асуудлаар хэрэглэгчид болон ард иргэдийн зүгээс нэхэмжлэл гаргаагүй байна. Харин Дөргөний УЦС-ыг байгуулахыг Дэлхийн байгаль хамгаалах сан хэмээх байгууллагаас эсэргүүцэн олон нийтэд хандаж байсан боловч ЭХЗГ-д хандаж нэхэмжлэл гаргасан баримт олдоогүй.</p> <p>Нийгмийн асуудлын хувьд 2001 оноос одоог хүртэл 5 удаа цахилгааны үнэ тарифыг өөрчлөн тогтоохдоо хэрэглэгчдийн эрх ашгийг түлхүү харгалзаж байсан. Хэрэглэгчдээс нэхэмжлэл ирдэггүй нь үүнтэй холбоотой юм.</p>	
Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй	✓
Байгаль орчин, нийгмийн асуудлаарх зохицуулах байгууллагын хариу үйл ажиллагаа нь чанарын нэг ч элементийг хангаагүй	Доод _
Байгаль орчин, нийгмийн асуудлаарх зохицуулах байгууллагын хариу үйл ажиллагаа нь чанарын нэг элементийг хангасан	Дунд _
Байгаль орчин, нийгмийн асуудлаарх зохицуулах байгууллагын хариу үйл ажиллагаа нь чанарын хоёр элементийг хангасан	Дээд _
Мэдээллийн эх сурвалж:	ЭХЗГ-ын жил бүрийн тайлан Ухаа худагийн ДЦС-ын ТЭЗҮ
Нэмэлт мэдээлэл:	

ЗҮЯ17. ЗОХИЦУУЛАГЧИЙН ЗҮГЭЭС ГАРГАЖ БҮЙ УРЬДЧИЛСАН ИДЭВХ ЧАРМАЙЛТ

Тайлбар:

Нэг.

Эрчим хүчний зохицуулах газар нь түлш, эрчим хүчний салбарыг зах зээлийн харилцаанд шилжүүлэх үйл явцыг эрчимжүүлэх талаар УИХ-ын тогтоолыг гаргахад шаардлагатай судалгаа хийж, холбогдох баримт бичиг материал, танилцуулгыг бэлтгэж ЭБЭХЯ болон УИХ-ын холбогдох гишүүдэд санал болгосноор 2010 оны 12-р сард “Түлш, эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай” 72-р тогтоол батлагдсан юм. Дээрх судалгааг тус байгууллага өөрийн санаачлагаар хийсэн гэж үзэж байна.

Түлш, эрчим хүчний салбарын санхүү, эдийн засгийн чадавхийг сайжруулах, найдвартай ажиллагааг хангахад чиглэгдсэн уг тогтоолд зохицуулах газрын ажил үүрэгтэй шууд холбоотой зарим заалтууд орсон байна. Тухайлбал, ахуйн цахилгааны үнэ, тарифыг шатлалтай болгон өрх бүрийн сарын хэрэглээний 150 кВт•ц-ийг одоогийн мөрдөж байгаа үнэ тарифыг индексжүүлэн тооцож, түүнээс дээшхи хэрэглээ болон үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын эрчим хүчний үнэ, тарифыг бодит өртгөөр тооцох, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад чадлын тариф нэвтрүүлэх, эрчим хүчний салбарын компаниудыг 2014 оноос эхлэн зах зээлийн зарчимд шилжүүлэн ажиллуулах бодлого, зохион байгуулалтын арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран авч хэрэгжүүлэхээр заажээ. ЭХЗГ-ын 2010 оны үйл ажиллагааны тайлан дахь “Даргын захиа”-нд 2010 онд хийж гүйцэтгэсэн ажлуудаас хамгийн ач холбогдол бүхий хоёр ажлын нэгээр “Түлш, эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 72-р тогтоолыг онцолсон байв.

Хоёр.

2011 онд ЭХЗГ нь өөрийн санаачлагаар цахилгаан, дулаан хэрэглэгчдэд зориулан зөвлөмж бэлтгэж товхимол болгон нийтэд зориулан хэвлүүлсэн байна. Энэхүү зөвлөмжид хэрэглэгч шинээр цахилгаан, дулааны сүлжээнд холбогдоход шаардлагатай техникийн нөхцөл авах, эрчим хүчээр хангагдах гэрээ байгуулах, эрчим хүчний төлбөр тооцоо хийх, хэрэглэгчдийн гомдол хүсэлтийг барагдуулахтай холбоотой асуудлуудын талаар болон эрчим хүчний үнэ тариф, тоолуур, хэмжих хэрэгсэл, мөн түгээмэл гардаг асуулт, хариултууд, эрчим хүчийг хэмнэх боломжуудын талаархи мэдээллүүдийг тусгасан байна.

Гурав.

Мөн 2011 онд “Эрчим хүчний зохицуулалт 10 жилд” нэртэй онол практикийн бага хурлыг зохион байгуулжээ. Энэ бага хурлаар эрчим хүчний зохицуулах байгууллагын үйл ажиллагаа, эрх зүйн байдлын онцлог, цахилгаан дулааны үнэ тарифыг хэрхэн тогтоодог, тариф тогтооход тулгамдаж байгаа асуудлууд, аймаг нийслэлийн зохицуулах зөвлөлүүдийн үйл ажиллагааны өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудлууд, хэвлэл мэдээллийнхэнтэй хэрхэн үр өгөөжтэй хамтарч ажиллах зэрэг 19 илтгэлийг хэлэлцүүлж илтгэлүүдийг эмхэтгэж тусгай ном болгон хэвлүүлж олны хүртээл болгожээ.

Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй	–
Сүүлийн хоёр жилд зохицуулах байгууллага урьдчилан санаачилга гаргаж байсан тохиолдол байхгүй.	Доод _
Сүүлийн хоёр жилд зохицуулах байгууллага урьдчилан санаачилга гаргаж байсан 1-4 тохиолдол байгаа.	Доодоос дунд ✓
Сүүлийн хоёр жилд зохицуулах байгууллага урьдчилан санаачилга гаргаж байсан таваас илүү тооны тохиолдол байгаа	Дунд _
Мэдээллийн эх сурвалж:	Эрчим хүчний зохицуулах газрын зохицуулагчидтай хийсэн ярилцлага Эрчим хүчний зохицуулах газар: 2010 оны үйл ажиллагааны тайлан, Улаанбаатар. 2011 он Улсын Их Хурлын 2010 оны 12-р сарын 09-ний өдрийн “Түлш, эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай” 72-р тогтоол Эрчим хүчний хэрэглэгчдэд зориулсан зөвлөмж, Улаанбаатар хот 2011 он Эрчим хүчний зохицуулалт 10 жилд: Эмхэтгэл, Улаанбаатар 2011 он
Нэмэлт мэдээлэл:	www.era.energy.mn

ЗҮЯ18. ЗОХИЦУУЛАХ БАЙГУУЛЛАГЫН ЭЗЭМШИЖ БУЙ БАРИМТ БИЧГҮҮДИЙГ НЭЭЛТТЭЙ БОЛГОХ

Тайлбар:

Эрчим хүчний зохицуулах газрын дүрэмд “Зохицуулагчдын зөвлөлийн шийдвэрийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтэд мэдээлэх” гэсэн заалт байдаг.

2011 онд үнэлгээний багийн гишүүд ЭХЗГ-ын зохицуулагч Д.Бассайхантай уулзалт хийхэд, одоо тус байгууллагад нууцын зэрэглэлтэй материал байхгүй, хуучин тийм материалын жагсаалт байсныг хүчингүй болгосон гэж тайлбарласан юм. Түүнчлэн зохицуулагчдын зөвлөлийн дарга Н.Мягмарсүрэн, албаны дарга Р.Ган-Эрдэнэ нар, нууцын зэрэглэлтэй материал байхгүй, ямар ч бичиг баримт иргэдэд нээлттэй гэж байв. Мөн Үнэ, тарифийн албаны дарга М.Ганчимэг: “Хуучин нууцын зэрэглэлтэй баримт бичиг гэж байгаагүй, нууцын тухай журамд яг тэр баримтыг нууцын зэрэгт хамруулна гэж заагаагүй. Энэ журмыг 2010 онд хүчингүй болгосон” гэсэн тайлбар өгөв.

Бодит байдлыг судалж үзэхэд газар 2004 онд “Байгууллагын нууцын тухай 20-р тогтоолыг гаргасан ба 2010 оны 10 сарын 19-ний 112 дугаар тогтоолоор хүчингүй болгосон байв.

ЭХЗГ-ын дүрмийн 23-т “Газрын үйл ажиллагаатай холбоотой мэдээ материал, баримт бичиг /төрийн болон байгууллагын нууцад хамаарахаас бусад/ нийтэд ил тод байна” гэж заажээ. Мөн ЭХЗГ-ын ажилчин албан хаагчдын ёс зүйн дүрмийн 2.1.2-т “Нээлттэй, ил тод зарчмыг баримтлана” гэжээ. Иймээс ЭХЗГ-т нууцын талаар гаргасан тодорхой заавар журам байхгүй бөгөөд бүх баримт бичиг олон нийтэд нээлттэй гэж үзэж болно.

ЭХЗХ-ноос “Эрчим хүчний статистик үзүүлэлтүүд” нэртэй эмхэтгэлийг жил бүр гаргадаг.

Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч компани аж ахуйн нэгж байгууллагуудын тухай товч лавлахийг 2007 онд гаргасан.

Эрчим хүчний зохицуулах газрын дүрэм заавруудын эмхэтгэлийг 2011 онд гаргасан.

Мөн тус газар нь үйл ажиллагааныхаа тайланг жил бүр хэвлэж гаргадаг.

Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй	–
Зохицуулах байгууллагын эзэмшиж буй бүх баримт бичгүүд нь нууцын зэрэглэлтэй, аль нэг оролцогч тал нууцлахыг хүссэн тохиолдолд зохицуулах байгууллага нууцлан хадгалдаг	Доод _
Зохицуулах байгууллагын эзэмшиж буй бүх баримт бичгүүд (эсвэл аль нэг оролцогч тал нууц хэмээн шаардаж буй) нь нууцын зэрэглэлтэй, гэхдээ зохицуулах байгууллага нь баримт бичгүүдийг нийтэд дэлгэх эрхтэй (аль нэг тал нь нууцлалыг шаардсан ч)	Доодоос дунд _
Иргэдэд баримт бичгүүд нээлттэй байж болохтой хамаатай шийдвэр нь зохицуулах байгууллагын өөрийн гаргах шийдвэр. Байгууллагад байгаа ямар баримт бичгийг олон нийтэд ил болгох аль нь нууц болохыг тодорхой заасан заалт, журам байхгүй.	Дунд _
Зохицуулах байгууллагаас тусгайлан нууц гэж заагаагүй бол эзэмшиж буй бүх баримт бичгүүд нээлттэй байх ёстой гэхдээ нууцлалын талаар тодорхой заасан заалт, журам байхгүй.	Дундаас дээд ✓
Зохицуулах байгууллагаас тодорхой цөөн тооны баримт бичгийг тусгайлан нууц гэж зааснаас бусдаар эзэмшиж буй бүх баримт бичгүүд нээлттэй байх ёстой мөн нууцлалын талаар тодорхой заасан заалт, журам байгаа.	Дээд _
Мэдээллийн эх сурвалж:	Эрчим хүчний зохицуулах газрын зохицуулагчид, холбогдох мэргэжлийн албаны даргатай хийсэн ярилцлага ЭХЗГ-ын дүрэм (Засгийн газрын 2001 оны 83-р тогтоолын хавсралт) ЭХЗГ-ын Зохицуулагчдын зөвлөлийн 2004 оны 20-р тогтоол “Байгууллагын нууцын тухай” ЭХЗГ-ын Зохицуулагчдын зөвлөлийн 2010 оны 10-р сарын 19-ний өдрийн 112-р тогтоол “Журам шинэчлэн батлах тухай” “Эрчим хүчний зохицуулах газрын ажилтан албан хаагчдын ёс зүйн дүрэм” (Эрчим хүчний зохицуулах газрын Зохицуулагчдын зөвлөлийн 2010 оны 11-р сарын 30-ний өдрийн 141-р тогтоолын хавсралт)

ЗҮЯ19. ОЛОН НИЙТ ЗОХИЦУУЛАГЧ АГЕНТЛАГЫН БИЧИГ БАРИМТТАЙ ТАНИЛЦАХ ГОРИМ

Чанарын элементүүд:	Т/Ү	Тайлбар:
Баримт бичгийн сайтар индексжүүлсэн мэдээллийн бааз	Т	<p>Эрчим хүчний зохицуулах хорооны бүх баримт бичиг цаасан болон электрон хэлбэрээр зохих журмын дагуу эмх цэгцтэй хадгалагдаж архивлагддаг. Үүнийг мэдээллийн бааз гэж үзэж болно.</p>
Баримт бичгийг үзэж харах/ олж авах энгийн боловч сайтар боловсруулсан үйлчилгээ	Ү	<p>Эрчим хүчний зохицуулах хорооноос олон нийтэд мэдээлэл хүргэх гол суваг нь www.erc.mn (2012 он хүртэл www.era.energy.mn) вэб сайт юм.</p> <p>2012 он хүртэл www.era.energy.mn сайтад дараах баримт бичгийг байршуулсан байв:</p> <ul style="list-style-type: none"> -ЭХЗГ-ын 2003-2010 оны тайлангууд (PDF формат дээр байгаа ба татаж авах боломжтой) -Ном товхимлууд (Дээрхи тайлангууд, тус газрын хэвлүүлсэн олон ном товхимолуудас зөвхөн “Эрчим хүчний ТЗЭ компаниудын лавлах”-ыг номыг байршуулсан байна) <p>Зохицуулах зөвлөлийн тогтоолын сан (2001-2011 гэж бичсэн зөвхөн 2009 онд тус газраас гарсан тогтоолуудыг татан авч үзэх боломжтой.</p> <p>Эрчим хүчний зохицуулах газар дээр иргэд очоод мэдээлэл авч боломжтой гэж байгаа ч мэдээлэл үзэх, танилцах, олж авахад нь зориулж цогц үйлчилгээ үзүүлэх талаар тусгайлан боловсруулж дагаж мөрдөж байгаа албан ёсны журам байхгүй. Газар дээр нь очиж судалж үзэхэд дараах байдлаар үйлчилж байна.</p> <ol style="list-style-type: none"> 1.Үнэ тарифтай холбоотой асуудлаар Үнэ тарифын албанд, тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлаар Тусгай зөвшөөрлийн албанд, зохицуулагчдын зөвлөлийн тогтоол шийдвэртэй холбоотой асуудлаар Зохицуулагчдын зөвлөлийн нарийн бичгийн даргад хандан мэдээлэл авч болно. Мөн хуучин оны материалуудтай танилцах бол архивын эрхлэгчид хандана. Архивын эрхлэгч, зохицуулагчдын зөвлөлийн нарийн бичгийн даргад баримт бичгийн жагсаалт байна. 2.Сонирхсон этгээдийн хүссэн мэдээллийг аль болох богино хугацаанд гаргаж өгөхийг хичээдэг ба архивын эрхлэгч мэдээллийг хувилж өгөөд “Хуулбар үнэн” гэсэн тэмдэг дардаг.
Боломжийн үнэ	Т	Бүх мэдээлэл үнэгүй.
Мэдээллийг өргөн түгээн тараах	Т	<p>ЭХЗХ-ны мэдээллийг хамгийн өргөн хүрээнд шуурхай түгээдэг суваг бол веб сайт юм.</p> <p>Мөн үе үе Эрчим хүчний салбарын нээлттэй өдөрлөгөөр зохион байгуулж тараадаг. Жишээлбэл, 2011 оны 11-р сарын 18-ны өдөр Эрдэс баялаг, эрчим хүчний салбарын нээлттэй өдөрлөг болж энэ үеэр Эрчим хүчний зохицуулах газар өөрийн байранд иргэд, хэрэглэгчтэй уулзалт зохион байгуулж үйл ажиллагаагаа танилцуулан та бүхний тавьсан санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байна.</p> <p>Дараа нь 2012 оны 5-р сарын 11-ны өдөр Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулсан Монгол Улсын Засгийн газрын нээлттэй өдөрлөгийн хүрээнд Эрчим хүчний зохицуулах хороо өөрийн асрыг ажиллуулсан.</p>

Тайлбарын үргэлжлэл:

2012 он хүртэл www.era.energy.mn сайт дараах бүтэцтэй байв.

-Бидний тухай (танилцуулга бүтэц зохион байгуулалт, газрын тайлан хэвлүүлсэн ном товхимол, гадаад харилцаа гэх мэт)

-Зохицуулагчдын зөвлөл (бүтэц, хурал, тогтоолын сан гэх мэт)

-Тусгай зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг, тусгай зөвшөөрөл эзэмшигчид, тэдгээрийн рейтинг гэх мэт)

-Үнэ тарифын зохицуулалт (тарифын саналыг хянан үзэх журам, тарифын байнгын аргачлал)

-Цахилгаан дулааны үнэ тариф (хэрэглэгчдэд борлуулах цахилгаан, дулааны үнэ тариф, эмзэг бүлгийн хэрэглэгчдийн үнэ тариф, нүүрсний уурхайнуудын үнэ гэх мэт)

-Цахилгаан зах зээл (нэг худалдан авагчтай загвар, спот зах зээл, аукционы зах зээл)

-Аймаг, нийслэлийн эрчим хүчний зохицуулагчдын зөвлөл (ажиллах журам, бүтэц, олгосон тусгай зөвшөөрлүүд гэх мэт)

- Хэрэглэгч (хэрэглэгчдийн эрх, үүрэг, санал хүсэлт хүлээх авах, гомдол маргаан шийдвэрлэх, эрчим хүч хэмнэх туршлага гэх мэт)

Үнэлгээ:	Сонгох:
Хамааралгүй/үнэлээгүй	-
Олон нийтийн зохицуулалтын холбогдолтой баримт бичигтэй танилцах горим журам нь чанарын үзүүлэлтийн элементүүдийг огт хангаагүй	Доод _
Олон нийтийн зохицуулалтын холбогдолтой баримт бичигтэй танилцах горим журам нь чанарын үзүүлэлтийн нэг элементийг хангасан	Доодоос Дунд_
Олон нийтийн зохицуулалтын холбогдолтой баримт бичигтэй танилцах горим журам нь чанарын үзүүлэлтийн хоёр элементийг хангасан	Дунд _
Олон нийтийн зохицуулалтын холбогдолтой баримт бичигтэй танилцах горим журам нь чанарын үзүүлэлтийн гурван элементийг хангасан	Дундаас дээд ✓
Олон нийтийн зохицуулалтын холбогдолтой баримт бичигтэй танилцах горим журам нь чанарын үзүүлэлтийн бүх дөрвөн элементийг хангасан	Дээд _
Мэдээллийн эх сурвалж:	Эрх зүй мэдээлэл, захиргааны албаны дарга Р. Ган-Эрдэнэтэй хийсэн ярилцлага www.era.energy.mn Эрчим хүчний зохицуулах газар: Дүрэм, журам, зааврын эмхэтгэл, Улаанбаатар, 2011 Эрчим хүчний зохицуулах газар: Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч компани, аж ахуйн нэгж, байгууллагуудын тухай товч лавлах, Улаанбаатар, 2007 Эрчим хүчний зохицуулах газраас жил бүр хэвлэж гаргадаг тус газрын үйл ажиллагааны тайлан Эрчим хүчний зохицуулах газраас жил бүр хэвлэж гаргадаг "Эрчим хүчний статистик үзүүлэлтүүд"
Нэмэлт мэдээлэл:	Эрчим хүчний зохицуулалт 10 жилд: Эмхэтгэл, Улаанбаатар 2011 он

ЗҮЯ20. ЗОХИЦУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООНЫ ОРОН ЗАЙ

Тайлбар:

Эрчим хүчний тухай хуулийн 8.5-д “Зохицуулах хорооны дэргэд хэрэглэгч, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тэнцүү тооны төлөөллөөс бүрдсэн, зөвлөх үүрэг бүхий орон тооны бус зөвлөл байгуулж болно” гэж заасан байдаг. 2011 оны 3-р сарын 1-ний ЭХЗГ-ын Зохицуулагчдын зөвлөлийн 3 дугаар тогтоолоор ЭХЗГ-ын Зохицуулагчдын зөвлөлд зөвлөх үүрэг бүхий “Орон тооны бус зөвлөлийн ажиллах журам”-ыг баталжээ. Одоогоор дараах бүрэлдэхүүнтэй байна.

Ажил олгогч эдийн холбооны гүйцэтгэх захирал	Төрийн бус байгууллага
МҮЭ-ийн холбооны дэд ерөнхийлөгч	Төрийн бус байгууллага
Женко группын гүйцэтгэх захирал	Хувийн хэвшлийн компани
Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын мэргэжилтэн	Засгийн газрын тохируулагч агентлаг
ДЦС-4 ТӨХК-ийн гүйцэтгэх захирал	Төрийн өмчийн компани
УБЦТС ТӨХК-ийн гүйцэтгэх захирал	Төрийн өмчийн компани
УБДС ТӨХК-ийн гүйцэтгэх захирал	Төрийн өмчийн компани
ОСНААУГ-ын дарга	
ЭХЗГ-ын мэргэжилтэн	Хараат бус зохицуулах байгууллага

Үүнээс гадна зохицуулах үйл ажиллагаан дахь олон нийтийн оролцооны талаар дараах дүрэм журмын заалтууд байна:

“Зохицуулагчдын зөвлөлийн хуралдааны журам” (Зохицуулагчдын зөвлөлийн 2009 оны 12-р сарын 22-ны өдрийн 58-р тогтоолын хавсралт)-д:

“Зохицуулагчдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилсан хэлэлцүүлгийн дараа өдөр дутмын аль нэг сонинд болон байгууллагын веб хуудсанд гаргана. Хурлын дараа асуудал хэрхэн шийдвэрлэгдсэн талаархи мэдээллийг тухайн асуудал оруулсан алба зохион байгуулан газрын веб хуудсанд тавина” гэж заажээ. Мөн түүнчлэн “Тусгай зөвшөөрөл эзэмшигчид, хэрэглэгчид, холбогдох байгууллагын төлөөлөгчид олон нийт болон бусад сонирхогч талуудыг оролцуулан хурлыг өргөтгөсөн хэлбэрээр хийж болно” гэсэн заалт байна.

“ЭХЗГ-т хандсан гомдол, маргааныг бүртгэх, шийдвэрлэх журам”-д:

“ЭХЗГ-аас олон нийтээс санал авах зорилгоор нийтлэг гомдлын талаар олон нийтэд мэдээлэх, Олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах арга хэмжээ авч болно”, “Нийтлэг гомдол болон олон нийтийн эрх ашгийг хөндөхүйц маргааныг Зохицуулагчдын зөвлөлийн нээлттэй хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ. Нээлттэй хурал хуралдах тухай мэдээллийг Зохицуулагчдын зөвлөлийн нарийн бичгийн дарга хурал болохоос ажлын 5 хоногийн өмнө мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ” гэж заасан байна.

“Олон нийтийн хэлэлцүүлэг явуулах журам”-д: (2005 оны 10 сарын 18, Дугаар 72)

“Энэ журмын зорилго нь эрчим хүчний салбарын зохицуулалтын ил тод байдлыг хангах, зохицуулалтын үйл явцад олон нийтийн оролцоог дэмжих, тэдний санал бодлыг Эрчим хүчний зохицуулах газраас шийдвэр гаргахад тусгахад оршино” гэжээ. “Олон нийтийн хэлэлцүүлэг (ОНХ) явуулах талаар 20-иос доошгүй хоногийн өмнө нийтэд мэдээлнэ. ОНХ-ээр хэлэлцэх асуудлыг нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах, холбогдох байгууллагуудад албан бичгээр мэдэгдэх зэргээр мэдээлнэ. ЭХЗГ-ын ОНХ-ийг хариуцаж буй ажилтнууд хэлэлцүүлэг эхлэх өдөр хүртэл хуралд оролцохоор тус газарт хандаж бүртгүүлсэн иргэд, байгууллагыг хэлэлцэх асуудлын талаархи мэдээллээр хангах үүрэг хүлээнэ. (Ингэхдээ зөвхөн шуудангийн зардал болон материалыг хэвлэн олшруулах зардалд дүйцэхүйц хэмжээний хураамж авч болно.) ЭХЗГ холбогдох материалыг өөрийн веб хуудаст байрлуулна. ОНХ явуулсан талаар ОНХ хийсэн өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ” гэсэн заалтууд байна.

Үнэлгээ:

Сонгох:

Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй

–

Хуульд зохицуулах үйл ажиллагаа нь нээлттэй бус, иргэд оролцох эрхгүй хэмээн заасан

Доод _

Хуульд зохицуулах байгууллага тусгайлан зөвшөөрөөгүй бол зохицуулах үйл ажиллагаа нь нээлттэй бус, үйл явц нь нээлттэй бус, иргэд оролцох эрхгүй хэмээн заасан	Доодоос дунд _
Хуульд зохицуулах үйл ажиллагаа нь нээлттэй байж, иргэд оролцох эрхтэй хэмээн тусгайлан заагаагүй	Дунд _
Хуулиар зохицуулах байгууллагын бүх үйл явц нь олон нийтэд нээлттэй хэмээн заасан ч иргэд оролцох эрх байхгүй	Дундаас дээд ✓
Хуулиар зохицуулах байгууллагын бүх үйл явц нь олон нийтэд нээлттэй хэмээн заасан ба иргэд оролцох эрх эдэлдэг	Дээд
Мэдээллийн эх сурвалж:	Зохицуулагчдын зөвлөлийн хурлын журам (Зохицуулагчдын зөвлөлийн 2009 оны 12-р сарын 22-ны 58 -р дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт) Олон нийтийн хэлэлцүүлэг явуулах журам (2005 оны 10 сарын 18, Дугаар 72) Эрчим хүчний зохицуулах газарт хандсан гомдол, маргааныг бүртгэх, шийдвэрлэх журам (2005 оны 10 сарын 11, Дугаар 71)
Нэмэлт мэдээлэл:	www.era.energy.mn

ЗҮЯ21. ЗОХИЦУУЛАХ БАРИМТ БИЧГҮҮД БОЛОН СОНСГОЛУУДЫН ОЛОН НИЙТИЙН ХҮРТЭЭМЖ

Тайлбар:

Энэ үзүүлэлтийг 2011 оны туршид олон нийтийн зүгээс баримт бичиг (нийтлэгдсэн баримт бичиг, журам, тушаал, заавраас бусад) авахаар гаргасан хүсэлтийн тоо, олон нийтийн төлөөлөл оролцсон хурлын тоо гэсэн хоёр үзүүлэлтээр үнэлэх ёстой.

Энэ асуудлаар ЭХЗГ-ын Эрх зүй, мэдээлэл, захиргааны албаны дарга Р.Ган-Эрдэнэтэй уулзаж ярилцсанаас гадна тус газрын 2011 оны тайлантай танилцаж үзлээ. Хариултаас үзэхэд, олон нийтийн зүгээс баримт бичиг авахаар гаргасан хүсэлтийг бүртгэдэггүй учир гаргасан тоо алга байв. Мөн тус газрын хурал семинарт иргэд, иргэний нийгмийн төлөөлөгчид оролцсон талаар бүртгэл мэдээлэл байсангүй. Мөн өнгөрсөн оны үйл ажиллагааных нь тайланг үзэхэд энэ талаар мэдээлэл байхгүй байв. Ийм учраас энэ үзүүлэлтийг үнэлэх боломжгүй байна

Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй	✓
Сүүлийн нэг жилийн хугацаанд баримт бичиг авах болон сонсголд оролцох зэрэг олон нийтийн оролцооны үйл явц, орон зайг хангасан 10 хүртэл тохиолдол байсан	Доод _
Сүүлийн нэг жилийн хугацаанд баримт бичиг авах болон сонсголд оролцох зэрэг олон нийтийн оролцооны үйл явц, орон зайг хангасан 11-25 хүртэл тохиолдол байсан	Дунд _
Сүүлийн нэг жилийн хугацаанд баримт бичиг авах болон сонсголд оролцох зэрэг олон нийтийн оролцооны үйл явц, орон зайгаар иргэдийн оролцоог хангасан 25 болон түүнээс дээш тооны тохиолдол байсан	Дээд _
Мэдээллийн эх сурвалж:	Эрх зүй, мэдээлэл, захиргааны албаны дарга Р. Ган-Эрдэнэтэй хийсэн ярилцлага Эрчим хүчний зохицуулах газраас Е-майллээр авсан асуултуудын хариулт Эрчим хүчний зохицуулах газар: 2010 оны үйл ажиллагааны тайлан, Улаанбаатар. 2011 он
Нэмэлт мэдээлэл:	

ЗҮЯ22 ЭМЗЭГ БҮЛГИЙН СОНИРХЛЫГ ТӨЛӨӨЛӨХ ИНСТИТУЦИЙН МЕХАНИЗМ

Чанарын элементүүд:	Тайлбар:
Хэрэглэгчдийн төлөөлөгчид	T ЭХЗГ-ын дэргэдэх орон тооны бус зөвлөх зөвлөлд Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн үндэсний холбоо, Ажил олгогч эздийн нэгдсэн холбооны төлөөлөл багтдаг. Мөн 2012 онд шинээр томилогдсон зохицуулагчдын нэг нь Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн нэгдсэн холбооны төлөөлөл юм.
Эмзэг бүлгийнхнийг тэдний нэрийн өмнөөс төлөөлөх	T Монголын Үйлдвэрчний эвлэлүүдийн нэгдсэн холбоо
Төрийн төлөөлөл	T Засгийн газрын тохируулагч агентлаг Шудрага өрсөлдөөн хэрэглэгчдийн төлөө газар
Нийгмийн хөгжлийн асуудлаар ажилладаг гүйцэтгэх байгууллагын төлөөлөл	Y
Бусад механизмууд	Y
<p>Үргэлжлэл тайлбар:</p> <p>Зохицуулагчдын зөвлөлийн дэргэдэх зөвлөх үүрэг бүхий орон тооны бус зөвлөх зөвлөл нь 8 хүний бүрэлдэхүүнтэй бөгөөд 4 нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн, 4 нь хэрэглэгч, олон нийтийн байгууллагын төлөөлөл буюу Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, Ажил олгогч эздийн холбоо, Үйлдвэрчний эвлэлүүдийн нэгдсэн холбооноос төлөөлөл багтдаг</p> <p>2010-2011 онд ЭХЗГ-аас Үйлдвэрчний эвлэлүүдийн нэгдсэн холбоо, Ажил олгогч эздийн нэгдсэн холбоотой хамтран сэтгүүлчдэд зориулсан уулзалт, семинар зохион байгуулсан.</p> <p>2010 оноос Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газартай Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж үнэ тариф, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах асуудлаар хамтарч ажиллахаар тохиролцээ.</p>	
Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй / Үнэлгээ хийгээгүй	—
Эмзэг бүлгийнхэн/оролцогч талуудын оролцоог зохицуулах байгууллагын үйл ажиллагаанд хамруулах талаар тусгайлсан ямар нэгэн үйл ажиллагаа хийгээгүй	Доод _
Эмзэг бүлгийнхэн/оролцогч талуудын оролцоог зохицуулах байгууллагын үйл ажиллагаанд хангалттай хэмжээнд хамруулах байнгын институцийн тогтолцоо байхгүй, гэхдээ тодорхой тохиолдлууд дээр зохицуулах байгууллага ийм төрлийн арга хэмжээ авах тохиолдол байдаг	Доодоос дунд ✓
Эмзэг бүлгийнхэн/оролцогч талуудын оролцоог зохицуулах байгууллагын үйл ажиллагаанд хангалттай хэмжээнд хамруулах институцийн нэг тогтолцоо байгаа	Дунд _
Эмзэг бүлгийнхэн/оролцогч талуудын оролцоог зохицуулах байгууллагын үйл ажиллагаанд хангалттай хэмжээнд хамруулах институцийн хоёр тогтолцоо байгаа	Дундаас дээд _
Эмзэг бүлгийнхэн/оролцогч талуудын оролцоог зохицуулах байгууллагын үйл ажиллагаанд хангалттай хэмжээнд хамруулах институцийн гурван тогтолцоо байгаа	Дээд _
Мэдээллийн эх сурвалж:	<p>Эрчим хүчний зохицуулах газрын веб сайт: www.era.energy.mn</p> <p>Монголын Үйлдвэрчний эвлэлүүдийн нэгдсэн холбооны веб сайт: www.ctu.mn</p> <p>Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн үндэсний холбооны веб сайт: www.consumers.mn</p> <p>Ажил олгогч эздийн нэгдсэн холбооны веб сайт: www.monef.mn</p> <p>Шударга өрсөлдөөн хэрэглэгчдийн төлөө газрын веб сайт: www.afccp.gov.mn</p>
Нэмэлт мэдээлэл:	

ЗҮЯ23. ЭМЗЭГ БҮЛГИЙНХЭН ЗОХИЦУУЛАХ ҮЙЛ ЯВЦАД ОРОЛЦОХ ЧАДАВХИЙГ БИЙ БОЛГОХ НЬ

Чанарын элементүүд:	Тайлбар:
Эмзэг бүлгийн оролцогч нарт хандсан мэдээлэл	Ү ЭХЗГ-аас хэрэглэгчдэд зориулсан гарын авлага, ном, товхимол бэлтгэн хэвлүүлж хэрэглэгчдэд тараадаг. Энд эмзэг бүлгийн хэрэглэгчдийн үнэ, тариф, эмзэг бүлгийн ангилалд ямар хүмүүс багтах, энэ бүлэгт хамрагдах журам гэх мэт мэдээлэл багтсан байдаг нь тэднийг бодитой мэдээллээр хангаж яваандаа тэдний оролцоог бий болгоход чиглэсэн гэж үзэж болох юм. Гэхдээ хангалтгүй.
Эмзэг бүлгийнхэн өөрсдийгөө төлөөлөхөд нь дэмжлэг үзүүлэх	Ү Зохицуулах газар нь эрх зүйн туслалцааг дээр дурьдсан мэдээлэл хэлбэрээр үзүүлдэг боловч санхүү болон техникийн бараг туслалцаа үзүүлдэггүй.
<p>Үргэлжлэл тайлбар:</p> <p>Эмзэг бүлгийн оролцооны чадавхийг дээшлүүлэхэд чиглэсэн санхүүгийн туслалцаа үзүүлсэн тохиолдол байхгүй. 2010 онд УБЦТС ХК-тай хамтарч Чингэлтэй дүүргийн эмзэг бүлгийн нэг хэрэглэгчийн цахилгааны хуримтлагдсан өр төлбөрийг шийдэж өгч, цахилгаантай болгосон байна) талаар мэдээлсэн боловч энэ нь асуулгад хамаарахгүй.</p>	
Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй	–
Зохицуулах байгууллага болон бусад төрийн байгууллагууд нь эмзэг бүлгийн чадавхийг бий болгох болон санхүүгийн, техникийн болон эрх зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа явуулдаггүй	Доод ✓
Зохицуулах байгууллага болон бусад төрийн байгууллагуудын эмзэг бүлгийн чадавхийг бий болгох чиглэлийн хүчин чармайлт нь чанарын нэг элементийг хангасан	Дунд _
Зохицуулах байгууллага болон бусад төрийн байгууллагуудын эмзэг бүлгийн чадавхийг бий болгох чиглэлийн хүчин чармайлт нь чанарын бүх хоёр элементийг хангасан.	Дээд _
Мэдээллийн эх сурвалж:	Эрчим хүчний хэрэглэгчдэд зориулсан зөвлөмж, Улаанбаатар хот, 2011 он Эрчим хүчний хэрэглээний эрх зүйн талаархи зөвлөмж (www.era.energy.mn)
Нэмэлт мэдээлэл:	

ЗҮЯ24. ЗОХИЦУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ ИРГЭНИЙ НИЙГМИЙН ОРОЛЦОО

Тайлбар: Зохицуулах байгууллагын холбогдох хүмүүс, тус байгууллагаас асуултаар авсан судалгаа, тус байгууллагын тайлан, холбогдох бичиг баримттай танилцаж үзэхэд сүүлийн хоёр жилийн хугацаанд иргэний нийгмийн бүлэг/хэрэглэгчдээс зохицуулах байгууллагад хандан ямар нэгэн асуудлыг хэлэлцүүлэн шийдүүлээгүй байна.	
Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй	-
Сүүлийн хоёр жилийн хугацаанд иргэний нийгмийн бүлэг/хэрэглэгчдээс зохицуулах байгууллагад хандан ямар нэгэн асуудлыг хэлцүүлэн шийдүүлээгүй	Доод ✓
Сүүлийн хоёр жилийн хугацаанд иргэний нийгмийн бүлэг/хэрэглэгчдээс зохицуулах байгууллагад хандан “хувийн сонирхолтой” холбоотой нэг асуудлыг хэлцүүлсэн	Доодоос дунд _
Сүүлийн хоёр жилийн хугацаанд иргэний нийгмийн бүлэг/хэрэглэгчдээс зохицуулах байгууллагад хандан “нийтийн сонирхолтой” холбоотой нэгээс гурван асуудлыг хэлцүүлсэн	Дунд _
Сүүлийн хоёр жилийн хугацаанд иргэний нийгмийн бүлэг/хэрэглэгчдээс зохицуулах байгууллагад хандан “нийтийн сонирхолтой” холбоотой гурваас дээш тооны асуудлыг хэлцүүлсэн	Дундаас дээд _
Дээрх үзүүлэлтүүдийг хангахын зэрэгцээ, сүүлийн хоёр жилийн хугацаанд хоёроос илүү тооны иргэний нийгмийн байгууллага/хэрэглэгчдээс зохицуулах байгууллагад хандан “нийтийн сонирхолтой” холбоотой нэг асуудлыг хэлэлцүүлж/ давж заалдахад оролцсон.	Дээд _
Мэдээллийн эх сурвалж:	Эрх зүй, мэдээлэл, захиргааны албаны дарга Р. Ган-Эрдэнэтэй хийсэн уулзалт Эрчим хүчний зохицуулах газраас Е-мэйлээр авсан асуултуудын хариулт Эрчим хүчний зохицуулах газар: 2010 оны үйл ажиллагааны тайлан, Улаанбаатар. 2011 он
Нэмэлт мэдээлэл:	

ЗҮҮЯ25. ЭРЧИМ ХҮЧ ХАНГАГЧ НАР ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУД БОЛОН ЭМЗЭГ БҮЛГИЙН ХҮН АМТАЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ БАЙГАА НЬ

Чанарын элементүүд	Тайлбар
Тусгайлан байгуулсан газар/хэлтэс	Ү Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ (УЦТС)-ий харьяа хэрэглэгчдэд үйлчлэх төвүүд хотын дүүрэг, салбаруудад ажилладаг. Гэвч эдгээр нь “хэрэглэгчдийг цахилгаанаар хангах үндсэн үүрэгтэй учир олон нийттэй зөвлөлдөх үүрэг бүхий тусгай газар/хэлтэс эсвэл энэ асуудлыг дангаар хариуцсан албан тушаалтан байх” гэсэн шаардлагыг хангахгүй байна.
Компанийн бодлого нь олон нийтийн оролцоог тусгасан байх	Ү УЦТС-ний алсын хараа болон эрхэм зорилгоос үзэхэд олон нийтийн оролцоог үйл ажиллагааныхаа гол зорилгыг болгоогүй байна: Алсын хараа: Найдвартай ажиллагааг хангасан, үйлчилгээгээр манлайлагч, дэлхийн жишигт хүрсэн компани болно. Эрхэм зорилго: Чадварлаг ажилтнуудаар чанартай үйлчилгээг хэрэглэгчиддээ хүргэж, цахилгаан эрчим хүчийг найдвартай түгээгч, аюулгүй ажиллагааг хангасан салбартаа тэргүүлэгч компани болно.
Зөвлөлдөх бүлэг байгуулан ажиллуулах	Ү Байхгүй
Эмзэг бүлгийнхэнд дэмжлэг үзүүлэх	Т Эмзэг бүлгийнхэнд дэмжлэг хөнгөлөлт үзүүлэх тохиолдлууд байдаг. Эмзэг бүлгийн зарим хэрэглэгчийн цахилгааны хуримтлагдсан өр төлбөрийг шийдэж өгч, цахилгаантай болгосон тохиолдлууд байна. Тухайлбал 2010 онд УБЦТС ХК-тай хамтарч Чингэлтэй дүүргийн эмзэг бүлгийн нэг хэрэглэгчийн цахилгааны хуримтлагдсан өр төлбөрийг шийдэж өгч, цахилгаантай болгосон байна.
Бүлгүүд хэрхэн гомдол гаргаж болохыг тусгасан мэдээлэл	Байхгүй
Үргэлжлэл тайлбар:	
Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй	–
Хамгийн гол эрчим хүч хангагч нь иргэний нийгэмтэй үр дүнтэй хамтран ажиллах чанарын нэг ч элементийг хангаагүй	Доод _
Хамгийн гол эрчим хүч хангагч нь иргэний нийгэмтэй үр дүнтэй хамтран ажиллах чанарын нэг элементийг хангасан	Доодоос дунд ✓
Хамгийн гол эрчим хүч хангагч нь иргэний нийгэмтэй үр дүнтэй хамтран ажиллах чанарын хоёр элементийг хангасан	Дунд _
Хамгийн гол эрчим хүч хангагч нь иргэний нийгэмтэй үр дүнтэй хамтран ажиллах чанарын гурван элементийг хангасан	Дундаас дээд _
Хамгийн гол эрчим хүч хангагч нь иргэний нийгэмтэй үр дүнтэй хамтран ажиллах чанарын дөрвөн элементийг хангасан	Дээд _
Мэдээллийн эх сурвалж:	Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ын хэлтсийн дарга Эрхэмбаяртай хийсэн ярилцлага Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ХК –ын веб: www.ubdn.mn
Нэмэлт мэдээлэл:	

ЗҮЯ26. ЗОХИЦУУЛАХ БАЙГУУЛЛАГЫН ТУШААЛ, ШИЙДВЭР

Тайлбар:

Зохицуулах байгууллагаас гаргаж байгаа тушаал шийдвэрт эрх зүйн талаас ямар шаардлага тавигддагийг судалж үзлээ. Зохицуулах байгууллагын үйл ажиллагааг хуульчилж өгсөн гол хууль болох Эрчим хүчний тухай хуулийн 8.1-д “зохицуулах газар нь эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх хангах үйл ажиллагааг зохицуулах чиг үүрэгтэй байна” гэж заажээ. Мөн түүнчлэн 9.2-т “Зохицуулах газар нь шийдвэрлэх асуудлаа зохицуулагчдын зөвлөлийн хурлаар хэлэлцэнэ. Хурлын шийдвэр тогтоол хэлбэртэй байна. Тогтоолыг тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч дагаж мөрдөнө” гэж зааж өгчээ.

Эрчим хүчний зохицуулах газрын дүрэм болон мөн зохицуулах зөвлөлийн хурлын журамд хурлын шийдвэр тогтоол хэлбэртэй байх бөгөөд хурлын явцад дэлгэрэнгүй тэмдэглэл хөтлөнө, зохицуулагчдын зөвлөл шийдвэр гаргахдаа аль нэг талын болон хувийн ашиг сонирхолын үүднээс хандахгүй байх зарчмыг баримтална гэж заасан байна.

Дээрхи хууль, журмаас харахад зохицуулах байгууллагын тогтоол, шийдвэр нь заавал үндэслэл дурдсан байх, олон нийтийн санал, шүүмжлэлийн тусгасан байх гэсэн шаардлага аль алинд нь тавигдаагүй байна.

Зохицуулах газрын зохицуулагчдын зөвлөлийн нэг тогтоолыг доор жишээ болгож харуулав.

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ЗОХИЦУУЛАГЧДЫН ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2009 оны 2 дугаарын 13-ны өдөр

Дугаар 9

Улаанбаатар хот Санхүү, эдийн засгийн байдалд шинжилгээ хийсэн дүнгийн тухай

Монгол Улсын Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.14, Засгийн газрын 2001 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан тус газрын дүрмийн 26.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 2008 оны үйл ажиллагааны дүнг авч хэлэлцээд Эрчим хүчний зохицуулах газрын Зохицуулагчдын зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. 2008 онд дулааны цахилгаан станцуудын дүнгээр дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүчийг өмнөх оноос 0,3 нэгжээр, төвийн бүсийн цахилгаан дамжуулалт, түгээлтийн алдагдлыг өмнөх оноос 0,6 нэгжээр тус тус бууруулсныг сайшаан тэмдэглэсүгэй.

2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 2008 оны үйл ажиллагааг дараахь байдлаар тус тус дүгнэсүгэй.

Үүнд:

“Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ” ТӨХК-ийг “хангалтгүй”;

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийг “дунд”;

“Эрдэнэт, Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийг “хангалтгүй”;

“Дархан, Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХК-ийг “дунд”;

“Багануур, Зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийг “хангалттай”;

ЗОХИЦУУЛАГЧДЫН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	Р.ГАНЖУУР
ЗОХИЦУУЛАГЧ	Г.ДАМДИНСҮРЭН
ЗОХИЦУУЛАГЧ	Р.МЯГМАР

Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй	–
Зохицуулах байгууллагын тушаал шийдвэр нь заавал үндэслэл дурдсан байх, олон нийтийн санал, эсэргүүцлийг тусгасан байх хууль зүйн шаардлага тавигдаагүй	Доод ✓
Зохицуулах байгууллагын тушаал шийдвэр нь заавал үндэслэл дурдсан байх, олон нийтийн санал, эсэргүүцлийг тусгасан байх хууль зүйн шаардлага байгаа ч хангалттай үндэслэл гаргах, олон нийтийн санал эсэргүүцлийг хамрах талаар хангалттай үндэслэл, үйл ажиллагаа хийгдээгүй байна	Дунд _
Зохицуулах байгууллагын тушаал шийдвэр нь заавал үндэслэл дурдсан байх, олон нийтийн санал, эсэргүүцлийг тусгасан байх хууль зүйн шаардлага байгаа	Дээд _

Мэдээллийн эх сурвалж: Эрчим хүчний тухай хууль. 2001 оны 2-р сарын 1-ний өдөр УИХ-аар батлагдсан.
Эрчим хүчний зохицуулах газрын дүрэм (Засгийн газрын 2001 оны 83-р тогтоолын хавсралт)
Зохицуулагчдын зөвлөлийн хурлын журам (Зохицуулагчдын зөвлөлийн 2009 оны 12-р сарын 22-ны 58 -р дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт)

Нэмэлт мэдээлэл:

ЗҮЯА 27. ШИЙДВЭРҮҮДИЙГ НИЙТЭД ТҮГЭЭХ

Чанарын элементүүд:	Тайлбар:
Хүртээмж хялбар байх	Ү ЭХЗГ-ын дүрмэнд “зохицуулагчдын зөвлөлийн шийдвэрийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтэд мэдээлэх” гэсэн заалт байгаа боловч тус байгууллагын www.era.energy.mn веб хуудсанд дахь зохицуулагчдын зөвлөлийн тогтоолын санд 2001-2011 оноор гэсэн цэс байгаа мэт боловч 2009 оноос бусад онуудыг үзэх боломжгүй байв. Харин 2012 оны 4-р сард шинээр нээгдсэн www.erc.mn сайтад тогтоолын сангийн цэс алга байна. Эдгээр тогтоолыг зохицуулагчдын зөвлөлийн нарийн бичгийн даргаас авч үзэх боломжтой ч хэрэглэгчид, олон нийтийн хувьд чирэгдэлтэй юм.
Цаг хугацаандаа түгээгдэх	Т Зохицуулагчдын зөвлөлийн хуралдааны журамд “Зохицуулагчдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилсан хэлэлцүүлгийн дараа өдөр дутмын аль нэг сонинд болон байгууллагын веб хуудсанд гаргана. Хурлын дараа асуудал хэрхэн шийдвэрлэгдсэн талаархи мэдээллийг тухайн асуудал оруулсан алба зохион байгуулж газрын веб хуудсанд тавина” гэж заасан байна. Гэхдээ хурал болох хугацааг хэд хоногийн өмнө зарлах, хурлаас гарсан шийдвэрийг хэд хоногийн дотор нийтэд мэдээлэх талаар хугацаа заагаагүй байна. Зохицуулах газрын веб хуудсанд дээр болон өдөр тутмын зарим сонин дээр хурлын зар болон хурлаас гаргасан шийдвэрийг тавьдаг. ЭХЗГ-ын Зохицуулагчдын зөвлөлийн энэ оны 11-р сарын 03-ны өдрийн ээлжит хуралдааны талаархи мэдээллийг 5 хоногийн дараа буюу 11-р сарын 8-нд зохицуулах газрын веб хуудсанд тавьсан байна. Сийрүүлбэл, “Ийст энерги девелопмент” ХХК-д Эрчим хүчний барилга байгууламж-600 МВт-ын хүчин чадалтай цахилгаан станц барих тусгай зөвшөөрөл олголоо. -ЭХЗГ-ын Зохицуулагчдын зөвлөлийн энэ оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн ээлжит хуралдаанаар “Ийст энерги девелопмент” ХХК-д 600 МВт-ын суурилагдсан хүчин чадал бүхий цахилгаан станц барих тусгай зөвшөөрлийг олголоо. -Тус цахилгаан станц Хэнтий аймгийн Мөрөн сумын нутагт Чандгана талын уурхайг түшиглэн баригдах бөгөөд станц ашиглалтад орсноор жилдээ 4,050 сая.кВт•ц ЦЭХ-ийг Төвийн эрчим хүчний системийн болон Дорнод бүсийн эрчим хүчний системд нийлүүлэх боломж бүрдэнэ. Ингэснээр Төвийн эрчим хүчний системийн хэмжээнд “Дулааны 4-р цахилгаан станц”-тай өрсөлдөхүйц хэмжээний томоохон эх үүсвэрүүд шинээр бий болох юм.
Орон нутгийн хэл дээр байх	Т Бүх тушаал шийдвэр монгол хэл дээр байгаа
Түгээлтийн олон загварыг ашиглах	Т ХХЗХ өөрийн веб хуудаснаас гадна өдөр тутмын сонин хэвлэлд мэдээ нийтлүүлж байна.

Тушаалыг ойлгоход тусалсан байх	Ү	Зохицуулах байгууллага нь гаргасан тогтоол шийдвэрээ тайлбарлан таниулах ажил тэр бүр зохион байгуулдаггүй. Харин олон нийтийн ашиг соирхолыг хөндсөн асуудлууд, тухайлбал цахилгаан дулааны үнэ тарифын талаар гаргасан тогтоолоо олон нийтэд тайлбарлах ажлыг зохион байгуулдаг.
---------------------------------	---	--

Үргэлжлэл тайлбар:

Зохицуулах газрын Веб хуудсан тавигдсан зарын жишээ:

**ЗОХИЦУУЛАГЧДЫН ЗӨВЛӨЛИЙН
ЭЭЛЖИТ ХУРАЛ БОЛНО
2011 оны 11 сарын 28**

Эрчим хүчний зохицуулах газрын Зохицуулагчдын зөвлөлийн ээлжит 38 дугаар хурал 2011 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 9.30 цагаас тус газрын хурлын танхимд болно.

Хурлаар зарим тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 2011 оны 12 дугаар сард мөрдөх тарифын тухай, Төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд 2012 онд мөрдөх цахилгаан дамжуулалт, түгээлтийн алдагдлын хувь хэмжээг тогтоох тухай, Дулааны цахилгаан станцуудын 2012 онд мөрдөх дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүчний хувь хэмжээг тогтоох тухай, "БНДС" ТӨХК-ийн дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах, эсэх тухай, "Оюутолгой" ХХК-д Эрчим хүчний барилга байгууламж 72 МВт-ын хүчин чадалтай дулааны станц барих тусгай зөвшөөрөл олгох, эсэх тухай зэрэг асуудлуудыг авч хэлэлцэж холбогдох шийдвэрийг гаргана.

ЗОХИЦУУЛАГЧДЫН ЗӨВЛӨЛ

Сонинд тавьсан зарыг зохицуулах газрын бичиг хэргийн ажилтан хадгалдаг тул үзэх боломжтой.

Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй	-
Зохицуулах байгууллагын шийдвэр/тушаалыг түгээх үйл явц нь чанарын нэг ч элементийг хангаагүй	Доод _
Зохицуулах байгууллагын шийдвэр/тушаалыг түгээх үйл явц нь чанарын нэгээс хоёр элементийг хангасан	Доодоос дунд _
Зохицуулах байгууллагын шийдвэр/тушаалыг түгээх үйл явц нь чанарын гурван элементийг хангасан	Дунд ✓
Зохицуулах байгууллагын шийдвэр/тушаалыг түгээх үйл явц нь чанарын дөрвөн элементийг хангасан	Дундаас дээд _
Зохицуулах байгууллагын шийдвэр/тушаалыг түгээх үйл явц нь чанарын таван элементийг хангасан	Дээд _
Мэдээллийн эх сурвалж:	<ul style="list-style-type: none"> - Эрчим хүчний зохицуулах газрын дүрэм (Засгийн газрын 2001 оны 83-р тогтоолын хавсралт) - Зохицуулагчдын зөвлөлийн хурлын журам (Зохицуулагчдын зөвлөлийн 2009 оны 12-р сарын 22-ны 58 -р дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт) Эрчим хүчний зохицуулах газрын вэб сайт - www.erc.mn вэб сайт - Мөн тус вэб сайтын 2012 оныг хүртэлх хувилбар - www.era.energy.mn сайт (тэнд тавигдсан мэдээллийг одоохондоо чөлөөтэй үзэж болно) - ЭХЗХ-ны бичиг хэргийн ажилтантай хийсэн ярилцлага

Нэмэлт мэдээлэл:

ЗҮЯ28. ТАРИФЫН ЗАРЧИМ, ФИЛОСОФИ

Чанарын элементүүд:	Тайлбар:
Нарийвчилсан дүн шинжилгээ	Т Эрчим хүчний тухай хуульд зааснаар тариф тогтооход дараах зарчмыг баримтлах ёстой. Үүнд, -үйл ажиллагааны бодит өртөг, зардалд тулгуурлах; -цахилгаан, дулааны хангалтад хэрэглэгчдээс тавих шаардлагатай уялдуулан хэрэглэгчийн ангилал тус бүрээр өртөг, зардлыг хуваарилах; -эрчим хүчний хэрэглээг зохицуулах боломжтой байх; -үнийн тогтвортой байдлыг хангах; -тусгай зөвшөөрөл эзэмшигчийн орлого нь түүний санхүүгийн чадавхи хэвийн байлгахуйц хэмжээнд байх; -цахилгаан, дулааны тарифын бүтэц хэрэглэгчид ойлгомжтой, энгийн байх; -эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах, диспетчерийн зохицуулалт хийх үйл ажиллагаанд техник, технологийн найдвартай ажиллагааны шаардлагад нийцүүлэн хамгийн бага өртгийн зарчмыг мөрдөх; -тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах зардал болон оруулсан хөрөнгийн өгөөжийг тооцсон ашгийн зохих түвшинг хангасан байх; ЭХЗГ нь Эрчим хүчний тухай хуулинд заасан дээрхи зарчмуудыг тариф тогтоох явцад хэрэгжүүлэх зорилгоор “Тарифын саналыг хянан шалгах журам” батлан дагаж мөрдөж байна. Энэ журмын зорилго нь тарифын саналыг хянан, шалгах үйл явцын ил тод байдлыг хангах, бүх талуудын эрх ашгийг хамгаалсан тарифыг батлахад олон нийтийн оролцоог хангах, саналыг тусгахад оршино гэж заажээ. Дээрхи хууль журмаас харахад тариф тогтоох үйл явцыг нарийвчилсан дүн шинжилгээний үндсэн дээр явуулах хууль эрх зүйн орчныг бүрдүүлсэн гэж дүгнэж болохоор байна.
Сөрөг нөлөөллийг бууруулах	Ү Эрдэс баялаг, эрчим хүчний яам болон Эрчим хүчний зохицуулах газраас тарифын сөрөг нөлөөллийг бууруулах хамгийн үр дүнтэй арга зам бол индексжүүлэх, мөн зохицуулах байгууллагын хараат бус байдлыг бэхжүүлэх явдал гэж үздэг. Энэ үүднээс Засгийн газраас Эрчим хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг УИХ-д өргөн барьж батлуулсан юм.
Ойлгоход хялбар байх	Т Хэрэглэгчдэд худалдах цахилгааны тарифыг Төвийн бүсийн үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын тариф, Төвийн бүсийн айл өрхийн тариф, Дорнод бүсийн ЭХС-ийн хэрэглэгчдэд худалдах тариф, Баруун бүсийн ЭХС-ийн хэрэглэгчдэд худалдах тариф, Даланзадгадын ДЦС-ын хэрэглэгчдэд худалдах цахилгааны тариф, Төвийн бүсийн эмзэг бүлгийн хэрэглэгчдийн тариф гэж б ангилан тогтоосон байна. Мөн дотор нь энгийн тоолууртай, цагийн ялгаварт тоолууртай гэж ангилснаас гадна сарын хэрэглээнээс нь хамаарч өөр өөр тарифтай байхаар тогтоожээ. Эдгээр ангилал тодорхой бөгөөд ойлгоход хялбар байхаар хийгдэж чадсан гэж үзэж байна.

Сүүлд тогтоосон тариф дээр философи/ зарчмыг баримтласан эсэх	Т	<p>Хамгийн сүүлд буюу 2011 оны 5-р сарын 1-ээс эхлэн мөрдөж байгаа тарифт хэрэглэгчдийн цахилгааны тарифыг 5.3-25% хүртэл нэмэгдүүлсэн юм. Тодорхой тарифыг тогтоохдоо дараах зарчмыг баримталжээ. Үүнд,</p> <p>-Үйлдвэрийн хэрэглэгчдийн оргил ачааллын үеийн эрэлтийг бууруулах, шөнийн цагийн хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор цагийн ялгавартай тариф тогтоож оргил ачааллын үеийн тариф өдрийн тарифаас 1.8 дахин их, шөнийн тариф өдрийн тарифаас 50% доогуур байна.</p> <p>-Айл өрхөд хэрэглээг зохицуулах замаар цахилгааны төлбөрөө бууруулах боломжийг олгох, үүний тулд шөнийн цагийн эрчим хүчний хэрэглээг дэмжих зорилгоор ахуйн хэрэглэгчдэд цагийн ялгавартай тариф тогтоож шөнийн цагаар хэрэглэсэн цахилгааны тарифыг өдрийн цагийнхаас 2 дахин бага байна.</p> <p>-Мөн хэмнэлтийг дэмжих зорилгоор ахуйн хэрэглэгчдийн сарын хэрэглээний түвшингээс хамаарсан буурах шатлалтай тариф тогтоожээ. Энэ нь тухайн сарын хичнээн хэрэглээ их байх тусам тариф нь төдийчинээ өндөр байх зарчим юм.</p> <p>-Нийгмийн эмзэг бүлэгт хамрагдах, амжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой ахуйн хэрэглэгчдийг үнийн өсөлтийн дарамтаас хамгаалах зорилгоор эмзэг бүлгийн тариф мөрдөнө.</p>
<p>Үргэлжлэл тайлбар: Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийг 2007 онд баталсан ба энэ хуулиар нар, салхи, усны эрчим хүчний эх үүсвэрээс үйлдвэрлэсэн цахилгааны үнэ тарифыг хууль батлагдсан өдрөөс 10 жилийн хугацаанд хатуу тогтоож мөрдүүлэхээр зааж өгсөн болно.</p>		
Үнэлгээ:	Сонгох:	
Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй		
Зохицуулах байгууллагын тариф тогтоох үйл явцад баримталдаг тарифын философи болон зарчим байхгүй	Доод _	
Тариф тогтоох үйл явц нь урьдчилан тодорхойлсон тарифын философи/ зарчмын дагуу явагддаг ч чанарын нэг ч элементийг хангаагүй/ нэгийг л хангасан	Доодоос дунд _	
Тариф тогтоох үйл явц нь урьдчилан тодорхойлсон тарифын философи/ зарчмын дагуу явагддаг ч чанарын хоёр элементийг хангасан	Дунд ✓	
Тариф тогтоох үйл явц нь урьдчилан тодорхойлсон тарифын философи/ зарчмын дагуу явагддаг ч чанарын гурван элементийг хангасан	Дундаас дээд _	
Тариф тогтоох үйл явц нь урьдчилан тодорхойлсон тарифын философи/ зарчмын дагуу явагддаг ба чанарын бүх дөрвөн элементийг хангасан	Дээд _	
Мэдээллийн эх сурвалж:	<p>Эрчим хүчний тухай хууль (2001 оны 2-р сарын 1-ний өдөр УИХ-аар батлагдсан)</p> <p>Тарифын саналыг хянан шалгах журам (ЭХЗГ-ын Зохицуулагчдын зөвлөлийн 2005 оны 74 дүгээр тогтоол)</p> <p>Эрчим хүчний зохицуулах газрын үнэ тарифын албаны дарга М. Ганчимэгтэй хийсэн ярилцлага</p> <p>Т.Энхтайван: Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн бие даасан байдлыг бэхжүүлнэ (Эрдэс баялаг, эрчим хүчний яамны дэд сайд Т. Энхтайваны "Өдрийн сонин"-ы 2011 оны 10-р сарын 31-ны дугаарт өгсөн ярилцлага)</p>	
Нэмэлт мэдээлэл:	<p>"Эрчим хүчний зохицуулалт 10 жилд" эмхэтгэл (Эрчим хүчний зохицуулах газар), Улаанбаатар, 2011 он.</p> <p>Эрчим хүчний зохицуулах газрын вэб сайт - www.erc.mn вэб сайт</p> <p>Мөн тус вэб сайтын 2012 оныг хүртэлх хувилбар - www.era.energy.mn сайт (тэнд тавигдсан мэдээллийг одоохондоо чөлөөтэй үзэж болно)</p>	

ЗҮҮЯ29. ЦАХИЛГААНЫ ҮНИЙГ БОЛОМЖИЙН ТҮВШИНД БАРИХ ШИЙДВЭР ГАРГАХАД ОРОЛЦОХ НЬ

Чанарын элементүүд:	Тайлбар:
Тариф тогтоох зарчим нь тариф боломжийн байхад анхаарал тавьсан байх	Т Цахилгааны тарифыг тогтоохдоо дараах зарчмыг баримтлана. Үүнд, -Үйл ажиллагааны бодит өртөг, зардалд тулгуурлах; -Цахилгаан, дулааны хангалтад хэрэглэгчдээс тавих шаардлагатай уялдуулан хэрэглэгчийн ангилал тус бүрээр өртөг, зардлыг хуваарилах; -Эрчим хүчний хэрэглээг зохицуулах боломжтой байх; Үнийн тогтвортой байдлыг хангах; -Цахилгаан, дулааны тарифын бүтэц хэрэглэгчид ойлгомжтой, энгийн байх ЭХЗГ-аас тодорхой тарифыг тогтоохдоо юуны өмнө хэрэглэгчдэд дарамт учруулахгүйгээр боломжийн түвшинд байхад онцгой анхаарч байна. Ялангуяа нийгмийн эмзэг бүлэгт хамрагддаг, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой ахуйн хэрэглэгчдийг үнийн өсөлтийн дарамтаас хамгаалах зорилгоор Эмзэг бүлгийн тарифыг 2008 оны ны 11-р сарын 11-ний 176-р тогтоолоор батлан 2009 оны 1-р сарын 1-ээс мөрдөж эхэлснээр тэд жирийн хэрэглэгчдээс бараг хоёр дахин хямд үнэтэй цахилгаан хэрэглэх болсон юм.
Тарифыг хянахад олон нийтийг оролцуулсан байдал	Ү Тариф тогтоох хурлын тогтоол, протокол бусад баримтанд хэрэглэгчид, олон нийтийн төлөөлөл хэрхэн оролцсон, хэдэн санал ирүүлсэн, тэдний саналыг хэрхэн авч үзсэн талаар баримт олдсонгүй.
Орлого багатай бүлгийг боловсруулах талаар	Ү Эрчим хүчний зохицуулах газраас “Хэрэглэгчдэд зориулсан гарын авлага” нэртэй ном, бусад товхимол зэргийг хэвлүүлэн хэрэглэгчдэд тараадаг. Энд эмзэг бүлгийн хэрэглэгчдийн үнэ, тариф, эмзэг бүлгийн ангилалд ямар хүмүүс багтах, энэ бүлэгт хамрагдах журам гэх мэт мэдээлэл багтсан боловч тэднийг боловсруулах талаар тусгайлсан үйл ажиллагаа явуулдаггүй.
Тайлбарын үргэлжлэл: Хэрэглэгчдийн цахилгааны тарифыг аль болох багаар тогтоож байгаад юуны өмнө нийгмийн халамжийн бодлого явуулж байгаа Засгийн газруудын зүгээс үзүүлдэг шахалт дарамттай холбоотой юм.	
Үнэлгээ:	Сонгох:
Хамааралгүй/ Үнэлээгүй	-
Тарифыг хянах явцад цахилгааны үйлчилгээг боломжийн үнээр хүргэх талаар шийдвэр гаргахад оролцох оролцооны чанарын үзүүлэлтийн элементийг огт хангаагүй	Доод _
Тарифыг хянах явцад цахилгааны үйлчилгээг боломжийн үнээр хүргэх талаар шийдвэр гаргахад оролцох оролцооны чанарын үзүүлэлтийн нэг элементийг хангасан	Доодоос дунд ✓
Тарифыг хянах явцад цахилгааны үйлчилгээг боломжийн үнээр хүргэх талаар шийдвэр гаргахад оролцох оролцооны чанарын үзүүлэлтийн хоёр элементийг хангасан	Дунд _
Тарифыг хянах явцад цахилгааны үйлчилгээг боломжийн үнээр хүргэх талаар шийдвэр гаргахад оролцох оролцооны чанарын үзүүлэлтийн гурван элементийг хангасан	Дээд _
Мэдээллийн эх сурвалж:	Эрчим хүчний зохицуулах газрын 2009, 2010 онуудын үйл ажиллагааны тайлангууд Тарифын саналыг хянан шалгах журам (ЭХЗГ-ын Зохицуулагчдын зөвлөлийн 2005 оны 74 дүгээр тогтоол) Эрчим хүчний зохицуулах газар: Эрчим хүчний хэрэглэгчдэд зориулсан зөвлөмжүүд
Нэмэлт мэдээлэл:	Эрчим хүчний зохицуулах газрын вэб сайт - www.erc.mn вэб сайт Мөн тус вэб сайтын 2012 оныг хүртэлх хувилбар - www.era.energy.mn сайт (тэнд тавигдсан мэдээллийг одоохондоо чөлөөтэй үзэж болно)

ЗҮЯЗО. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ

Чанарын элементүүд:		Тайлбар:
Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн хянах үйл явцыг сайтар тодорхойлсон байх	Т	<p>Эрчим хүчний тухай хуульд зааснаар тусгай зөвшөөрөл эзэмшихийг хүссэн хуулийн этгээд нь өргөдлөө ЭХЗГ буюу аймаг нийслэлийн зохицуулах зөвлөлд гаргана. Өргөдөлд хавсаргах баримт бичгийн жагсаалтыг хуулиар зааж өгчээ.</p> <p>Хүлээж авсан өргөдлийг хянах үйл явцын талаар хуульд дараах байдлаар заажээ. Тухайлбал, зохицуулах газар нь шаардлагатай гэж үзвэл өргөдөл, түүнд хавсаргасан баримтын талаар дүгнэлт гаргуулахаар хөндлөнгийн шинжээч томилж болно, өргөдлийг хүлээж авснаас хойш 60 хоногийн дотор тусгай зөвшөөрөл олгох эсэх шийдвэр гаргана, хэрэв баримт бичиг шаардлага хангаагүй гэж үзвэл хүлээж авснаас хойш 10 хоногийн дотор буцаана, зөвшөөрөл олгосон шийдвэр буюу олгохоос татгалзсан тухай үндэслэлийг нийтлэнэ, тусгай зөвшөөрлийг санхүүгийн чадавхитай, тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан буюу явуулах боломжтой хуулийн этгээдэд олгоно, нэг үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахаар хэд хэдэн сонирхогч хуулийн этгээд өргөдөл гаргасан бол сонгон шалгаруулах замаар олгоно гэхчлэн заажээ.</p> <p>Цахилгаан, дулаан түгээх, хангах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулах замаар олгох журмыг ЭХЗГ-аас боловсруулж баталсан байна.</p>
Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хянах шийдэх шалгуур үзүүлэлтийг сайтар тодорхойлсон байх	Ү	<p>Эрчим хүчний тухай хуулинд Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хянах шийдэх шалгуур үзүүлэлтүүдийн талаар маш бүрхэг заалт байна. Тухайлбал, тусгай зөвшөөрлийг санхүүгийн чадавхитай, тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан буюу явуулах боломжтой хуулийн этгээдэд олгох гэсэн заалтууд нь маш ерөнхий, үүнийг нарийвчилсан шалгуур үзүүлэлтүүд байхгүй байна.</p>
Тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулах/ эргүүлэн авах/ түр зогсоох үйл явцын тодорхой байдал	Т	<p>Эрчим хүчний тухай хуулинд тусгай зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт оруулах шинэчлэх, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох талаар тодорхой дэлгэрэнгүй заалтууд байна. Тухайлбал, тусгай зөвшөөрөл олгосон нөхцөл өөрчлөгдсөн, эсвэл тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан бол тусгай зөвшөөрөл олгогч тусгай зөвшөөрлийг шинэчлэх буюу нэмэлт өөрчлөлт оруулж болно гэж заасан. Мөн тусгай зөвшөөрлийг дараах үндэслэлээр хүчингүй болгоно гэж заасан байна:</p> <p>Тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан; Тусгай зөвшөөрөл эзэмшигч татан буугдсан, дампуурсан; Тусгай зөвшөөрлийг хууль бусаар эзэмшсэн нь тогтоогдсон; Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн боловч зөрчлийг хугацаанд нь арилгаагүй; Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөө биелүүлээгүй буюу байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж зөрчсөн.</p>
Маргаан шийдэх	Ү	<p>Эрчим хүчний зохицуулах газар болон, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд үүссэн маргааныг хэрхэн шийдвэрлэх талаархи заалтыг Эрчим хүчний тухай хууль болон бусад холбогдох дүрэм журмаас олсонгүй.</p>

Даган мөрдөлт болон гүйцэтгэлийн мониторинг	Т	<p>ЭХЗГ нь тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааг хянах, үнэлэлт, дүгнэлт өгөх зорилгоор тэдгээрийн үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг сар, улирал бүр, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилтийн тайланг жил бүр авч үнэлэлт, дүгнэлт өгч, хяналт тавин ажилладаг юм байна.</p> <p>Эрчим хүчний томоохон 18 компани, Орон сууц, нийтийн аж ахуйн дулаан түгээх 26 компанийн 2009 оны жилийн эцсийн болон 2010 оны улирлын үйл ажиллагааны үр дүнг Зохицуулагчдын зөвлөлийн хурлаар хэлэлцэж дүгнэлт өгчээ.</p> <p>Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааны гол үзүүлэлтүүд болох ашиг, алдагдал, өглөг, авлага, станцын дотоод хэрэгцээний цахилгаан, дамжуулалт болон түгээлтийн алдагдал, дулааны сүлжээний нэмэлт усны зарцуулалт, орлого, зардал зэрэг үзүүлэлтүүдийг бенчмаркингийн аргаар дүгнэж ТЗЭ-дийн рейтингийг тогтоодог юм байна.</p>
---	---	--

Үргэлжлэл тайлбар:
 ЭХЗГ-т 2010 онд нийт 23 аж ахуйн нэгж, байгууллагаас 8 төрлийн 33 тусгай зөвшөөрөл шинээр авах болон хугацааг сунгуулахаар ирүүлсэн өргөдөл, баримт бичгийг Зохицуулагчдын зөвлөлийн хурлаар хэлэлцсэний үндсэн дээр 19 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан байна. Харин Эрчим хүчний тухай хууль зөрчсөн "ЗМЗ" ХХК-ийн цахилгаан импортлох тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах асуудлыг түдгэлзүүлжээ. Түүнчлэн эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл хүссэн "Оюутолгой" ХХК, "Сайншанд салхин парк" ХХК-иудын ирүүлсэн баримт бичгүүдэд шүүмж хийж холбогдох хуулиудад заасан баримт бичгүүдийн бүрдүүлэлт дутуу байсан тул буцаасан байна. ЭХЗГ нь одоогийн байдлаар 10 төрлийн 163 тусгай зөвшөөрөл эзэмшигч 77 аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд зохицуулалт хийж байна.

Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй	-
Лицензэд тавигдах шаардлага болон үүнээс чөлөөлөгдөх талаар тодорхой заасан журам байхгүй	Доод _
Тусгай зөвшөөрөл олгох үйл явц нь нэгээс хоёр чанарын элементийг хангасан	Доодоос дунд _
Тусгай зөвшөөрөл олгох үйл явц нь чанарын гурван элементийг хангасан	Дунд ✓
Тусгай зөвшөөрөл олгох үйл явц нь чанарын дөрвөн элементийг хангасан	Дундаас дээд _
Тусгай зөвшөөрөл олгох үйл явц нь чанарын бүх таван элементийг хангасан	Дээд _

Мэдээллийн эх сурвалж: Эрчим хүчний тухай хууль
 Цахилгаан, дулаан түгээх, хангах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулах замаар олгох журам (ЭХЗГ-ын Зохицуулагчдын зөвлөлийн 2003 оны 61-р тогтоолын хавсралт)
 Эрчим хүчний зохицуулах газар: Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч компани, аж ахуйн нэгж, байгууллагуудын тухай товч лавлах, Улаанбаатар, 2007
 Эрчим хүчний зохицуулах газрын жил тутмын тайлангууд

Нэмэлт мэдээлэл: Эрчим хүчний зохицуулах газрын вэб сайт - www.erc.mn вэб сайт
 Мөн тус вэб сайтын 2012 оныг хүртэлх хувилбар - www.era.energy.mn сайт (тэнд тавигдсан мэдээллийг одоохондоо чөлөөтэй үзэж болно)

ЗҮЯЗ1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ, ҮЙЛДВЭРҮҮДИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Чанарын элементүүд:	Т	Тайлбар:
Тайлан заавал гаргах шаардлага	Т	Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйл ажиллагааныхаа тайланг ашиг, алдагдал, өглөг, авлага, станцын дотоод хэрэгцээний цахилгаан, дамжуулалт болон түгээлтийн алдагдал, дулааны сүлжээний нэмэлт усны зарцуулалт, орлого, зардал зэрэг үндсэн үзүүлэлтээр сар, улирал бүрээр гаргах үүрэгтэй. ЭХЗГ-аас тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилтийн тайланг жил бүр авч хянан үнэлэлт, дүгнэлт өгдөг.
Хүртээмж хялбар байх	Ү	Эрчим хүчний зохицуулах газрын вэб сайтад тусгай зөвшөөрөл эзэмшигч 83 аж ахуйн нэгжийн нэр тусгай зөвшөөрлийнхөө төрлөөр байна. Эндээс ямар төрлийн хэдэн тусгай зөвшөөрөл эзэмшиж байгааг харж болно. Харин тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн жил улирал, сарын тайлангууд тавигдаагүй бөгөөд зөвхөн ЭХЗГ дээр очиж үзэх боломжтой.
Цаг хугацаандаа хүртээмжтэй байх	Ү	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн талаархи үндсэн мэдээллийг харуулсан "Тусгай зөвшөөрөл эзэмшигч компани, аж ахуйн нэгж байгууллагуудын тухай товч лавлах"-ыг 2007 онд гаргасан ба түүнээс хойш ахиж шинэчлэгдээгүй байгаа. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тайланг ЭХЗГ-ын зохицуулагчдийн зөвлөлөөр хэлэлцээд дүнг ЭБЭЯ болон холбогдох бусад байгууллагуудад тогтмол мэдээлдэг гэж үйл ажиллагааныхаа тайланд бичсэн байна.
Орон нутгийн хэлээр хүртээмжтэй байх	Т	Бүх тайлангуудыг монгол хэл дээр гаргаж байна
Тайлангийн параметруудийн зохистой болон тодорхой байдал	Т	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааны гол үзүүлэлтүүд: ашиг, алдагдал, өглөг, авлага, станцын дотоод хэрэгцээний цахилгаан, дамжуулалт болон түгээлтийн алдагдал, дулааны сүлжээний нэмэлт усны зарцуулалт, орлого, зардал зэрэг үзүүлэлтүүдийг бенчмаркингийн аргаар дүгнэж ТЗЭ-дийн рейтингийг тогтоодог юм байна.
Цогц тайлан гаргах	Ү	

Үргэлжлэл тайлбар:

Эрчим хүчний зохицуулах газар (ЭХЗГ)-ын Зохицуулагчдын зөвлөл эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч томоохон компанудын үйл ажиллагааг хэлэлцэн дүгнэж рейтингийг тогтоодог ба ашиг, алдагдал, цахилгаан, дулааны эрчим хүчний өр, авлагыг бууруулсан байдал, борлуулалтын орлого цуглуулалтын хувь, техник эдийн засгийн үзүүлэлтүүд, эрчим хүчний хангамжийн найдвартай байдал, хэрэглэгчдээс гаргасан санал, гомдол зэргийг харгалздаг. 2011 оны эхний хагас жилийн рейтинг дараах байдлаар гарчээ.

Рейтинг	Компани
I	"Улаанбаатарын дулааны сүлжээ" ТӨХК
II	"Дулааны 4-р цахилгаан станц" ТӨХК
III	"Багануур, зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК
IV	"Дархан, Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ" ХК
V	"Дулааны 2-р цахилгаан станц" ТӨХК
VI	"Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК
VII	"Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК
VIII	"Дарханы дулааны сүлжээ" ТӨХК
IX	"Эрдэнэт, Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК
X	"Дарханы дулааны цахилгаан станц" ТӨХК
XI	«Улаанбаатарын цахилгаан түгээх сүлжээ» ТӨХК
XII	«Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ» ТӨХК
XIII	"Дулааны 3-р цахилгаан станц" ТӨХК
XIV	"Баруун бүсийн эрчим хүчний систем" ТӨХК
XV	"Багануурын дулааны станц" ТӨХК
XVI	"Налайхын дулааны станц" ТӨХК
XVII	Даланзадгадын дулааны цахилгаан станц" ТӨХК
XVIII	"Алтай- Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК

Үнэлгээ:	Сонгох:
Боломжгүй/ Үнэлгээ хийгээгүй	_
Үйлчилгээний байгууллага болон тусгай зөвшөөрөл эзэмшигч нар (цахилгааны компаниуд) нь зохицуулах байгууллагад байнга тайлан гарган өгч байх шаардлага тавигдаагүй	Доод _
Үйлчилгээний байгууллага болон тусгай зөвшөөрөл эзэмшигч нар нь зохицуулах байгууллагад байнга тайлан гарган өгч байх шаардлага тавигддаг ч тайлан гаргаж буй байдал нь чанарын нэгээс хоёр элементийг хангасан	Доодоос дунд _
Үйлчилгээний байгууллага болон тусгай зөвшөөрөл эзэмшигч нар нь зохицуулах байгууллагад байнга тайлан гарган өгч байх шаардлага тавигддаг ч тайлан гаргаж буй байдал нь чанарын гурван элементийг хангасан	Дунд ✓
Үйлчилгээний байгууллага болон тусгай зөвшөөрөл эзэмшигч нар нь зохицуулах байгууллагад байнга тайлан гарган өгч байх шаардлага тавигддаг ч тайлан гаргаж буй байдал нь чанарын дөрвөөс таван элементийг хангасан	Доодоос дунд _
Үйлчилгээний байгууллага болон тусгай зөвшөөрөл эзэмшигч нар нь зохицуулах байгууллагад байнга тайлан гарган өгч байх шаардлага тавигддаг ч тайлан гаргаж буй байдал нь чанарын бүх зургаан элементийг хангасан	Доод _
Мэдээллийн эх сурвалж:	Эрчим хүчний зохицуулах газар: Дүрэм, журам, зааврын эмхэтгэл, Улаанбаатар, 2011 Эрчим хүчний зохицуулах газар: Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч компани, аж ахуйн нэгж, байгууллагуудын тухай товч лавлах, Улаанбаатар, 2007 Эрчим хүчний зохицуулах газрын жил тутмын тайлангууд ЭХЗГ-аас жил бүр хэвлэж гаргадаг "Эрчим хүчний статистик үзүүлэлтүүд" эмхэтгэл
Нэмэлт мэдээлэл:	Эрчим хүчний зохицуулах газрын вэб сайт - www.erc.mn вэб сайт Мөн тус вэб сайтын 2012 оныг хүртэлх хувилбар - www.era.energy.mn сайт (тэнд тавигдсан мэдээллийг одоохондоо чөлөөтэй үзэж болно)

ЗҮЯЗ2. ХЭРЭГЛЭГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ЭРЧИМ ХҮЧ ХАНГАМЖИЙН ЧАНАР

Чанарын элементүүд:	Тайлбар: Хэрэглэгчийн хувьд хамгийн чухал үзүүлэлт бол үйлчилгээний чанар, цахилгаан эрчим хүчний найдвартай хангамж юм. Үйлчилгээний чанарт техникийн нөхцөл олгох, цахилгаан түгээх сүлжээнд холбох; цахилгаан хангамжийн талаар хэрэглэгчээс ирүүлсэн өргөдөл, гомдолд хариу өгөх; хэрэглэгчийн хүсэлтээр техникийн үйлчилгээ хийх; хэрэглэгчийн цахилгаан хангамжийн тасралтын үргэлжлэх хугацаа, тасралтыг сэргээх; тоолуур баталгаажуулах зэрэг үзүүлэлтүүд орно. Эрчим хүчний хангамжийн чанарт хүчдэлийн хэлбэлзэл; давтамж, хүчдлийн уналт зэрэг техникийн үзүүлэлтүүд хамаарна.
---------------------	---

Мөрдөгдөж буй стандартууд:

Хэрэглэгчийн үйлчилгээ, хангамжийн чанар	T	Хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангаж буй компани, аж ахуйн нэгж байгуулагаас хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээнд тавих шаардлагыг тогтоосон "Цахилгаанаар хангагчаас хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний шаардлага" MNS 5872 стандартыг ЭХЗГ-аас санаачлан боловсруулж, эрчим хүчний салбарын техникийн хороогоор хэлэлцэж, улмаар Стандартчилал, хэмжилзүйн үндэсний Зөвлөлийн 2008 оны 11-р сарын 27-ны өдрийн 35 дугаар тогтоолоор батлагдсан бөгөөд 2009 оны 1-р сарын 15-ны өдрөөс эхлэн улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөж байна. Энэхүү стандарт нь хэрэглэгчдэд техникийн нөхцөл олгох, цахилгаан түгээх сүлжээнд холбох; цахилгаан хангамжийн талаар хэрэглэгчээс ирүүлсэн өргөдөл, гомдолд хариу өгөх; хэрэглэгчийн хүсэлтээр техникийн үйлчилгээ хийх; хэрэглэгчийн цахилгаан хангамжийн тасралтын үргэлжлэх хугацаа, тасралтыг сэргээх; тоолуур баталгаажуулах, бичилт хийх хугацаа гэсэн 5 үндсэн хэсэг, 41 заалттай.
Заавал хангамжийн стандарттай байх шаардлагатай	T	Цахилгаан эрчим хүчний хангамжийн чанарын стандартыг хангагч байгууллага ба хэрэглэгчдийн хооронд байгуулсан гэрээнд тусгах байдлаар хэрэгжүүлдэг.
Стандартын чанар:		
Гүйцэтгэлийн мониторинг	T	ЭХЗГ нь 2005 оноос хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний хангамжийн тасалдлыг олон улсын хэмжээнд мөрддөг индексүүдийг ашиглан тогтоож байна. Ингэснээр тасалдлын шалтгааныг ангилан бүртгэж, тасалдлын хэмжээг олон улсын жишгээр авч үздэг болжээ.
Стандартын хэрэгжилтэд тавих хяналт	Y	ЭХЗГ нь цахилгаан эрчим хүчний үйлчилгээний болон хангамжийн чанарын стандартын хэрэгжилтэнд бүрэн гүйцэд хяналт тавьж чаддаггүй.
Стандартыг мөрдөж буй тухай мэдээллийг хянаж /үр дүнг нийтийн хүртээл болгосон	Y	Стандартыг мөрдөж буй талаар болон хэрэгжилтийн тайланг олон нийтэд түгээсэн талаархи мэдээлэл олдоогүй.
Хэрэглэгчдээс гаргасан гомдол	T	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааны талаар болон хэрэглэгчдээс эрх ашгаа хамгаалуулахаар 2009 онд Эрчим хүчний зохицуулах газарт хандан ирүүлсэн 49 өргөдөл гомдлыг шалган шийдвэрлэсэн байна. Нийт ирсэн гомдлын 45% буюу 22 өргөдөл гомдол нь цахилгааны төлбөр тооцоо, цахилгааны чанарын асуудалтай болон цахилгаан тоолуурын холбоотой байжээ. Эдгээр гомдол саналыг холбогдох тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй нь хамтран шийдвэрлэсэн байна.
Тайлбарын үргэлжлэл:		

Үнэлгээ:	Сонгох:
Хамааралгүй/ Үнэлээгүй	–
Хэрэглэгчийн үйлчилгээ, цахилгаан хангамжийн чанарын гүйцэтгэлийн тодорхой стандарт байхгүй	Доод _
Хэрэглэгчид үзүүлэх үйлчилгээ, хангамжийн чанарын стандарт байгаа ч заавал мөрдөх албагүй	Доодоос дунд _
Хэрэглэгчид үзүүлэх үйлчилгээ, хангамжийн чанарын стандартыг заавал мөрдөх шаардлагатай ч чанарын зөвхөн нэг элементийг хангасан	Дунд _
Хэрэглэгчид үзүүлэх үйлчилгээ, хангамжийн чанарын стандартыг заавал мөрдөх шаардлагатай ч чанарын хоёроос - гурван элементийг хангасан	Дундаас дээд ✓
Хэрэглэгчид үзүүлэх үйлчилгээ, хангамжийн чанарын стандартыг заавал мөрдөх шаардлагатай ч чанарын бүх дөрвөн элементийг хангасан	Дээд _
Мэдээллийн эх сурвалж:	Цахилгаан хангамжийн тасалдлыг бүртгэх, тогтоох журам (ЭХЗГ-ын Зохицуулагчдын зөвлөлийн 2005 оны 4-р сарын 1-ний 74 дүгээр тогтоол) “Цахилгаанаар хангагчаас хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний шаардлага” MNS 5872 стандарт (Стандартчилал, хэмжилзүйн үндэсний Зөвлөлийн 2008 оны 11-р сарын 27-ны өдрийн 35 дугаар тогтоолоор батлагдсан) ЭХЗГ-ын 2010 оны үйл ажиллагааны тайлан
Нэмэлт мэдээлэл:	Эрчим хүчний зохцуулах газрын вэб сайт - www.erc.mn вэб сайт Мөн тус вэб сайтын 2012 оныг хүртэлх хувилбар - www.era.energy.mn сайт (тэнд тавигдсан мэдээллийг одоохондоо чөлөөтэй үзэж болно)

“МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭ” ТАЙЛАНГИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ПРОТОКОЛ

2012 оны 11 дүгээр сарын 16.

Нээлттэй Нийгэм Форумын хурлын танхим

15:04 цагт эхлэв.

Б.Мөнхсоёл /ННФ-ын Эдийн засгийн асуудал хариуцсан менежер/ хэлэлцүүлгийг нээж үг хэлэв:

-Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Бидний урилгыг хүлээн авч энэхүү хэлэлцүүлэгт хүрэлцэн ирсэн та бүхэнд талархал дэвшүүлье! Манай ННФ Төв Евразийн төсөлтэй хамтран Эрчим хүчний засаглал /ЭХЗ/-ын судалгаа хийсэн. Энэ нь юун судалгаа болох, түүнд ямар аргачлал хэрэглэсэн талаар илтгэл тавих хүмүүс тодорхой ярих учраас би дэлгэрэнгүй ярихгүй. Энэ судалгааг бид анх 2011 оны 3-р сард олон улсын зөвлөх, сургагч багш нарыг урьж, судалгааны аргачлалаа ТББ-уудад зааж журмаар эхэлсэн. Улмаар 2011 оны намар судалгааны баг байгуулж ажлаа эхэлсэн. Одоо тайлан маань ерөнхийдөө төсөл маягаар дуусч, уг төслийн хувилбар нь та бүхэнд урилгатай хамт очсон тул тодорхой хэмжээгээр танилцаж амжсан байх. Томоохон өөрчлөлт хийж чадахгүй ч гэсэн энэ хэлэлцүүлгийн тэмдэглэл болон оролцогчдын санаа оноог тодорхой хэмжээгээр тусгахын тулд тайлангаа эцсийн хувилбараар хараахан хэвлээгүй байгаа юм.

ЭХЗ-ын энэ судалгааг одоогоор дэлхийн 10-аад орон хийгээд байна. Монгол Улсын хувьд судалгааг хамгийн сүүлд Пакистан улстай зэрэг эхлүүлсэн. Судалгааны аргачлалын хувьд Вашингтонд байрладаг, эрчим хүчний салбар /ЭХС/-аар ажилладаг Дэлхийн нөөцийн институт, Энэтхэгийн Prayas гэдэг ТББ хоёрын нийлж боловсруулсан аргачлал бөгөөд ЭХЗ-ын асуудлыг бодлого боловсруулах үйл явц, зохицуулах үйл явц гэсэн хоёр чиглэлээр судалсан, тус тус 32, 36 үзүүлэлттэй. Бусад орны хувьд өөрийн орны онцлог болон илүү чухалчлан үзэж буй асуудалдаа тохируулаад 68 үзүүлэлтээс тухайн улсын судлаачид сонгож, жижигрүүлэх маягаар явуулсан байдаг. Монгол Улсын хувьд ЭХЗ-ын бүх асуудлыг чухалчилж үзсэн тул бүх асуултанд хариулт өгөхийг оролдож энэ судалгааг хийсэн байгаа.

Судалгааны үр дүнг танилцуулахын өмнө хэлэлцүүлгийнхээ хөтөлбөрийн дагуу манай судалгаанд зөвлөхөөр оролцсон Тажикистан улсын “Хэрэглэгчдийн Эрх Ашгийг Хамгаалах Нийгэмлэг” -ийн захирал Бахадур Хабибовыг энэхүү судалгааны аргачлал болон бусад орны судалгааны үр дүнгийн талаар танилцуулга хийхийг урьж байна.

Бахадур Хабибовын презентаци 15.30 цагт дуусав.

Үүний дараа Б.Мөнхсоёл Б.Бат, Г.Пүрэвдорж, Ж.Доржпүрэв, Д.Цэрэнжав гэсэн 4 гишүүнтэй судалгааны баг болон Д.Сүхгэрэл, Ц.Түмэнцогт, Р.Ганжуур, Б.Туяа, Х.Ганбаатар, Я.Нямжаргал, Ган-Эрдэнэ нарын 7 хүний бүрэлдэхүүнтэй зөвлөх баг байгуулан ажилласнаа танилцууллаа.

Үндсэн илтгэл - Судалгааны тайлан Д.Цэрэнжав 16 цаг хүртэл үргэлжлэв.

Б.Мөнхсоёл: Та бүхэн төслийг хэвлэмэл байдлаар авсан, тэндээс хэр их хөдөлмөр зарцуулсныг олж харсан байх гэж найдаж байна. Ингээд та бүхнийг асуулт-хариулт, санал шүүмжээ хэлнэ үү хэмээн урьж байна. Бидний хийсэн судалгаанаас ажиглахад манай улсад ер нь эрчим хүчний чиглэлд төвлөрч ажилладаг, түүгээр дагнан мэргэшсэн иргэний нийгмийн байгууллага /ИНБ/ ховор, байгаа байгууллагууд нь ЭХС-ын ажилтнуудын байгуулсан Эрчим хүчний инженерүүдийн холбоо /МЭХИХ/, Эрчим хүчний ассоциаци гэх мэт салбарын хүмүүсийн байгуулсан холбоо л байдаг. Яг хэрэглэгч талаасаа дорвитой ажилладаг байгууллага их ховор байгаа юм билээ. Тийм ч учраас 3 талын оролцоог бүрдүүлсэн хамтын ажиллагаа буюу эвсэл байгуулна гэсэн зорилготой ажиллаж байгаа тул та бүхэн үнэтэй санал бодлоо хуваалцана уу.

*Эрчим хүчний салбарын
үйл ажиллагааны нийт
дүн юун 3,15 харин 2,0 гэсэн
үнэлгээ авах ёстой.*

Р.Гаанжуур /МЭХИХ/

Р.Гаанжуур /МЭХИХ/: Манай улсын эрчим хүчний салбарын үйл ажиллагааг анх удаа олон улсын аргачлалаар дүгнэж, үнэлгээ гаргасан байна. Энэ бол маш их цаг хугацаа шаардсан ажил. Үүнийг ННФ сайн зохион байгуулж, “Монгол Улсын эрчим хүчний засаглалын үнэлгээний тайлан” хэмээх үнэхээр хэрэгтэй ном гаргажээ. Өнөөдөр ЭХЗ-ыг үнэлэх цаг хугацаа нь болсон байсан. Ялангуяа шинэчлэлийн Засгийн газрын босгон дээр шинэ сайд ер нь эрчим хүчний ямар салбар хүлээн авч байгаа, цаашдаа юу хийх ёстой гэдэг талаар та бүхний бүтээсэн ном маш их ашиг тустай зүйл болжээ. Би хувьдаа сэтгэл маш өндөр, та бүхний ажлыг онцоос илүү сайнаар, онцсайн гэж үнэлмээр байна. Холбоог төлөөлсөн салбарын инженерийн хувьд маш том гарын авлага боллоо гэж үнэлж байна. Тэгээд энэ бол төсөл, цаашдаа зарим санал хүлээж авах юм байна гэж ойлгоод 3 санал хэлье:

1-рт, тайланд зарим нэг алдаа байна билээ. Жишээ нь, IY цахилгаан станцыг 1981 онд биш, 1983 онд ашиглалтанд орсон гэх мэт. Гэхдээ энэ хамаагүй, хамгийн гол нь ном гарсан нь чухал явдал. Эрчим хүчний салбарын үйл ажиллагааны нийт дүн - 3,15 гэдгийг дунд гэж ойлгож байна. Би үүнийг манай хүмүүс жоохон зөөлөн дүгнэжээ гэж үзэж байна. Юун 3,15, харин 2 гэсэн үнэлгээ авах ёстой. Яагаад гэвэл Y цахилгаан станцынхаа асуудлыг 10 жилирчихаад өнөө болтол шийдэж чадаагүй, сая томилогдсон шинэ сайд нь одоо газрын асуудлаа газар дээр нь хөөцөлдөөд явж байгаа тул ЭХЗ-д дунд үнэлгээ тавих аргагүй. ЭХЗ-ын үнэлгээг сайжруулахын тулд төрийн өмчит хувьцаат компаниудын 51 хувийг нь төрд өгөөд 49 хувийг олон нийтийн хяналтанд оруулах хэрэгтэй юм. Үрлэг зарлага өндөр байна гэдэг чинь олон нийтийн хяналт байхгүй гэсэн үг. Тэгэхдээ концессын аргаар бус, зөвхөн хөрөнгийн биржээр дамжуулан хувьцаа гаргаад түүнийг нь хэн ч авч болно шүү дээ. Тэгээд өөрсдийнхөө 49 хувийн төлөөллийг оруулаад хяналтаа тавих юм бол эрчим хүчний компаниудын үр ашгийг дээшлүүлэх, өртөг зардлыг буруулах асуудал аяндаа шийдэгдэх юм. 49 хувиасаа 25-ыг нь нийт хамт олонд нь хувьцаа болгоод өгчих юм бол тэд өөрсдөө өмчтэй болчихно. Та нөхөд үүнийг нэлээд сайн авч үзнэ үү.

2-рт, зохицуулах байгууллага маань өнөөдөр 3,1 гэсэн оноо авсан байна. Гэтэл 2 жилийн өмнө 2010 онд Монголын ЭХЗГ-ыг уриад олон улсын чуулга уулзалтанд презентаци хийлгэдэг байсан. АНУ-ын ОУХА-аас “Төв Азийн эрчим хүчний зохицуулах байгууллагад танайхыг үлгэр жишээ болгоод сургалт зохион байгуулъя” гэдэг байсан. Гэтэл өнөөдөр 3,1 гэдэг үнэлгээ авна гэдэг үнэхээр харамсалтай. Үүнийг би хувь хүмүүстэй гэхээсээ тухайн салбарын зохион байгууллалттай холбоотой гэж ойлгож байна. ЭХЗГ буюу ЭХЗХороо Засгийн газраас хараат байна. Зохицуулагч нарыг сайд санал болгоод Ерөнхий сайд томилж байгаа тохиолдолд шууд хараат гэж ойлгож болно. Үүний оронд Ерөнхийлөгч санал болгоод УИХ-аар хэлэлцүүлснээр олон нийтэд ил тод болох юм. Түрүүн зохицуулагч нарыг томилох асуудал хаалттай байгааг хэллээ. АНУ-д бол Ерөнхийлөгч нь 5 зохицуулагчийг санал болгоод Сенат нь томилдог. Энэ байгууллага нь үнэхээр хараат бус байдлаар ажилладаг.

3-рт, “Улаанбаатар зэрэг хотод жилдээ цөөн - 3-4-хөн саражиллуулахын тулд том цахилгаан станц барих хэрэггүй, жижиг ус халаалтын зуух барьж асуудлыг шийдэх хэрэгтэй” гэсэн нэг зөвлөмжирхүү юм бичсэн байна. Сүүлийн үед мэргэжлийн бус хүмүүс ингэж яриад байгаа юм. Нийслэлийн дулааны асуудлыг шийдвэрлэхийн тулд Ү цахилгаан станцыг барихгүй гэх юм бол Налайхын ДЦС шиг 20 зуух барих юм билээ. Монэнержи консалт гэдэг компани үүнийг хийсэн байгаа. 20 жижиг станцыг хойгуур, урдуур байрлуулж, тэдэн рүү төмөр зам, машинаар нүүрсээ тээх юм уу? Нүүрсээр л ажиллана шүү дээ. Жилдээ Налайхын станц 60 мянган тонн нүүрс түлдэг гэж байгаа. 5-тн-ын машинаар нүүрсээ тээвэрлэх юм бол зөвхөн нэг станцыг нүүрсээр хангахын тулд 12000 рейс хийх гэж байна. Том станцуудын яндан өндөр, үнс утаагаа 20-30 км хол хаяхаар тусгайлан тооцоолсон байдаг. 20 жижиг зуухны утаа хаашаа явж, үнсээ яах вэ гэхчлэн том эрчим хүчний асуудлыг жижиг эрчим хүчний аргаар шийдвэрлэх нь мэргэжлийн маш ноцтой, их том асуудал шүү!

Гадаадын мэргэжилтнээс асууя. Бид сүүлийн 20 жил барууны мэргэжилтнүүдийг харж, сонсож ирсэн. Өнөөдөр ах дүү Тажикистан улсын олон улсын эрчим хүчний мэргэжилтэнг харж байгаадаа би их баяртай байна. Энд яригдаж буй 9 орон ЭХС-таа ямар үр дүнд хүрсэн бэ? Танд энэ талын баримт байгаа бол бидэнд үзүүлж болох уу?

Бахадур Хабибов: Халуун дулаан үг хэлсэнд их баярлалаа. Та бүхэнтэй ажиллахад надад ч бас тааламжтай байна. Би Монголд 3 дахь удаагаа ирж байна. Хаана юу байдгийг мэднэ, бараг өөрийн хүн гэсэн үг. Тайлангийн хувьд тэдгээрийг бүгдийг нь авч болно, гэхдээ ихэнх нь англиар бичигдсэн, 100-180 хуудастай том тайлан байгаа. Хэрэв сонирхож байгаа бол би Б.Мөнхсоёлтой ярья. Энэ бүх материал Интернетэд байгаа тул хожуу олгох боломжтой.

Г.Оюунтуяа /"Хүнс" эвсэл/: Өнгөрсөн жил Бахадур болон бусад хүмүүс ирээд ЭХС-ыг үнэлье гэж ярьж байхад их хэцүү санагдаж байсан. Асуулт нь олон, их төвөгтэй, манайд бараг тохирох юм байхгүй тул үнэлгээ хийхэд хэцүү байсан. Гэтэл манай ажлын багийнхан ямар боловч асуудлыг цэгцлээд өөрсдийн нөхцөлд тохируулан буулгаж, үнэлгээ хийж

Гэр хорооллын цахилгааны хүчин чадал маш муу байдаг, Жишээ нь, нэг халуун тогоо залгаад дээрээс нь ус буцалгагч залгахад тог унтардаг.

Г.Оюунтуяа /"Хүнс" эвсэл/

чадсан нь туйлын сайн хэрэг боллоо. Харин энэ үнэлгээнд салбарын хүнд суртлын асуудал тулгараагүй юм болов уу гэж Д.Цэрэнжав гуайн илтгэлээс бодогдож байна. Нөгөө талаар манайд эрчим хүчийг зүй зохистой ашиглах талаар их асуудал байдаг. 2010-2011 онд бүх станцуудын дэргэд дэд станц барина гэж ярьж байсан. Үүнийг ИНБ-ууд эсэргүүцэж байсан. Дэд станц барья гэдгийг “Станцын хажууд бас нэг нүүрс түлэх юм уу? Салхины хүч, стандарт нь ямар байх билээ?” гэхчлэн ярьж байсан. Мөн Ү станцаа барих уу, эсвэл одоо байгаа IY станцынх нь хүчин чадал хэр бүрэн ашиглагддаг юм бол гэдэг асуудал байна. Энэ асуудлын хүрээнд нар, сарны эх үүсвэрийг гаргаж тавих боломж байсан уу? Ер нь энэ асуудлыг мэргэжлийн түвшинд хэлэлцэж байгаа нь мэдээж сайн хэдий ч хамгийн гол нь хэрэглэж байгаа иргэдийнхээ саналыг дороос нь авбал ямар вэ?

Гэр хорооллын цахилгааны хүчин чадал маш муу байдаг, Жишээ нь, нэг халуун тогоо залгаад дээрээс нь ус буцалгагч залгахад тог унтардаг. Энэ бүхэн хойшдын зөвлөмжид ямар байдлаар тусаж болох вэ, манайд энэ нь одоо асуудал мөн үү? Мөн хөдөөгүүр хол газар 2 ч юм уу 4 айл уулын ам өөд 85-100 км хол газар цахилгаан үүсвэрийн үндсэн шугам татсан байдаг нь нэн сайн хэрэг ч тэнд ажиллаж, амьдарч буй иргэд замаас нь тог авъя гэхээр зөвшөөрөл хэрэгтэй болдог. Үүнийг авах боломж нь юу байдаг вэ?

Б.Мөнхсоёл: Зарим нэг асуудал нь ЭХС-ын өөрийнх нь асуудал байна. Харин манай судалгааны зорилго бол ЭХС маань иргэдэд хэр нээлттэй, ил тод байж, тэдний оролцох боломжийг нь хэр хангаж ирэв ээ гэх зэргийг нь үнэлсэн засаглалын судалгаа байгаа. ЭХС өөрөө маш өргөн хүрээтэй асуудал, тэр бүхнийг бид хамраагүй, энэ бол ЭХС-ын судалгаа гэдгийг сануулмаар байна.

Г.Пүрэвдорж /Монголын эрчим хүчний ассоциацийн ерөнхий нарийн бичгийн дарга/: Судалгаа маань эрчим хүчний салбарын өнөөгийн байдлын засаглал ямар байна вэ гэдэг асуултын хүрээнд явагдсан. Өөрөөр хэлбэл, өнөө хүртэлх нөхцөл байдалд үнэлгээ өгч байна гэж ойлгож болно. Түүнээс гадна зарим зүйл ч байгаа. Тухайлбал, ирээдүйд эрчим хүчийг хэрхэн хөгжүүлэх, тус салбарын хууль эрхзүйн орчин яаж бүрдсэн, түүний ил тод байдал ямар байгаа вэ гэдгийг бид харгалзан эдгээр асуудлын дагуу хариулт өгсөн. Сая эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээтэй холбоотой манай орны тулгамдсан асуудлыг асуулаа. Өнөөдөр манай улсын ЭХС сайн, маш сайн ажиллаж байгаа гэж хэлж болно. Үүнд юу дутагдсан бэ гэхээр тус салбарыг түрүүлүүлэн хөгжүүлэх төрийн бодлого тодорхой хэмжээгээр алдагдсан, өөрөөр хэлбэл, Ү цахилгаан станцыг барих гээд 8 жил яриад чадаагүй, одоо ч хаана барих нь тодорхойгүй байгаа нь эрчим хүчний салбарыг чадлын дутагдалд оруулж, найдвартай эрчим хүчээр хэрэглэгчдийг тасралтгүй хангах үүрэг, зорилгоо биелүүлэхэд хүндрэл учруулж байна. Энэ үнэлгээ тайланд байгаа. Д.Цэрэнжав сая олон жишээ ярилаа. Ү ТЭЦ, Могойн голын дулааны цахилгаан станц /ДЦС/ зэрэг станцуудыг барих гэж яаж будилж, хугацаа алдаж байна вэ гэдэг нь тус салбарын бодлогын дүн, ил тод байдал сайнаас доор, дунд хавьд үнэлэгдэж байгаагийн жишээ. Манай эрчим хүчний салбарынхан харьцангуй сайн ажиллаж байгаа учраас энэ дүнг тодорхой хэмжээгээр дээш нь татаж байгаа юм.

Нөгөөтэйгүүр энд нэг зүйл ажиглагдаж байгаа нь, иргэний нийгмийн оролцоо нь үнэ тарифын асуудал дээр л ил тод байдал нь гарч ирж байна. Шинэ эх үүсвэрүүдийг бараг бариагүй учраас уул уурхай болон бусад салбарынхтай адилхан иргэний нийгмийн оролцоо маш бага байгаа. Яагаад гэвэл хуучин тоноглолоороо ажиллаж байгаа. Харин сая шинээр Дөргөн, Тайширын станцуудыг барих асуудал дээр эдгээр объектын талаар ард иргэд эерэг, сөрөг янз бүрийн санал хэлж, тэдгээрийг зөв чиглэлд оруулах талаар дуу хоолойгоо хүргэж байна. Тэр бүхэн тус салбарын объектуудыг шинэчлэх, чадлын дутагдлыг арилгахад чухал нөлөөтэй. Жишээ нь, биднийг судалгаа хийж байхад Эгийн голын УЦС-ын асуудал бараг яригдаагүй байсан, одоо л хэлэлцүүлж байгаагаас бус энэ бол нэлээд эрт хийсэн судалгаа юм. Тэгэхээр одоо энэ станцыг баривал яах вэ гэдэг дээр янз бүрийн хэлэлцүүлэг явуулж, шинэ шинэ объектыг барихад иргэдийн дуу хоолой ихээхэн сонстож, байгаль орчны болон бусад асуудлыг ард нийтэд ил тод болгоход чухал үүрэгтэй байх гэж бодож байна.

Б.Бат /МУИС-ийн ЭЗС-ийн багш/: Шинэ эх үүсвэрүүдийн тухай асуудал гарч ирсэн учраас хариулъя. Ерөнхийдөө манай улс 1991 онд эрчим хүчний салбарын анхны мастер төлөвлөгөөгөө боловсруулан гаргаж байсан. Үүний дараа 2001 онд гаргаж байсан, харин одоо 2025 он хүртэлх байдлаар АХБ-ны санхүүжилтээр боловсруулж байгаа учраас бодлоготой холбоотой малгай баримт бичиг бидэнд олдоогүй. Биднийг судалгаа хийж байхад Монгол Улсын Засгийн газраас сэргээгдэх эрчим хүчийг 2020 он гэхэд нийт эрчим хүчний 20 хувийг эзлүүлэх зорилт тавьсан нь яг ямар чиглэлд, үйл ажиллагааны ямар хөтөлбөрөөр, сэргээгдэх ямар эрчим хүч ашиглан ийм үзүүлэлтэд хүрэх гээд байгаа нь тодорхой бус байсан. Өөрөөр хэлбэл, үйл ажиллагааны хөтөлбөр байхгүй. Засгийн газар том том УЦС-д нэлээд анхаарч байгаа, харин хувийн хэвшлийн зүгээс ялангуяа маш жижиг хэмжээний нарны болон салхин станц барьж байна. Жишээ нь, дулааны асуудлыг нарны коллектороор шийдэх байдлаар Цэвэр агаар сан НЗДТГ-тай хамтраад 14 айл сонгон авч дулааны коллектор суурилуулж, үр ашгийг нь судалж байгаа юм билээ. Тэгэхээр хувийн хэвшлийн зүгээс тодорхой ахиц дэвшил байна гэж хэлэх байна.

Д.Чулуунбаатар /МХЭАХН-үүдийн нэгдсэн холбооны ерөнхий нарийн бичгийн дарга, ЭХЗХ-нд хэрэглэгчийн байгууллагыг төлөөлсөн орон тооны бус зохицуулагч/: Тайлантай холбогдуулаад 2 санал хэлье. Мөн тайлбар хийх зүйл байна. Эхнийхийг нь сая Р.Гаанжуур гуай хэллээ. Тайланд “Манайд эрчим хүчний харьцангуй сайн засаглал бүрэлдэж эхэлсэн байна” гэсэн дүгнэлт байна. Би Р.Гаанжуур гуайтай санал нэг байна. Сайн засаглал бүрэлдэж эхлэх нь битгий хэл, хөндлөнгөөс харахад манайд энэ салбар харанхуй явж ирсэн. Наанадаж Ү цахилгаан станцын асуудал байна. Ер нь ЭХС-т мастер төлөвлөгөө байх ёстой атал одоо болтол байхгүй байгаа. Бид энэ төлөвлөгөөг даруй гаргаач гэж М.Сономпил сайдад шаардаж байгаа ч энэ асуудал хэрхэх нь тодорхойгүй байна. Цаашдаа ЭХЗХ-ноос гаргасан прогнозоор 2015-2016 онд 11-12 сая кВт эрчим хүчний хэрэглээ үүсэх хандлагатай байгаа. Энэ хэрэглээг хангах үйлдвэр бас тодорхойгүй байгаа. Ийм харанхуй байдалтай явж байгаа салбарт арай л зөөлдсөн дүн тавьжээ.

Монгол Улсын Засгийн газраас сэргээгдэх эрчим хүчийг ямар хөтөлбөрөөр, ямар төрлийг нь ашиглан нийт эрчим хүчний 20 хувийн үзүүлэлтэд хүрэх гээд байгаа нь тодорхой бус байсан.

Б.Бат /МУИС-ийн ЭЗС-ийн багш/

2-рт, ЭХС-ыг анхнаасаа бодлоготой, төлөвлөгөөтэй хөгжүүлж ирсэн бол Оюутолгой болон бусад толгойг онгичихгүйгээр зөвхөн хэдэн томоохон нүүрсний уурхайд ДЦС бариад л эрчим хүчээ экспортлоход маш их мөнгө олох боломжтой байсан. Нөгөөтэйгүүр Зохицуулах хороо цаасан дээр хараат бус байгууллага байна гэж заасан атлаа хөрсөн дээрээ буухаар хамгийн хараат газар болж хувирсан. Зохицуулагчдыг Засгийн газраас, Ерөнхий сайд томилдог тул Засгийн газраас хараат болсон. Үнэ тарифын хувьд 72-р тогтоол ёсоор 2014 онд тус салбарыг зах зээлийн зарчмаар авч гарья гэвэл хамгийн түрүүнд ЭХЗХ-г хараат бус болгох хэрэгтэй. Өнөөдөр уг нь үнэ тариф нэмэх шаардлагатай байдаг, гэтэл Засгийн газрын байр суурь ойлгомжгүй, биднийг нэмнэ гэхээр Засгийн газар эргээд бидэнд хэрхэн хандах нь тодорхойгүй байгаа учраас энэ завсар нь бид дүлэгнээд оновчтой шийдэл гаргаж чадахгүйд хүрч байгаа. Албан ёсны санал маань ийм байна.

Тайлбар хэлэх зүйл гэвэл, зохицуулагчийн асуудал ил тод бус байна гэсэн нь яг үнэн, гэхдээ үүнд шалтгаан байгаа. Эрчим хүчний тухай хууль 2011 оны сүүлээр батлагдсан. Гэтэл Зохицуулагчдын зөвлөлд хэрэглэгчийн байгууллагын төлөөллийг оруулж ажиллуулах асуудал ерөөсөө шийдэгдээгүй байгаа. Үнэ тариф тогтоох, хэрэглэгчийн эрх ашигтай холбоотой асуудалд хэрэглэгчийн байгууллагын төлөөллийг оруулахыг удаа дараа шаардаж ирсэн ч ерөөсөө хүлээн авдаггүй байсан. Харин “аз” болж энэ оны 1-р сард бензин, шатахууны үнийг үндэслэлгүй нэмсэнтэй холбоотойгоор үнэ тариф тогтоодог байгууллагад хэрэглэгчдийн байгууллагын төлөөлөл оруулахаар тэмцсэний хүчинд сая 4-р сард төлөөллийг ШӨХТГ-ын дэргэдэх зөвлөлд оруулсан. Ингэж оруулж байгаа нь л аз болохоос бус өргөн олон нийтээр хэлэлцүүлэг хийлгээд тэр дундаас сонгон шалгаруулах боломжгүй байсан. Хуулиндаа “Хэрэглэгчдийн байгууллагын төлөөлөл” гэж заасан учраас л хэрэглэгчийн байгууллагын дунд сонгон шалгаруулалт явуулснаас бус олон нийтийн дундаас сонгон шалгаруулах боломж огт байгаагүй.

Б.Цэвээн /Үү цахилгаан станцын захирал/: Өнөөдөр ННФ Монгол Улсын ЭХС-т чухамхүү үгүйлэгдэж байсан орон зайг бий болгох оролдлого хийж байгаад их баяртай байна. Яагаад гэвэл, эрчим хүчний үйлдвэрлэл гэдэг, ер нь эрчим хүч гэдэг нь цэвэр инженерийн ухаанаар бүтдэг ажил. Үүнийг олон нийтэд нээлттэй, зөвөөр ойлгуулахад энэ хэлэлцүүлэг их хувь нэмэр оруулах байх. Би тус салбарт 30 жил ажиллаж байгаа хүний хувьд үүнийг дэмжин ажиллахаа илэрхийлж байна. Тэгэхдээ бас бүхнийг нэг тийш нь туйлшруулж болохгүй байх. “ЭХС өнгөрсөн жилүүдэд ихээхэн хэмжээний зээл, тусламж авсан, цалин харамж өндөр байдаг” гэдгийг маш зөвөөр ойлгуулах хэрэгтэй юм. 1990-ээд онд хотод хэзээ тог ирэх нь мэдэгдэхгүйгээр удтал тасардаг хүнд үе байсан. Өнөөдөр ийм зүйл байхгүй байгаа. Энэ нь уг салбарт тодорхой хэмжээний бодлого явсны үр дүн. Тухайлбал, манай цахилгаан станц л гэхэд 1979 онд суурийг нь тавьж, 1983 онд анхны үйлдвэрлэлээ явуулсан, ирэх онд 30 жилийнхээ ойг тэмдэглэх гэж байгаа. Зээл, тусламжийн хувьд нийтдээ 140-өөд сая долларын зээл, тусламж бид авсан. Үүний үр дүн юу болов гээд харахад 1990-ээд онд

*Монголын эрчим
хүчний систем
хоёрхон хөлтэй. Нэг
хөл нь IV цахилгаан
станци, нөгөөдөх нь
ОХУ-ын эрчим хүчний
системээс авч буй
өндөр хүчдэлийн
шугам.*

*Б.Цэвээн
/IV цахилгаан
станцины захирал/*

манай станцад бараг 150-200-гаад Зөвлөлтийн мэргэжилтэн ажилладаг байсан, конвейерийн жижүүрээс эхлээд даргаа хүртэл бүгд орос, бид дагалдан ажилладаг байсан. Ардчилсан хувьсгал гарч оросууд бөөнөөрөө явсны дараа л хүндрэл их гарсан. 100 хувь Оросын технологиор баригдсан цахилгаан станцын сэлбэг материалаас аваад аваар саатал, гал, тэсрэлт их гардаг байсан. Өнөөдөр манай станц 1990-ээд оныхоосоо бараг 100 дахин шинэчлэгдсэн гэж хэлж болохоор байгаа. Энэ бол тус салбарын бодлогын үр дүн гэж хэлж болно. 1990-ээд онд ажиллаж байсан оросууд маань сүүлийн 2-3 жилд олноороо буцаж ирэхдээ ТЭЦ 4 байгаа болов уу, энэ их шуурганд хийсээд алга болсон болов уу, байгаа бол ямар байдалтай байгаа бол, очиж жаахан сайжруулъя ч гэх юм уу бизнесийн өөр санаатай ирдэг байх. Өнөөдөр оросууд ирээд “Та нар биднээс хэдэн 10 дахин урагшаа ахисан байна, яаж ингэж чадав аа?” гэж гайхдаг. Хоёрхон хоногийн өмнө Уралын трубины заводуос ирсэн ерөнхий захирал, ТУЗ-ийн дарга нь “Би Оросын эрчим хүчний салбарт 30 гаруй жил ажиллахдаа танайх шиг ийм цахилгаан станц үзээгүй” гэж гайхаж байсан. Тэгэхээр төр засгийн бодлого зөв явж, түүнийг нь бид хэрэгжүүлж ирснээр тасалдал өнөөдөр түүх болж байна. Харин сүүлийн жилүүдэд дэндүү улс төржсөн учраас бодлого алдагдсан тал бий.

Энд ЭХС-ын бодлогын болон зохицуулалтын үйл явцад үнэлгээ өгсөн байна. Энэ бол хүмүүсийн өгсөн асуулт-хариултыг нэгтгэн гаргасан дүн болохоос бус та бүхний асуул-хариултын дүн биш. Хүмүүс буруу ойлголттой байгаа учраас зарим хүмүүсийн шүүмжлээд байгаа буруу үнэлэлт байж магадгүй. Бодлогын хувьд зохицуулалтаас арай доогуур үнэлгээтэй байх болов уу гэж би боддог. Харин ч манай салбарын зохицуулах үйл ажиллагаа сүүлийн жилүүдэд олон улсын жишигт нэлээд ойртсон үйл ажиллагаа явуулдаг болсон. Харамсалтай нь улс төр дэндүү их оролцдог болж зохицуулах үйл ажиллагаагаа зохих хэмжээнд явуулж чадахгүй, гаргасан шийдвэрээ хамгаалж чадахгүйд хүрч байна. Ерөнхий зохицуулагчийг улс төрөөс хамаарахгүйгээр 6 жилээр томилно гэж хуулинд заачихаад нь тэр хугацаанд нь хүргэхгүйгээр сольж байгаа нь зохицуулах үйл ажиллагаанд улс төр шууд оролцож байгаагийн илрэл. Салбарын бодлого зохицуулалтанд улс төр оролцохыг л ННФ нээлттэй үйл ажиллагаагаараа маш их шүүмжлэх хэрэгтэй байна. Ямар нэг юманд улс төр оролцохоор буруу замаар будаа тээх нь аргагүй. Бодлого дээр л гэхэд нэг сайд гарч ирээд л Эгийн голын УЦС-ын шав тавьж байхад дараагийн сайд нь гарч ирэнгүүтээ үүнийг байхгүй болгодог, Бараг л чи УЦС-аас татгалзвал чамайг сайд болгоё гэдэг нөхцөлтэйгөөр сайдаар томилдог байж болох уу? Тэгэхээр нөгөө хар хайрцагны бодлого хаана байна вэ? Үүний цаана би том гүрний том бодлого явж байгаа гэж боддог. Би энэ салбарт мэргэшсэн хүний хувьд хэлэхэд, манай ЭХС бие даан ажиллах чадвар байхгүй. Систем гэдэг чинь өөрөө 4 тулгууртай байж найдвартай оршин тогтнодог. Хамгийн бага найдвартай систем нь 3 тулгууртай байдаг. Тэгэхэд Монголын эрчим хүчний систем 2-хон хөлтэй. Нэг хөл нь IV цахилгаан станц, нөгөөдөх нь ОХУ-ын эрчим хүчний системээс авч буй өндөр хүчдэлийн шугам. Энэ хоёр л ямар нэгэн байдлаар доголдох

юм бол Монголын эрчим хүчний систем шууд зогсоно. Ийм аюултай нөхцөлийн эрсдэлийг хэрхэн багасгах вэ гэхээр 200-300 мВт-ын чадалтай УЦС-ыг маш яаралтай барих ёстой. Яагаад гэвэл Ази, Европын өндөр хөгжилтэй орнуудын эрчим хүчний системд ДЦС-ууд нь дандаа базовый горимд буюу үргэлж тогтмол ачаалалтай ажилладаг. Харин хэрэглээний өсөлт, бууралтыг УЦС, атомын цахилгаан станц мэтийн маневрлах чадвар өндөртэй стистемээр тохируулдаг жамтайг мэргэжлийн хүмүүс сайн ойлгоно. Гэтэл өнөөдөр Монгол Улсын эрчим хүчний хэрэглээний өсөлтийг IY цахилгаан станц дангаараа тохируулдаг. Өөрөөр хэлбэл, орой 6-8 цагийн оргил ачааллын үед манай станц ачааллаа 480 мВт хүртэл нэмээд шөнөдөө 320 мВт болтол нь хасдаг. Нүүрсээр ажилладаг цахилгаан станцын тоноглолын хувьд ингэж байнга дээшээ доошоо болгож, зогсоож ажиллуулах нь тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаа, насжилтанд маш хортой. Аюулгүй байдлын үүднээс УЦС хамгийн хэрэгтэй. Биднийг энэ тухай хэлэхээр арьсаа хамгаалж, мэргэжлийн баахан юм ярьж байна гэдэг. Тиймээс үүнийг олонд танигдсан хүмүүс, олон нийт хэлэх хэрэгтэй. Урьд нь бид Оросоос 60-70 хувь хамаардаг байсан бол одоо 90-95, бүр 99 хувь хамаарч байна. Хэдхэн хоногийн өмнө ОХУ манай улстай холбож буй 2 шугамаа зэрэг тасалсан. Үүнийг шууд анхааруулга л гэж ойлгосон. Тэгээд цагийн дараа “Гэмтэл нь арилчихлаа” гээд залгачихаж байгаа юм. Ид өвлийн ачаалалтай үед ийм тасалдал гарвал яах вэ? Улсыг биш цахилгаан станц өөрийгөө хөлдөөхгүйн тулд дотоод нөөцөө авч үлдэх буюу бүх тоноглолоо зогсоох түвшинд очвол сүйрэл гэсэн үг. Ийм нөхцөл байдлаас гарч, эрсдэлийг буруулахын тулд нийгэм маань их бэлтгэгдсэн, мэдээлэлтэй байх шаардлагатай. Монгол Улс асар том нутаг дэвсгэртэй, асар их баялагтай атал энэ баялгаа ашиглахгүйгээр Байгаль нуур руу алдаад байна шүү дээ. Тиймээс эерэг ойлголт өгөхийн тулд мэргэжлийн биднээс мэдээлэл материал авах, хамтран ажиллах асуудал нээлттэй байгаа шүү!

Байгаль орчинтой холбоотойгоор нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах асуудлыг ярихад цахилгаан станцуудын яндангаас гарч байгаа утаа, доошоо харуулаад тавьсан хувингаас гарч буй утааны тухай ярьдаг нь олон нийт ЭХС, цахилгаан станцын талаар ямар өрөөсгөл ойлголттой байгаагийн жишээ. Манай IY цахилгаан станц Улаанбаатарын агаарт нэг дусал ч бохирдол үүсгэдэггүй, тэр доош нь харуулаад тавьсан хувингаас утаа биш уур гарч байгаа юм. Энэ нь эсрэгээрээ орчныхоо агаарыг зөөллөж, эергээр нөлөөлнө. Манай цахилгаан станцын янданг 250 метр өндөртэйгөөр сонгож авсан байдаг нь социализмын үед жинхэнэ проект гэдгийг хэрхэн хийдэг, тэр бүх судалгааны үндсэн дээр хийсэн байдаг. Мэдээж хэрэг, цахилгаан станцад суурилагдсан цахилгаан шүүлтүүр гэж байгаа. Шаталгаар үүссэн хорт хий, үнс ялгах энэ төхөөрөмжийн үйл ажиллагаа 98,99 хувь, үлдсэн нэг зууны хэдэн хувь нь хаана хаягдах вэ? Тэр нь Богд уулыг давж хаягдахаар тооцоологдсон. Зарим хэвлэлд манай станцыг салхин талдаа баригдсан гэсэн байдаг. Тийм биш, Улаанбаатар хотын салхины чиглэл Туул голынхоо эрэг дагуу зүүнээсээ баруун тийшээ байдаг тул харин ч маш зөв байрлалтай байгаа. Энэ мэтчилэн олон нийтэд ойлгуулж, тайлбарлах зүйл маш олон байна.

Мөн үнэ тарифтай холбоотой асуудал бий. Мэдээжийн хэрэг, одоо манайд ажиллаж байгаа зарим станц 1950-аад оны ЗХУ-ын техниктэйгээ байгаа. Хамгийн сүүлд манай станц 1970-1980-аад онд ЗХУ-ын технологиор ашиглалтанд орсон ч өнөөдөр технологийн шинэчлэлийг маш эрчимтэй хийсэн. Манай бүтээдэхүүний өртөг 4 цент хүрэхгүй байна. Бид ард түмнээ хамгийн хямд цахилгаан, дулааны эрчим хүчээр хангаж байгаа. Гэтэл хамгийн хямд үйлдвэрлэл явагддаг, олон УЦС-тай ОХУ-д 1 КВт цахилгаан эрчим хүчний үнэ 7-8 цент болсон байгаа. Өнөөдөр ЭХС-т гадаадын хөрөнгө оруулалт хэрэгтэй юу гэвэл хэрэгтэй. Гэтэл манай үнийг хараад 4-5 центээр зарж байгаа эрчим хүчинд хөрөнгө оруулаад хэзээ түүнийгээ эргэж авах юм билээ гээд хөрөнгө оруулж ирэхгүй байна шүү дээ.

Үүнээс гадна, өмнө би хэлсэн, эрчим хүчний үйлдвэр бол цэвэр инженерийн ухаанаар явдаг, маш аюултай, улсын онцгой объект байдаг. Тэнд 550 градус халуун уур, 220 мянган вольтын өндөр хүчдэл, халуун ус, дөнгөж чүдэнз зурахын төдий дэлбэрэх магадлалтай хальсан тоосонцор байдаг. Гэхдээ энэ бүгд аюулгүй ашиглагдах ёстой, харин үүнийг мэргэшсэн ажилтнууд, мэргэжлийн инженерүүд ажиллуулдаг. Өнөөдөр ЭХС-ын цалинг өндөр байна гэж байна. Манай станцын дундаж цалин сая хүрч байгаа нь харин ч бага байгаа. Ийм цалингаар хүмүүсийг тогтоон барьж ажиллуулахгүй бол Оюутолгой, Тавантолгойн зүгээр экскаваторын машинистад 2000-3000 доллар амлаж байна. Харин ч монгол хүн “Дассан газрын даавуу зөөлөн” гэдэг ч юм уу, зах зээлийг жинхэнэ утгаар нь ой тойндоо хүртэл ойлгоогүй ч юм уу, сая төгрөгтөө сэтгэл хангалуун биш ч хуучин газраа өдөр шөнөгүй ажиллаж л байна. Тэр хүмүүс яваад өгвөл яах вэ? Тэгэхээр цалин хангамж өндөр гэдэг PR-ын оронд эсрэгээр нь - энд мэргэшсэн боловсон хүчин, мэргэшсэн инженерүүд энэхүү цэвэр инженерийн байгууламжийг ажиллуулдаг гэдэг талаас нь PR-даж байж зөв ойлголтонд хүрэх юм.

С.Ганболд /Монголын Эрчим хүч, геологи-уул уурхайн үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга/: Юуны өмнө сайхан үнэлгээний тайлан болжээ. 2-рт, жинхэнэ энергетикүүд байгаа учраас буруу зөрүү яривал уучлаарай. Тайланг уншихад “үнэ тариф”, “ил тод байдал” гэдэг үгс ахиухан орох ёстой байсан болов уу, тэгэхдээ би шүүмжлэлтэй хандаж байгаа юм биш. Өнөөдөр манай эрчим хүчний салбар яагаад хөгжихгүй байна вэ гэхээр үнэтэй холбоотой асуудлаас л болж байгаа. Өртгөө багасга, зардлаа тана л гэдэг, танаад танаад цөөхөн хэдэн төгрөг гарна, тэр нь ЭХС-ыг хөгжүүлэхэд төдий л нэмэр болохгүй.

2-рт, манай ажилтнуудын цалинг бусад салбарынхнаас хэт түрүүлсэн гэж болохгүй байх. 4-р цахилгаан станцынхан сая төгрөгийн дундаж цалинтай байдаг юм. Баруун бүсийн эрчим хүчнийхний цалин 230 000-350 000 төгрөг байдаг. Хэт өндөр гээд биччихээр үүнийг дагаад чирэгдэж байгаа дулааны, түгээхийн, дамжуулахынхан гээд маш олон станц байгаа. Энэ өгүүлбэрийг хасах хэрэгтэй. Шинэчлэлийн Засгийн газрын зарим нөхөд эрчим хүчнийхэн болоод байгаа юм байна, өндөр цалинтай, хэт түрүүлээд байгаа юм байна гэж бодох вий. Тэгэхээр амьдралд жоохон ойролцоо, дунджаар нь бичихгүй бол болохгүй байх. 18 газрын дундаж цалинг авч үзвэл надад байгаа шүү.

Өнөөдөр манай эрчим хүчний салбар яагаад хөгжихгүй байна вэ гэхээр үнэтэй холбоотой асуудлаас л болж байгаа. Өртгөө багасга, зардлаа тана л гэдэг, танаад танаад цөөхөн хэдэн төгрөг гарна, тэр нь ЭХС-ыг хөгжүүлэхэд төдий л нэмэр болохгүй.

С.Ганболд /Монголын Эрчим хүч, геологи-уул уурхайн үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга/:

Засаглал гэдэг бол эн түрүүнд хүн өөрөө, тухайн салбарын боловсон хүчин өөрсдөө засаглал байх ёстой гэж би боддог. Хэт улс төржиж, дээрээс нь засаглаад байхаар энэ салбар урагш явахгүй байна. Тиймээс стратегийн ач холбогдолтой гэдэг үүднээс нь энэ үнэлгээндээ бага зэргийн сонордуулга маягийн зүйл бичвэл хүн ойлгох байх. Уншаад байхад энд голдуу сайн юм байна. Муу юм байвч цухас дурдаад өнгөрчээ. Нэг зүйл нэмж хэлэхэд, манай эрчим хүчинд засаглалд хамаарахгүйгээр Хятадаас эрчим хүч авч байгаа баруун 3 аймгийн 3 сум байгаа. Тэнд ямар нөлөө, ямар засаглал байгаа гэдгийг та нар мэдэж байгаа. Мөн баруун бүсэд Оросоос 6,6 тэрбумын төгрөгийн дотац авч байгаа гэдэг байх. Засаглалаас чинь гадуур өөр орны засаглал энд бас яваад байна шүү дээ. Үүнд бодит үнэлэлт, дүгнэлт өгч болдоггүй юм болов уу гэсэн санаа байна.

Гадна дотно явж байхад, жишээ нь Бээжинд айл болгоны хашаан дээр бойлер, нар, салхины ч юм уу эрчим хүчний эх үүсвэр харагдах юм. Түүнийг хямдхан авчраад өгчихвөл айл болгон усаа хямдхан халаачих механизм байсаар байтал баахан зуух барих хэрэггүй санагдана.

Энд бас хүн талаасаа ерөөсөө дурдсан юм алга. Засаглалд ЭХС-ын 8 билүү 10-аад мянган хүн байгаа. Тэдний цалин хөлс өндөр, нийгмийн хамгаалалт сайн гэхээсээ илүүтэйгээр зарим нэг зүйл нэммээр байна. Засгийн газрын эрх мэдэлтнүүд үүнийг уншиж сонирхох байх. Дээр нь нэмж хэлэхэд та нөхөд зөвлөмждөө 3 зүйл бичсэнээ бага зэрэг дэлгэрүүлэхгүй бол арай л дутмаг мэт санагдаад байна. “Цаашид тайлан гаргана” гээд цахим хуудасны тухай дурдаад орхисон байна.

Эцэст нь хэлэхэд бидний хамтын ажиллагаа маш муу байгаа. Тайланг уншиж байхад “Зарим ТББ-ууд ИНБ-уудын эсэргүүцэлтэй тулсан” гэсэн нэг зүйл байна билээ. Гарцаагүй тулна аа. Эрчим хүчний үнэ нэмэх гэхээр Д.Чулуунбаатар дарга яаж нэмэх юм гээд нэг юм хэлнэ, МҮЭХ-ны ерөнхийлөгч С.Ганбаатар 100 хувь эсэргүүцнэ, би бас салбараа өмөөрөөд Ерөнхийлөгчийг эсэргүүцнэ. Энэ тулгардаг механизмыг даван гарахын тулд хамтын ажиллагаа хэрэгтэй. Эхлээд зөвшилцөөгүйгээс ийм эсэргүүцэлтэй тулаад байгаа тул хамтын ажиллагаагаа сайжруулах нь зөв. Эцэст нь хэлэхэд Эрчим хүч, геологи-уул уурхайн үйлдвэрчний эвлэлийн холбоо ажил олгогчтойгоо ЭХС-ын сайн сайхны төлөө хамтран ажилладаг тул үүнд бүү санаа зовоорой.

Р.Хаишчулуун /МУИС-ийн ЭЗС-ийн багш/: Мэргэжлийн хүмүүс байгаа учраас техникийн асуудал гэхээсээ илүү тайланг сайжруулах, илүү фокустай болгох талаас нь хэдэн үг хэлье. Ерөнхийдөө ямар нэгэн хэмжээгээр үнэлгээ гаргачихлаа, харин үүнийгээ харьцуулах талаас нь бага зэрэг тодруулж өгөөч. Энэ нь муу юм уу, сайн юм уу? Шилжилтийн шатандаа байгаа бусад улсад ямар байгаа вэ? Жишээ нь, олон улсын судлаач ирсний хувьд өөрийнхөө Тажикистан улстай харьцуулахад байдал ямар байгаа юм, би энэ талаар олж үзсэнгүй.

Хоёдугаарт, засаглалыг ерөнхийдөө шийдвэр гаргах механизм гэж үздэг тул яг засаглалтай холбоотой зүйлсээ илүү тодруулж бичих нь зүгээр болов уу. Учир нь манай ЭХС их том шинэчлэл дунд байгааг энд бичсэн байгаа ч түүнийгээ задлаагүй байна. Урьд өмнө төрийн өмчийн цахилгаан

*Том том цахилгаан
станц барих, орон
нутгийн цахилгаан
эрчим хүчний
сүлжээг бүгдийг
нь улсын нэгдсэн
систем болгох,
хараат байдлаас
ангижрах зэрэг
том зорилтуудыг
биелүүлэхийн тулд
бодлогын шийдвэрүүд
нь таарч байна
уу, үгүй юү гэдгийг
үзмээр.*

*Р.Хашчулуун
/МУИС-ийн ЭЗС-ийн
багш/*

станцууд давамгайлж байсан системийг зохицуулж байсан үеэс хувийн хэвшлийн, эсвэл төр, хувийн хэвшлийн зарчмаар баригдах том, шинэ бизнесийн салбарын зохицуулалт руу явж байгаа. Систем өөрчлөгдөж байгаа учраас энэ үед гарч буй засаглалын механизм хэр зэрэг байна вэ гэдэг асуудал нэн чухал. Жишээ нь татаастай байсан салбараас 2014 он гэхэд зах зээлийн зарчимд шилжих гэж байна. Тэгвэл энэ шийдвэр гаргах механизм өөрчлөгдөх үү, үгүй юү? Шийдвэрээ гаргахдаа зорилготойгоо хэр зэрэг нийцэж байгаа талаар шинжилгээ байвал зүгээр мэт санагдана. Ер нь энэ том том цахилгаан станц барих, орон нутгийн цахилгаан эрчим хүчний сүлжээг бүгдийг нь улсын нэгдсэн систем болгох, хараат байдлаас ангижрах зэрэг том зорилтуудыг биелүүлэхийн тулд бодлогын шийдвэрүүд нь таарч байна уу, үгүй юү гэдгийг үзмээр санагдаж байна. Жишээ нь сая ТЭЦ 5 дээр ярилаа л даа. Засаглалыг айхавтар унагааж байгаа алхам бол энэ болсон. Яагаад гэвэл урьд өмнө хэчнээн жил судалж, олон улсын байгууллага, АХБ-аар судалгаа хийлгэж, бүх талаасаа хэлэлцээд болно гэсэн зүйлээ нэг л өдөр унагаад цахилгаан станцаа тал газар барихаар боллоо. Тал газар шинэ цахилгаан станц барих юм бол түүнийг нь холбох дэд бүтцээ хэн барих вэ? Төлөвлөсөн юм байгаа юү? Түүнийг нь хэн тооцож, зураг, ТЭЗҮ-ийг нь хэн хийх юм бэ? Хувийн хөрөнгө оруулагчидтай болж байгаа өнөөгийн системд энэ нь улс өөрөө шийдвэр гаргачихаад бүх зардлыг хувийн хөрөнгө оруулагчдад үүрүүлж байгаа гэсэн үг. Тэр нь эцэстээ төр-хувийн хэвшлийн хийж буй гэрээ учраас бүх нэмэлт зардалдаа сууна, тэгэхээр цахилгааны үнэ өндөр болно. Урьд өмнө 4 жил судалгаа хийсэн бол энэ шийдвэрийг өөрчлөхийн тулд бас л 4 жил ч юм уу судалгаа хийж байж, нэг аргумент гаргаж ирэх ёстой шүү дээ.

Сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлнэ гээд том том төсөл явж байна. Түүнийг зохицуулахад одоогийн тогтолцоо бэлэн юм уу гэдгийг шийдвэр гаргах механизм талаасаа, тариф талаасаа, наад зах нь хэлэлцэх талаасаа үзэх хэрэгтэй. Бусад улсад үүнийг хэрхэн зохицуулдгийг харгалзвал зүйтэй болов уу.

Дараа нь орхигдсон юм уу гэж бодогдсон 2 зүйл байна. Тухайлбал, орон нутгийн цахилгаан станцууд байгаа гэж тайланд бичсэн байгаа ч түүний зохицуулалтыг би ерөөсөө олж уншсангүй. Мөн шинээр баригдсан хувийн станцуудын зохицуулалт алга байна. Жишээ нь, Ухаахудагийн цахилгаан станц ашиглалтанд ороод жил гаруй болж байна, түүнийг яаж зохицуулж байна вэ? Зөв зохицуулалттай байгаа бол зөв гэж хэлэх хэрэгтэй, учир нь Чандманийн, Тавантолгойн, Оюутолгойн цахилгаан станцууд ар араасаа орж ирнэ. Тэгэхээр орон нутгийн зохицуулалт, тэр дотроо хувийн станцуудын зохицуулалтыг тодруулж өгөөсэй. УЦС хоёр ч баригдлаа. Түүний зохицуулалт нь болж байна уу, үгүй юү? Энэ талаар бас үг алга. Эдгээр асуудлыг тодруулбал яасан юм бэ?

Хоёрдугаарт, зохицуулалтын зөвлөмжүүдийг би харлаа. 1-4 нь “Зохицуулах үйл явцын зөвлөмж” гэж байна. Ерөнхийдөө 4 хэсэгт хувааснаас бус зөвлөлд хараат бус байдал бий болгох, нээлттэй болгох гэсэн нэг л юмыг хэлээд байна. Тэгэхээр түүнийг олон салгаад тал талаас нь дахин дахин яриад байх хэрэггүй болов уу гэж бодсон юм.

Д.Цэрэнжав: Би нэг санаа хэлчихье. Б.Цэвээн дарга түрүүн ЭХС бол инженерийн ухаанд тулгуурласан салбар гэж хэллээ. Ер нь эрчим хүчтэй холбоотой зүйлс уншиж, энэ чиглэлийн хэлэлцүүлэгт сууж байхад ямар нэгэн санаа гаргахаар түүнийг өлгөж аваад тал талаас нь шүүмжилж боловсруулдаг механизм манайд үгүйлэгдээд байна. Хоёр жилийн өмнө Баабар Үү цахилгаан станцтай холбоотойгоор 1990-ээд онд хувьчилчих байсан юм гэсэн үндсэн санаа бүхий нийтлэл бичсэн. Үүнд нь Б.Цэвээн дарга хариулахдаа “Үгүй ээ, Казахстанд хувьчилчихаад сүүлд нь илүү өндөр үнээр худалдаж авсан” гэсэн нэг маргаан дэгдсэн. Үүнийг манай эрчим хүчний салбарт хэрэгтэй яриа хөөрөө болж цааш өрнөх болов уу гэж хүлээсэн ч ганц нэг сэтгэгдэл харагдаад тэгсхийгээд өнгөрсөн. Сүүлийн нэг жилийн турш янз бүрийн юм уншиж, Иргэний танхимын хэлэлцүүлэгт оролцож байхад хүмүүсээс маш гоё гоё санаа гарах юм. Үүнийг хаа нэгтээ өлгөж аваад буруу зөвийг нь хөгжүүлдэг механизм ерөөсөө алга. ЭХС нарийн мэргэжлийн салбар юм бол шинжлэх ухаантай адилхан өмнөх мэдлэгтээ тулгуурлан цаашаа баяжин хөгжиж, улам боловсронгуй болгох замаар явдаг байх ёстой гэж би бодож байна. Энэ салбартай холбоотой, ялангуяа УЦС, 5-р цахилгаан станц гээд чухал чухал асуудалтай холбоотой гоё гоё санаанууд ерөөсөө өлгөгдөхгүй юм. Бид аргаа бараад хэлэлцүүлгийн талбарыг вэб сайт байдлаар сонгож авдаг ч юм уу гэж бодож байна.

Би түрүүхэн нэг өгүүлэл уншлаа. Үү цахилгаан станцыг III станцын хажууд барих эсэх тухайд урьд нь эрчим хүчний сайд байсан Батхуяг гэдэг хүн саналаа илэрхийлэхдээ “Хэрэггүй ээ, олон сая тонн нүүрсийг УБ-г оруулж ирэх хэрэггүй, тэнд нь станцаа байгуулаад цахилгаан үйлдвэрлэх...” гэхчлэн бичсэн нь их сонин санагдсан. Буруу зөвийг нь унших юм сан, хүмүүс юу гэж шүүмжилсэн бол гэхээр унших юм ерөөсөө байхгүй, нэг хүн нэг санаа хэлээд л агаарт цацагдаад л таг болдог. Ийм хэлэлцүүлгийн механизм манай эрчим хүчний салбарт маш их хэрэгтэй байна. Бид бас олигтой, тодорхой зүйл санал болгож чадахгүй байна. Та бүхний санаа оноонд үндэслээд ийм нэг талбарыг л бий болгох гэж оролдоод байгаа юм.

Б.Мөнхсоёл: 17 цаг болж байгаа тул 2 хүний асуултыг сонсоод саналаа хаая.

С.Мойлтмаа /IRIM судалгааны хүрээлэнгийн/: Би засаглалын чиглэлээр, иргэдийн оролцооны чиглэлээр судалгаа хийдэг. Цэрэнжав ах, ННФ-ын мэргэжилтнээс асуух 2 зүйл байна. Бодлогын зөвлөмж дээр олон нийтийн оролцоог хангах талаар зөвлөмж байсан, үүн дээр бусад орны ямар нэгэн сайн жишээ, шууд авч хэрэгжүүлчихээр санал болгож буй механизм байгаа юу? Энэ талаар тайланд тусгаж судлаагүй байгаа бол цаашид хэрхэн судлах вэ?

2-рт, “Цаашид юу хийх вэ?” гэдэг дээр “Сонирхогч талуудын хамтын ажиллагааны механизм бий болгоно” гэсэн 3 зүйл байна, Үүнийг яаж бодит ажил хэрэг болгох, хэн хариуцах, хэрхэн зохион байгуулалтаар хангах вэ гэдэг асуудал сонирхол татаж байна.

Б.Мөнхсоёл: Цэрэнжав гуай бидэнтэй хамтарч ажилласны хувьд өөрийнхөө санааг, мөн бид дотроо ярилцаж байсан санааг буулгачихсан байгаа. Ерөнхийдөө анх судалгааг Нээлттэй нийгэм хүрээлэнгийн

*Эрчим хүчний салбар
гэлтгүй аливаа
бодлого, шийдвэртэй
холбоотой асуудалд
иргэдийг оролцуулна
гээд хууль, журам
гаргасан ч иргэд
нь мэдээлэлгүй бол
идэвхтэй оролцож
чадахгүй. Тэднийг
механикаар, хүчээр
“чирж” авч ирэх
боломжгүй, харин эрх
ашиг нь хөндөгдсөн
хүмүүс л оролцоно.*

*Б.Мөнхсөёл
/ННФ-ын менежер/*

олон улсад хэрэгжүүлсэн туршлагад тулгуурлан Монголд хийе гэдэг санаачилгын үндсэн дээр судалгааны ажлыг эхлүүлж, бараг л дуусчихлаа. Тайлан бол, мэдээж, хэвлэгдэнэ. Үүний дараа яах вэ гэдэг дээр бид ярилцаж байгаа. Тэгээд хэлэлцүүлгийн үр дүнд янз бүрийн санаа оноо гарна байх гэсэн хүлээлттэй байгаа, эхнээсээ ч ерөнхийдөө гарч байна. Олон улсын практикийн хувьд, миний ойлгосноор зөвхөн ЭХС гэлтгүй аливаа бодлого, шийдвэртэй холбоотой асуудал дээр иргэдийн оролцоог яаж бий болгох вэ гэхээр, иргэдийг оролцуулна гээд хууль, журам нь гарчихдаг, гэтэл иргэд сонирхолгүй бол, эсвэл мэдлэг, мэдээлэлгүй бол идэвхтэй оролцохгүй, түүнийг механикаар, хүчээр чирж авчрахгүй, эрх ашиг нь хөндөгдсөн хүн л оролцоно. Гэтэл хүн бүр эрчим хүч хэрэглэдэг болохоор энэ нь үнэхээр хүн болгоны эрх ашгийг хөндсөн асуудал мөн. Тэгвэл тэр хүний анхаарлыг яаж татаж, өдөөж өгөх вэ гэхээр мэдээллээр л хангаж, мэдлэгжүүлэх хэрэгтэй. Тиймээс бид яаж мэдээллээр хангах вэ гэдэгт эхлээд анхаарч байна. Одоо энэ судалгааны тайланг хууль боловсруулагчид ч өгнө, иргэдэд ч тараана. Нөгөөтэйгүүр байнгын, нэг удаагийн биш утгаар сайт нээнэ гэсэн. Хүмүүс ч гэсэн эвсэл байгуулах хүлээлттэй байгаа юм байна. Манай ННФ-д төсөв, уул уурхайн олборлох салбарын ил тод байдлын чиглэлээр ажилладаг хэд хэдэн эвсэл байгуулсан туршлага бий. Түүн шигээ “Эрчим хүчний санаачилга” гэсэн эвсэл байгуулах зорилготой байна. Тэгэхдээ нэг асуудал гарна, тэр нь юу вэ гэхээр одоогоор энэ чиглэлээр идэвхтэй иргэд, иргэний нийгэм байхгүй. Тиймээс үүнийг бий болгоход анхаарч байна. Олон улсын туршлага гэвэл яг тэр улс нь илүү ил тод, нээлттэй гэж хэлэх юм байхгүй, адилхан шатандаа явж байгаа. Хөгжилтэй улсууд бол өөр асуудал, манайхтай ижил түвшинд явж байгаа орнууд дотроо Монгол арай ахицтай ч явж байгаа тал бий. Олон улсын түвшинд EGI partners гэдэг байгууллага байгаа. Дэлхийн нөөцийн байгууллага судалгаа хийсэн 10 орныхоо энэ мэт судалгаан дээр ажилласан шинжээчдийг нийлүүлээд Partners гэдэг байгууллага байгуулсан юм. Түүнд Монголоос ННФ байгаа. Аль нэг улс нь ЭХЗ-тай холбоотой туршлага судалъя, мэдээлэл авъя гэвэл бие биедээ ханддаг олон улсын сүлжээ маягийн байгууллага юм. Шинээр байгуулагдсан энэ байгууллага зарим мөнгөтэй, том байгууллагуудыг гүйцэхгүй ч ийм оролдлого, санаачилга байгаа. Та бүхний хэлсэн санаа оноо бидний цаашдын үйл ажиллагааг өдөөж өгөх үндэс суурь болно. Хэрэв хэрэгцээ шаардлага байхгүй бол үгүй болох байсан гэтэл, хэрэгцээ харагдаж байна. Тэгэхээр бид үргэлжлүүлэн ажиллана.

П.Баатар /Дөргөний УЦС-ын зөвлөх инженер/: Хоёр илтгэгчдээ баярлалаа. Би Дөргөний УЦС-ын зөвлөх инженер. Тус станц 2008 онд ашиглалтанд орсон, одоо 4 жил хэвийн ажиллаж байгааг дуулгахад таатай байна. Энэ тайланд 2 зүйл дурдагдсан байна: “Дөргөн, Тайширын УЦС-тай холбогдсон маргаан гарч байсан, сүүлийн үед Сэлэнгийн УЦС-ын талаар сонин хэвлэлээр шуугьж байна” гэж энд бичигджээ. Монголд УЦС хэрэгтэй талаар Б.Цэвээн ерөнхий инженер их сайхан ярилаа. Түүний ярьсан дээр нэмж хэлэхэд Монголын эрчим хүч гэдэг бол үйлдвэрлэл, тээвэрлэлт, хэрэглээ нь нэг агшинд явагддаг хүнд үйлдвэрлэл юм. Үүнийг нуруун дээрээ үүрч явна гэдэг, тэр тусмаа Монгол шиг дэлхийн хамгийн хүйтэн

УЦС эдийн засгийн хямралд өртдөггүй учраас улс болгонд байдаг юм. Одоо НҮБ-ын гишүүн 180 орон УЦС-тай, цөлийн арванхэдэн оронд л угаасаа гол ч байхгүй болохоор УЦС байх аргагүй юм.

*П.Баатар
/Дөргөний УЦС-ын зөвлөх инженер/*

нөхцөлд байдаг орны нийслэлийн хэрэглээний 70 хувийг үүрч явна гэдэг нь Б.Цэвээн инженерт ямар их ачаалал, асар том хариуцлага ногдож байгааг та бүхэн төсөөлөх байх. “Монголын эрчим хүч 2 хөлтэй” гэж Б.Цэвээн инженер хэллээ. Би бол нэг хөлтэй гэмээр байна. Хилийн цаана байгаа хөлийг суга таяг л гэж үзэхээс бус ямар хөл гэх вэ. Дэлхийн эрчим хүч ерөөсөө 2 хөлтэй байдаг, нэг нь нүүрсээр ажилладаг ДЦС, нөгөөдөх нь УЦС. Хоёр дахь нь манайд байхгүй. 2008 онд Дөргөний УЦС-ыг асар их эсэргүүцэлтэйгээр ашиглалтанд оруулсан. Одоо хүмүүс ойлгож дэмжээд дараагийн том УЦС-ыг барих, өөрөөр хэлбэл, өндөр технологи буюу хуримтлал үүсгэдэг технологийг Монголд нутагшуулах боломжтой юм байна гэж байгаа. Дан ДЦС болохоор хуримтлал үүсгэдэггүй. Ү цахилгаан станц барья гэхэд хуримталсан сан байхгүй байна. Тэр хуримтлал үүсгэдэг станцыг нь дэлхий даяар УЦС гээд зарлачихсан. Олон улсын байгууллага манай ЭХС-ын хөгжлийг тогтворгүй хэмээн дүгнэсэн шүү дээ. УЦС 200 жил ажилладаг, бусад нь 20-45 жил ажилладаг. Тэгэхээр тогтвортой хөгжлийн тулгуур технологи гэж НҮБ нэгэнт зарлачихсан байхад манайх эсэргүүцээд байх юм. Энэ талаар олон нийтэд зөв мэдээлэл хүргээч ээ гэж та нөхдөд хэлмээр байна.

Манайд УЦС яагаад хэрэгтэйг нотлох 10 шалтгаан уг нь байдаг ч цаг хэмнээд 3-ыг нь л хэлье:

1. Эрчим хүчний хангамжийн аюулгүй байдлыг баталгаажуулна. Жишээ нь, баруун бүсийн эрчим хүчний систем Оросоос шугам авахад тэр шугамын тулгуур нь салхинд нурж унан 3 аймгийн төв хөлдөж байсан. Дөргөний УЦС ашиглалтанд орсноор эрчим хүчний аюулгүй байдал нь хангагдсан. Төвийн бүсэд 100 хувь нүүрсээр ажиллаж байна, энд аюулгүй байдал хангагдсан юм байхгүй. Миний хэлдгээр суга таягтай л байна, энэ таяг нь хугараад уначихвал яах вэ?
2. 2008 онд дэлхий даяар эдийн засгийн хямрал болсон, 2012 онд ахиад болох гэж байна. УЦС эдийн засгийн хямралд өртдөггүй учраас улс болгонд байдаг юм. Одоо НҮБ-ын гишүүн 180 орон УЦС-тай, цөлийн арванхэдэн оронд л угаасаа гол ч байхгүй болохоор УЦС байх аргагүй юм.
3. УЦС экологийн хувьд цэвэр нөхөн сэргээгддэг эх үүсвэр болдог. Саяхан Нью-Йоркт мэдээлснээр Улаанбаатарын агаарын бохирдол дэлхийд хоёрдугаарт орж байна гэнэ. Утаанд удаан байвал маш аюултай тул түүнийг бууруулах биш, арилгах зорилт тавих ёстой. Үүнийг нэн даруй хийхгүй бол нийслэлд төвлөрсөн сая гаруй хүний эрүүл мэндэд эрсдэл үүсгэх аюултай. Тиймээс л УЦС гэж яриад байгаа юм.

О.Бум-Ялагч /”Монголын Ногоон эвсэл” байгаль орчны ТББ/: Энэ хэлэлцүүлэгт оролцуулсанд баярлалаа. Өнөөдөр ЭХС-ын мэргэжлийн улсууд ирээд ярьж байна. ТББ-уудыг хараад байхад ер нь мэргэжлийн ТББ ихэвчлэн гишүүдийнхээ ашиг сонирхлыг илэрхийлсэн байгууллагууд байдаг учир түүндээ л төвлөрч яриад байх шиг байна. Гэхдээ нийгмийн болон байгаль экологийн ашиг сонирхол гэдэгт анхаарч ярих ёстой

байх. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хууль байгаа, энэ хуулиндаа нийцүүлж л үйл ажиллагаагаа явуулах ёстой байх.

Ү цахилгаан станцыг III станцын хажууд барих гэж байснаа болилоо гэдэг нь 4 жил судалгааг нь хийж байхад орчных нь газрыг хувь хүмүүс худалдаад авчихсан юм байна билээ. Эргүүлээд 50 тэрбум төгрөгөөр зарна гэж байх шиг байна. Манай нийгмийн хөгжил шилжилтийн гэдэг утгаараа нийгмийн яг идэвхтэй давхарга нь байхгүй, гадаадад гараад явчихсан байгаа. Араас залуу үе гарч ирээд нийгмийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцтол нэлээд их эрсдэл үзэх байх.

Энэ судалгаа хийж буй эрчим хүчний салбар гол салбар тул олон нийтийн оролцоо маш чухал. Хүмүүсийн цалин их, бага байна гэж ярьж байна. Эрчим хүчний үнийг чөлөөлчихвөл нийгмийн ихэнх хэсэг болсон ядуучууд нь яаж төлөх вэ гэдэг асуудал тавигдана. Үүний оронд ард түмнийхээ амьдралыг дээшилтэл ЭХС-ыг татаасаар явуулах хувилбар байгаа байх гэж бодож байна.

УЦС сайн л гэнэ. Нөгөө талаас байгаль экологи, биосуурт нөлөөлдөг тал бий. Орчин үеийн технологиор байгаль экологид сөргөөр нөлөөлдөггүй УЦС барьдаг болсон гэсэн. Энэ мэт санаачилгыг дэвшүүлээд сэргээгдэх эрчим хүч, Хятадад байгаа технологиуд зэрэг янз бүрийн арга, технологи оруулж ирж болох юм. Улаанбаатар хотыг утаанаас салгахад ЭХС-ын хүмүүс ерөөсөө оролцохгүй байна гэж ажиглагддаг. Тэд их өндөр боловсролтой хүмүүс ч нийгмийн өмнө хүлээсэн хариуцлага манай мэргэжилтэй боловсон хүчинд алга байх шиг байна. Зүгээр нийгмийн идэвхтэй улсууд л яриад байдаг, жинхэнэ мэргэжил эзэмшсэн хүмүүс нь мэргэжлийн хүний үүднээс гээд л суугаад байдаг. Нийгэм маань бүгдээрээ хордоод, хүүхдүүд маань өвчтэй болж, ахмадууд маань урт наслахгүй байна. Монголын боловсролтой сэхээтнүүд үүнийг л ойлгож бие биендээ ихэрхэж, нэг нэгийгээ доош нь хийхгүйгээр хамтран ажиллаж байж нийгмийнхээ асуудлыг шийдэж чадна. Манай нийгмийн 75 хувь нь 35 хүртэлх насны залуучууд байгаа. Энэ залуус удахгүй гарч ирээд нийгмээ аваад явчихна, харин тэр хүртэл нь бид холион бантан хутгачихгүйгээр яаж нэг юм залгуулах вэ гэдэг асуудал бий.

Ч.Нанжидсамбуу /АОЭХ-ны Бизнесийн харилцааны хэлтсийн дарга/: ЭХЗ гээд ярихаар засаглал гэдэг талаас нь ганц хоёр санаа хэлье. Монголын ЭХС, шатахууны салбарын хөгжлийн ирээдүйг хараад байхад төрийн хатуу үнэ тариф тогтоодог энэ салбарууд аажмаар хөгшрөөд доошоо л уруудаад байхаас бус дээшээ өгсөж байгаа нь ерөөсөө харагдахгүй байна. Үүний шалтгаан нь юу юм бол гээд янз бүрийн хүний санаа бодол, судалгаанаас үзэхэд хатуу үнэ тариф тогтоогоод улс төрийн шалтгаанаар юм уу ямар нэгэн шалтгаанаар үнийг нь бариад байна. Тийм учраас нөгөө салбар нь хөрөнгө оруулалт хийж чаддаггүй, техник технологио шинэчилж чаддаггүй. Энэ асуудал тойруу замаар явсаар байгаад ерөөсөө үнэ тариф дээр очоод тогтчихсон. Энд хараад байхад “ЭХЗ-ыг цааш хэрэгжүүлэхэд сонирхогч талуудын хамтын ажиллагааны механизм бий болгоно” гэж байна. Үнэ тариф тогтоох чиглэлээр засаглалын зарчмуудыг хараад байхад хэн нэгний ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалж байх хүнийг ерөөсөө

*Монголын ЭХС, шатахууны
салбарын хөгжлийн
ирээдүйг хараад байхад
төрийн хатуу үнэ тариф
тогтоодог энэ салбарууд
аажмаар хөгширөөд доошоо л
уруудаад байхаас бус дээшээ
өгсөж байгаа нь ерөөсөө
харагдахгүй байна.*

*Ч.Нанжидсамбуу
/АОЭХ-ны Бизнесийн
харилцааны хэлтсийн
дарга/:*

оруулдаггүй юм билээ. Өөрөөр хэлбэл, тэр хүн шийдвэр гаргах механизмд оролцохоороо өөрийнхөө төлөөлж буй бүлгийн төлөө л гар өргөдөг юм билээ. Тэгэхээр шийдвэр гаргах механизмд гар өргөхдөө хэн нэгний хараат бус, сонирхлын зөрчилгүй, гаргаж буй шийдвэр нь энэ салбарын одоогийн болон ирээдүйн нөхцөл байдлыг аль болохоор уялдуулсан хараат бус шийдвэр гаргадаг хүмүүсийг л сонгодог юм байна. Жишээ нь, Хэрэглэгчийн төлөө газрын хүн тэнд суучихаар зөвхөн хэрэглэгчийнхээ төлөө бодож л гар өргөдөг. Энэ талаар бага зэрэг оруулбал зүгээр юм болов уу гэж бодсон юм.

2-рт, тайланд “Нийгмийн нөлөөллийн үнэлгээ” гэдэгт эмзэг бүлгийн амьжиргаа, цалин хөлс, аюулгүй ажиллагаа талаас нь л бичсэн байна. Сүүлийн үеийн компаниудын тайланг харахад энэ үнэлгээнд соёл урлаг, дуу хөгжим, газрын хөрсөн доорх юм уу усан доорх эртний үнэт баялаг зэрэг маш олон ойлголт багтдаг юм байна билээ. Тиймээс “Нийгмийн нөлөөллийн үнэлгээ” гэдэгт илүү дэлгэрэнгүй зүйл оруулах хэрэгтэй. Магадгүй Сэлэнгэ мөрөн дээр УЦС барих гэж байгаа бол нийгмийн нөлөөллийн үнэлгээ талыг нь маш сайн хийгээд түүнийгээ олон нийтэд сайтар ойлгуулбал нутгийн ард түмэн, жинхэнэ оролцогч талуудын дэмжлэг авч магадгүй юм.

Г.Оюунтуяа /”Хүнс” эвсэл/: Би хүмүүсийн хэлээгүй ганцхан санал хэлье. Энэ төсөл үргэлжилмээр санагдаж байна. Яагаад гэвэл төслөөс гарсан зөвлөмж, цаашид хийх ажил, хамгийн гол нь ЭХС-т сайн засаглал тогтооход юу хийх вэ, тухайлбал, улс төрийн нөлөөг яаж бууруулж ядаж багасгах вэ?

2-рт, ЭХС-т ямар засаглал ямар дүрэм журмаар явах вэ? ДЦС нэмж барих юм уу, УЦС нэмж барих уу, аль эсвэл сэргээгдэх эрчим хүчээр явах юм уу?

3-рт, иргэдийн оролцоо, тэднийг мэдээлэлжүүлэх, мэдлэгжүүлэх. Өнөөдөр ямар ч мэдээлэлгүй, эсвэл үй олон ТВ, сонинтой мэдээллийн хүчирхийллийн нийгэмд тэр олон ТВ, сониноор янз бүрийн мэдээлэл өгөхийн оронд иргэдэд зөв, бодитой мэдээлэл өгдөг албан ёсны талбар бий болгох санал албан ёсоор тавьж байна. Тухайлбал, УЦС сайн гээд л ярьж байна. УЦС-д газарзүйн байрлал их чухал байдаг болов уу. Тухайлбал, Енисей мөрний УЦС гэхэд үнэхээр л усыг нь хаагаад УЦС баримаар хоёр уулын хооронд их гоё харагддаг. Гэтэл Говь-Алтайн Тайширын УЦС-ын усыг дүүргэхийн тулд Монгол Улсын 3 аймаг, тэр нутгийн иргэд бэлчээр усгүй, газар нутаггүй, амьжиргаагүй болсон шүү дээ. Усыг нь дүүргэсний дараа усаа тавиад эхлэхэд өнгөрсөн зун Говь-Алтай аймгийн Жаргалан суманд байдаг Эрээн нуурын сав усаар дүүрч байсан. Энэ хооронд нутгийн иргэд бэлчээр байхгүй, амьжиргаагүй болсон учраас нутгаасаа дүрвээд Улаанбаатар хотын хог дээр гарсан шүү дээ. Зөвхөн муу талаас нь ярьж байгаа юм биш, яг ийм л нөлөөллийг яримаар байна. Би иргэний нийгмийн салбарт иргэдийн төлөөлөл болдог учраас иргэдэд ингэж туссан гэдэг талаас нь үргэлжлүүлэн судлах саналтай байна.

Г.Пүрэвдорж: Тайланг бичсэний хувьд хоёрхон үг хэлье. Энэ тайланг та бүхний санал бодлыг авч тусгаад улам сайжруулан гарах ёстой. Бид дөрөв хийсэн үнэлгээндээ санаа зовж суулаа. Үнэн хэрэгтээ та нар яг үнэллээ л

дээ. Бид яг олон улсын стандарт аргачлал хэрэглэснээс илүү юм нэмээгүй, яг тэр асуултанд хариулахаар ийм л үр дүн гардаг юм. Монгол Улсад эрчим хүчний зохицуулалтын болон бодлогын үйл явцыг үнэлэх хууль эрх зүйн баримт бичгүүд ямар нэгэн хэмжээгээр сайн байгаа. Гэтэл түүнийгээ хэрэгжүүлэх явцдаа болохоо байчихдаг. Жишээ нь, Б.Цэвээн дарга “Бид Улаанбаатар хотод ямар ч бохирдол үүсгэдэггүй, Үү цахилгаан станц бараг 99,99 хувиар цэвэрлээд гаргадаг” гэлээ. Гэтэл бүх тайланд агаарын бохирдлын нэлээд хувийг ДЦС эзэлдэг гэж бичдэг. Харин үүнийгээ ЭХС-ынхан ил тод хэлдэггүй, түүнд зарцуулсан мөнгө төгрөгийг нь зохицуулагч нар хийдэггүй юм. Манай ЭХЗ иймэрхүү л байдлаар явж байгаа.

Тайлан та бүхэнд очно, түүнийг улам боловсронгуй болгоод ЭХС-ыг сайн болгохын төлөө зохих зохих түвшиндээ хичээн ажиллавал ЭХЗ сайжрахад их амархан байгаа. Сайн засаглалд маш муугаар нөлөөлж буй зүйл бол ЭХЗ дахь чадлын дутагдал. Энэ бол бидний тулгамдсан асуудал, манай улс төрийн нөлөө, улс төрчид л ийм болгосноос бус өөр юм байхгүй шүү дээ.

Б.Бат /МУИС-ийн ЭЗС-ийн багш/: Үнэтэй санал, зөвлөгөө өгсөн та бүхэнд баярлалаа. Нэмж хэлэхэд бидний бичсэн тайлан бол ЭХС-ын үнэлгээ биш, ЭХЗ-ын үнэлгээ байгаа. Салбарын зарим асуудлууд гарч ирж байна. Хэлэлцүүлэг өрнөж байхад том том УЦС-уудын талаар яригдлаа. Яагаад ингээд яригдаад байгаагийн цаад шалтгааныг бид судалгааны явцад үзэхэд ерөөсөө хуулиндаа 1 мВт болон 135 кВт-аас дээш цахилгаан шугам сүлжээ бол байгаль орчны үнэлгээ хийлгэх ёстой, энэ үнэлгээг хийлгэчихээд тайлангаа ил тод байлгах ёстой гээд заачихсан байгаа. Гэтэл энэ нь байдаггүй. Хүмүүс Ү цахилгаан станц баригдахаар яах юм, түүний байгаль орчны үнэлгээ юу байна, УЦС байгуулахаар ямар нөлөөлөл байгаа зэргийг мэдэхгүй байгаа учраас л маргаад байгаа болов уу. Түүнийг нь ил тод болгоод, дээр нь мэргэжлийн хүмүүс оролцоод явбал илүү үр дүнтэй байх болов уу. Дээр нь нэмж хэлэхэд, ЭХС өнөөдөр ДЦС байх уу, УЦС барих уу гэдэг асуудал аль хэдийнэ мастер төлөвлөгөөндөө тусгагдсан л байх ёстой зүйл. Гэтэл 2025 он хүртэл хөгжүүлэх ийм төлөвлөгөө өнөөдөр гараагүй байгаа.

Б.Мөнхсоёл: Хоёр цаг хагас үргэлжилсэн хэлэлцүүлэгт маань идэвхтэй, анхааралтай оролцсон та бүхэнд их баярлалаа. Хэрэв эвсэл байгуулагдвал бидэнд хийх зүйл их байгаа. Түрүүн миний хэлсэнчлэн олон улсын түншлэлийн түвшинд ажиллаж байгаа түншлэлийн байгууллага маань маш олон аргачлал боловсруулсан. Зөвхөн эрчим хүчний засаглалын асуудлаар бус, иргэдийг цаашид мэдлэгжүүлэх, мэдээлэлжүүлэх талаар, үнэ тарифын асуудлаар 10 гол асуулт, ЭХС-ыг төлөвлөх талаар 10 гол асуулт гэхчлэн судалгааны аргачлалууд байгаа. Тэдгээрийг ашиглах талаар бид бас бодно. Эцсийн тайланг бид та бүхэнд хүргүүлнэ. Баярлалаа.

17.30-д дуусав. Тэмдэглэл хөтөлсөн С.Отгонцэцэг

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ИНСТИТУЦИ, ТЭДГЭЭРИЙН УДИРДАХ АЛБАН
ТУШААЛТНУУД (2012 ОНЫ 12-Р САРЫН БАЙДЛААР)

УЛСЫН ИХ ХУРАЛ

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд “түлш, эрчим хүч” гэсэн багц асуудал багтдаг. Тус байнгын хорооны бүрэлдэхүүн:

1. **Бат-Эрдэнэ.Д**
2. **Батбаяр.Н**
3. **Баттулга.Х**
4. **Батцогт.Д**
5. **Баярсайхан.Ц**
6. **Болорчулуун.Х**
7. **Ганбат.Д**
8. **Гантөмөр.Л**
9. **Ганхуяг.Д**
10. **Гарамгайбаатар.Б –**
11. **Даваасүрэн.Ц**
12. **Дэмбэрэл.С**
13. **Одонтуяа.С**
14. **Оюунгэрэл.Ц**
15. **Тэрбишдагва.Д**
16. **Уянга.Г**

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

Сайд **М.Сономпил**, УИХ-ын гишүүн

Дэд сайд **Д.Доржпүрэв**

Төрийн нарийн бичгийн дарга **Д.Дэлгэрцогт**

Төрийн захиргааны, удирдлагын хэлтсийн дарга **Л.Батсайхан**

Хуулийн хэлтсийн дарга **Б.Баяр**

Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга **П.Товуудорж**

Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

Ц.Баярбаатар

Эрчим хүчний хэлтсийн дарга **Д.Чимэддорж**

Түлшний хэлтсийн дарга **Н.Болдхүү**

Сэргээгдэх эрчим хүчний хэлтсийн дарга **М.Ангараг**

Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга **П.Болд**

Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга **С.Баярбат**

Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга **Ц.Мөнхбаяр**

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Хорооны гишүүд буюу зохицуулагчид:

1. Эрчим хүчний зохицуулах хорооны дарга, орон тооны гишүүн
Т.Цэрэнпүрэв
Монгол Улсын Ерөнхий сайдын 2012 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн 36 тоот захирамжаар Эрчим хүчний зохицуулах хорооны даргаар томилогдсон.
2. Орон тооны гишүүн, зохицуулагч **Н.Мягмарсүрэн**
Монгол Улсын Ерөнхий сайдын 2012 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн 36 дугаар захирамжаар Эрчим хүчний зохицуулах хорооны зохицуулагчаар 4 жилийн хугацаатай томилогдсон.
3. Орон тооны гишүүн, зохицуулагч **Д.Бассайхан**
Монгол Улсын Ерөнхий сайдын 2012 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн 36 дугаар захирамжаар Эрчим хүчний зохицуулах хорооны зохицуулагчаар 4 жилийн хугацаатай томилогдсон.
4. Орон тооны бус гишүүн, зохицуулагч **Д.Чулуунбаатар**
(Монголын хэрэглэгчдийн эрхашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн нэгдсэн холбооны ерөнхий нарийн бичгийн дарга)
Монгол Улсын Ерөнхий сайдын 2012 оны 4-р сарын 3-ны өдрийн 36 тоот захирамжаар Эрчим хүчний зохицуулах хорооны орон тооны бус зохицуулагчаар 2 жилийн хугацаатай томилогдсон.